



МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК

ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2022 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ТӨСӨЛ

Улаанбаатар хот
2021 он



**ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН
ТАЛААР 2022 ОНД БАРИМТЛАХ
ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ТӨСӨЛ**

Улаанбаатар хот
2021 он



ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ.....	5
ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2022 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙГ БАТЛАХ УИХ-ЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН 2 ДУГААР ЗААЛТЫН ТАНИЛЦУУЛГА.....	6
ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2022 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ТӨСӨЛ	27
ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2022 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА	28
ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2021 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ БАТЛАХ ТУХАЙ УИХ-ЫН 2020 ОНЫ 32 ДУГААР ТОГТООЛЫН ХЭРЭГЖИЛТ.....	54
ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2021 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ХЭРЭГЖИЛТ	67
ТӨСЛИЙН ТООЦОО СУДАЛГАА	76
1. ИНФЛЯЦ	76
2. БОДИТ СЕКТОР	77
2.1. Нийт нийлүүлэлт	77
2.2. Нийт эрэлт	79
3. УЛСЫН ТӨСӨВ.....	79
4. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ, БОДЛОГЫН АНХААРАХ АСУУДЛУУД	83

4.1. Эдийн засгийн өсөлтийн төсөөлөл.....	83
4.2. Төсвийн бодлогын төлөв.....	88
4.3. Мөнгө, зээлийн үзүүлэлтийн төлөв.....	91
4.4. Төлбөрийн тэнцэл, гадаад секторын төлөв.....	92
4.5. Бодлогын анхаарах асуудлууд.....	95
5. МӨНГӨНИЙ ҮЗҮҮЛЭЛТҮҮД.....	103
5.1. Мөнгөний нийлүүлэлт, зээл.....	103
5.2. Орон сууцны ипотекийн зээлийн хөтөлбөр.....	108
5.3. Мөнгөний зах, хүүний түвшин.....	110
5.4. Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш.....	114
6. ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ, ГАДААД ЗАХ ЗЭЭЛ.....	115
6.1. Төлбөрийн тэнцэл.....	115
6.2. Хөрөнгө оруулалтын позиц.....	120
6.3. Монгол Улсын гадаад өр.....	123
7. САНХҮҮГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДАЛ.....	126
7.1. Санхүүгийн салбар.....	128
7.2. Банк бус санхүүгийн салбар.....	129
7.3. Банкны салбарын өнөөгийн байдал, цаашдын төлөв.....	132
7.4. Банкны салбарын эрсдэл даах чадвар.....	139
СТАТИСТИКИЙН ХАВСРАЛТУУД.....	140

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны ... сарын ... өдөр

Дугаар ...

Төрийн ордон,
Улаанбаатар хот

ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2022 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт, Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2022 онд баримтлах үндсэн чиглэл”-ийг хавсралтаар баталсугай.

2. Дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/, Монголбанк /Б.Лхагвасүрэн/, Санхүүгийн зохицуулах хороо /Д.Баярсайхан/-нд тус тус даалгасугай.

1/ Цар тахлаас үүдэлтэй хүндрэлийг даван туулж, эдийн засгийн сэргэлтийг дэмжих, өсөлтийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн төсөв, мөнгө, санхүүгийн бодлогыг хэрэгжүүлэх;

2/ Уул уурхайн бус экспортыг дэмжих бодлогыг нэгтгэн тодорхойлж, санхүүгийн дэд бүтэц, санхүүжилтийн хүртээмжтэй тогтолцоог бүрдүүлэх, бизнесийн орчныг сайжруулах чиглэлээр олон улсын санхүүгийн байгууллага, хувийн хэвшилтэй хамтран ажиллах;

3/ Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-ын 2023 оны харилцан үнэлгээнд бэлтгэх ажлын хүрээнд Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Монгол Улсын Үндэсний хөтөлбөр болон үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлж, ФАТФ-ын зөвлөмжийн үнэлгээг дээшлүүлэх;

4/ Орон сууцны санхүүжилтийн урт хугацааны тогтвортой тогтолцоог бүрдүүлж, хэрэгжүүлж эхлэх бэлтгэл ажлын хүрээнд Монголбанк хөнгөлөлттэй хүүтэй ипотекийн зээлийн хөтөлбөрийг Засгийн газарт 2023 онд багтаан бүрэн шилжүүлэх, энэ хугацаанд хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх;

5/ Монгол Улсын Их Хурлын 2020 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Зээлийн хүүг бууруулах стратеги”-ийн хэрэгжилтийг хангах хүрээнд гэрээний маргаан шийдвэрлэх үйл явцыг хялбаршуулах, зээлийн эрсдэлийн зардлыг бууруулах чиглэлээр эрх зүйн орчныг боловсронгуй болгох ажлыг эрчимжүүлэх;

6/ Уур амьсгалын өөрчлөлтийн эдийн засаг, санхүүгийн салбарт үзүүлэх нөлөөг судалж, бүсийн болон олон улсын байгууллагуудаас гаргасан зөвлөмж, санаачилгатай уялдсан тогтвортой санхүүжилтийн бодлого, стратеги боловсруулж хэрэгжүүлэх;

7/ Засгийн газрын 2021 оны 42 дугаар тогтоолоор батлагдсан “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10.0 (арван) их наядын цогц төлөвлөгөө”-нд тусгагдсан ажлын байрыг дэмжих зээл, хөдөө аж ахуйг дэмжих зээл, малчдыг дэмжих зээл, ипотекийн зээл, репо санхүүжилтийн зээл болон бусад төсөл, арга хэмжээний хэрэгжилт, хяналтыг үргэлжлүүлэх;

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо /Ж.Ганбаатар/-нд үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г. ЗАНДАНШАТАР

ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2022 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙГ БАТЛАХ УИХ-ЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН 2 ДУГААР ЗААЛТЫН ТАНИЛЦУУЛГА

2. Дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/, Монголбанк /Б.Лхагвасүрэн/, Санхүүгийн зохицуулах хороо /Д.Баярсайхан/-нд тус тус даалгасугай.

1/ Цар тахлаас үүдэлтэй хүндрэлийг даван туулж, эдийн засгийн сэргэлтийг дэмжих, өсөлтийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн төсөв, мөнгө, санхүүгийн бодлогыг хэрэгжүүлэх

УИХ-ын 2020 оны 5 дугаар сарын 13-ны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-ын 2020 оны 8 дугаар сарын 28-ны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д хүртээмжтэй өсөлттэй холбоотой зорилтууд багтсан боловч үр дүнг үнэлэх тодорхой шалгуур үзүүлэлт тусгагдаагүй байна.

Үндэслэл

Сүүлийн жилүүдэд улс орнуудын хооронд болон улс орон доторх тэгш бус байдал гүнзгийрч байгаа нь эдийн засгийн өсөлтийн хүртээмжтэй байдлын асуудлыг эрдэмтэн судлаач болон бодлого боловсруулагчдын анхаарлын төвд оруулаад байна. Ялангуяа цар тахлын үеийн эдийн засгийн хүндрэлд нийгмийн эмзэг бүлгүүд илүү өртөж, эдийн засгийн өсөлтийн хүртээмжтэй байдлын ач холбогдлыг улам тодотголоо. Манай улсын хувьд хамгийн бага орлоготой хүн амын хорин хувь¹, жижиг, дунд аж ахуйн нэгжүүд нь хямралд илүү өртөж байна². Хүртээмжтэй өсөлт нь эдийн засгийн өсөлт, түүний тогтвортой бөгөөд хүртээмжтэй байдлыг ойлгоно. Өсөлтийн хүртээмжтэй байдал гэдэг нь ирээдүй үеийнхнийгээ харгалзан хамгаалахын зэрэгцээ нийгмийн бүхий л бүлэг, газар нутгийн байршлаас үл харгалзан хүн бүрийн амьдралын чанар дээшилж байхыг хэлнэ. Түүнчлэн цаг уурын өөрчлөлт, үүнээс үүдэлтэй байгалийн гамшигт үзэгдэл нь ирээдүйд эдийн засаг, санхүүгийн системд цар тахлын үеийнхээс илүү хүнд нөхцөл байдлыг үүсгэх эрсдэлтэй юм. Иймээс хүртээмжтэй, тогтвортой өсөлтийг хангах, нийгмийн сайн сайхан байдлыг нэмэгдүүлэхэд бодлогын зорилтыг чиглүүлэх шаардлагатай байна.

Азийн хөгжлийн банкнаас “Хүртээмжтэй өсөлт”-ийг хэмжихдээ нийгмийн бүх бүлэг эдийн засагт тэгш оролцох боломжтой байгаа эсэх; мөн орлогын бус үзүүлэлтүүд болох эрүүл мэнд, боловсрол, хүнс тэжээл, нийгмийн оролцоо зэрэг зүйлд оролцох боломжтой байгаа эсэхээс хамаарна гэжээ. Ийнхүү 2011 онд АХБ-наас ядуурал, тэгш бус байдал, бодлого (эрүүл мэнд, боловсрол гэх мэт), засаглал, институцийн хувьд Хүртээмжтэй өсөлтийг хэмжих 35 үзүүлэлтүүдийг танилцуулсан байдаг³. Монгол Улсын хувьд хүртээмжтэй байдал сул байгаа ба цар тахлын нөхцөл байдлаас үүдэн цаашид муудах хүлээлттэй байна. Зарим гол үзүүлэлтүүдийг авч үзвэл дараах байдалтай байна.

- **Тэгш бус байдал харьцангуй бага.** Монгол Улсын хувьд тэгш бус байдлын үндсэн үзүүлэлт болох “жини коэффициент” 2021 оны байдлаар 0.327 байгаа нь дэлхийн улс орнуудтай харьцуулахад орлогын тэгш бус байдал харьцангуй бага байгааг илтгэж байна.
- **Эдийн засгийн шокоос шалтгаалж ядуурал нэмэгдэх өндөр эрсдэлтэй.** Ядуурлын

¹ Судалгааны үр дүнгээр хамгийн бага орлоготой хорин хувийн хүн амын хэрэглээ 2020 онд 15 хувь хүртэлх хувиар буурч байсан бол бусад хүн амын бүлгийн хэрэглээ 10 хүртэлх хувиар буурчээ (НҮБ, 2021).

² Судалгаагаар мөнгөн хөрөнгийн дутагдалд ЖДҮ-үүдийн 44 хувь, том аж ахуйн нэгжийн 15 хувь нь өртсөн бол хөрөнгө оруулалт ба санхүүжилтийн асуудал ЖДҮ-ийн 57 хувь, том аж ахуйн нэгжүүдийн 15 хувьд тулгарсан байна. Түүнчлэн ажилчдаа цомхотгох шийдвэрийг ЖДҮ-үүдийн 19 хувь, томоохон аж ахуйн нэгжүүдийн 4 хувь нь гаргажээ байна

³ Эх сурвалж: “Framework of Inclusive Growth Indicators - Key Indicators for Asia and the Pacific 2011” (2012), *Asian Development Bank*.

түвшин 2010 онд 38.8 хувь буюу ойролцоогоор 10 хүн тутмын 4 нь ядуу байсан бол 2018 оны байдлаар ядуурлын түвшин 28.4 хувь буюу ойролцоогоор 4 хүн тутмын 1 нь ядуу болж ядуурлын түвшин буурсан байна. Гэсэн хэдий ч хүн амын 15 орчим хувь нь ядуурлын шугамын ойролцоо байгаа буюу ядууралд өртөх эрсдэлтэй байна⁴. Эдгээр иргэд нь эдийн засаг, эрүүл мэнд, уур амьсгал зэрэгт сөрөг өөрчлөлт ороход ядууралд өртөх хамгийн өндөр эрсдэлтэй юм. Иймд эдгээр иргэдийн эдийн засгийн оролцоог дэмжих, орлого хэрэглээг хамгаалах зэрэг нь цар тахлын энэ үед чухал ач холбогдолтой болж байна.

- **Эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж бүс хооронд муу байна:** Хүн амын эрүүл мэндийн салбарын нөөц хангалттай хэмжээнд байгаа ч газар зүйн байршлын хувьд эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж тэгш бус байна. Тухайлбал, 1000 км² талбайд оногдох эмч, сувилагчийн тоо хотод 1228, 1185 байхад аймгийн төвүүдэд 193, 260, харин хөдөөд 2.7, 4 байна.
- **Боловсролын чанарын ялгаа өндөр байна:** Хүйсийн ялгаварлал харьцангуй багатай хэдий ч бүс хооронд тэгш бус байдал өндөр байна. Тухайлбал, тэгш бус байдлын улмаас алдагдсан боломж Баруун бүс (13.2%), Хангайн бүс (10.2%), Зүүн бүс (11.2%), Төвийн бүс (9.2%) буюу улсын дундаж (8.4%)-аас өндөр байна⁵. Түүнчлэн төрийн болон хувийн хэвшлийн хооронд боловсролын чанарын ялгаа өндөр байна.
- **Санхүүгийн хүртээмж сайн боловч санхүүгийн гүнзгийрэлтийг сайжруулах шаардлагатай:** Манай орны хувьд санхүүгийн хүртээмж дунд орлоготой орнуудаас сайн, өндөр орлоготой орны түвшинд байна. Тухайлбал, 100'000 насанд хүрсэн хүн амд ногдох АТМ-н тоо 148.8, 100'000 насанд хүрсэн хүн амд ногдох банкны салбарын тоо 63.9, санхүүгийн байгууллагад данстай 15-аас дээш насны иргэдийн хувь 93% байна. Гэвч санхүүгийн секторт банкны систем давамгайлж, жижиг дунд үйлдвэрлэлд санхүүжилтийн хүртээмж сул⁶, урт хугацаатай санхүүжилтийн хэрэгцээг хангаж чадахгүй байна.
- **Тогтвортой хөгжлийн асуудал тулгамдсан хэвээр байна:** Монгол Улсын хувьд “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийг Монгол Улсын Их Хурлын 2020 онд 52 дугаар тогтоолоор баталсан билээ. Энэхүү ажлын хүрээнд Монгол Улсын Засгийн газар “Урт хугацааны хөгжлийн бодлогын эрхэм 9 зорилго”-ыг тодорхойлон ногоон хөгжил, эдийн засгийн хөгжил, нийгмийн хөгжлийн үр дүнд бий болгосон баялгийг хүндээ хүргэж Монгол хүний сайн сайхан байдлыг дээшлүүлэхэд чиглэн ажиллахаар тусгасан.

Хувийн сектор болон Засгийн газрын хамтын ажиллагаа хүртээмжтэй өсөлтийг бий болгоход чухал ач холбогдолтой (Зураг 1). Эдийн засагт хувийн сектор чухал байр суурь эзэлдэг боловч зах зээлийн эдийн засгийн үйл ажиллагаа нь нийгэм, эдийн засгийн тэгш бус байдлыг нэмэгдүүлдэг. Ийнхүү Засгийн газар зах зээлийн гажуудлаас эхлээд эдийн засгийн өсөлт, түүний хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэхэд олон чиг шугамаар нөлөөлнө. Үүнийг тоймлон авч үзвэл:

- Засгийн газар хууль дүрэм, зохицуулалтаар хангахаас гадна нийгмийн бодлогуудыг хэрэгжүүлэх улс төрийн үйл явцыг бий болгоно. Энэ нь засаглалын чанарт, цаашилбал хүртээмжтэй өсөлтөд нэн чухал юм.
- Эдийн засгийг тогтворжуулахад чиглэсэн макро бодлогуудын үр ашигтай байдал нь эдийн засгийн хэлбэлзлийг бууруулах, хямралд орохоос сэргийлэх зэргээр тэгш, хүртээмжтэй

⁴ Эх сурвалж: “Ядуурлын дүр төрх-2018, Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны 2018 оны үндсэн үр дүн” (2019), *УСХ, Дэлхийн банк*.

⁵ Эх сурвалж: “Орлого, хэрэглээний тэгш бус байдал” (2020), *УСХ*.

⁶ Азийн Хөгжлийн банкны “Хүртээмжтэй бөгөөд тогтвортой өсөлтийн үнэлгээ” тайланд “ЖДҮ-үүд нийт бүртгэлтэй аж ахуйн нэгж байгууллагуудын 90 хувь, нийт ажлын байрны 50 хувийг бүрдүүлдэг хэдий ч 36800 ЖДҮ-ийн 90 гаруй хувь нь банк санхүүгийн байгууллагаас тогтмол санхүүжилт авах боломжгүй байсаар байна” гэжээ.


өсөлтөд нөлөөлнө. Шударга өрсөлдөөн, шинэ бизнес болон инновацийг дэмжих зэргээр улс орны эдийн засгийн олон тулгуурт бүтцийг дэмжих нь хүртээмжтэй зах зээлийн чухал хүчин зүйл болно. Олон тулгууртай байх нь эдийн засгийн эмзэг байдлыг бууруулж, улмаар эдийн засгийн өсөлтөд эерэгээр нөлөөлнө.

- Дэд бүтэц, боловсрол, эрүүл мэнд зэрэг Засгийн газраас үзүүлдэг нийгмийн үйлчилгээнүүдийн чанартай, хүртээмжтэй байдал нь хүн бүрт тэгш боломжийг бий болгож ядуурал, тэгш бус байдлыг бууруулах, цаашид даамжруулахгүй байх гол хүчин зүйл болно.
- Татвар, татаасын бодлогоор нийгмийн эмзэг бүлэгт чиглэсэн орлогын дахин хуваарилалтыг үр ашигтай явуулснаар нас, хүйс, бүс нутаг зэрэг нийгмийн бүлгүүдийн хоорондын тэгш бус байдлыг бууруулахад томоохон нөлөө үзүүлнэ.
- Өрийн тогтвортой байдал, байгалийн баялгийн бууралт, цаг уур, байгаль орчны өөрчлөлт зэргээс үүдэх сөрөг нөлөөллүүдийг ирээдүй хойч үедээ бий болгохгүй байхад анхаарч ажиллах нь өсөлтийн тогтвортой, хүртээмжтэй байдалд чухал юм.

Макро эдийн засгийн бодлого хэрэгжүүлдэг голлох институцийн нэг болох Төв банкны хувьд үнийн тогтвортой байдал, макро эдийн засгийн хэлбэлзэл, түүний тогтвортой байдал, санхүүгийн үйлчилгээний чанар, түүний хүртээмжтэй байдал зэрэгтэй холбогдох засаглалын чанараар дамжуулан хүртээмжтэй өсөлтөд голлон нөлөөлдөг. Үүнд:

- Инфляц нам түвшинд байх нь иргэдийн бодит орлогыг хамгаалах хүчин зүйл болохоос гадна хэлбэлзэл багатай үнийн түвшин бизнес төлөвлөгөө хийх зэргээр зах зээл дэх тодорхой бус байдлыг бууруулдаг. Түүнчлэн үнийн түвшнийг тодорхой түвшинд байлгах замаар мөнгөний бодлого хэрэгжүүлэх нь макро эдийн засгийн өрнөл, уналтын савлагааг тогтворжуулах суурь нөхцөл болно. Цар тахлын өмнөх 30 жилд инфляц, тэгш бус байдал хоёул буурсан байдаг. Нам түвшний инфляц нь ядуурал буурах, орлого нэмэгдэж байгаа дундаж давхаргын хүн ам нэмэгдэхтэй салшгүй холбоотой.
- Санхүүгийн хүртээмжийг сайжруулах нь капиталын хуримтлалыг нэмэгдүүлэх, бүтээмжийг өсгөх, эдийн засаг дахь нөөцийг үр ашигтай хуваарилах зэргээр хүртээмжтэй өсөлтийг бий болгоход томоохон хүчин зүйл болдог. Түүнчлэн нийгмийн зорилтод бүлгүүдэд санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх нь ядуурлыг бууруулах, тэгш бус байдалд эерэг нөлөөтэй юм.
- Хүн бүр мөнгөн хөрөнгө хадгалах, биет болон хүмүүн капитал, бизнест хөрөнгө оруулах боломжтой байх нь санхүүгийн секторын хүртээмжтэй байдлаас шалтгаална. Санхүүгийн тогтолцоо сайн бүрэлдэж тогтсон тохиолдолд хадгаламж татах, түүнийг үр ашигтай хөрөнгө оруулалтын төслүүдэд хуваарилж, эрсдэлийг тархах, бараа үйлчилгээ ба мэдээлэл солилцох нөхцөлийг хөнгөвчилдөг. Мөн хувь хүний хөгжил, аливаа бизнесийн байгууллага үйл ажиллагаагаа ахиулахад санхүүгийн боломжийг олгодог. Түүнчлэн даатгалын үйлчилгээ эдийн засгийн субъектуудад санхүүгийн эрсдэлээ удирдахад тус нэмэр болно.

Зураг 1. Хүртээмжтэй өсөлтийг бүрдүүлэх суурь механизм



Дээр дурдсан бодлогууд, түүний хэрэгжилт нь нас, хүйс, бүс нутаг, үе хоорондын тэгш байдалд нөлөөллөө үзүүлж эргээд хувийн секторт буюу үйлдвэрлэлийн хүчин зүйлсэд нөлөө үзүүлдэг буюу бодлогын чанар, үр дүн нь тухайн эдийн засгийн хөгжлийн тойрог руу орох уу эсвэл уруудлын тойрог руу орох уу гэдгийг шийдэх үндсэн хүчин зүйл юм. Монгол Улсын хувьд хүртээмжтэй өсөлт, бодлогын үр дүнтэй байдлыг хэмждэг хүний хөгжлийн индекс, өрсөлдөх чадварын индекс зэрэг үзүүлэлтүүдээрээ бусад орнуудтай харьцуулахад тааруу байгааг харгалзаж бодлого боловсруулж, хэрэгжүүлж буй байгууллагууд бодлого, үйл ажиллагаагаа хүртээмжтэй өсөлтийг бий болгоход чиглүүлж, хэрэгжилтийн үр дүн, чанарт анхаарлаа хандуулах нь нэн чухал байна.

Улс орнуудын хувьд эдийн засгийн бодлогоо цар тахлын сөрөг нөлөөг бууруулахад чиглүүлэхээс гадна эдийн засгийн сэргэлтийг хүртээмжтэй байлгах, зорилтод бүлэгт чиглэсэн нийгмийн бодлогод анхаарал хандуулах шаардлагатайг онцолж байна. Гэхдээ хөгжиж байгаа орнуудын хувьд төсвийн алдагдалыг санхүүжүүлэх болон өрийн тогтвортой байдлын асуудал хүндэрч байгаагаас шалтгаалан төсвийн бодлогыг илүү ухаалаг, зорилтот бүлэгт чиглүүлэх, шаардлагатай бүтцийн шинэчлэлт хийх нь чухал болж байна. Төв банкны хувьд цар тахлын эсрэг бодлогын хүүгээ бууруулсан нь бага орлоготой өрхүүдэд үзүүлсэн цар тахлын сөрөг нөлөөг бууруулж байна. Мөн уламжлалт бус бодлогоор эдийн засгийн үйл ажиллагааг дэмжиж байна. Гэвч улс орнууд цаашид инфляцын түвшин өсөх нь тэгш бус байдлыг нэмэгдүүлэх эрсдэлтэй болохыг анхаарах шаардлагатай. Санхүүгийн хүртээмжийг сайжруулах, цахимжуулалт, ногоон санхүүжилт зэргийг нэмэгдүүлэх нь илүү тогтвортой өсөлтийг бий болгох, тогтвортой хөгжлийн зорилтыг хангахад шаардагдах нөөцийг бий болгох ач холбогдолтой.

Стратеги

- Бодлого боловсруулагч бүр хүртээмжтэй эдийн засгийн өсөлтөд хувь нэмрээ оруулна.
- Судалгаа шинжилгээнд үндэслэсэн стратеги төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэн, үр дүнг хянаж дүгнэнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ

- Төсвийн бодлогыг өрийн тогтвортой байдлыг харгалзан мөчлөг сөрсөн байдлаар хэрэгжүүлэх, зарцуулалтын оновчтой байдал, үр ашгийг нэмэгдүүлэх
- Хүртээмжтэй өсөлтийг дэмжихэд шаардлагатай татварын тогтолцоог судлах, үр дүнг танилцуулах
- Халамжийн бодлогыг зорилтот бүлэг рүү чиглүүлэхэд шаардлагатай өгөгдлийн санг бүрдүүлэх, бодлого боловсруулахад ашиглах
- Төв банк макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн мөчлөг сөрсөн бодлогыг хэрэгжүүлэх
- Санхүүгийн секторын тогтвортой байдалтай нийцтэйгээр жижиг дунд үйлдвэрлэл, ногоон санхүүжилтийн хүртээмж, урт хугацаатай санхүүжилтийг нэмэгдүүлэх
- Тогтвортой өсөлтийн зорилтыг хангах бодлогын судалгааг хийж, хэрэгжүүлж эхлэх


2/ Уул уурхайн бус экспортыг дэмжих бодлогыг нэгтгэн тодорхойлж, санхүүгийн дэд бүтэц, санхүүжилтийн хүртээмжтэй тогтолцоог бүрдүүлэх, бизнесийн орчныг сайжруулах чиглэлээр олон улсын санхүүгийн байгууллага, хувийн хэвшилтэй хамтран ажиллах

Үндэслэл

Сүүлийн жилүүдэд манай орны уул уурхайн экспортын хэмжээ нэмэгдэж бараа, үйлчилгээний нийт экспортын 80 орчим хувийг дангаар бүрдүүлж байгаа бол уул уурхайн бус барааны экспортын жин мэдэгдэхүйц буурч 10 орчим хувьтай байна (Зураг 2). Үүнээс үзэхэд эдийн засаг уул уурхайн экспорт, эрдэс бүтээгдэхүүний дэлхийн зах зээл дээрх үнээс хэт хамааралтай болж байна. Түүнчлэн байгалийн баялаг хязгаартайн дээр эрдэс бүтээгдэхүүний олборлолт байгальд ээлгүй байдаг нь урт хугацааны тогтвортой хөгжилд сөрөг нөлөөтэй юм. Иймд, уул уурхайгаас бусад салбаруудын үйлдвэрлэлийг дэмжих, экспортыг төрөлжүүлэх шаардлага урган гарч байна.


Монголчуудын уламжлалт соёл, онцлогоос хамаарч уул уурхайн бус экспортод ямааны ноолуур, мах, махан бүтээгдэхүүн зэрэг малын гаралтай бүтээгдэхүүний экспорт өндөр жин эзэлж байна. Мөн хушны самар экспортлож эхэлсэн ч зарим жилүүдэд экспорт тасарч, тогтвортой бус байна. Дээр дурдсанаас бусад экспортын бүтээгдэхүүнүүд бага дүнтэй олон нэр төрөл бөгөөд нийлбэр дүнгээрээ төдийлөн нэмэгдээгүй байна (Зураг 3). Үүний дээр уул уурхайн бус экспортод нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүний экспорт маш бага байгааг онцлон тэмдэглэх нь зүйтэй юм.

Зураг 2. Монгол Улсын нийт экспортын бүтэц, 5 жилийн интервалаар



Эх сурвалж: Монголбанк, ГЕГ

Зураг 3. Монгол Улсын уул уурхайн бус салбарын экспортын бүтэц



Эх сурвалж: Монголбанк, ГЕГ

Уул уурхайн бус экспортын хэмжээ бага, тогтвортой бус, экспортын голлох нэр төрлийн тоо нэмэгдэхгүй байгаа зэргээс харахад уул уурхайн бус салбарын үйлдвэрлэл, экспортыг бодлогоор дэмжих, тулгамдаж буй бэрхшээлүүдийг таньж мэдэх, тохирсон бодлогын зохицуулалт, арга хэмжээ авах шаардлага бий болжээ. Түүнчлэн, 2011 оноос хойш гаднаас орж ирсэн нийт шууд хөрөнгө оруулалтын 73 хувь⁷ нь зөвхөн уул уурхайн салбарт хийгдсэн нь уул уурхайн бус салбарт хөрөнгө оруулалт бага байгааг илэрхийлэх нэг үзүүлэлт юм.

Уул уурхайн бус экспортыг дэмжих чиглэлээр “Уул уурхайн бус бүтээгдэхүүний экспортын тоо мэдээний тойм”-ийг Гаалийн ерөнхий газраас дэлгэрэнгүй тоо мэдээлэл авч боловсруулсан. Тус дүн шинжилгээний үр дүнд уул уурхайн бус экспортыг дэмжих чиглэлээр урьд өмнө хийгдэж байсан олон төсөл хөтөлбөрүүд хангалттай үр дүнд хүрээгүй шалтгааныг тодруулж, цаашид энэ чиглэлээр баримтлах стратегийг тодорхойлов. Үүнд төр ба хувийн хэвшлийн хооронд албажуулсан тогтолцоо бий болгох, дэд бүтцийг дэмжих (экспортын санхүүжилт, даатгал, батлан даалтын тогтолцоо), экспортын бүтээгдэхүүний бүлэг дээр суурилсан маркетингийн цогц бодлого явуулах, төр – хувийн хэвшлийн түншлэлийн механизмыг тодорхойлж хэрэгжүүлэх зэрэг саналууд багтсан.

Экспортыг дэмжих чиглэлээр хэрэгжиж ирсэн төсөл, хөтөлбөрүүдийн үр дүнг хангалтгүй гэж үзсэн ба тэдгээрийн хэрэгжилт, үр өгөөжийг нэмэгдүүлэх шаардлагатай байна. Тухайлбал, Засгийн газрын 2018 оны 278-р тогтоолоор батлагдсан “Монгол Экспорт хөтөлбөр”-ийн хэрэгжилтэд хийсэн үнэлгээг Хүснэгт 1-т харуулав.

Хүснэгт 1. “Монгол Экспорт хөтөлбөр”-ийн үнэлгээ (хураангуй)

<p>Институцийн хувьд:</p>	<ol style="list-style-type: none"> 1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, хугацаа, хариуцах институци зэрэг нь тодорхой бус байна. Мөн хөтөлбөрийн үр нөлөө, шалгуур үзүүлэлтүүд, суурь болон зорилтот түвшин тодорхой бус, үр дүн, биелэлтийг ил тод тайлагнах, хөндлөнгийн мониторингийн тогтолцоог тодорхой заагаагүй бөгөөд зөвхөн төрийн яам, агентлагуудад хуваарилсан бүтэцтэй байна. 2. Хүнс, хөнгөн үйлдвэр, уул уурхай, аялал жуучлалын салбарын дунд хугацааны бодлого, хөтөлбөрүүдийг үндэсний хэмжээнд уялдуулан зохицуулах, хувийн хэвшил дээр тулгуурласан, түүнтэй тус хөтөлбөрүүдийг хамтран хэрэгжүүлэх нэгдсэн удирдлага, институцийн механизм бодитой үүсэж хэрэгжээгүй байна. 3. Олон улсын туршлагаас үзэхэд тухайн улс экспортыг дэмжих, хөгжүүлэх хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэхийн тулд энэ чиглэлээр мэргэшсэн, арга зүйн төдийгүй экспортын зорилтот захын мэдлэг, мэдээллийг бизнес эрхлэгчдэд өгөх чадавхитай, экспортлогчтой нягт холбоотой ажиллаж тэдний санал бодол, итгэлийн индексийг тогтмол гаргаж мониторинг хийдэг, экспортын санхүүжилтийн дэмжих механизмыг санхүүгийн байгууллагуудтай хамтран бий болгодог төрийн, хувийн эсвэл төр – хувийн хэвшлийн хамтарсан институцүүд байдаг. Экспортыг харьяалах, дэмжих агентлаг байхгүй, гол төлөв гадаад харилцааны улс төр, дипломатын үйл ажиллагааг хариуцаж ирсэн, бизнесээс хөндий, экспортын зах зээл, маркетингийн шаардлагатай чадавхи нь бүрэлдээгүй төрийн яаманд энэ ажлыг хариуцуулах нь хөтөлбөрийг амжилттай, тууштай хэрэгжүүлэхэд хүндрэл учруулж байна.
----------------------------------	---

⁷ ГШХО-н позицйин статистик, ГШХО-н судалгаа, Монголбанк

<p>Өрсөлдөх чадварын хувьд:</p>	<ol style="list-style-type: none"> 1. Мал аж ахуйн салбарын бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг олон улсын хэмжээнд хүртэл нэмэгдүүлэх шаардлагатай. 2. Экспортын бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх, хөгжүүлэх арга зам, санхүүжилтийг тодорхой болгох шаардлагатай. 3. Тээвэр ложистикийн салбарт шударга өрсөлдөөний ижил тэгш орчин бий болгох, өртөг зардлыг бууруулах, дэд бүтцийг хөгжүүлэх, үйлчилгээг цахим болгох гэх мэт төрийн үйлчилгээ, бодлогыг сайжруулах шаардлагатай. Энэ чиглэлээр дорвитой өөрчлөлт гарахгүй байгааг экспортын бүтээгдэхүүний замын зураг, цахим нэг цонхны хэрэгжилтийн байдал, Дэлхийн Банк болон Азийн Хөгжлийн Банкны холбогдох судалгаа, индексүүд харуулж байна.
<p>Стратеги, үзэл баримтлалын хувьд:</p>	<ol style="list-style-type: none"> 1. “Нээлтэй, эрдэсийн экспортоос өндөр хамааралтай жижиг эдийн засгийн” хувьд “импортын уян хатан бодлого” болон “үндэсний үйлдвэрлэл, дотоодын зах зээлийг хамгаалах” бодлогын тэнцвэрийг олох, Монгол Улсын нөхцөл байдалд тохирсон бодлого, үзэл баримтлалыг бий болгох. Энэ чиглэлээр сүүлийн жилүүдэд авсан хэд хэдэн бодлогын арга хэмжээ нь бодит үр дүн өгөхөөсөө илүү Дэлхийн Худалдааны Байгууллагын өмнө хүлээсэн үүрэгтэй зөрчилдөх, дотоодын үйлдвэрлэгчдийн дунд инкубаторын хиймэл орчин үүсгэх, экспортын өрсөлдөх чадварыг бууруулах, мөн “moral hazard” буюу ёс зүйн гажуудал үүсгэх зэрэг эрсдлүүдийг дагуулж байна. 2. Эдийн засгийн чөлөөт бүс, аж үйлдвэрийн паркуудын үйл ажиллагаа жигдрээгүй байгаа нь чөлөөт бүсийн хөгжлийн талаарх үзэл баримтлал нь оновчтой бус бөгөөд үйлдвэрлэл, бизнесийн төвлөрлийг харгалзаагүй, нийт эдийн засгийн болон бизнесийн тааруу орчинд бизнесийн санаа, сэжим түлхэц “тусгайлан бэлдсэн газарт” очиж бизнес, хөрөнгө оруулалт хийхэд хангалттай бус байдагтай холбоотой. Эдгээр тусгай бүс, паркийг БНХАУ, ОХУ-ын сонирхолтой уялдуулж, холбосон нөхцөлд хөгжүүлэх боломжтой. Мөн энэ чиглэлээр эдийн засаг, улс төрийн дипломат үйл ажиллагаа, бизнес, хөрөнгө оруулалтын орчинг бүхэлд нь шинэчлэх төрийн бодлого хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Экспортыг дэмжих чиглэлээр хэрэгжиж ирсэн хөтөлбөрүүдийн нийтлэг дутагдал, сул талууд нь:

1. Экспортлогчийн бүлэглэлт, бүтээгдэхүүн, бүтээгдэхүүний бүлгийн дүн шинжилгээнд суурилагагүй, зорилтот шинж чанар агуулаагүй;
2. Экспортын санхүүжилтийн дотоод, гадаад тогтолцоо бүрдээгүй. Бүх хөтөлбөр дээр улсын төсөв, гадаад, дотоодын байгууллага, иргэдийн хандив, тусламж, олон улсын байгууллагын тусламж, төсөл хөтөлбөрийн санхүүжилт зэрэг эх үүсвэрийг хуваарилдаг хэдий ч биелэлт, гүйцэтгэл хангалтгүй;
3. Экспортлогчдод, хувийн хэвшлийн сэдэл санаа, сэжим түлхэцийг бий болгосон эрх зүйн орчин бүрэлдээгүй, тэдний шууд оролцоог хангасан, тэд санаачилж хөтөлж явах бодлогын механизм, орчин сул, хэрэгжилт, биелэлтэнд тавих хөндлөнгийн хяналт мониторингийн тогтолцоо үүсээгүй;
4. Экспортын замын зураг өрсөлдөх чадвар муу, хүнд суртал ихтэй, цаг хугацаа их, зардал өндөр, экспортлогчдод мэргэжлийн туслалцаа, арга зүйн зөвөлгөө өгөх, сургалт явуулах, экспортыг дэмжих, хөгжүүлэх асуудлыг шууд гардан хариуцах экспортыг дэмжих агентлаг байгуулах эсвэл энэ асуудлыг МҮХАҮТ, Уул уурхайн бус экспортлогчдын холбоо гэх мэт байгууллагад гэрээний үндсэн дээр хариуцуулаагүй;
5. “Экспортлогч үндэстэн” болох нийгмийн уур амьсгалыг үндэсний хэмжээнд бүрдүүлэх брендинг хийх, олон улсын байгууллагуудтай энэ чиглэлээр ажиллаж, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, санхүүжилт татах хүчин чармайлт сул гэх мэт дутагдал сул тал ажиглагдаж байна.

Иймээс үйл ажиллагааны төлөвлөгөө нь агуулгын хувьд эдгээр асуудлыг шийдэхэд чиглэсэн байвал зохино.

Стратеги

- Уул уурхайн бус экспортыг нэмэгдүүлэх чиглэлээр төр, хувийн хэвшлийн үүрэг, хариуцлагын албажуулсан тогтолцоон дээр суурилсан байна.
- Экспортын санхүүжилт, даатгал, батлан даалтын тогтолцоог Засгийн газар, Монголбанк хамтран хамаарах чиг үүргийн хүрээнд бий болгоно.
- Тодорхой бүтээгдэхүүн, бүтээгдэхүүний бүлэг дээр суурилан тэдгээрийн экспортын маркетингийн чадавхи, зорилтот зах зээлд нэвтрэн орох боломж, экспортын хэмжээ зэргээр нь ангилсан байна.
- Экспортлогч компаниудын туршлага, мэдлэг, чадвар, зах зээлд нэвтрэх стратегийн хандлага, хоёр хөршийн зорилтот зах зээлийн сегментийн тодохойлолт зэргийг төр - хувийн хэвшлийн түншлэлийн механизмын хүрээнд тодорхойлж хэрэгжүүлэх агуулгатай байна.

Хэрэгжүүлэх арга хэмжээ

1. Засгийн газрын зүгээс 2022-2023 оны төсөвт “Уул уурхайн бус экспортыг дэмжих, урамшуулах, хөгжүүлэх санг” тусад нь байгуулах, Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн гол бүрдэл хэсэг болгох
2. Төр – хувийн хэвшлийн хамтарсан механизмийг нэвтрүүлэх:
Хувийн хэвшлийг төлөөлж Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим, Уул уурхайн бус экспортлогчдын холбоо, мэргэжлийн холбоод, Зураасан код, газар зүйн заалтын чиглэлээр ажилладаг ТББ-ууд, төрийн талаас эдийн засгийн хөгжлийн асуудал хариуцсан яам (шинээр байгуулах), Монголбанк, Сангийн яам, Хөгжлийн банк, Гадаад хэргийн яам, Экспортыг дэмжих агентлаг (шинээр байгуулах шаардлаатай) болон салбарын яамдын оролцоог хангасан тогтолцоотой байх.
3. Экспортын батлан даалт, даатгалын өнөөгийн үйлчилж буй тогтолцоог боловсронгуй болгох
4. “Монголын Экспорт хөтөлбөр”-т тусгагдсан бодлогын чиглэлүүдийг эрэмбэлэн хэрэгжүүлэх
5. Экспортын замын зургийг хялбаршуулан өрсөлдөх чадвартай болгох, экспортын зардал, цаг хугацааг эрс бууруулж тэргүүлэгч орнуудын эгнээнд орох, гадаад худалдаанд шаардагдаж буй бичиг баримтын тоог бууруулах, гадаад худалдааны цахим нэг цонхны үйлчилгээг бодитой нэвтрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх, гүйцэтгэлийн хөндлөнгийн хяналт шалгалтыг жил бүр хийх;
6. Уул уурхайн бус бүтээгдэхүүн экспортлогч аж ахуйн нэгжүүдийг экспортлосон бүтээгдэхүүний үнийн дүнгээр бүлэглэсэн бүтцийг уул уурхайн бус экспортыг хөгжүүлэх дунд хугацааны төлөвлөгөөнд харгалзан ашиглах
 - 6.1. Экспортын бүтээгдэхүүнийг экспортын үнийн дүнгээр 4 бүлэгт ангилж, бүлэг тус бүрийг дотор нь уул уурхайн бус, уламжлалт экспортын бүтээгдэхүүний бүлэг, уул уурхайн бус, уламжлалт бус экспортын бүтээгдэхүүний бүлэг гэж бодлогын арга зүйн хувьд ангилан экспортыг дэмжин урамшуулах, экспортыг хөгжүүлэх гэсэн бодлогын хоёр хандлагыг хослуулан хэрэгжүүлэх
 - 6.2. Гаалийн ерөнхий газраас гаргасан экспортын тоон мэдээлэл дээр үндэслэн “Топ-30 Экспортлогч”-ийн жагсаалтыг гарган жил бүр шинэчилж байх, эдгээр аж ахуйн нэгжийн гаргаж буй бүтээгдэхүүний экспортын хэмжээ, нэр төрлийг нэмэгдүүлэх бүтээгдэхүүн, бүтээгдэхүүний бүлэг дээр суурилсан зорилтот төлөвлөгөө хэрэгжүүлэх. Үүнд:
 - “Уул уурхайн бус экспортлогчдын Үндэсний анхдугаар чуулган”-ыг Засгийн газар зохион байгуулж тэдгээрийн санал бодлыг сонсох;
 - 1 мянган ам. доллар хүртэлх экспорт хийдэг аж ахуйн нэгжид инкубаторын орчин бий болгон экспортлох чадварыг нь нэмэгдүүлэх, экспортын тохирох санхүүжилтэд хамруулах;
 - 6-10 мянган ам. долларын экспорт хийдэг аж ахуйн нэгжийг “гарааны экспортлогч”-ийн ангилалд оруулж экспортын санхүүжилт, батлан даалт, даатгалын тогтолцоонд хамруулах;
 - 10-100 мянган ам. долларын экспорт хийдэг аж ахуйн нэгжийг бүтээгдэхүүний нэр төрлөөр нь ангилан “гарааны экспортлогч”, “зүгширч буй экспортлогч” ангилалд хамруулан дээрхтэй ижил тогтолцоонд хамруулах;
 - 100 мянга-1 сая хүртэлх ам. долларын бүтээгдэхүүн экспортлогч аж ахуйн нэгжийг экспортын туршлага, зээлийн түүх, төлбөрийн чадвар зэргээс нь хамааруулан экспортын санхүүжилт, батлан даалт, даатгалын тогтолцоонд хамруулах;
 - 6.3. Дээрх бүлгүүдэд орсон экспортын бүтээгдэхүүнүүд жил бүр тогтмол экспортлогдож байсан ч экспорт нь тасалдсан эсхүл цөөн удаа экспортлогдоод зогссон бүтээгдэхүүний диагностик шинжилгээг нарийвчлан, бүтээгдэхүүн бүрээр хийж, шалтгааныг (санхүүжилтийн, зах зээлийн боломжийн эсвэл экспортын зах зээлд нэвтрэх маркетингийн төлөвлөгөө оновчтой биш эсвэл байгаагүй зэрэг) илрүүлэн шийдвэрлэх. Тухайлбал, экспорт тасарсан шалтгааныг бүтээгдэхүүн бүрээр нь диагностик шинжилгээ хийх, экспортлогчдоос нь ярилцлага авах зэргээр шалтгаан, хүчин зүйлийг тодруулж цаашид тогтвортой экспорт болох сувгуудыг тодорхойлох.

3/ Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-ын 2023 оны харилцан үнэлгээнд бэлтгэх ажлын хүрээнд Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Монгол Улсын Үндэсний хөтөлбөр болон үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлж, ФАТФ-ын зөвлөмжийн үнэлгээг дээшлүүлэх

Үндэслэл

Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-ын 2023 оны харилцан үнэлгээнд бэлтгэх ажлын хүрээнд:

ФАТФ-аас Монгол Улсын 2 дахь удаагийн Харилцан үнэлгээг 2017 онд хийж, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог дутагдалтай гэж дүгнэсэн. Монгол Улс холбогдох арга хэмжээг авч ажилласан боловч 2019 оны 10 дугаар сарын 18-ны өдөр ФАТФ-аас манай орныг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай улс орнуудын жагсаалт буюу “Саарал” жагсаалтад оруулсан. Үүнтэй холбогдуулан саарал жагсаалтаас гарах үйл явцын хүрээнд Монгол Улс ФАТФ-тай хамтран 4 Шууд хэрэгжилтийн хүрээнд авч хэрэгжүүлэх нийт 6 ажил бүхий үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх үүрэг даалгавар авсан.

Үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх үүрэг даалгаврыг биелүүлэхээр Монгол Улсын Ерөнхий Сайдын 172 дугаар захирамжаар 2019 оны 12 дугаар сард Сангийн Сайдаар ахлуулсан ажлын хэсэг байгуулагдсан. Түүнчлэн Засгийн газрын 2019 оны 463 дугаар тогтоолоор ФАТФ-ын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай улс орнуудын жагсаалтаас Монгол Улсыг гаргах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталж, Үндэсний зөвлөл, Хамтын ажиллагааны зөвлөлийн гишүүн байгууллагууд, хувийн хэвшил болон мэргэжлийн холбоодын хамтарсан ажлын хэсгүүд уг төлөвлөгөөний дагуу эрчимтэй ажилласан. Үүний дүнд 2020 оны 10 дугаар сарын 23-ны өдөр Монгол Улсыг ФАТФ-ын стратегийн дутагдалтай улс орнуудын жагсаалтаас гаргасан талаар ФАТФ-ын ээлжит хурлаар албан ёсоор мэдэгдсэн. Монгол Улс бусад улс орнуудтай харьцуулахад хамгийн богино хугацаанд буюу 1 жилийн дотор Саарал жагсаалтаас гарч чадсан улс болсон нь улс төрийн өндөр түвшний дэмжлэг, төр хувийн хэвшлийн хамтын ажиллагаа сайн байсны үр дүн юм.

Монгол Улсыг 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдөр Европын Холбооны мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай, өндөр эрсдэлтэй гуравдагч улс орнуудын жагсаалтад (хар жагсаалт гэж нэрлэгддэг) оруулсан. Иймд ФАТФ-аас Монгол Улсыг саарал жагсаалтаас гаргасан болон төрийн байгууллагуудын Европын комисстой хамтран ажилласны үр дүнд 2021 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр 2015/849 тоот тогтоолыг гаргаж, Монгол Улсыг Европын Холбооны мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай, өндөр эрсдэлтэй гуравдагч улс орнуудын жагсаалтаас хассан. Монгол Улс цаашид хар, саарал жагсаалтад орохгүйн тулд ФАТФ-аас гаргасан олон улсын стандарт, зөвлөмжүүдийг дагаж мөрдөх, хууль эрх зүйн орчноо тогтмол шинэчлэх, хэрэгжилтийг хангах шаардлагатай юм.

ФАТФ-аас 2023 онд харилцан үнэлгээний хүрээнд Монгол Улсад 5 дахь жилийн явцын үнэлгээг хийхээр төлөвлөж байна. Энэ хүрээнд Монгол Улсын хувьд ФАТФ-ын техник хэрэгжилтийн 40 зөвлөмж болон үр дүнтэй байдлын шууд хэрэгжилтийн 11 үзүүлэлтийн хэрэгжилтийг дахин үнэлэх юм. Иймээс ФАТФ-аас хийгдэх энэхүү харилцан үнэлгээнд онцгой анхаарал хандуулж, бэлтгэл ажлыг хангаснаар мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог бэхжүүлэх, улмаар Монгол Улс дахин стратегийн дутагдалтай орнуудын жагсаалтад орохгүй байх нөхцөл бүрдэнэ. Иймд 2022 онд төрийн өндөр дээд түвшинд ач холбогдол өгч мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх чиглэлээр олон улсын болон дотоодын төр, хувийн хэвшлийн холбогдох байгууллагууд идэвхтэй хамтран ажиллаж, ФАТФ-ын харилцан үнэлгээний бэлтгэл ажлыг хангах шаардлагатай юм.

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Монгол Улсын Үндэсний хөтөлбөр болон үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх:

Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-аас гаргасан техник хэрэгжилтийн зөвлөмж 1-ийн дагуу улс орнууд өөрсдийн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх Үндэсний эрсдэлийн үнэлгээг хийж гүйцэтгэх, түүний үр дүнд тулгуурлан эрсдэлд суурилсан аргачлалыг хэрэгжүүлж, тухайн эрсдэл үүсэхээс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ авахыг зөвлөсөн байдаг. Үүнтэй холбоотойгоор 2016 онд Монгол Улсын анхны Үндэсний эрсдэлийн үнэлгээний тайланг боловсруулж гаргасан бөгөөд Засгийн газрын 2017 оны 143 дугаар тогтоолоор “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг баталсан. Уг хөтөлбөрийг 2017-2019 онд хэрэгжүүлж, улмаар 2020 онд хэрэгжилтийг үнэлсэн.

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх Үндэсний эрсдэлийн үнэлгээг тогтмол шинэчлэх шаардлагатай байдаг учраас Санхүүгийн мэдээллийн албанаас санаачлан Сангийн сайдын 2020 оны 20 дугаар тушаалаар Үндэсний эрсдэлийн үнэлгээг хийх ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсэгт төрийн байгууллагууд, хувийн хэвшлийн төлөөлөл болон мэргэжлийн холбоод оролцож, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээг хийж ажиллав. Улмаар Сангийн сайдын 2020 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн 90 дүгээр тушаалаар батлагдсан нийт 11 дэд ажлын хэсэгт 52 байгууллагын 128 төлөөлөгчдөөс бүрдсэн том баг салбар тус бүрийн эрсдэлийн үнэлгээг Дэлхийн банкны аргачлалын дагуу дараах салбаруудын хүрээнд хийж гүйцэтгэв. Үүнд:

- | | |
|------------|---|
| Модуль 1. | Мөнгө угаах аюул заналхийллийг үнэлэх дэд ажлын хэсэг |
| Модуль 2. | Үндэсний эмзэг байдлыг үнэлэх дэд ажлын хэсэг |
| Модуль 3. | Банкны салбарын эмзэг байдлыг үнэлэх дэд ажлын хэсэг |
| Модуль 4. | Үнэт цаасны салбарын эмзэг байдлыг үнэлэх дэд ажлын хэсэг |
| Модуль 5. | Даатгалын салбарын эмзэг байдлыг үнэлэх дэд ажлын хэсэг |
| Модуль 6. | Банк бус санхүүгийн байгууллагын салбарын эмзэг байдлыг үнэлэх дэд ажлын хэсэг |
| Модуль 7. | Санхүүгийн бус бизнес мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдийн салбарын эмзэг байдлыг үнэлэх дэд ажлын хэсэг |
| Модуль 8. | Терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг үнэлэх дэд ажлын хэсэг |
| Модуль 9. | Санхүүгийн хүртээмжтэй бүтээгдэхүүний эрсдэлийг үнэлэх дэд ажлын хэсэг |
| Модуль 10. | Ашгийн бус байгууллагын эмзэг байдлыг үнэлэх дэд ажлын хэсэг |

Үндэсний эрсдэлийн үнэлгээг хийснээр мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх нөөц бололцоог зохистой хуваарилах, болзошгүй эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх боломж нөхцөл бүрдэх юм. Мөн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны бодит үр дүнг дээшлүүлэх, Шууд хэрэгжилтийн үр дүнг сайжруулах, тогтолцоог чанаржуулах ач холбогдолтой. Иймд Дэлхийн банкны аргачлалын дагуу хийж гүйцэтгэсэн Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх Үндэсний эрсдэлийн үнэлгээний тайлангийн үр дүнд үндэслэн “Монгол Улсын Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Үндэсний хөтөлбөр, түүний хэрэгжилтийг хангах үйл ажиллагааны төлөвлөгөө”-г боловсруулах юм. Уг хөтөлбөрийг Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн дагуу Үндэсний зөвлөлөөр хэлэлцүүлэн Засгийн газар, Улсын Их Хуралд танилцуулж батлуулах шаардлагатай.

Шинээр батлагдах Үндэсний хөтөлбөр нь ФАТФ-аас хийх Харилцан үнэлгээний хүрээнд 5 дахь жилийн явцын үнэлгээний бэлтгэл ажлын суурь болно. Үндэсний хөтөлбөрийн зорилтуудыг

хангах үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх нь 2023 оны харилцан үнэлгээгээр Монгол Улс ФАТФ-ын техник хэрэгжилтийн 40 зөвлөмж болон үр дүнтэй байдлын шууд хэрэгжилтийн 11 үзүүлэлтийн хэрэгжилтийн үнэлгээг амжилттай ахиулах үндэс болно.

Түүнчлэн Үндэсний хөтөлбөрөөр дамжуулан Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа-2050”, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 2021-2030 оны хооронд хэрэгжүүлэх үйл ажиллагаа, Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Улсын Их Хурлын 2020 оны 24 дугаар тогтоолоор батлагдсан Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах ач холбогдолтой юм.

ФАТФ-ын зөвлөмжийн үнэлгээг дээшлүүлэх:

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр ФАТФ-аас гаргасан техник хэрэгжилтийн 40 зөвлөмж болон шууд хэрэгжилтийн 11 зөвлөмжийн шалгуурыг дэлхийн улс орнууд дагаж мөрдөх үүрэгтэй бөгөөд эдгээр зөвлөмжийн биелэлтийг тодорхой давтамжтайгаар үнэлдэг.

Монгол Улс 2020 оны эцсийн байдлаар ФАТФ-ын техник хэрэгжилтийн 40 зөвлөмжөөс 37 зөвлөмжийг “Дийлэнхийг биелүүлсэн” болон “Бүрэн биелүүлсэн” гэдэг үнэлгээг авсан бөгөөд 3 зөвлөмжийн хувьд хагас биелүүлсэн гэж үнэлүүлсэн байна. Дээрх үнэлгээтэй холбоотойгоор “Хэсэгчлэн биелүүлсэн” үнэлгээтэй 3 зөвлөмжийн үнэлгээг ахиулах, бусад зөвлөмжүүдийн үнэлгээг хэвээр хадгалах зорилгоор 2020 оны 5 дугаар сарын 25-ны өдөр Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Үндэсний зөвлөлийн дарга бөгөөд Хууль зүй, дотоод хэргийн сайд “ФАТФ-ын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх 40 Зөвлөмжийн техник хэрэгжилтийн дутагдлыг сайжруулах ажлын төлөвлөгөө”-г баталж, холбогдох байгууллагуудыг хэрэгжүүлж ажиллахыг үүрэг болгосон.

Монголбанкны дэргэдэх Санхүүгийн мэдээллийн албанаас холбогдох байгууллагуудтай хамтран ФАТФ-ын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх 40 Зөвлөмжийн техник хэрэгжилтийн үнэлгээг ахиулах Монгол Улсын 2021 оны явцын тайланг боловсруулж, Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэгт (APG) 2021 оны 02 дугаар сарын 01-ний өдөр хүргүүлсэн. Явцын тайланд ФАТФ-ын 40 зөвлөмжөөс “Хэсэгчлэн биелүүлсэн” үнэлгээтэй зөвлөмж 1, 8, 15-ын үнэлгээг ахиулах зорилгоор энэ чиглэлээр гаргасан ахиц дэвшлийн талаарх дэлгэрэнгүй тайланг бэлтгэж хүргүүлсэн.

Зөвлөмж 1-ийн дагуу улс орнууд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлээ тодорхойлох үүрэгтэй бөгөөд тус эрсдэлийг хэрхэн бууруулах, удирдах талаарх бодлого, стратегийг гаргасан байхыг шаарддаг байна. Иймд Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн дагуу Санхүүгийн мэдээллийн албанаас Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх Үндэсний эрсдэлийн үнэлгээг хийж гүйцэтгэх ажлыг зохион байгуулж, нийт 30 гаруй төр, хувийн хэвшлийн байгууллагын, 200 орчим төлөөллүүдтэй хамтран гүйцэтгэсэн. Мөн уг зөвлөмжийн хүрээнд Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны А-26 дугаар тушаалаар батлагдсан “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам”-д холбогдох нэмэлт өөрчлөлтүүдийг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2021 оны А-31 дугаар тушаалаар оруулсан. Ингэснээр мэдээлэх үүрэгтэй этгээдүүд эрсдэлд суурилсан аргачлалын хүрээнд бага эрсдэлтэй харилцагчийн хувьд хялбаршуулсан таньж мэдэх үйл ажиллагааг явуулах боломж бүрдэн, Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгээс Монгол Улсыг зохицуулалттай салбаруудын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг үнэлгээг тогтмол хийж гүйцэтгэн, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тогтолцоог сайжруулсан гэж дүгнээд Зөвлөмж 1-ийн техник хэрэгжилтийн үнэлгээг ахиулж, “Дийлэнхийг биелүүлсэн” үнэлгээтэй болгохоор тогтсон. 2021 оны 7 дугаар сард болсон Ази Номхон далайн мөнгө угаахтай

тэмцэх бүлгийн жилийн хурлаар үнэлгээг баталгаажуулахаар болсон.

Зөвлөмж 8-ын үнэлгээг ахиулах хүрээнд ашгийн бус байгууллагын салбарын эрсдэлийн үнэлгээг хийх, хяналт шалгалт, зохицуулалтын хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх, чадавхыг бэхжүүлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах, мөрдөн шалгах ажиллагаа, хамтын ажиллагааг сайжруулах чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажлуудыг тайланд тусгасан. Энэ хүрээнд ашгийн бус байгууллагын салбарын эрсдэлийн үнэлгээг Дэлхийн банкны аргачлалын дагуу хийж гүйцэтгэсэнээс гадна чадавхыг бэхжүүлэх сургалтуудыг зохион байгуулсан. Цаашид ашгийн бус байгууллагын салбарыг үйл ажиллагааны төрөл тус бүрээр нь зохицуулах Холбооны эрх зүйн байдлын тухай, Сангийн эрх зүйн байдлын тухай, Нийтэд тустай үйл ажиллагааны тухай хуулийн төслүүдийг батлуулах чиглэлээр холбогдох байгууллагууд хамтран ажиллах зайлшгүй шаардлагатай. Учир нь ФАТФ-ын техник хэрэгжилтийн зөвлөмж 8-ын үнэлгээг ахиулахад нэн тэргүүнд уг хуулийн төслүүдийг батлуулах, эрх зүйн орчинг бүрдүүлэх ёстой юм. Уг хуулиудыг батлуулснаар ашгийн бус байгууллагын салбарын хяналт шалгалт, зохицуулалтын тогтолцоо, хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх ач холбогдолтой юм.

Зөвлөмж 15 буюу шинэ технологитой холбоотой шаардлагуудын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд ФАТФ-аас дэлхийн улс орнуудад явуулсан судалгаагаар нийт 115 гаруй улс орнууд виртуал хөрөнгийн салбарын үйл ажиллагааг хүлээн зөвшөөрч, зохицуулалтын орчинг бий болгохоор ажиллаж байна. Энэ хүрээнд Монголбанкны Ерөнхийлөгчийн 2020 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн А-23 дугаартай тушаалаар виртуал хөрөнгийн салбарын хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгох, хуулийн төслийг боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан. Улмаар виртуал хөрөнгийн салбарын талаарх олон улсын туршлага, хууль, эрх зүйн орчинтой холбоотой судалгааг хийж гүйцэтгэсэн бөгөөд холбогдох байгууллагуудтай хамтран виртуал хөрөнгийн салбарын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээг хийхээр ажиллаж байна. Түүнчлэн Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо болон бусад эрх бүхий байгууллагуудтай хамтран Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн төслийг боловсруулсан. Тус хуулийн төслийг Засгийн газраас өргөн мэдүүлсэн бөгөөд 2021 оны 6 дугаар сарын 17-ны өдөр Улсын Их Хурлаар хэлэлцэхийг дэмжсэн. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн төсөлд виртуал хөрөнгө болон виртуал хөрөнгийн үйлчилгээг ФАТФ-ын шаардлагад нийцүүлэн тодорхойлж, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч, түүний үйл ажиллагаанд баримтлах зарчим, тавигдах шаардлага, бүртгэх, хяналт тавих, холбогдох эрх, үүргийг тусгаж, хамтын ажиллагаа, хариуцлагын тогтолцоог бүрдүүлэхийг зорьсон. Уг хуулийн төсөл батлагдсанаар виртуал хөрөнгийн хууль эрх зүйн орчинг бүрдүүлж, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдийг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлээс урьдчилан сэргийлэх, ФАТФ-ын техник хэрэгжилтийн зөвлөмжийн стандартыг хангах ач холбогдолтой юм. Ази Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгээс 2021 онд тайлагнасан Монгол Улсын явцын тайлантай танилцаад хууль эрх зүйн орчныг бүрдүүлээгүй гэж үзэж зөвлөмж 15-ын үнэлгээг ахиулаагүй болно. Иймд Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн төслийг 2021 оны Монгол Улсын Их Хурлын намрын чуулганаар хэлэлцэн баталснаар 2022 онд Монгол Улс шинэ технологи буюу техник хэрэгжилтийн зөвлөмж 15-ын үнэлгээг ахиулах боломжтой.

ФАТФ болон Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэгтэй хамтран ажиллаж техник хэрэгжилтийн зөвлөмж 8 болон зөвлөмж 15-ын үнэлгээг хууль эрх зүйн орчныг бүрдүүлсэнээр ахиулах ажлыг үргэлжлүүлэн тайлагнаж ажиллах болно.

Стратеги

- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний тогтолцоог сайжруулах дунд хугацааны бодлого, стратегийг хэрэгжүүлнэ.
- Богино хугацаанд Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны хууль, эрх зүйн орчинг бүрдүүлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ

- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Үндэсний хөтөлбөрийг ажлын төлөвлөгөөний хамт төр, хувийн хэвшилтэй хамтран хэрэгжилтийг хангах
- ФАТФ-ын техник хэрэгжилтийн зөвлөмж 8-ын үнэлгээг ахиулах хүрээнд ашгийн бус байгууллагуудын хууль, эрх зүйн орчинг бүрдүүлэх
- ФАТФ-ын техник хэрэгжилтийн зөвлөмж 15-ын үнэлгээг ахиулах хүрээнд виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн хуулийн төслийг батлуулах
- Ази Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэгт хүргүүлэх Монгол Улсын тайланг холбогдох төрийн байгууллагуудтай хамтран бэлтгэх

4/ Орон сууцны санхүүжилтийн урт хугацааны тогтвортой тогтолцоог бүрдүүлж, хэрэгжүүлж эхлэх бэлтгэл ажлын хүрээнд Монголбанк хөнгөлөлттэй хүүтэй ипотекийн зээлийн хөтөлбөрийг Засгийн газарт 2023 онд багтаан бүрэн шилжүүлэх, энэ хугацаанд хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх;

Үндэслэл

Монголбанк, Засгийн газар хамтран 2013 оны 3 дугаар сараас эхлүүлсэн “Барилгын салбарыг дэмжих, улмаар орон сууцны үнийг тогтворжуулах” дэд хөтөлбөр дотроос түүний 2 дахь хэсэг болох “Орон сууцны санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бий болгох хөтөлбөр” өнөөг хүртэл хэрэгжиж байна.

Энэхүү хөтөлбөрийн хүрээнд Монголбанк, Засгийн газар, банкуудын эх үүсвэрээр нийт 5.7 их наяд төгрөгийн хөнгөлөлттэй хүүтэй зээлийг нийт 98.6 мянган зээлдэгчид 2021 оны 7 дугаар сарын эцсийн байдлаар олгоод байна. Үүнээс 9,276 өрхөд олгосон 679.5 тэрбум төгрөгийн зээл нь жилийн 6 хувийн хүүтэй байна. Хөтөлбөрийн зээлийн хүүг жилийн 6 хувь болгосноор зээлдэгчийн сарын төлбөрийн хэмжээ 20 орчим хувиар багасч, үүнийг дагаад өрхийн орлогын шаардлагатай доод хэмжээ мөн ижил хувиар буурав.

Хэдийгээр тус хөтөлбөр нь дундаж орлоготой өрхүүдийн орон сууцны нөхцөлийг сайжруулах, агаар, орчны бохирдол болон орон нутгийн шилжилт хөдөлгөөнийг бууруулах зэрэг нийгмийн олон талын ач холбогдолтой боловч хөнгөлөлттэй санхүүжилт учир Төв банкны мөнгөний бодлогын зорилттой нийцдэггүй.

Тиймээс олон улсын жишигт нийцүүлэн Монголбанк 2020 оноос эхлэн ипотекийн зээлийн хөтөлбөрийг Засгийн газарт шилжүүлэх бэлтгэлийг бүрэн хангаад байсан боловч Ковид-19 цар тахлын эдийн засагт үзүүлсэн нөлөөнөөс шалтгаалан “Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль”-ийн дагуу Монголбанк 2021 онд хөтөлбөрийг үргэлжлүүлэн санхүүжүүлэв. Үүний зэрэгцээ цар тахлын эдийн засагт үзүүлсэн нөлөө төдийлөн саармагжаагүйгээс Засгийн газар “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-г хэрэгжүүлж эхэлсэн тул Монголбанк ипотекийн хөтөлбөрийг 2023 онд багтаан Засгийн газарт шат дараатай шилжүүлэхээр төлөвлөж байна.

Гэвч тус хөтөлбөрийг Засгийн газарт шилжүүлэх хүртэлх хугацаанд санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэхэд дараах нөхцөл байдал үүсээд байна.

- **Ипотекийн зээлийн хэрэгцээ нэмэгдэж байна.** Тухайлбал, 2021 оны эхний 6 сарын байдлаар нийт 1,182.3 тэрбум төгрөг (14.8 мянган иргэн)-ийн ипотекийн зээлийн хүсэлт ирснээс шаардлага хангасан 468.6 тэрбум төгрөг (6.3 мянган иргэн)-ийн зээл олгогдсон байна. Харин 201.1 тэрбум төгрөг (2.6 мянган иргэн)-ийн зээл холбогдох журам, гэрээний шаардлагуудыг хангаагүй, эсвэл өөрийн хүсэлтээр хүсэлтээ эргүүлэн татсан зэрэг шалтгааны улмаас

олгогдоогүй байна. Түүнчлэн 512.7 тэрбум төгрөг (5.8 мянган иргэн)-ийн ипотекийн зээлийн хүсэлт банкууд дээр хуримтлагдаж, сар тутам ойролцоогоор 196.6 тэрбум төгрөг (2.2 мянган иргэн)-ийн хүсэлт шинээр ирж байна. Иймд ипотекийн зээлийн эрэлт өндөр үед хөтөлбөрийн санхүүжилтийн эх үүсвэрийг тогтвортой түвшинд байлгах нөхцөл үүссэн.

- **Монголбанкны санхүүжилтийн эх үүсвэр буурах эрсдэл үүссэн.** Коронавируст цар тахлын хүндрэлтэй холбоотойгоор банкууд орон сууцны ипотекийн зээлийн хуваарьт төлөлтийг хойшлуулах хүсэлтийг иргэдээс хүлээн авч шийдвэрлэж буй бөгөөд 2020 оны 4 дүгээр сараас 11 дүгээр сарын хооронд нийт 2 их наяд төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй 38,152 зээлдэгчийн зээлийн эргэн төлөлтийн хугацааг 6 хүртэл сараар, 2020 оны 12 дугаар сараас 2021 оны 7 дугаар сарын 1-ний өдөр хүртэлх хугацаанд нийт 2.9 их наяд төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй 55,728 иргэний зээлийн эргэн төлөлтийг хүү хуримтлуулахгүйгээр хойшлуулав. Эдгээр хойшлуулсан зээлийн үлдэгдэл нь нийт ипотекийн зээлийн үлдэгдлийн 80 орчим хувийг эзэлж байна. Ийнхүү төлбөрийг хойшлуулснаар санхүүжилтийн үндсэн эх үүсвэр болох Ипотекийн зээлээр баталгаажсан бонд (ИЗББ)-ын үндсэн болон купоны төлбөрийн эргэн төлөлт тасалдаж, улмаар хөтөлбөрийг санхүүжүүлэх эх үүсвэр багасах өндөр эрсдэл үүсээд байна. Иймд ИЗББ-ын ирээдүйн мөнгөн урсгалаас санхүүжүүлэх замаар эх үүсвэрийг шийдвэрлэж, хөтөлбөрийн санхүүжилтийн эх үүсвэрийн тасралтгүй байдлыг хангах шаардлага бий болсон.

Хөтөлбөрийг цаашид урт хугацаанд тогтвортой үргэлжлүүлэх зорилгоор олон улсын тэргүүн туршлага, зах зээлийн зарчимд суурилсан орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх чиглэлээр судалж, санал боловсруулах ажлын хэсгийг Монголбанк, Сангийн яам, Барилга хот байгуулалтын яамны төлөөллийг оролцуулан байгуулсан. Тус ажлын хэсэг сан бүрдүүлэх замаар тогтвортой санхүүжилтийн тогтолцоог бий болгох, ажил эрхэлж байгаа хүмүүсийн нийгмийн даатгалтай нь санхүүжилтийг уялдуулах зэрэг олон улсын сайн туршлагыг нэвтрүүлэхээр судалж байна. Дунд болон урт хугацаандаа иргэдийг орон сууцжуулахад чиглэсэн хөтөлбөрүүдийг зах зээлийн зарчмаар санхүүжих хэлбэрт шилжүүлэх нь хамгийн үр ашигтай байдаг. Үүний тулд макро эдийн засгийн оновчтой бодлого явуулах замаар зах зээлийн хүүг бууруулах, иргэдийн орлогыг нэмэгдүүлэх, санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь зохистой юм. Ингэснээр ипотекийн болон энэ төрлийн хөтөлбөрүүдийг төрөөс дэмжих, татаас, хүүгийн хөнгөлөлт үзүүлэх шаардлагагүй болох юм. Иймд тогтвортой санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх хүртэлх хугацаанд хөтөлбөрийн тасралтгүй байдлыг хангаж, санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэнэ.

Стратеги

- Нийгэмд гарч буй эерэг үр дүн, цар тахлын эдийн засагт үзүүлсэн нөлөө зэргийг харгалзан хөтөлбөрийн санхүүжилтийг “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-г хэрэгжүүлэх хугацаанд Засгийн газар, Монголбанк болон банкуудын эх үүсвэрээр шийдвэрлэх
- Олон улсын санхүүгийн байгууллагуудын зөвлөмж, олон улсын сайн туршлагатай нийцүүлэн орон сууцны ипотекийн хөтөлбөрийг Засгийн газарт шилжүүлэх бэлтгэл ажлыг хангаж, дунд болон урт хугацаанд зах зээлийн зарчимд суурилсан ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх

Хэрэгжүүлэх арга хэмжээ

- Орон сууцны ипотекийн хөтөлбөрийн санхүүжилтийн эх үүсвэрийг олон улсын сайн туршлагад үндэслэн төрөлжүүлж, холбогдох эрх зүйн баримт бичгүүдэд шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүдийг оруулж, орон сууцны санхүүжилтийн урт хугацааны тогтвортой тогтолцоог бүрдүүлэх бэлтгэл ажлыг хангах
- Монголбанк, Сангийн яам, Барилга хот байгуулалтын яамны төлөөллөөс бүрдсэн ажлын хэсгээс хөтөлбөрийг Засгийн газарт шилжүүлэх саналыг боловсруулах
- Хөнгөлөлттэй хүүтэй ипотекийн зээлийн хөтөлбөрийн санхүүжилтийг “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-г хэрэгжүүлэх хугацаанд Монголбанк хэрэгжүүлэх
- Мөнгөний бодлогын зорилт, ипотекийн зээлээр баталгаажсан бондын эргэн төлөлтөд нийцүүлэн хөтөлбөрийг санхүүжүүлэх

5/ Монгол Улсын Их Хурлын 2020 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Зээлийн хүүг бууруулах стратеги”-ийн хэрэгжилтийг хангах хүрээнд гэрээний маргаан шийдвэрлэх үйл явцыг хялбаршуулах, зээлийн эрсдэлийн зардлыг бууруулах чиглэлээр эрх зүйн орчныг боловсронгуй болгох ажлыг эрчимжүүлэх

Үндэслэл

Улсын Их Хурлын 2020 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн “Зээлийн хүүг бууруулах стратеги батлах тухай” 21 дүгээр тогтоолоор зээлийн хүүг 2019 оны суурь түвшнээс дөрвөн нэгж хувиар бууруулж, 2023 оны эцэст сарын нэг хувьд хүргэх зорилтыг тавьсан. Зээлийн хүүг бууруулах стратегийн зорилт, үр дүнд тогтсон хугацаанд хүрэх, стратегийн арга хэмжээг бодитой хэрэгжүүлэхийн тулд иргэний эрх зүйн харилцаанд оролцогчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зохицуулалтыг сайжруулах шаардлагатай байна.

Зээлийн хүү нь эдийн засгийн суурь хүү болон үйл ажиллагааны зардал, санхүүгийн эрсдлийн зардал буюу санхүүгийн зуучлалын өртгөөс хамаардаг. Санхүүгийн эрсдэлийн зардал өндөр байгаа суурь хүчин зүйлийн нэг нь иргэний эрх зүйн харилцаанд оролцогчдын эрх, хууль ёсны ашиг сонирхолыг хамгаалах зохицуулалт, механизмыг бүрдүүлдэг хуулийн зохицуулалт дутмагаас шалтгаалж байна. Тухайлбал, чанаргүй зээлээс улбаатай зээлийн эрсдэлийн сангийн зардал, чанаргүй авлагыг барагдуулахтай холбоотой хэрэг маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны зардлын хэмжээ нь Иргэний хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Компанийн тухай хууль, Дампуурлын тухай хууль, Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хууль, Хөрөнгийн үнэлгээний тухай хууль, Санхүүгийн түрээсийн тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Зээлийн мэдээллийн тухай хууль, Хөдлөх хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хууль болон холбогдох бусад хуулийн оновчтой бус зохицуулалтаас шалтгаалж байна.

Банкны зээлийн хүүний бүтцийг авч үзвэл татан төвлөрүүлсэн эх үүсвэрийн зардал 60 орчим хувь (9.8 нэгж хувь), үйл ажиллагааны зардал 17 хувь (2.8 нэгж хувь), зээлийн эрсдэлийн зардал 11 хувь (1.8 нэгж хувь), банкны ашиг болон бусад зардал 12 хувь (1.9 нэгж хувь)-ийг тус тус эзэлж байна. Зээлийн хүүг бууруулах стратегид зээлийн хүүний зардал өндөр байх, чанаргүй зээлийн хэмжээ нэмэгдэхэд нөлөөлж байгаа дээр дурдсан хууль тогтоомжийг сайжруулах талаар тусгасан байдаг. Мөн Монгол Улсын Их Хурлын хуулийн 38 дугаар зүйл, Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-д Санхүүгийн түрээсийн тухай, Дампуурлын тухай, Компанийн тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиудыг боловсронгуй болгох асуудлыг Засгийн газар санаачлах буюу түүний эрхлэх асуудлын хүрээнд хамааруулсан байна.

Ковид-19 цар тахлын үед эдийн засгийг дэмжих хүрээнд иргэдийн зээл төлөх хугацааг хойшлуулсантай холбоотойгоор чанаргүй зээлийн түвшин хэвийн үзүүлэлттэй байгаа боловч зээл төлөлтийг хэвийн горимд шилжүүлэхэд чанаргүй зээлийн удирдлага, шийдвэрлэлт чухал бөгөөд энэ нь чанаргүй зээлийн огцом өсөлтөөс сэргийлэх чухал хүчин зүйл болно.

Иймд зээлийн хүүний зардлыг бууруулах, чанаргүй зээлийг бууруулах хүрээнд дээр дурдсан хуульд дор дурдсан агуулгатай өөрчлөлтийг оруулах хуулийн төслийг боловсруулж, нэн тэргүүнд өргөн мэдүүлэх шаардлагатай байна:

- Зээл төлөх хөшүүргийг ашиглаж, чанаргүй зээлийг төлүүлэх, барьцаа хөрөнгөөр зээлийн төлбөрийн үүргийг хангуулах ажиллагааг хялбаршуулах,
- Зээл төлүүлэх ажиллагааг шүүхийн бус журмаар шийдвэрлэх,
- Үүргийн гүйцэтгэлийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмаар хангуулах явцад хөрөнгийн үнэлгээ, эх үүсвэрийн өртгийг хадгалах, хамгаалах.

Стратеги

- Чанаргүй зээлийн үр дагавар, чанаргүй зээлийг шийдвэрлэх ач холбогдол, энэ чиглэлээр үүсэж буй тулгамдсан асуудлын талаар олон нийтэд зөв ойлголт бүрдүүлэх, холбогдох судалгааны үр дүнг нийтэд танилцуулна.
- Зээлийн хүүг бууруулах, чанаргүй зээлийг шийдвэрлэх хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох ажлыг Засгийн газрын хууль зүйн бодлогын зорилт, төлөвлөгөөтэй уялдуулна.

Хэрэгжүүлэх арга хэмжээ

- Хуулийн төслийн санал, холбогдох судалгааг Хууль тогтоомжийн тухай хуульд нийцүүлэн боловсруулах
- Хуулийн төслийн санал, судалгааг хууль санаачлагчид уламжилж, хууль санаачлагчтай хамтран олон нийт, холбогдох бусад байгууллагаас санал авч хуулийн төсөлд тусгах
- Хуулийн төслийг хэлэлцүүлж, батлуулахад хууль санаачлагч, Улсын Их Хурлын холбогдох байнгын хороотой хамтран ажиллах
- Хуулийн төсөл батлагдсаны дараа хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор хуулийн төслийг олон нийтэд таниулах, холбогдох дүрэм, журмыг баталж, мөрдүүлэх арга хэмжээ авах

б/ Уур амьсгалын өөрчлөлтийн эдийн засаг, санхүүгийн салбарт үзүүлэх нөлөөг судалж, бүсийн болон олон улсын байгууллагуудаас гаргасан зөвлөмж, санаачилгатай уялдсан тогтвортой санхүүжилтийн бодлого, стратеги боловсруулж хэрэгжүүлэх

Уур амьсгалын өөрчлөлт (УАӨ), дэлхийн дулаарал нь хүн төрөлхтний өмнө тулгамдаж буй томоохон бэрхшээл, сорилт гэдгийг дэлхий нийтээр хүлээн зөвшөөрч, 2015 онд Парисын хэлэлцээрийг баталсан. Тус хэлэлцээрийн гол зорилго нь дэлхийн дулаарлыг аж үйлдвэржилтийн өмнөх үетэй харьцуулахад 2°C-с доош барьж, цаашлаад 1.5°C-с хэтрүүлэхгүй байх явдал билээ. Улс орнуудын хувьд уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой томоохон эрсдэл, сорилтыг дангаар шийдвэрлэх, даван туулах нөөц боломж хомс тул олон улсын түвшинд хамтран ажиллах, туршлага солилцох, цаашлаад төрийн байгууллагууд хоорондын уялдааг сайтар хангах замаар нэгдсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх, бэлэн байдлаа сайжруулах шаардлага тулгарч байна. Ковид-19 цар тахалтай холбоотойгоор дэлхийн даяар УАӨ, дэлхийн дулаарлын үр дагавар, ач холбогдлыг нэмэгдүүлэн, төрөөс хэрэгжүүлэх стратеги, төлөвлөгөө, бодлогын шийдвэр гаргахад улам бүр харгалзан үзэж байна.

НҮБ-ын дэргэдэх IPCC (Intergovernmental Panel on Climate Change) зөвлөлийн УАӨ-ийн талаарх цогц, дэлгэрэнгүй судалгаанд дурдсанаар дэлхийн гадаргын температур аж үйлдвэржилтийн өмнөх үеэс 1.09°C хэмээр нэмэгдээд байна⁸. Харин манай орны жилийн дундаж агаарын хэм сүүлийн 80 жилд 2.25°C-ээр дулаарсан нь дэлхийн дунджаас 2 дахин өндөр үзүүлэлт юм. Энэхүү цаг агаарын дулаарал, уур амьсгалын эрчимтэй өөрчлөлтөөс шалтгаалан манай улсад байгалийн гамшиг, аюулт үзэгдлийн тоо сүүлийн 10 жилд 1990-ээд онтой харьцуулахад 2-3 дахин өсжээ. Манай орны нийт нутаг дэвсгэрийн 76.8 хувь нь цөлжилт, газрын доройтолд өртөөд байгаа бол нийт бэлчээрийн 57 хувь нь доройтолд ороод байна⁹. Эдгээр байгаль орчны доройтол, цаг уурын гамшигт үзэгдэл, экосистемийн тэнцвэргүй байдал нь нийт эдийн засаг, тэр дундаа хөдөө аж ахуйн салбар, хүнсний үйлдвэрлэл улмаар иргэдийн амьдралын чанарт томоохон эрсдэл, бэрхшээлийг үүсгэж байна.

Цаг уурын өөрчлөлтөөс шалтгаалан үүсэх эрсдэлийг шилжих сувгаас хамаарч шилжилтийн болон шууд (transitional and physical) гэсэн хоёр төрлийн эрсдэлд ангилах боломжтой¹⁰. Шилжилтийн эрсдэл нь дэлхийн улс орнуудын засгийн газар, холбогдох төрийн байгууллагууд нь УАӨ-ийн эсрэг, арга хэмжээ авахгүй, хугацаа алдсанаас шалтгаалан учирч болох эрсдэл бөгөөд уг хохирол нь харьцангуй өндөр байх боломжтой. Учир нь УАӨ-тэй холбоотой олон нийтийг хамарсан зохицуулалт, авч хэрэгжүүлэх арга хэмжээний цар хүрээ нь хувийн сектор, иргэдийг хамрах бөгөөд тэдгээрийн бизнесийн загвар, ашигт ажиллагаа, зан төлөвт нөлөөлөх боломжтой юм. Харин шууд эрсдэл нь УАӨ-өөс шалтгаалан ган гачиг, ойн түймэр, үер зэрэг байгалийн гамшигт үзэгдлүүд, дэлхийн дулаарал, их хэмжээний хур тунадас, далайн усны түвшин нэмэгдэх зэрэг томоохон өөрчлөлтөөс үүдэн гарах хохирол, учирч болох гарз юм. Иймд олон улсын туршлага, санаачилгуудад тулгуурлан УАӨ-тэй холбоотой эрсдэлийн шинжилгээ, тооцоо судалгааг хийж гүйцэтгэн, эдийн засгийн салбар хоорондын уялдаа, аж ахуй нэгжид үзүүлэх нөлөө, үр дагаврыг тодорхойлсны үндсэн дээр сөрөг нөлөөллийг бууруулах бодлого, төлөвлөгөөг хэрэгжүүлэх нь чухал болж байна.

УАӨ-д дасан зохицох чадварыг сайжруулах, сөрөг нөлөөг бууруулахын тулд ногоон, тогтвортой хөрөнгө оруулалтад төрийн болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг чиглүүлэх шаардлагатай. Тухайлбал, Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа, Хөгжлийн Байгууллагын тооцоолсноор тогтвортой хөгжлийн зорилтуудыг биелүүлэхийн тулд 2030 он хүртэл жил бүр 6.3 орчим их наяд ам.долларын хөрөнгө оруулалт шаардлагатай бол Парисын хэлэлцээрийн зорилгыг хангахын тулд тус санхүүжилтийг 6.9 их наяд ам.доллар болгож нэмэгдүүлэх хэрэгтэй байна¹¹. Олон улсын зах зээлд ногоон бонд, тогтвортой санхүүжилтийн хэмжээ сүүлийн жилүүдэд эрчимтэй нэмэгдсээр байна. Тухайлбал, 2020 онд шинээр гаргасан ногоон, нийгэм болон тогтвортой¹² (GSS) байдлыг дэмжих бондын хэмжээ өмнөх жилээс бараг 2 дахин нэмэгдэж 700 тэрбум ам.долларт хүрсэн. Ингэснээр тогтвортой өрийн зах зээл (sustainable debt market)-ийн хэмжээ 1.7 их наяд хүрсэн бөгөөд 2006 оноос хойш 10³000 орчим GSS тодотголтой өрийн хэрэгсэл зах зээлд нэвтэрчээ. Хэдийгээр энэ нь 100 их наяд ам.долларын үнэлгээтэй бондын зах зээлийн багахан хэсгийг эзэлж буй боловч зах зээлд оролцогчдын анхаарлыг ихээр татаж, цаашид хурдтай хөгжих хүлээлттэй байна¹³.

⁸ Эх сурвалж: “Climate Change 2021: The Physical Science Basis” (2021), Intergovernmental Panel on Climate Change.

⁹ Эх сурвалж: “Монгол орны байгаль орчны төлөв байдлын тайлан 2017-2018 он” (2019), Байгаль орчин, аялал жуучлалын яам.


¹⁰ Эх сурвалж: “First Progress Report” (2018), NGFS.

¹¹ Эх сурвалж: “Financing Climate Futures: Rethinking Infrastructure Policy Highlights” (2018), OECD.

¹² Green, social and sustainability (GSS)

¹³ Эх сурвалж: “Sustainable Debt: Global state of the market” (2021), Climate Bonds Initiative.

Зураг 4. Шинээр гаргасан ногоон, нийгэм болон тогтвортой байдлыг дэмжих бондын хэмжээ, 2015-2020 он



Эх сурвалж: Climate Bonds Initiative, 2021

Стратеги

- Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой эрсдэлийн шинжилгээ, тооцоо судалгааг хийж гүйцэтгэнэ.
- Монгол Улсын дунд ба урт хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтөд тусгагдсан зорилтуудтай уялдуулан Тогтвортой хөгжлийн санхүүжилтийн стратеги, шалгуур үзүүлэлтийг боловсруулж, санхүүгийн салбарт нэвтрүүлнэ.
- Төрийн байгууллага, институциуд уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой эрсдэлийг бууруулах чиглэлээр нягт уялдаатай хамтран ажиллана.
- Уур амьсгалын өөрчлөлт, тогтвортой санхүүжилтийн ойлголт, мэдээллийг түгээн дэлгэрүүлэх, олон нийтийн анхаарлыг нэмэгдүүлнэ.
- Тогтвортой санхүүжилтийн хүрээнд гадаад зах зээлээс эх үүсвэр босгох чиглэлээр ажиллана.

Хэрэгжүүлэх арга хэмжээ

- Уур амьсгалын өөрчлөлтийн нийгэм, эдийн засаг, салбаруудад үзүүлж болох нөлөө, учирч болох эрсдэлийн шинжилгээ, судалгааны ажил гүйцэтгэх, тоон мэдээний чанарыг сайжруулах
- Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг бууруулахад чиглэсэн зөвлөмж, санаачилгатай уялдсан тогтвортой санхүүжилтийн талаар баримтлах бодлого, стратеги боловсруулах
- Төрийн байгууллагууд уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэлийг бууруулах чиглэлээр нягт уялдаатай хамтран ажиллах, хөрөнгө оруулалтын шийдвэр гаргалтад харгалзан үзэх
- Хэрэгжүүлсэн бодлого арга хэмжээний хэрэгжилтэд тавих хяналтын тогтолцоог бүрдүүлэх, үр дүнд үнэлэлт, дүгнэлт өгөх, үүн дээр үндэслэн дараагийн шатны төлөвлөгөө, арга хэмжээг авах
- Тогтвортой хөгжлийн зорилтуудтай уялдсан байгаль орчин, нийгэмд эерэг үр нөлөө үзүүлдэг эдийн засгийн үйл ажиллагааны ангилал, тусгайлсан шалгуур үзүүлэлт, баталгаажуулалтын аргачлал бүхий Тогтвортой хөгжлийн санхүүжилтийн таксономи боловсруулах
- Орон сууцны ипотекийн санхүүжилтийн журамд эрчим хүчний хэмнэлттэй болон ногоон барилгыг санхүүжүүлэх тухай заалт, аргачлалыг нэмж оруулах
- Тогтвортой санхүүжилтийг санхүүгийн байгууллагад амжилттай сайн хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор Төв банкны зүгээс авч хэрэгжүүлэх боломж бүхий хөшүүргийн арга хэрэгслүүдийг судалж нэвтрүүлэх
- Банкны салбарын статистик тайлан мэдээллийг хүйсээр ангилан нийтэд мэдээлэх, жендерийн мэдрэмжтэй санхүүжилтийн тогтолцоо бүрдүүлэх чиглэлд салбарын холбоод, санхүүгийн байгууллагуудтай хамтран ажиллах
- Тогтвортой санхүүжилтийн талаарх олон нийтийн мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх чиглэлээр судалгаа, шинжилгээг дэмжиж ажиллах

7/ Засгийн газрын 2021 оны 42 дугаар тогтоолоор батлагдсан “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10.0 (арван) их наядын цогц төлөвлөгөө”-нд тусгагдсан ажлын байрыг дэмжих зээл, хөдөө аж ахуйг дэмжих зээл, малчдыг дэмжих зээл, ипотекийн зээл, репо санхүүжилтийн зээл болон бусад төсөл, арга хэмжээний хэрэгжилт, хяналтыг үргэлжлүүлэх

Үндэслэл

Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлын нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулж, эдийн засгийг идэвхжүүлэх зорилтын хүрээнд банкуудын зээлийн эрсдэлийг бууруулж, бизнесийн үйл ажиллагаа, ажлын байрыг дэмжих, хөдөө аж ахуйг дэмжих, барилгын салбар түүний дагалдах салбарыг дэмжих зорилгоор Засгийн газраас бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 42 дугаар тогтоолоор батлагдсан “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-ний 2.1-д тусгагдсан “Ажлын байрыг дэмжих зээл”, 2.3-д тусгагдсан “ипотекийн зээл”, 2.4-т тусгагдсан “репо санхүүжилтийн зээл”, 2.5-д тусгагдсан хаврын тариалалт, ноос, ноолуур болон арьс шир бэлтгэлийн чиглэлээр “Хөдөө аж ахуйг дэмжих зээл” болон малчдын үйл ажиллагааг дэмжсэн “Малчдыг дэмжих зээл”-ийг банкуудын эх үүсвэрт тулгуурлан олгохоор заасан. Эдгээр зээл, санхүүжилт болон төсөл, арга хэмжээнд хамрагдсан иргэн, аж ахуйн нэгжид Засгийн газраас хүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаанд Төв банк (Монголбанк)-ны тухай хуульд заасан Засгийн газрын санхүүгийн зуучлагч, банканд хяналт тавих чиг үүрэгтэйгээр холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж байна.

Төлөвлөгөөний хэрэгжилт 2021 оны 7 дугаар сарын 28-ны өдрийн байдлаар дараах үр дүнд хүрсэн байна. Үүнд:

1. Ажлын байрыг дэмжих зээл

Нийт 23,092 харилцагчид 1,738.2 тэрбум төгрөгийн зээл олгосон буюу 87 хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнээс 18,150 иргэний 609.4 тэрбум төгрөгийн зээл, 4,942 аж ахуйн нэгжийн 1,128.9 тэрбум төгрөгийн зээлийг олгоод байна. Ингэснээр нийт 94,185 ажлын байрыг дэмжсэн байна.

2. Репо санхүүжилтийн зээл

Нийт 2,733 харилцагчид 618.3 тэрбум төгрөгийн зээл олгосон. Үүнээс 1,202 иргэний 141.2 тэрбум төгрөгийн зээл, 1,531 аж ахуйн нэгжийн 477.1 тэрбум төгрөгийн зээлийг олгоод байна. Ингэснээр нийт 26,784 ажлын байрыг дэмжсэн байна.

3. Ипотекийн зээл

Нийт 7,272 харилцагчид 540.2 тэрбум төгрөгийн зээл олгосон. Үүнээс орон нутагт 1,855 харилцагчийн 99.4 тэрбум төгрөгийн зээл, Улаанбаатар хотод 5,417 харилцагчийн 440.7 тэрбум төгрөгийн зээлийг олгоод байна.

4. Хөдөө аж ахуйг дэмжих зээл

Нийт 19,983 харилцагчид 315.0 тэрбум төгрөгийн зээл олгосон. Үүнээс орон нутагт 19,663 харилцагчийн 210.4 тэрбум төгрөгийн зээл, Улаанбаатар хотод 320 харилцагчийн 104.7 тэрбум төгрөгийн зээлийг олгоод байна. Малчдыг дэмжих зээл 193.8 тэрбум төгрөг буюу 62 хувь, хаврын тариалалтын зээл 30.1 тэрбум төгрөг буюу 9.6 хувь, ноолуур бэлтгэлийн 91.1 тэрбум төгрөг буюу 28.9 хувийг бүрдүүлж байна.

Стратеги

- Засгийн газрын 2021 оны 42 дугаар тогтоолоор батлагдсан “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10.0 (арван) их наядын цогц төлөвлөгөө”-нд тусгагдсан зээлүүдийн санхүүжилтийн ерөнхий гэрээнд заасан зориулалт, шаардлага, холбогдох арилжааны банкуудын журам, зааврын дагуу олгогдсон эсэх, зээлийн зарцуулалт, мөн арилжааны банкууд зээлийн хүүгийн дэмжлэгийг үнэн зөв тайлагнасан эсэх болон үйл ажиллагаатай холбоотойгоор газар дээрх болон зайны хяналтыг гэрээнд заасан хугацаанд тогтмол хийж, гүйцэтгэнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ

- Банкуудаас ирүүлсэн зээлийн мэдээг нэгтгэн Сангийн яам болон бусад оролцогч байгууллагуудыг мэдээллээр хангах, тайлагнах
- Засгийн газраас төлөх хүүгийн дэмжлэгийн тооцооллыг сар бүр түүвэрчлэн хянаж, Сангийн яаманд хүргүүлэх
- Зээлүүдтэй холбоотой банкны харилцагч иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлын хариуг шалган хүргүүлэх
- Монголбанк, Сангийн яам болон бусад оролцогч байгууллагуудтай хамтарсан газар дээрх болон зайны хяналт шалгалтыг банкуудад хийж, үр дүнг тайлагнах

Монгол Улсын Их Хурлын
2021 оны ... сарын ... –ны өдрийн
... дугаар тогтоолын хавсралт

ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2022 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ТӨСӨЛ

1. Мөнгөний бодлогын зорилтын хүрээнд:

1.1. Хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляцыг 2022-2024 онд +/-2 нэгж хувийн интервалд 6 хувийн орчимд тогтворжуулна. Инфляцыг тогтворжуулахад чиглэсэн мөнгөний бодлогын шийдвэрийг гаргахдаа зах зээлийн зарчимд тулгуурлан нийлүүлэлтийн шалтгаантай үнийн өсөлтийн шууд бус нөлөөг нягтлан үзэж, эдийн засгийн сэргэлтийг удаашруулахгүй байх зарчмыг баримтлана.

1.2. Ковид-19 цар тахлын хүндрэлийг даван туулах, эдийн засгийн сэргэлт, дунд хугацааны макро тогтвортой байдлыг дэмжсэн зээлийн тогтвортой өсөлтийг хангаж, банкны системд эрсдэл хуримтлагдахаас сэргийлсэн макро зохистой бодлогыг мөнгөний бодлоготой хослуулан хэрэгжүүлнэ.

1.3. Төв банкны олон нийттэй харилцах харилцааг хөгжүүлж, бодлогын ил тод байдлыг хадгалж ажиллана.

2. Банкны салбарын тогтвортой байдлын хүрээнд:

2.1. Эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан банкны салбарын хяналт шалгалт, зохицуулалтын арга хэрэгслийг олон улсын стандартад нийцүүлэх арга хэмжээг үргэлжлүүлж, цар тахлын эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах хүрээнд мөрдөгдөж буй зохицуулалтыг ердийн нөхцөлд шилжүүлэх төлөвлөгөөг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

2.2. Банк хувьцаат компани хэлбэрээр үйл ажиллагаа явуулах хууль, эрх зүйн шаардлагын хүрээнд хяналт шалгалт, зохицуулалтыг боловсронгуй болгож мөрдүүлнэ.

2.3. Банкны салбарын эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийн хүрээнд хийсэн судалгаа, үр дүнд үндэслэн эрх зүйн зохицуулалтын давхардал, хийдлийг арилгаж нэгдмэл байдлыг хангах, зээлийн мэдээлэл, үүсмэл санхүүгийн хэрэгсэл, буцаан худалдан авах барьцаат санхүүжилтийн хэлцлийн эрх зүйн орчныг боловсронгуй болгох арга хэмжээ авна.

3. Санхүүгийн захын дэд бүтэц, түүний институцийг бэхжүүлэх хүрээнд:

3.1. Төв банкны цахим мөнгө гаргах талаар судалж, хөгжүүлнэ.

3.2. Үндэсний төлбөрийн системийн эрх зүйн орчныг сайжруулах замаар шинэ технологид суурилсан санхүүгийн үйлчилгээг дэмжиж, төлбөрийн систем дэх хяналтын чиг үүргийг хэрэгжүүлнэ.

3.3. Санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах хүрээнд иргэд, бичил, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн санхүүгийн суурь мэдлэгийг дэмжинэ.

3.4. Макро эдийн засаг, санхүүгийн зах зээлийн шинжилгээнд их өгөгдлийг ашиглах техникийн болон мэргэшлийн ур чадварыг үе шаттайгаар бүрдүүлж эхлэнэ.

ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2022 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Ковид-19 цар тахлын сөрөг нөлөөгөөр 2020 онд дэлхийн эдийн засаг огцом уналтад орсон. Гэхдээ 2020 оны сүүлээс эхлэн хөгжингүй орнуудын эдийн засаг, санхүүгийн зах зээл идэвхжиж, зах зээлд оролцогчдын хүлээлт сайжирч, сэргэлт гарч байна. Вирусын тархалт, авч хэрэгжүүлж буй бодлого, эдийн засгийн сэргэлт улс орнуудад ялгаатай байна. Дэлхийн эдийн засгийн идэвхжлийг даган түүхий эдийн үнэ нэмэгдсэний зэрэгцээ нийлүүлэлтийн сүлжээний доголдол, тээврийн зардлын өсөлт, эдийн засгийн сэргэлтийг дагасан эрэлтийн хүчин зүйлсийн нөлөөгөөр хөгжингүй болон хөгжиж буй орнуудад үнийн өсөлт эрчимжих хандлагатай боллоо.

Өнгөрсөн онд огцом агшсан манай эдийн засаг энэ оны эхний хагаст 6.3 хувиар өслөө. Гэсэн хэдий ч хөл хорио, хилийн хязгаарлалт, вирусын тархалттай холбоотойгоор эдийн засгийн идэвхжил саарч, өсөлт 2 дугаар улиралд муудсан боловч 2021 оны эцэст эдийн засаг цар тахлын өмнөх буюу 2019 оны түвшинд хүрч сэргэх хүлээлттэй байна. Өсөлтийн цаашдын төлөвийг авч үзвэл уул уурхайн салбар 2 дугаар улиралд саарсан хандлага оны сүүлийн хагаст үргэлжлэх бол уул уурхайн бус салбар макро бодлогын арга хэмжээнүүд болон гадаад сэргэлттэй уялдан эрчимжих хүлээлттэй байна.

Дэлхийн эдийн засгийн сэргэлт, түүхий эдийн үнийн өсөлтөөр дамжин манай экспортын орлого, төсвийн орлогод дэмжлэг үзүүлэх нөхцөл бүрдсэн билээ. Тухайлбал, энэ оны 7 дугаар сарын байдлаар экспортын үнэ жилийн 34.6 хувиар, импортын үнэ 18.6 хувиар өсч, гадаад худалдааны нөхцөл жилийн 13.6 хувиар сайжирчээ. Хэдийгээр гадаад эрэлт, үнэ сайжирсан ч манай экспортын биет хэмжээ төдийлөн сэргэхгүй байгаа нь уул уурхайн салбарын өсөлт, төсвийн орлого бүрдүүлэлт, төлбөрийн тэнцэлд сөрөг нөлөө үзүүллээ. Харин дотоод эдийн засгийн идэвхжил, уул уурхайн томоохон төсөл, дэд бүтцийн бүтээн байгуулалтууд, дэлхийн зах зээл дээрх газрын тосны үнэ зэргээс үүдэн импорт оны эхний 7 сард 31.9 хувиар тэллээ. Ийнхүү импорт экспортоос хурдтай өссөн нөлөөгөөр урсгал тэнцлийн алдагдал өмнөх оны мөн үеэс 2 дахин тэлээд байна.

Монгол Улсын Засгийн газар, Монголбанкнаас цар тахлын сөрөг нөлөөг бууруулах, эдийн засгийн сэргэлтийг дэмжих зорилгоор багц бодлого, зохицуулалтын арга эмжээг авч хэрэгжүүлсэн нь санхүүгийн тогвортой байдлыг хадгалах, өрхийн орлогыг дэмжиж хэрэглээг тэтгэх, зээлийн өсөлтийг эрчимжүүлж эдийн засгийн идэвхжлийг дэмжиж байна. Тухайлбал, өнгөрсөн онд жилийн 6.5 хүртэлх хувиар агшиж байсан нийт зээлийн үлдэгдэл энэ оны 7-р сард 12.3 хувьд хүрч өсөхөд эдийн засгийн идэвхжил болон “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-ний хэрэгжилттэй холбоотойгоор шинээр олгосон зээлийн өсөлт голлон нөлөөлөв. Гэхдээ вирусын шинэ хувилбарын тархалттай холбоотойгоор эдийн засгийн салбаруудын өсөлт харилцан адилгүй, цаашдын төлөв жигд бус байгаагийн дээр тодорхой бус байдал буурахгүй байна.

Төв банк инфляцыг 2022-2024 онд 6 ± 2 нэгж хувийн интервалд тогтворжуулах зорилтыг хангахад чиглэсэн бодлого хэрэгжүүлнэ. Өнгөрсөн онд инфляц бага түвшинд хадгалагдсан хэдий ч 2021 оны 4 дүгээр сараас эхлэн суурь үеийн нөлөө, нэг удаагийн шинжтэй, нийлүүлэлтийн хүчин зүйлсийн голлох нөлөөгөөр инфляц нэмэгдлээ. Эдгээр хүчин зүйлсийн нөлөөгөөр инфляц өсөх хэдий ч 2022 оны сүүлийн хагаст зорилтын орчимд тогтворжих хүлээлттэй байна. Гэвч дэлхийн эдийн засгийн сэргэлт, олон улсын нийлүүлэлтийн сүлжээ, логистикийн сааталтай холбоотойгоор гадаад инфляц болон дэлхийн зах зээл дээрх хүнс, шатахууны үнэ хүлээлтээс давж өсөх, дотоод зах зээл дээр нийлүүлэлтийн шалтгаанаар инфляцын төлөв нэмэгдэх эрсдэлтэй байна. Иймд эрэлтийн шалтгаантай инфляцыг зөв таних, нөгөө талаас нийлүүлэлтийн шалтгаантай инфляцын шууд бус нөлөөг нягтлан үзэж, эдийн засгийн сэргэлтийг удаашруулахгүй байхаар мөнгөний бодлогын шийдвэрийг гаргах нь зохимжтой гэж Монголбанк үзэж байна. Мөн цар тахлын хүндрэлийг даван туулах, эдийн засгийн сэргэлт, дунд хугацааны макро тогтвортой байдлыг дэмжсэн

зээлийн тогтвортой өсөлтийг хангаж, банкны системд эрсдэл хуримтлагдахаас сэргийлсэн макро зохистой бодлогыг мөнгөний бодлоготой хослуулан хэрэгжүүлнэ.

Цар тахлын эдийн засагт үзүүлж буй сөрөг нөлөөллийг бууруулах хүрээнд авч хэрэгжүүлж буй санхүүгийн зохицуулалтын арга хэмжээг ердийн нөхцөл рүү шат дараатай шилжүүлэхэд ирэх оны банкны хяналт шалгалтын бодлого чиглэгдэх болно. Банк, санхүүгийн салбарын эрх зүйн шинэтгэлийн хүрээнд банкны хяналт шалгалтын олон улсын сайн туршлага, зохицуулалтыг манай улсын банкны системийн онцлогт нийцүүлэн, шат дараатайгаар нэвтрүүлэх, эрсдэлд суурилсан хяналт шалгалтын арга барилд шилжих ажлуудыг үргэлжлүүлж байна. Тухайлбал, банкны төлбөрийн чадвар, өөрийн хөрөнгийн хүрэлцээ, актив хөрөнгийн ангилал, зохистой засаглалын шаардлагыг боловсронгуй болгох, Монголбанкаас тавих хяналт шалгалтыг үр нөлөөтэй хэрэгжүүлэхэд мөрдөх журам, зааврыг шинээр боловсруулах, шинэчлэн батлах, нэмэлт өөрчлөлт оруулах ажлуудыг 2020-2021 онд хийж гүйцэтгэлээ. Цаашид эдгээр шинэчилсэн хяналт шалгалтын журам, зохицуулалтыг мөрдүүлэх ажлыг цар тахлын улмаас үүсээд буй нөхцөл байдалтай уялдуулан шат дараатайгаар хэрэгжүүлнэ. Түүнчлэн, Банкны тухай хуулийн 2021 оны нэмэлт, өөрчлөлтийн дагуу хувьцаат компани хэлбэртэй банкны хяналт шалгалт болон зохицуулалтыг боловсронгуй болгох, энэ чиглэлээр бусад эрх бүхий байгууллагатай хамтран ажиллана.

Төв банкны олон нийттэй харилцах харилцааг цар тахлын нөхцөл байдалд нийцүүлэн үргэлжлүүлж, бодлогын ил тод байдлыг хадгалах, Төв банкны цахим мөнгө гаргах талаар судалж, хөгжүүлэх, үндэсний төлбөрийн системийн эрх зүйн орчныг боловсронгуй болгож шинэ технологид суурилсан санхүүгийн үйлчилгээг үргэлжлүүлэн дэмжих, эдийн засаг, санхүүгийн зах зээлийн шинжилгээнд их өгөгдлийг ашиглахад шаардлагатай чадавхийг хөгжүүлэх стратеги боловсруулах чиглэлээр тодорхой ажлуудыг хийхээр төлөвлөж байна.

Ирэх онд Ковид-19 цар тахлын хүндрэлийг даван туулж, эдийн засгийн сэргэлтийг дэмжихэд чиглэсэн олон ажлыг Монголбанк төрийн бусад байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэхээр УИХ-ын тогтоолын төсөлд тусгалаа. Энэ хүрээнд цар тахлын үеийн эдийн засгийн хүндрэлд нийгмийн эмзэг бүлгүүд илүү өртөж, ажилгүйдлийн түвшин нэмэгдэхээр байгаа нь эдийн засгийн бодлогуудын өмнө тулгарах нэн тэргүүний сорилт болохоор байна. Иймээс иргэдийн амьдарлын чанарыг сайжруулахад шаардлагатай дунд, урт хугацааны тогтвортой хөгжлийн зорилтуудыг ирэх онд хэрэгжүүлэх эдийн засгийн сэргэлтийг дэмжих бодлоготойгоо нягт уялдуулж, эдийн засгийн өсөлтийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд анхаарал хандуулах шаардлагатай болж байна.

Сүүлийн жилүүдэд давтамж нь тогтмол нэмэгдэж буй байгалийн гамшигт үзэгдэл, түүний эдийн засгийн засагт үзүүлж буй сөрөг нөлөө нэмэгдсээр байна. Уур амьсгалын өөрчлөлт, дэлхийн дулаарал нь хүн төрөлхтний өмнө тулгамдаж буй томоохон бэрхшээл, сорилт гэдгийг дэлхий нийтээр хүлээн зөвшөөрөхөд хүргэх болсон. Манай орны хувьд жилийн дундаж агаарын хэмийн дулаарал дэлхийн дунджаас 2 дахин өндөр, газрын доройтол, цаг уурын гамшигт үзэгдэл, экосистемийн тэнцвэргүй байдал нэмэгдсэн нь нийт эдийн засаг, тэр дундаа хөдөө аж ахуйн салбар, хүнсний үйлдвэрлэл улмаар иргэдийн амьдралын чанарт томоохон эрсдэл, бэрхшээлийг цаашид үүсгэхээр байна. Иймд уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадварыг сайжруулах, сөрөг нөлөөг бууруулахын тулд уур амьсгалын өөрчлөлтийн Монгол Улсын нийгэм, эдийн засаг, салбаруудад үзүүлэх нөлөө, учирч болох эрсдэлийн шинжилгээний арга зүйг хөгжүүлэх, ногоон, тогтвортой санхүүжилтийн тогтолцоог хөгжүүлэх стратегийг боловсруулж, амжилттай хэрэгжүүлэхэд хяналт тавих болон зохицуулагч байгууллагуудаас бодлогын дэмжлэг үзүүлэх шаардлагатай байна. Монголбанк уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг судлах, ногоон, тогтвортой санхүүжилтийг тогтолцоог хөгжүүлэхэд олон улсын байгууллага, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагатай хамтран ажиллаж, мөнгөний бодлого, санхүүгийн зохицуулалтын арга хэрэгслүүдийг ашиглан хэрэгжилтийг нь дэмжихэд цаашид анхаарал хандуулна.

Уул уурхайн бус экспортын бодлогыг нэгтгэн зангидах, санхүүгийн дэд бүтэц, санхүүжилтийн тогтолцоог хөгжүүлэх, Мөнгө, угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний хөтөлбөр болон үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх, санхүүгийн гэрээний маргаан шийдвэрлэх үйл явцыг хялбаршуулах, зээлийн эрсдэлийн зардлыг бууруулахад чиглэсэн холбогдох хууль тогтоомжийг боловсронгуй болгоход төр, хувийн хэвшлийн байгууллагуудын нягт хамтын ажиллагаа чухал хэвээр байна.

Макро эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдлыг нэгтгэн дүгнэвэл цар тахлын нөлөөгөөр эдийн засагт оролцогчдын хүлээлт өөрчлөгдөж, бизнесийн үйл ажиллагаа хязгаарлагдаснаас МУ-ын эдийн засаг өнгөрсөн онд огцом агшиж, энэ онд сэргэх хандлага ажиглагдаж байгаа ч өсөлтийн цаашдын төлөв эдийн засгийн салбар хооронд харилцан адилгүй байхаар байна. Гадаад орчин сайжирч, түүхий эдийн үнэ өндөр түвшинд хадгалагдаж байгаа хэдий ч үүний үр ашгийг вирусын тархалтыг бууруулах, экспортын тээвэрлэлтийн асуудлыг шийдэхгүйгээр хүртэх боломж хязгаарлагдмал байна. Цар тахлын нийгэм, эдийн засагт үзүүлж буй нөлөө нь урд өмнө нь тохиож байгаагүй том хэмжээтэй, олон удаагийн давалгаагаар цаашид ч үргэлжлэхээр байна. Иймээс цаашид нийгэм, эдийн засгийн бодлого, зохицуулалтын арга хэмжээг хямралын суурь шалтгаан болж буй вирусын тархалтыг хяналтандаа оруулах боломжийг нэмэгдүүлэхэд чиглүүлэхээс гадна дунд, урт хугацааны тогтвортой хөгжлийн зорилттой уялдуулан эдийн засгийн сэргэлтийг дэмжих, зорилтод бүлэгт чиглэсэн халамжийн бодлогыг хэрэгжүүлэх, иргэдийн бодит орлогыг хамгаалах замаар ядуурлыг нэмэгдүүлэхгүй байхад чиглүүлэх шаардлагатай байна.

Цаашид Ковид-19 цар тахлын нөлөөгөөр эдийн засагт бий болсон сөрөг нөлөөг бууруулахын зэрэгцээ үүсэж болзошгүй эрсдэлээс сэргийлэх, эдийн засгийн сэргэлтийг удаашруулахгүйгээр макро эдийн засаг, ажил эрхлэлтийн урт хугацааны тогтвортой байдлыг хангах замаар эдийн засгийн өсөлтийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд макро эдийн засгийн бодлогуудыг чиглүүлэх нь чухал болж байна. Монголбанкны бодлого, үйл ажиллагаа эдгээр зорилтыг хангахад чиглэнэ.

МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД


ЗОРИЛТ 1.1

Хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляцыг 2022-2024 онд +/-2 нэгж хувийн интервалд 6 хувийн орчимд тогтворжуулна. Инфляцыг тогтворжуулахад чиглэсэн мөнгөний бодлогын шийдвэрийг гаргахдаа зах зээлийн зарчимд тулгуурлан нийлүүлэлтийн шалтгаантай үнийн өсөлтийн шууд бус нөлөөг нягтлан үзэж, эдийн засгийн сэргэлтийг удаашруулахгүй байх зарчмыг баримтлана.

Үндэслэл

Инфляцыг онилох мөнгөний бодлого нь инфляцыг зорилтот түвшний орчимд хадгалахаас гадна хүлээлтээр дамжуулан тогтворжуулах зорилгыг давхар агуулдаг. Зах зээлийн эдийн засгийн мэдээллийг дамжуулах үндсэн хэрэгсэл нь үнэ болдог. Иймд инфляц нам түвшинд **тогтвортой** байх нь иргэдийн бодит орлого, өрхийн амьжиргааг хамгаалахын зэрэгцээ макро эдийн засгийн өрнөл, уналтын савлагааг бууруулах суурь нөхцөл болно. Төв банк инфляцын зорилтыг урьдчилан тодорхойлж, түүнийг хангахад чиглэсэн бодлого хэрэгжүүлснээр зах зээлийн тодорхой бус байдлыг бууруулж, хөрөнгө оруулалт, санхүүгийн шийдвэр гаргахад хялбар болгож, улмаар дунд, урт хугацааны эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмжинэ. Түүнчлэн инфляцын дарамтгүй эдийн засгийн өсөлт нь иргэдийн бодит орлого, амьдралын түвшинг дээшлүүлнэ.

Зураг 5. Инфляц, түүний хэлбэлзэл (улирлаар)



Эх сурвалж: Монголбанк


Цар тахлын дараах эдийн засгийн сэргэлтийн үед инфляцыг тогтворжуулах нь бодлогын чухал зорилт байх болно. Эдийн засаг сэргэхтэй уялдан эрэлтийн шалтгаантай инфляц алгуур нэмэгдэхийн зэрэгцээ шатахууны үнийн өсөлт, тээвэр агуулахын зардлын өсөлт, дэлхий нийтийг хамарсан инфляцын өсөлт зэрэг нийлүүлэлтийн хүчин зүйлс инфляцын дийлэнх хэсгийг бүрдүүлэхээр байна. Инфляц төв банкны зорилтыг түр хугацаанд давах тохиолдолд бодлогын оновчтой хариу үйлдэл үзүүлэх нь эрэлтийн болон нийлүүлэлтийн шалтгааныг зөв таньсаны үндсэн дээр тодорхойлогдох юм.

Монгол Улсын хувьд инфляц цар тахлын өмнөх 3 жилд 8 хувийн орчимд хадгалагдсан бол 2020 онд дунджаар 3.7 хувь буюу зорилтот түвшнээс доогуур байв. Үүнд цар тахлын нөлөөгөөр эрэлт хумигдсаны зэрэгцээ нийлүүлэлтийн болон нэг удаагийн шинжтэй хүчин зүйлсийн үнийн бууралт

голлон нөлөөллөө. Хэрэглээний сагсны 30-40 хувийг импортын бараа, 30 орчим хувийг цаг агаарын төлөв, улирлын онцлог, нэг удаагийн шинжтэй үнэ нь өөрчлөгддөг хүнсний бүтээгдэхүүн, хатуу түлш зэрэг бараа бүтээгдэхүүн эзэлдэг. Харин хэрэглээний үнийн индексийн хэлбэлзлийн 50 орчим хувь нь Хятадын эдийн засгийн өсөлт, гадаадын шууд хөрөнгө оруулалт, зэсийн үнийн хэлбэлзлээр тайлбарлагдаж байгаа бол дотоод талаас нийлүүлэлтийн буюу зардлын шалтгаантай хэлбэлзэл 20 орчим хувийг нь тайлбарлаж байна¹⁴. Иймээс инфляцын хэлбэлзлийн гол хэсэг нь гадаад зах зээлд гарч буй өөрчлөлт болон дотоодын нийлүүлэлтийн шалтгаантай шокоос үүдэлтэй байна. Түүнчлэн гадаад шокоос үүдэлтэй валютын ханшийн өөрчлөлт нь инфляцад хүчтэй нөлөөлсөөр байна.

Цар тахлаас шалтгаалан 2020 оны 2-р улирлаас 2021 оны 1-р улирлыг дуусталх хугацаанд манай улсын инфляц нам түвшинд байсан бөгөөд үүнд хэрэглээний сагсны 10 хувийг бүрдүүлдэг шатахуун, хатуу түлшний үнэ буурсан нь голлон нөлөөлсөн. Харин хүнсний бүлэг, түүн дотроо махны үнэ цар тахлын үед инфляцыг нэмэгдүүлэх чиглэлд нөлөөлж, түүний 20-30 хувийг бүрдүүлээ. Хэрэглээний сагсны үлдсэн 60 гаруй хувийг бүрдүүлдэг бүтээгдэхүүн, үйлчилгээгээр тооцсон инфляцын түвшин дотоод эдийн засгийн нөхцөл байдалтай уялдан алгуур саарч 2 нэгж хувь орчимд хүрсэн. Үүнээс импортын барааны инфляц 1.0 нэгж хувийг бүрдүүлж байв (Зураг 6).

Зураг 6. Инфляцын бүрэлдэхүүн хэсэг (сараар)



Эх сурвалж: Монголбанк

Төв банк инфляцын зорилтот түвшинг бууруулж 2021 оноос эхлэн дунд хугацаанд 6 (+/-2) хувийн орчимд тогтворжуулах зорилтыг тавьсан. Цар тахлын сөрөг нөлөөгөөр эрэлт хумигдаж, инфляц 2020 онд бага түвшинд хадгалагдсан хэдий ч 2021 он гарснаар нэг удаагийн, нийлүүлэлтийн шинжтэй үнийн суурь нөлөө арилж, эрэлтийн шалтгаантай инфляц нэмэгдэж эхэллээ. Ирэх онуудад инфляц зорилтот түвшний орчимд хадгалагдах хүлээлт хэвээр байна (Зураг 6).

Улс орнууд өөрийн онцлог, эдийн засгийн бүтэц, хөгжил зэргээс хамааран инфляцын зорилтот түвшинг харилцан ялгаатай тогтоож байна. Төв банкуудын туршлагаас харахад инфляцын зорилтот түвшинг 1) цэгэн, 2) цэгэн голчтой интервал болон 3) интервалаар тогтоох гэсэн үндсэн 3 арга хэлбэр ашиглаж байна. Жишээлбэл, инфляцыг онилох мөнгөний бодлого хэрэгжүүлдэг 70 гаруй улсаас 2021 оны байдлаар 35 улс нь цэгэн голчтой интервал утгаар инфляцын зорилтот түвшинг тогтоосон байна.

¹⁴ Эх сурвалж: Д.Ган-Очир, Л.Даваажаргал, “Монголын эдийн засгийн том хэмжээний VAR загвар: Гадаад шокын нөлөө” (2019), International Economic Journal, Товхимол 33, Хуудас 42-64.

Хөгжиж буй орнуудын инфляцын хэлбэлзэл хөгжингүй орнуудынхтай харьцуулахад өндөр байдгаас гадна гадаад, дотоод орчны өөрчлөлтөд илүү эмзэг байдаг. Түүнчлэн, хөгжиж буй орнуудын төсвийн сахилга бат сул, санхүүгийн зах зээлийн хөгжил дорой, олон нийтийн төв банкинд итгэх итгэл муу байдаг нь инфляцын хэлбэлзлийг бууруулахад хүндрэл учруулдаг. Иймээс хөгжиж буй орнуудад инфляцын зорилт алдагдах эрсдэлийг бууруулах, эдийн засгийг тогтворжуулахад чиглэсэн бодлого хэрэгжүүлэх нь чухал байдаг. Өөрөөр хэлбэл, инфляцын зорилтыг цэгэн голчтой интервалтай утгаар тогтоох нь төв банкнаас үнийн тогтвортой байдлыг хангахын зэрэгцээ эдийн засгийг тогтворжуулах, богино хугацаанд эдийн засгийн идэвхжилийг дэмжих бодлогын орон зайг нэмэгдүүлэх ач холбогдолтой.

Инфляцын хэлбэлзэл өндөр, төв банкны бодлогоор шууд нөлөөлөх боломжгүй нийлүүлэлтийн хүчин зүйлсийн инфляцад үзүүлэх нөлөө их, гадаад орчны савлагаанд өртөмтгий манай орны хувьд инфляцын зорилтыг цэгэн голчтой интервалаар тогтоох нь тохиромжтой юм. Энэ нь олон нийтийн төв банканд итгэх итгэлийг нэмэгдүүлж, зах зээлд оролцогчдын хүлээлтийг удирдах, улмаар дунд, урт хугацаанд инфляцын өндөр хэлбэлзлийг үргэлжлүүлэн бууруулахад эерэг нөлөөтэй.

Стратеги

- 1. Эрэлтийн шалтгаантай инфляцын дарамтыг зөв таних.** Мөнгөний бодлогын үндсэн хэрэгсэл болох бодлогын хүү нь зээл олголт, хүү, ханш, хөрөнгийн үнэ, хүлээлт зэрэг гол сувгуудаар дамжин хэрэглээ, хөрөнгө оруулалт, экспорт, импортод нөлөөлөх замаар эдийн засгийн идэвхжлийг эрэлт талаас удирдаж, инфляцад нөлөөлнө. Харин цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан тээвэр, логистик, агуулахын саатал гарах, зардал нэмэгдэх зэрэг нийлүүлэлтийн шок, нөгөө талаас дотоод эрэлт сэргэхтэй холбоотойгоор эрэлтийн шалтгаантай үнийн өсөлт бий болж байгаа нь төв банкуудын өмнө инфляцын дарамтыг оновчтой тодорхойлох сорилт болж байна.
- 2. Эдийн засгийн сэргэлтийг удаашруулахгүйгээр инфляцыг дунд хугацаанд тогтворжуулахад чиглэсэн байдлаар мөнгөний бодлогын төлөвийг өөрчилнө.** Цар тахлын дараах эдийн засгийн сэргэлттэй зэрэгцэн үнийн түвшний өсөлт нэмэгдэж байна. Суурь үеийн болон нийлүүлэлтийн шалтгаанаар инфляц зарим тохиолдолд зорилтот түвшнээс давж болох ч инфляцын дарамтыг зөв тодорхойлох замаар түүнийг дунд хугацаанд тогтворжуулах оновчтой мөнгөний бодлогыг хэрэгжүүлнэ. Ингэхдээ эдийн засаг сэргэх үйл явцад сөрөг нөлөө үүсгэхгүй байхаар мөнгөний бодлогын төлөвийг алгуур өөрчлөх бөгөөд мөнгөний бодлогыг хэрэгжүүлэхдээ зах зээлийн зарчимд суурилсан арга хэрэгслийг ашиглаж, хүүгийн нэгдсэн бодлогыг хэрэгжүүлнэ.
- 3. Ирээдүйд чиглэсэн мөнгөний бодлогыг хэрэгжүүлнэ.** Эрэлтийн болон нийлүүлэлтийн гаралтай, бүтцийн эсвэл түр зуурын шинж чанартай шокын нөлөөгөөр инфляцад хэлбэлзэл үүсдэг. Тухайлбал, гадаад зах зээл дээрх түүхий эдийн үнийн хэлбэлзэл, хөрөнгийн урсгалын өөрчлөлт, олон улсын худалдааны гэрээ, тарифын өөрчлөлт, санхүүгийн зах зээл дээрх инноваци, технологи болон дэд бүтэц сайжрах, ган, зуд гэх мэт байгалийн гэнэтийн үзэгдлүүд, төсвийн зардал, бүтээмж, цалин орлогын өсөлт зэрэг хүчин зүйлсийн нөлөөгөөр инфляц тодорхой хугацаанд зорилтот түвшнээс хазайх тохиолдол бий. Тухайн нөхцөлд шокын шалтгаан, шинж чанар, цар хүрээ, үргэлжлэх хугацаа, үнийн түвшинд үзүүлэх нөлөөллийг харгалзан үзэж дунд хугацаанд инфляцыг зорилтот түвшинд хадгалахад чиглэсэн мөнгөний бодлогыг хэрэгжүүлнэ.

Мөнгөний бодлогын хэрэгслээр удирдах боломжгүй инфляцын хэлбэлзлийг бууруулахад эдийн засгийн бусад агентуудын үүрэг чухал юм. Тиймээс дунд, урт хугацаанд инфляцыг нам, тогтвортой түвшинд барихад дараах арга хэмжээ чухал үүрэг гүйцэтгэнэ. Тухайлбал:

- Эдийн засгийг олон тулгууртай болгон төрөлжүүлэх. Ингэснээр валютын ханшийн савалгааг тогтворжуулах, инфляцад шилжих нөлөөллийг бууруулах зэрэг олон талын эерэг нөлөө үзүүлнэ;
- Хөдөлмөрийн бүтээмж, ажиллах хүчний ур чадварыг нэмэгдүүлэх. Энэ нь цалингийн өсөлтийн инфляцад үзүүлэх нөлөөг бууруулна;
- Төсвийн сахилга бат, өрийн зохистой удирдлагыг хэрэгжүүлж, эдийн засгийн хэт халалт, уналтын мөчлөг дагасан бодлогоос зайлсхийх;
- Гадаад худалдаа болон гадаадын шууд хөрөнгө оруулалтын бодлого, тэдгээрийн хууль эрх зүй, татварын орчны зохицуулалтуудыг сайжруулах;
- Барааны нийлүүлэлтийн гинжин хэлхээ, дэд бүтцийг сайжруулах. Энэ нь барааны түр хугацааны хомсдолоос үүдсэн үнийн өсөлтөөс сэргийлэхэд тусална;
- Иргэд, олон нийтийн санхүүгийн суурь мэдлэг, сахилга батыг сайжруулахад чиглэсэн боловсролын үйл ажиллагааг өргөжүүлэх. Ингэснээр иргэдийн хэрэглэх, хуримтлуулах зан төлөвт эерэгээр нөлөөлнө.

Хэрэгжүүлэх арга хэмжээ

- Мөнгөний бодлогын шийдвэрийг Мөнгөний бодлогын хороогоор хэлэлцэж, хараат бусаар, хамтын зарчимд тулгуурлан гаргах. Мөнгөний бодлогын хороог жилд 4-өөс доошгүй удаа хуралдуулах бөгөөд хурлын товгыг оны эхэнд зарлана. Хорооноос гарсан шийдвэр эдийн засагт оролцогчдын үйл хөдлөлд нөлөөлөх замаар инфляцын хүлээлтийг удирдахад чухал ач холбогдолтой юм.
- Мөнгөний бодлого боловсруулж шийдвэр гаргах үйл явцыг сайжруулж, бодлогын шийдвэрийн үндэслэл, холбогдох тооцоо, судалгааны чанарыг сайжруулах ажлыг үргэлжлүүлэх. Энэ хүрээнд:
 - Макро эдийн засгийн үзүүлэлтүүдийн харилцан хамаарал, мөнгөний бодлогын шилжих сувгийн талаарх судалгааг өргөжүүлэх;
 - Эдийн засгийн шинжилгээ, төсөөлөл, учирч болзошгүй эрсдэлүүдийг тодорхойлоход шаардлагатай тоон болон чанарын мэдээллийн баазыг өргөтгөх;
 - Төсөөлөл, симуляци хийх шинжилгээний загваруудыг сайжруулж, хөгжүүлэх;
 - Олон улсын байгууллагууд, төв банкууд, судалгааны байгууллагуудтай хамтран шинжилгээ, тооцоолол дээр ажилладаг экспертүүдийн ур чадварыг тогтмол дээшлүүлэх;
- Мөнгөний бодлогын олон нийттэй харилцах харилцааг өргөжүүлж, үр дүнтэй байдлыг дээшлүүлэх арга хэмжээг авч ажиллах

ЗОРИЛТ 1.2

Ковид-19 цар тахлын хүндрэлийг даван туулах, эдийн засгийн сэргэлт, дунд хугацааны макро тогтвортой байдлыг дэмжсэн зээлийн тогтвортой өсөлтийг хангаж, банкны системд эрсдэл хуримтлагдахаас сэргийлсэн макро зохистой бодлогыг мөнгөний бодлоготой хослуулан хэрэгжүүлнэ.

Үндэслэл

Монголбанк нь мөнгөний бодлогын үр нөлөөг нэмэгдүүлэх, макро эдийн засгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх, санхүүгийн системд эрсдэл хуримтлагдаж бодит эдийн засагт сөргөөр нөлөөлөхөөс сэргийлэх зорилгоор макро зохистой бодлогыг мөнгөний бодлоготой хослуулан хэрэгжүүлж байна.


Дэлхийн санхүүгийн 2008-2009 оны хямралын дараа улс орнуудын туршлага нь дан ганц мөнгөний бодлогоор санхүүгийн системд үүссэн хүндрэлийг зөөлрүүлж, мөчлөгийн далайцыг бууруулах боломжгүй болохыг нотолсон бөгөөд сүүлийн 10 гаруй жилийн турш зохицуулагч

байгууллагууд макро зохистой бодлогын арга хэрэгслийг хөгжүүлэх, шинжилгээний арга зүйг сайжруулах, институцийн чадавхыг бэхжүүлэх чиглэлд эрчимтэй ажиллаж байна. Ялангуяа зарим хөгжингүй орнуудад банкуудын өөрийн хөрөнгийн хүрэлцээг нэмэгдүүлэх, нөөц эрсдэлийн сан үүсгэх зэргээр хөрөнгийн нөөцийг бүрдүүлж байсан нь Ковид-19 цар тахлаас үүдэлтэй банк, санхүүгийн системд үүссэн хүндрэлийг даван туулахад дэмжлэг үзүүлэв. Түүнчлэн, макро зохистой бодлогын арга хэрэгслээр дамжуулан цар тахлын банк, санхүүгийн системд үзүүлэх сөрөг нөлөөг зөөлрүүлж, системийн эрсдэл үүсэхээс сэргийлэх арга хэмжээг өргөн хүрээнд хэрэгжүүллээ. Тодруулбал, 2020 оны эхний улиралд дэлхийн улс орнуудын авч хэрэгжүүлсэн бодлогын арга хэмжээний 40 хувийг макро зохистой бодлогын арга хэрэгслүүд бүрдүүлж байна.

Манай улсын хувьд Ковид-19 цар тахлаас үүдэн 2020 онд эдийн засаг болон санхүүгийн мөчлөгийн огцом уналт бий болж, санхүүгийн системд эрсдэл хуримтлагдах нөхцөл үүссэнийг харгалзан иргэд, аж ахуй нэгжүүдийг хамгаалах, банкны секторын тогтвортой байдлыг хангахад чиглэсэн зохицуулалтын арга хэмжээг шуурхай хэрэгжүүлж ажиллалаа. Эргэн төлөлт нь доголдсон хэрэглээний зээлд бүтцийн өөрчлөлт хийж хугацааг сунгах, орон сууцны хөнгөлөлттэй хүүтэй зээлийн эргэн төлөлтийг хойшлуулах, “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-д онцгой нөхцөл байдал үүссэн хугацаанд мөрдөх нэмэлт, өөрчлөлтийг оруулах зэргээр холбогдох зохицуулалтын арга хэмжээг авлаа. Үүний үр дүнд 2021 оны 6 дугаар сарын байдлаар төлбөрийн хүндрэлд орсон 146,704 зээлдэгчийн 1.2 их наяд төгрөгийн хэрэглээний зээл, 2,249 ААН-ийн 2.6 их наяд төгрөгийн бизнесийн зээл, 59,926 өрхийн 3.1 их наяд төгрөгийн ипотекийн зээлийн эргэн төлөлтийг хойшлуулаад байна. Өөрөөр хэлбэл, банкны системээс гаргасан нийт зээлийн 27.2 хувьд бүтцийн өөрчлөлт хийсэн байна.


2021 он гарснаас хойш дэлхий дахинд эдийн засаг, санхүүгийн зах зээл сэргэж, эрдэс бүтээгдэхүүний үнэ өсч, гадаад орчинд эерэг өөрчлөлтүүд гарсантай зэрэгцэн 2020 онд уналттай байсан бизнес, санхүүгийн мөчлөг 2021 оны 1 дүгээр улирлаас сэргэж эхэллээ (Зураг 7). Түүнчлэн, Ковид-19 цар тахлаас шалтгаалан буурч байсан зээл олголт энэ оны эхнээс нэмэгдэж, 2021 оны 6 дугаар сарын эцсийн байдлаар нийт зээл өмнөх оны мөн үеэс 10.3 хувиар өссөн дүнтэй байна (Зураг 8). Зээл олголт ийнхүү нэмэгдэж байгаа нь иргэд, аж ахуй нэгжүүдийн төлбөрийн чадварт дэмжлэг үзүүлж байгаа бөгөөд цаашид зээлийн өсөлтийг дотоод эдийн засгийн нөхцөл байдал, макро орчинтой уялдуулан тогтвортой хадгалах шаардлага үүсч байна.

Зураг 7. Санхүүгийн мөчлөг (улирлаар)



Эх сурвалж: Монголбанк

Зураг 8. Зээлийн жилийн өсөлт (улирлаар)



Эх сурвалж: Монголбанк

Гэвч зээлийн хэт өсөлт нь системийн эрсдэл хуримтлагдах нөхцөлийг бүрдүүлж, банкны салбарын хямралыг өдөөгч нэг хүчин зүйл болдгийг дэлхийн санхүүгийн хямрал, ялангуяа 2008-2009 оны хямралаас харсан¹⁵. Түүнчлэн, дотоод эрэлтээр бус нийлүүлэлтээр өдөөгдсөн зээлийн хэт өсөлт нь зээл чанаргүйдэх эрсдэлийг нэмэгдүүлэх бөгөөд нэгэнт зээлийн эрсдэлтэй холбоотойгоор алдагдал хүлээж эхэлсэн зээлдэгч зээлийн нөхцөлөө хатууруулж, зээл олголтоо бууруулж эхэлдэг. Энэхүү цикл удаан хугацаанд үргэлжилвэл банк, санхүү, макро эдийн засгийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөх тул дотоод эдийн засгийн нөхцөл, макро орчинтой уялдуулж, зээлийн тогтвортой өсөлтийг хангах нь бодит эдийн засагт дэмжлэг үзүүлэх чухал хүчин зүйл болох юм (Зураг 9). Дэлхийн улс орнууд зээлийн хэт өсөлтийг хязгаарлах макро зохистой бодлогын арга хэрэгслүүдийг нэвтрүүлэн хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд сүүлийн жилүүдэд мөчлөг сөрсөн өөрийн хөрөнгийн нөөц сан, системийн эрсдэлийн санг бүрдүүлэх, хөшүүргийн харьцааг хугацааны хувьд ялгаатай тогтоох, зээлдэгчдэд шууд хандсан буюу зээл-үнэлгээний харьцаа, зээл-орлогын харьцаанд хязгаар тогтоох зэрэг арга хэрэгслийг өргөнөөр хэрэглэж байна. Манай улсын хувьд мөн адил зээлийн өсөлтийг тогтворжуулахад чиглэсэн макро зохистой бодлогын оновчтой арга хэрэгслийг тодорхойлж, шаардлагатай тохиолдолд бодлогын арга хэмжээг хэрэгжүүлж ажиллах нь цар тахлын үеийн банкны салбарын болзошгүй хүндрэлээс сэргийлж, тогтвортой санхүүгийн салбарын суурийг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх юм.

Зураг 9. Макро эдийн засаг-Санхүүгийн зах зээлийн харилцан хамаарал¹⁶



Үүний зэрэгцээ, зээлдэгчийн төлбөрийн чадварыг харгалзан зээлийн төлбөр, хугацаа зэрэгт хөнгөлөлт үзүүлэх замаар өрийн дарамтыг нь бууруулж, банк, санхүүгийн тогтвортой байдлыг хангаж ажиллах нь цар тахлын үеийн нэг чухал сорилт болоод байна. Иймд ирэх онд макро зохистой бодлого, санхүүгийн зохицуулалт нь дотоод эдийн засгийн нөхцөл байдал, макро орчинтой уялдсан зээлийн тогтвортой өсөлтийг хангахад чиглэхийн зэрэгцээ цар тахлын үеийн эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулж, зээлдэгчийн өрийн дарамтыг харгалзан хөнгөлөлт үзүүлэх зэргээр санхүүгийн системийн тогтвортой байдлыг хадгалах шаардлага үүсэж байна. Цаашлаад санхүүгийн системд хуримтлагдаж болзошгүй эрсдэлийг тогтмол хянаж, сөрөг нөлөөг урьдчилан тооцож, банк, санхүүгийн тогтвортой байдлыг хадгалахад чиглэсэн макро зохистой бодлогыг үргэлжлүүлж, мөнгөний бодлоготой хослуулан хэрэгжүүлэх нь чухал юм.

¹⁵ Эх сурвалж: Lucia Alessi and Carsten Detken, “Identifying excessive credit growth and leverage” (2014), European central bank, Working paper series No.1723, p.5-6

¹⁶ Эх сурвалж: Jaromir Benes, Inci Otter-Robe, and David Vavra, “Modeling with Macro-Financial linkages: Credit and policy shocks in emerging markets” (2009), IMF working paper, WP/09/123, p.19.

Стратеги

Монголбанк макро зохистой бодлогыг тодорхойлж, хэрэгжүүлэхдээ дараах стратегийг баримтлан ажиллана. Үүнд:

- Санхүүгийн системд эрсдэл учруулах макро хүчин зүйлсийн эрсдэлийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, түүнд чиглэсэн макро зохистой бодлогын арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- Бодит эдийн засаг болон санхүүгийн салбар хоорондын харилцан хамаарал, гадаад орчны нөлөөг нарийвчлан тодорхойлох шинжилгээний арга зүйг хөгжүүлнэ.
- Системийн эрсдэлийн шинжилгээ, стресс тест, бодлогын үр нөлөөг тодорхойлох шинжилгээний арга зүйг олон улсын туршлагад үндэслэн судалж, макро эдийн засаг, санхүүгийн системийн бүтцэд нийцүүлэн макро зохистой бодлогын шинжилгээний цогц арга зүйг хөгжүүлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ

- Банкны системийн эрсдэлийг шинжлэх, макро зохистой бодлогын үр нөлөөг тооцох шинжилгээний аргачлал, индикаторуудыг олон улсын туршлагад нийцүүлэн хөгжүүлж, бодлогын шийдвэр гаргалтанд нэвтрүүлэх
- Зээлийн өсөлтийг тогтворжуулахад чиглэсэн макро зохистой бодлогын оновчтой арга хэрэгслийг тодорхойлж, холбогдох бодлогын арга хэмжээг авч ажиллах
- Банкны системийн тогтвортой байдлын эрсдэлийг тогтмол хянаж, шаардлагатай тохиолдолд макро зохистой бодлогын арга хэмжээг хэрэгжүүлж ажиллах
- Санхүүгийн мөчлөгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, мониторинг хийх

ЗОРИЛТ 1.3

Төв банкны олон нийттэй харилцах харилцааг хөгжүүлж, бодлогын ил тод байдлыг хадгалж ажиллана.

Үндэслэл

Ковид-19 цар тахлын үеийн тодорхой бус байдлыг бууруулахад төв банкны ил тод байдал, олон нийттэй харилцах харилцаа чухал үүрэг гүйцэтгэж байна. Төв банкуудын хувьд зах зээл дээрх хүлээлтийг удирдах нь санхүүгийн зах зээлд үүссэн савлагааг тогтворжуулж, эдийн засгийн хямралыг хохирол багатай даван туулахад чухал ач холбогдолтой юм. Түүнчлэн, цар тахлын дараах эдийн засгийн сэргэлт зах зээлд оролцогчдын хүлээлт ямар байхаас ихээхэн шалтгаалах тул үр дүнтэй олон нийттэй харилцах харилцаа чухал хэвээр байна.

Төв банкны олон нийттэй харилцах харилцаа нь: (1) төв банкны үндсэн зорилт, (2) үндсэн зорилтоо биелүүлэхийн тулд хэрэгжүүлэх мөнгөний бодлогын стратеги, арга хэлбэр, (3) эдийн засгийн төлөв ба түүнтэй уялдуулан гаргасан бодлогын шийдвэрийн үндэслэл, (4) цаашид хүлээгдэж буй эрсдэлүүд болон авч хэрэгжүүлэх арга хэмжээ зэргийг эдийн засагт оролцогчдод тайлбарлах үйл ажиллагааны цогц юм. Төв банкны олон нийттэй харилцах харилцаа нь зах зээлд оролцогчдын мэдээллийн тэгш бус байдлыг бууруулах, мөнгөний бодлогын ил тод байдлыг нэмэгдүүлэх замаар төв банкинд итгэх итгэлийг дээшлүүлж, бодлогын үр нөлөөг сайжруулна.

Стратеги

Монголбанкны олон нийттэй харилцах харилцааг өмнөх туршлагад тулгуурлан цаг үеийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн тасралтгүй сайжруулахын зэрэгцээ олон улсын төв банкуудын сайн туршлагыг нэвтрүүлэх замаар боловсронгуй болгоно. Олон нийтэд түгээх мэдээллийн агуулга, түүнийг түгээх сувгуудыг хөгжүүлэхдээ зорилтот бүлгийн онцлогт нийцүүлэн мэдээллийг хүргэнэ.

1. Олон нийтэд түгээх мэдээллийн агуулга

- Төв банкны хуулиар ногдсон үндсэн зорилт, мөнгөний бодлогын арга хэлбэр, бодлогын шийдвэрүүд ба тэдгээрийн үндэслэлийг энгийн ойлгомжтой тайлбарлана;
- Мөнгөний болон макро зохистой бодлогын үндсэн зорилт, арга хэлбэр, бодлогын шийдвэрийн үндэслэлийг олон нийтэд тайлбарлана;
- Шаардлагатай үед санхүүгийн зах зээлийг төөрөгдүүлэх мэдээллийг залруулах, эдийн засгийн дотоод, гадаад орчны төлөвийг тайлбарлана;
- Төв банкны эдийн засагт гүйцэтгэх үүрэг, оруулах хувь нэмрээс гадна мөнгөний бодлогын хэрэгслээр удирдах аргагүй хүчин зүйлсийг тайлбарлана

2. Мэдээлэл түгээх суваг

- Эдийн засаг, санхүүгийн салбар дахь цахим шилжилтэд төв банк манлайлж оролцон технологийн дэвшилтэд шийдлийг ашиглан мэдээллийн шуурхай бөгөөд хүртээмжтэй байдлыг дээшлүүлнэ.
- Төв банкны олон нийттэй харилцах сувгуудыг олон улсын сайн туршлага, зорилтот бүлгүүдийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэхээр тогтмол хөгжүүлнэ.

3. Зорилтот бүлэг

- Мэдээлэл түгээхдээ санхүүгийн зах зээлийн мэргэжлийн оролцогчид, төрийн шийдвэр гаргах байгууллагууд, олон улсын байгууллагууд, судалгааны байгууллагууд, хэвлэл мэдээллийн байгууллагууд болон иргэд, аж ахуйн нэгжүүд тус бүрийн онцлог, хэрэгцээ шаардлагад тохирсон арга хэлбэрийг сонгоно.
- Төв банк олон нийттэй харилцахдаа зорилтот бүлгүүдийн онцлогийг нарийвчлан тодорхойлсны үндсэн дээр тохирсон арга хэлбэрээр мэдээллийг түгээнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ



- Мөнгөний бодлогын шийдвэрийн үндэслэл болсон тооцоолол шинжилгээ, төсөөллүүдийг багтаасан Инфляцын тайлангийн чанар, агуулгыг тогтмол сайжруулах. Үүний тулд:
 - Тооцоо шинжилгээнд ашигладаг тоон мэдээллийн чанарыг сайжруулж, ашигладаг загваруудыг хөгжүүлэх
 - Тайлан боловсруулдаг мэргэжилтнүүдийн ур чадварыг дээшлүүлэх, улмаар төсөөллийн нарийвчлал, тайлангийн загвар дизайн, ойлгомжтой байдлыг тогтмол сайжруулах
 - Дэлхийд тэргүүлэх төв банкуудын сайн туршлагын элементүүдийг нэвтрүүлэх, олон улсын экспертүүдийн өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх
 - Хэрэглэгчдийн судалгаан дээр үндэслэн тайланд шаардлагатай сайжруулалтууд, өөрчлөлтийг тогтмол хийх
- Мөнгөний бодлогын мэдэгдлийн загварыг тогтсон хэлбэрт оруулж, олон улсын экспертүүдийн өгсөн зөвлөмжүүдийг нэвтрүүлэх
- Мөнгөний бодлогын хорооны шийдвэрийг танилцуулах хэвлэлийн хурлын нээлтийн илтгэлийг агуулга, чанарыг сайжруулах
- Мөнгөний бодлогын шийдвэрийг танилцуулах хэвлэлийн хурлыг урьдчилж товлосон хуваарийн дагуу зохион байгуулж, хурлаар түгээсэн мэдээллийг зорилтот бүлгүүдэд үр дүнтэй хүрэх сувгуудаар түгээх
- Мөнгөний бодлоготой холбоотой контентуудыг тогтсон давтамжтайгаар, урьдчилж зарласан хуваарийн дагуу олон нийтэд хүргэх үүднээс дотоод үйл ажиллагаа, мэдээлэл дамжих процессийг илүү үр ашигтай болгох
- Олон нийтийн дунд төөрөгдөл үүсгэх эрсдэлийг хаах, Төв банкнаас түгээж буй мэдээллийн үр дүнг дээшлүүлэх зорилгоор олон нийттэй харилцах харилцах стратегийг сайжруулах
- Төв банкны олон нийттэй харилцах харилцаанд ашиглагдаж буй сувгуудад үнэлэлт дүгнэлт өгч, үр дүнтэй байдлыг хэмжиж шаардлагатай өөрчлөлт сайжруулалтуудыг хийх
- Мэдээлэл түгэх орчин эрчимтэй цахим хэлбэрт шилжиж байгаатай холбоотойгоор мэдээллийг үр дүнтэй түгээх технологийн дэвшлүүдийг нэвтрүүлж, ашиглах
- Мэдээллийн хүртээмж бага орон нутагт мэдээлэл түгэх үр дүнтэй сувгуудыг хөгжүүлэх
- Залуу үеийн хэрэглээнд нийцсэн мэдээллийн сувгуудыг хөгжүүлэх, контент боловсруулж түгээх
- Мөнгөний бодлогын шийдвэр, үндэслэлийг олон нийт илүү ойлгоход дэмжлэг үзүүлэх зорилгоор зорилтот бүлгүүдэд чиглэсэн эдийн засгийн суурь мэдлэгийг түгээх

БАНКНЫ САЛБАРЫН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ХҮРЭЭНД

ЗОРИЛТ 2.1.

Эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан банкны салбарын хяналт шалгалт, зохицуулалтын арга хэрэгслийг олон улсын стандартад нийцүүлэх арга хэмжээг үргэлжлүүлж, цар тахлын эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах хүрээнд мөрдөгдөж буй зохицуулалтыг ердийн нөхцөлд шилжүүлэх төлөвлөгөөг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

Үндэслэл

Монголбанкаас банк, санхүүгийн салбарын эрх зүйн шинэтгэлийн хүрээнд хяналт шалгалтын олон улсын сайн туршлага, зарчим, зохицуулалтыг манай улсын банкны системийн онцлогт нийцүүлэн, шат дараатайгаар нэвтрүүлэх, эрсдэлд суурилсан хяналт шалгалтын арга барилд шилжих ажлуудыг үргэжлүүлж байна.

Олон улсын түвшинд “Банкны хяналт шалгалтын Базелын хороо”-ноос санхүүгийн байгууллагын үйл ажиллагаа, зохистой засаглал, төлбөрийн чадварын үзүүлэлтүүд болон үр нөлөөтэй хяналт шалгалтад баримтлах зарчимд нийтлэг шалгуур тогтоож, харьцуулах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор цуврал стандартыг боловсруулан гишүүн орнуудад мөрдүүлж ирсэн.

Манай улсын хувьд банкны төлбөрийн чадвар, өөрийн хөрөнгийн хүрэлцээ, актив хөрөнгийн ангилал, зохистой засаглалын шаардлагыг боловсронгуй болгох, Монголбанкаас тавих хяналт шалгалтыг үр нөлөөтэй хэрэгжүүлэхэд мөрдөх журам, зааврыг шинээр боловсруулах, шинэчлэн батлах, нэмэлт өөрчлөлт оруулах ажлуудыг 2020-2021 онд хийж гүйцэтгэлээ. Цаашид эдгээр шинэчилсэн хяналт шалгалтын журам, зохицуулалтыг мөрдүүлэх ажлыг цар тахлын улмаас үүсээд буй нөхцөл байдалтай уялдуулан шат дараатайгаар хэрэгжүүлнэ.

Базел стандартын Бүлэг 1-д тусгагдсан өөрийн хөрөнгийн зохистой харьцааны доод түвшин нь: 1) банканд учирч болох бусад эрсдэл, 2) эрсдэлд нөлөөлдөг хүчин зүйлс (ялангуяа чанарын), 3) банкны эрсдэлд оруулах гадаад орчны нөлөөлөл, эдийн засгийн мөчлөгийн уялдаа зэргийг тусгаагүй тул цаашид өөрийн хөрөнгийн шаардлагыг тооцохдоо Бүлэг 2 “Хяналт шалгалтын үйл ажиллагаа”-г түлхүү нэвтрүүлж, зохистой харьцааны үзүүлэлтэд тусгах шаардлагатай байна.

Бүлэг 2 нь банк эрсдэлээс сэргийлэх хангалттай хэмжээний өөрийн хөрөнгөтэй байх, эрсдэлийн удирдлагыг сайжруулах, банк тус бүрийн үйл ажиллагаа, бизнесийн цар хүрээний онцлогт тулгуурлан хяналтын зохистой тогтолцоо бүрдүүлэхийг шаарддаг. Цаашид Монголбанкаас Европын холбооны сайн туршлагад үндэслэн Базел стандартын Бүлэг 2-ыг хэрэгжүүлэхийг зорьж ажиллана.

Цар тахлын үед банкуудад мөрдүүлж буй зохицуулалтын хүрээнд 2021 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт 252,257 зээлдэгчийн 7.9 их наяд төгрөгийн зээл цар тахалд өртсөнөөс 68 хувь буюу 185,671 зээлдэгчийн нийт 5.37 их наяд төгрөгийн зээлд бүтцийн өөрчлөлт хийжээ. Сүүлийн 14 сарын хугацаанд системийн зээлийн дундаж хугацаа 4.2 сар буюу 128 хоногоор уртассан бөгөөд бүтэц өөрчилсөн зээлийн дундаж хугацаа 83.5 сар болж 28.7 сараар системийн дунджаас урт байна. Энэ нь бүтцийн өөрчлөлт хийх хөнгөлөлтийн арга хэмжээ нь зээлийн дундаж хугацаанд өндөр нөлөө үзүүлсэн байгааг харуулж байна.

Тус зохицуулалтын арга хэмжээг хэт удаан хугацаанд хэрэгжүүлэх нь санхүүгийн салбарт аажмаар эрсдэл хуримтлагдах, ёс суртахууны гажуудал (moral hazard)-ыг нэмэгдүүлэх зэрэг сөрөг үр дагавартай тул цаашид зөвхөн цар тахалд өртсөн бөгөөд бүтцийн өөрчлөлт хийгдээгүй байгаа зээлийг уг арга хэмжээнд хамруулах зохицуулалтын арга хэмжээг авах нь зүйтэй байна.

Иймд цар тахлын эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах хүрээнд мөрдүүлж буй зохицуулалтыг ердийн нөхцөлд шилжүүлэх төлөвлөгөөг 2021 оны 6 дугаар сард баталсны дагуу банкны үйл ажиллагааны зохистой харьцаа, актив хөрөнгийг ангилахтай холбоотой шаардлагуудыг шат дараатайгаар хэвийн горимд шилжүүлэх болно.

Стратеги

- Ковид-19 цар тахлын банк, санхүүгийн салбарт үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах хүрээнд хэрэгжүүлж буй мөчлөг сөрсөн бодлогын арга хэмжээ, зохицуулалтыг эдийн засгийн сэргэлттэй уялдуулан шат дараатайгаар ердийн нөхцөлд шилжүүлнэ.
- Банкны өөрийн хөрөнгийн зохистой харьцаа, активын ангилал, хөрвөх чадварын үзүүлэлт болон хяналт шалгалтын хүрээнд банкуудад тавигдах шаардлагыг Базелын цуврал стандарттай нийцүүлэн нэвтрүүлнэ.
- Банкны салбарын эрсдэл даах чадвар болон тогтвортой өсөлтийг хангах зорилгоор банкны хяналт шалгалтын хүрээнд тогтоосон олон улсын стандарт, банкны тухай хууль тогтоомжийг мөрдүүлэхэд бусад эрх бүхий байгууллагуудтай хамтран ажиллана.

Хэрэгжүүлэх арга хэмжээ

- “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-ын хүрээнд цар тахлын үед мөрдүүлж буй зохицуулалтыг эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан журмын ердийн нөхцөлд шилжүүлэх
- “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”-ын дагуу бүрдүүлэх шаардлагатай, банкнийг эрсдэлээс хамгаалах зориулалт бүхий нөөц интервалыг эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан мөрдүүлэх
- Банкны үйл ажиллагаанд шинэчлэн тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг банкуудад нэвтрүүлэх ажлыг үргэлжлүүлж, хэрэгжилтэд хяналт тавих
- Базелын цуврал стандартын холбогдох хэсгүүд, банкны актив хөрөнгөд ангилал тогтоох аргачлалыг нэвтрүүлэх, банкны хяналт шалгалт зохицуулалтын талаарх хэм хэмжээ тогтоосон акт, шийдвэрийг гаргаж мөрдүүлэх
- Базел стандартын Бүлэг 2-т заасан банкуудын өөрийн хөрөнгийн хүрэлцээг дотооддоо үнэлэх аргачлал (ICAAP)-ыг банкны системд үзүүлэх нөлөөлөлд үндэслэн шат дараатайгаар нэвтрүүлэх ажлыг эхлүүлэх

ЗОРИЛТ 2.2.

Банк хувьцаат компани хэлбэрээр үйл ажиллагаа явуулах хууль, эрх зүйн шаардлагын хүрээнд хяналт шалгалт, зохицуулалтыг боловсронгуй болгож мөрдүүлнэ.

Үндэслэл

Монгол Улс хоёр шатлалт банкны тогтолцоонд шилжсэнээс хойш хүчин төгөлдөр үйлчилж байгаа банкны хууль тогтоомжид банкнийг үүсгэн байгуулах хэлбэрт аливаа шаардлага, хязгаарлалт тавигдаж байгаагүй бөгөөд үйл ажиллагаа эрхэлж буй бүх банкууд хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хэлбэрээр үүсгэн байгуулагдсан, хувь эзэмшлийн төвлөрөл өндөртэй, цөөн тооны нөлөө бүхий хувьцаа эзэмшигчидтэй байх нийтлэг бүтэцтэй байна.

Эдийн засгийн шинжлэх ухааны чухал судлагдахуун болох “Төлөөллийн онол” компанийн хувьцааны эзэмшигчийн өмчлөл ба компанийн удирдлага хоорондын харилцан хамаарлыг тогтоосныг ашиглан судлаачдын зүгээс банкны хувьцаа эзэмшлийн төвлөрөл хэмжээ ба банкны эрсдэл, үйл ажиллагааны тогтвортой байдлын шууд хамаарлыг тогтоожээ. Монгол Улсын хувьд энэхүү судалгааны үр дүнг өнөөгийн байдалд буулгаж үзвэл банкуудын хувьцаа эзэмшил нь 1-3 тооны хувьцаа эзэмшигчдэд хэт төвлөрч, өмчлөл-хяналтын харилцан тэнцвэр алдагдаж ашиг

сонирхлын зөрчлөөс үүдэлтэй банкны хүлээж болох эрсдэлийн түвшин нэмэгдсэн, энэ нь зарим тохиолдолд банкныг төлбөрийн чадваргүй болгон төр, нийт хохирох байдал гарч байна.

Олон улсын судалгааны ажлуудад хувь эзэмшлийн төвлөрлийн талаар дараах дүгнэлтүүдийг хийсэн байна. Үүнд:

- Ойрх дорнод буюу Арабын орнуудын хувьд аливаа төрлийн хувь эзэмшлийн төвлөрөл өндөр байх тусам банкны санхүүгийн тогтвортой байдалд нөлөөлдөг бөгөөд санхүү төлбөрийн чадваргүй болох эрсдэл ихтэй байдаг нь тогтоогджээ. Гэхдээ энэхүү эрсдэл нь аль нэг төрлийн хувьцаа эзэмшилтэй (төрийн, гэр бүлийн, байгууллагын гэх мэт) тусгайлан холбогдоогүй байна.
- Европын арилжааны банкуудад хийсэн судалгаагаар хувь эзэмшлийн төвлөрөл өндөртэй банкууд орлогоо тогтвортой харагдуулахын тулд зээлийн эрсдэлийн санг өөрсдийн үзэмж, тооцоололд үндэслэн тогтоодог талаар дүгнэсэн. Энэхүү хандлага нь хяналт шалгалтын шаардлага өндөртэй, аудитыг өндөр чанартай гүйцэтгэдэг улс орнууд болон хувь эзэмшлийн төвлөрөл багатай банкуудад харьцангуй бага ажиглагджээ. Иймд хяналтын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн хувь эзэмшлийг хязгаарлах эсвэл хяналт шалгалтыг нэмэгдүүлж, хөндлөнгийн аудитын чанарыг сайжруулахыг судалгааны материалд зөвлөсөн байна.
- Европын ХК болон ХХК хэлбэртэй арилжааны банкуудын хувьд хувь эзэмшлийг судалсан судалгаагаар ХХК хэлбэртэй банкуудын эрсдэлийн түвшинд хувь эзэмшлийн бүтэц ихээхэн нөлөөтэй гэж гарчээ. Томоохон хөрөнгө оруулагч болон санхүүгийн бус компаниуд нь их хэмжээний хувь эзэмшдэг банкны хувьд илүү эрсдэлтэй стратеги, үйл ажиллагааг эрхлэх хандлагатай байна. Харин ХК хэлбэртэй банкуудын хувьд хувь эзэмшлийн бүтэцэд орсон өөрчлөлт нь эрсдэлтэй үйл ажиллагаанд илүү ихээр хөрөнгө оруулахтай хамааралгүй байсан боловч ХК хэлбэртэй банкинд өндөр хувь эзэмшдэг тохиолдолд зээлийн дефолт болох эрсдэл багатай байжээ.
- Азийн орнуудад хийсэн судалгаагаар хувь эзэмшлийн төвлөрөл нэг стандарт хазайлтаар нэмэгдэхэд эрсдэл хүлээх сонирхол (risk-taking) 6-8 хувиар нэмэгдэх тооцоо гарсан. Энэ нь банкууд хувь эзэмшлийн төвлөрлөө нэмэгдүүлэх тусам илүү эрсдэлтэй үйл ажиллагаанд хөрөнгө оруулах төлөвтэйг харуулж байна.
- Тайваны банкуудад хийсэн судалгаагаар дотоодын (inside management) болон Засгийн газрын хувь эзэмшил өндөртэй банкуудын хувьд хугацаа хэтэрсэн зээлийн хэмжээ өндөр, өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт доогуур байсан байна. Харин гадаадын хувь эзэмшил өндөртэй, засаглал сайтай банкуудын хувьд хугацаа хэтэрсэн зээлийн хэмжээ багатай, өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт сайн байжээ.

Монгол улсад үйл ажиллагаа явуулж байгаа банкууд тайлан мэдээллээ олон нийтэд дэлгэрэнгүй байдлаар мэдээлэх, хөрөнгийн биржээс тавигдах засаглал, ил тод байдлын шаардлагыг дагах шаардлагагүй, харьцангуй хаалттай орчинд үйл ажиллагаа явуулдаг бөгөөд Монголбанкаас банкуудад хийх хяналт шалгалт нь тодорхой давтамжтай байх тул хувь эзэмшлийн төвлөрөл өндөртэй банкуудын эрсдэлтэй үйл ажиллагаанд тухай бүр хяналт тавих боломж хязгаарлагдмал байна.

Иймд банкны хувьцаа эзэмшилд тавигдах тоо хэмжээний хязгаарлалтыг тогтоож, банкны үйл ажиллагааг хувьцаат компанийн хэлбэрээр явуулах шаардлагыг Улсын Их Хурлын 2021 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн нэгдсэн чуулганаар баталсны дагуу Банкны тухай хуульд оруулж, олон нийтийн төлөөллийг банкны хувь эзэмшлийн бүрэлдэхүүнд оруулах замаар өмчлөл-удирдлага-хяналтын тэнцвэртэй байдлыг бүрдүүлэх, засаглалын орчин, давхар хяналтын үйл ажиллагааг сайжруулах ач холбогдол бүхий эрх зүйн орчныг бүрдүүллээ.

Түүнчлэн хувьцаат компани хэлбэрээр өөрчлөн байгуулагдаж, шинэ хөрөнгө оруулалт татах нь банкны өөрийн хөрөнгийн бүтэц, чанарыг сайжруулж эрсдэл даах чадварыг нэмэгдүүлэх ба банкны үйл ажиллагааны олон улсын стандартыг нэвтрүүлэх, банкны хяналт шалгалт, бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлж, хөрөнгийн зах зээлийн хөгжил, банкин дахь олон нийтийн оролцоо хяналтыг бий болгох ач холбогдолтой юм.

Банкны тухай хуулийн дээрх нэмэлт, өөрчлөлтийн дагуу 2022 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор банкны системд нөлөө бүхий банкууд нээлттэй хувьцаат компани, бусад банкууд хувьцаат компани хэлбэртэйгээр өөрчлөн байгуулагдах шаардлагатай.

Банкны тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд Монголбанкаас банкны үйл ажиллагааг зохицуулах журам, захиргааны хэм хэмжээний актыг шинээр боловсруулж байна. Банкийг үүсгэн байгуулах, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцэд өөрчлөлт оруулахтай холбоотой харилцаа, банкны нэгдлийн хяналт шалгалт, банкны үйл ажиллагааны зөвшөөрлийг төрөлжүүлэх, төрөлжсөн банканд тавигдах шалгуур, шаардлагыг тодорхойлох, зохицуулах зорилго бүхий журмуудыг шат дараатайгаар Захиргааны ерөнхий хуулийн дагуу боловсруулан баталж, мөрдүүлнэ. 2021 оны 9 дүгээр сарын байдлаар “Банкны системд нөлөө бүхий банкийг тогтоох аргачлал”, “Банкийг хувьцаат компани хэлбэртэйгээр өөрчлөн байгуулах, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өөрчлөх төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх, тайлагнах, хянах түр журам”-ыг баталж, “Хувьцаат компани хэлбэртэй банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцэд өөрчлөлт оруулах зөвшөөрлийн журам”-ыг батлахаар ажиллаж байна.

Цаашид үнэт цаасны зах зээлийн тухай хууль, тогтоомжтой нийцүүлэн банкны хяналт шалгалтын журам, зохицуулалтыг шинэчлэн боловсруулах, мэдээллийн сангийн дэд бүтцийг бүрдүүлэх чиглэлээр Санхүүгийн зохицуулах хороо, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв, хөрөнгийн биржүүдтэй хамтран ажиллана.

Стратеги

- Банкны тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн хэрэгжилтийг хангах, банкны салбарын шинэтгэлийг амжилттай хэрэгжүүлэх зорилгоор бусад эрх бүхий байгууллагуудтай хамтран ажиллана.
- Банкны хяналт шалгалт, зохицуулалт болон зөвшөөрлийг хувьцаат компани хэлбэртэй банкны үйл ажиллагаа, өмчлөл, засаглалд нийцүүлэн боловсронгуй болгоно.

Хэрэгжүүлэх арга хэмжээ

- Хувьцаат компани хэлбэртэй банкны хяналт шалгалтын талаарх хэм хэмжээ тогтоосон акт шинээр боловсруулах, эсвэл одоогийн зохицуулалтыг боловсронгуй болгох
- Банк шинээр үүсгэн байгуулах, хувьцаат компани хэлбэртэй банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ болон хувьцаа эзэмшигчдийн бүтцэд өөрчлөлт оруулах зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг өөрчлөх, эсвэл шинээр боловсруулах
- Монголбанк Санхүүгийн зохицуулах хороо болон бусад эрх бүхий байгууллагуудтай хамтран хувьцаат компани хэлбэртэй банкийг зохицуулах, хяналт тавих эрх зүйн орчинг боловсронгуй болгох, эрх бүхий байгууллага хороондын харилцаа болон хамтын ажиллагааг сайжруулах чиглэлээр ажиллах

ЗОРИЛТ 2.3.

Банкны салбарын эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийн хүрээнд хийсэн судалгаа, үр дүнд үндэслэн эрх зүйн зохицуулалтын давхардал, хийдлийг арилгаж нэгдмэл байдлыг хангах, зээлийн мэдээлэл, үүсмэл санхүүгийн хэрэгсэл, буцаан худалдан авах барьцаат санхүүжилтийн хэлцлийн эрх зүйн орчныг боловсронгуй болгох арга хэмжээ авна.

Үндэслэл

Улсын Их Хурлын 2016 оны 71 дүгээр тогтоолоор батлагдсан “Эдийн засгийг сэргээх хөтөлбөр”, 2017 оны 11 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”, 2017-2021 оны “Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэл”-ийн хүрээнд Монголбанкнаас “Банк, санхүүгийн салбарын хууль, эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж байна. Тус хөтөлбөрийн хүрээнд банк, санхүүгийн салбарын голлох хуулиудад тус салбарыг хөгжүүлж, тогтвортой байдлыг хангах, харилцагч, хадгаламж эзэмшигч, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр зарчмын шинжтэй өөрчлөлт, шинэчлэл хийж байгаа билээ. Уг шинэчлэлийг үргэлжлүүлэн дор дурдсан хууль тогтоомжийн төсөл, төслийн саналыг зохих журмын дагуу Улсын Их Хурлаар хэлэлцүүлж, батлуулах арга хэмжээ авна.

Монголбанкнаас санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээний хөгжлийн хурдацтай уялдуулан шаардлагатай эрх зүйн зохицуулалтыг бий болгох чиглэлээр 2022 онд Банк, санхүүгийн салбарын хууль эрх зүйн шинэтгэлийг үргэлжлүүлнэ. Энэ хүрээнд санхүүгийн үүсмэл хэрэгсэл, хувьцаа, үнэт цаасны эрх зүйн орчныг төрийн бусад байгууллага, олон улсын байгууллагатай хамтран бүрдүүлнэ. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулиар санхүүгийн хэрэгслийг тодорхойлсон байдаг. Гэвч гадаад валют, бараа бүтээгдэхүүний нэгдсэн захын дэд бүтэц, оролцогчдын тоо, мэдлэг дутмаг байдал болон хууль хоорондын давхардал, зөрчлөөс улбаатай хийдэл зэрэг нь үүсмэл санхүүгийн хэрэгслийн хөгжилд тодорхой бэрхшээлийг үүсгэж байгаа бөгөөд үүнтэй холбоотойгоор банк, санхүүгийн салбарын хүрээнд хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийн төлөв байдалд судалгаа хийж, тэдгээрийн давхардал, хийдэл, зөрчлийг арилган уялдаа холбоог сайжруулах шаардлага үүссэн юм. Иймд Монголбанкнаас банк, санхүүгийн салбарын хүрээнд хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийн төлөв байдалд судалгаа хийж, тэдгээрийн давхардал, хийдэл, зөрчлийг арилган уялдаа холбоог сайжруулах зорилгоор Дэлхийн банкны «Төсөв, санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх төсөл»-ийн хүрээнд дотоодын зөвлөлтэй гэрээ байгуулан хамтран ажиллаж байна.

Улсын Их Хурлын 2020 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Зээлийн хүүг бууруулах стратеги”-ийн 2.5-д Зээлийн мэдээллийн санд бүх төрлийн санхүүгийн байгууллагын зээлтэй холбоотой мэдээлийн агуулгыг нэмэгдүүлж зээлийн мэдээллийн сангийн үйл ажиллагааг өргөжүүлэн, зээлдэгчийн эрсдлийг бодитой үнэлэх нөхцөлийг бүрдүүлэхээр заасан. 2012 оноос мөрдөж буй Зээлийн мэдээллийн тухай хуульд зээлийн мэдээллийн санд мэдээлэл нийлүүлэх үүрэг зарим төрийн оролцоотой санхүү, зээлийн үйл ажиллагаа явуулдаг байгууллагад оногдуулаагүй, Монголбанкнаас тусгай зөвшөөрөл олгоход зээлийн мэдээллийн зах зээлийн хүчин зүйл, тусгай зөвшөөрөл хүсэгчийн төсөлд эрсдэлийн үнэлгээ хийх боломжийг тогтоогоогүй зэрэг асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байна.

Монгол Улсын дотоодын зах зээлд репо болон биржийн бус санхүүгийн үүсмэл хэлцлийн хэмжээ өсч байгаа боловч Иргэний хууль тогтоомжид тодорхойлсон суурь хэлцлүүдээр тодорхойлогдохгүй, эрх зүйн зохицуулалт сайтар хөгжөөгүй байна. Энэ төрлийн хэлцэл хийгч талуудад дампуурлын ажиллагаа эхэлсэн бол тооцоо нийлэх заалтууд нь хүчин төгөлдөр үйлчлэх эсэх, барьцаа нь ердийн барьцааны зохицуулалтаас ялгаагүй байна. Олон улсын түвшинд шаардлага хангасан гэж үздэг GMRA, ISDA мастер хэлцлүүдийг ашигласан тохиолдолд тухайн санхүүгийн байгууллагын

зээлийн эрсдэл 85-90 хувиар буурдаг гэсэн тооцоо байдаг. Иймд санхүүгийн барьцаат хэлцлийн эрх зүйн орчинг боловсронгуй болгож репо болон үүсмэл санхүүгийн мастер гэрээнүүдийн тооцоо нийлэх заалтын хүчин төгөлдөр байдлыг баталгаажуулах зорилгоор Санхүүгийн барьцаат хэлцлийн тухай хуулийн төслийг боловсруулах шаардлагатай. Хуулийн төсөл нь Монгол Улсад санхүүгийн хэлцэлтэй холбогдсон үүргийн гүйцэтгэлийн эрх зүйн орчныг боловсронгуй болгож, санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, хөгжлийг дэмжихэд чиглэх юм.

- Санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах тухай хуулийн төсөл

Монгол Улсын Их Хурлын 2016 оны 71 дүгээр тогтоолоор баталсан “Эдийн засгийг сэргээх хөтөлбөр”-ийн 2 дугаар зүйл, Засгийн газрын 2017 оны 299 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-өөр Санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах зохицуулалтыг боловсронгуй болгох зорилт дэвшүүлсэн байдаг. Түүнчлэн Монгол Улсад санхүүгийн хэрэглэгчийн эрх, түүний өнөөгийн нөхцөл байдлын талаар анх Дэлхийн банкнаас 2012 онд «Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, санхүүгийн суурь боловсролын өнөөгийн байдлын оношилгоо дүгнэлт», Азийн хөгжлийн банкнаас 2017 онд «Монгол Улсын санхүүгийн салбарт хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах хууль, эрх зүйн болон зохицуулалтын өнөөгийн тогтолцоо ба түүнийг шинэчлэх төсөл»-ийн хүрээнд “санхүүгийн зах зээлийн оролцогчид санхүүгийн үйлчилгээ авахдаа шаардлагатай мэдлэг, мэдээллийг үнэ төлбөргүй авах, зөрчигдсөн эрхээ мэргэшсэн байгууллагаар хурдан шуурхай, чирэгдэл багатайгаар шийдвэрлүүлэх хууль, эрх зүйн тогтолцоог боловсронгуй болгох, санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тусгайлсан эрх зүйн орчныг бүрдүүлэх” шаардлагатай тухай дүгнэлт, зөвлөмж өгсөн байдаг. Түүнчлэн, санхүүгийн салбарын хэрэглэгчид аливаа санхүүгийн үйлчилгээг авахад шаардлагатай мэдлэг, мэдээлэл, боловсролоор үнэ төлбөргүй хангуулах, зөрчигдсөн эрхээ эрх бүхий мэргэшсэн байгууллагаар хурдан шуурхай, чирэгдэл багатайгаар шийдвэрлүүлэх, санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчийн үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх, тэдгээрт зохицуулагч байгууллагын зүгээс тавих хяналт, шалгалтыг өндөржүүлэх хууль, эрх зүйн зохицуулалт шаардлагатай байгаа нь практикт нотлогдож байна. Иймд дээр дурдсан дүгнэлт, зөвлөмж, шаардлагыг үндэслэн Санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах тухай хуулийн төслийг боловсруулаад байна. Тус хуулийн төслөөр Монгол Улсад анх удаа санхүүгийн хэрэглэгч гэсэн нэр томъёог тодорхойлж, санхүүгийн хэрэглэгчийн эрхийг Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулиас тусад нь зохицуулах эрх зүйн орчинг бүрдүүлэх, санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээнд тавигдах шаардлага стандартыг тогтоож, санхүүгийн хэрэглэгч тухайн бүтээгдэхүүн, үйлчилгээний талаарх мэдээлэл, ойлголтыг үнэн бодитоор үнэ төлбөргүй авахтай холбогдох харилцааг зохицуулна. Мөн хариуцлагатай зээлдэгчийн зарчимд тулгуурласан мөнгө хүүлэлтийн эсрэг зохицуулалтыг тусгаж, хэрэглэгчийг аливаа өрийн дарамтад өртөх эрсдэлээс хамгаалсан онцлог зохицуулалтыг тусгасан болно.

- Иргэний хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Улсын бүртгэлийн хууль тогтоомж болон бусад холбогдох хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төсөл

Өр, төлбөрийг шүүхийн журмаар албадан барагдуулах ажиллагааг сайжруулан боловсронгуй болгох, чанаргүй активыг үр ашигтай шийдвэрлэх, барьцаа хөрөнгөтэй холбоотой бүртгэлийн тогтолцоог боловсронгуй болгох зорилгоор Иргэний хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Улсын бүртгэлийн хууль тогтоомж болон холбогдох хуульд нэмэлт өөрчлөлт оруулах судалгааг хийж гүйцэтгэх, хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2018 оны А-323, А-324 дүгээр тушаалаар байгуулсан. Уг ажлын хэсэгт Монголбанк, Сангийн яам, Монголын банкны холбоо, хуульч, өмгөөлөгчдийн төлөөллийг оролцуулсан. Ажлын хэсгээс Иргэний хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулж, хуулийн төслийн саналыг Хууль зүй дотоод хэргийн яаманд уламжлаад байна.

Хуулийн төсөлд “хуульд өөрөөр заагаагүй бол нэг этгээд оролцсон нь дуудлага худалдаа, уралдаан явагдаагүй гэж үзэх үндэслэл болохгүй байх, барьцаагаар хангагдсан үүргийн гүйцэтгэлийн шаардлагыг татан буугдаж байгаа хуулийн этгээдэд холбогдох шаардлагын дарааллын 2 дугаарт эрэмбэлэх, шүүхийн хянан шийдвэрлэх ажиллагаанд урьдчилсан хэлэлцүүлгийн шат бий болгох, шүүх хуралдааныг хүндэтгэн үзэх зайлшгүй шалтгаанаас бусад шалтгаанаар хойшлуулахгүй байх, хэргийн оролцогчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч, өмгөөлөгчийг удаа дараа солих тохиолдлыг хязгаарлах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хугацаанд нь, хэвийн явуулахад удаа дараа, санаатай саад учруулсан зохигчоос шүүх хугацаа алдсаны нөхөн олговор авч, нөгөө талд гаргуулах зохицуулалтыг хуулийн төсөлд оруулахаар тусгаад байна.

- Векселийн тухай хуулийн төсөл

Сүүлийн жилүүдэд векселийн хэрэглээ эрс нэмэгдэж, зохицуулах шаардлагатай олон шинэ харилцаа үүссэн, векселийг өрийн удирдлагын зорилгоор зохисгүй түвшинд хэрэглэсэн, векселд холбогдох бусад хууль тогтоомж шинэчлэгдсэн зэргээс шалтгаалан векселийн тухай хууль өнөөгийн санхүүгийн зах зээлийн харилцаанд хэрэглэх шаардлагыг хангахгүй болж, векселийн хэрэглээнээс үүдсэн санхүүгийн эрсдэлийг бий болгож эхэлсэн. Тухайлбал, векселийн тухай хуулиар хязгаарлалт тогтоогоогүйн улмаас Засгийн газар өнгөрсөн жилүүдэд төсвөөс гадуурх санхүүжилтийн эх үүсвэрийг векселиэр босгон Засгийн газрын өрийн дарамтыг ихээр нэмэгдүүлж, улсын өрийн тогтворгүй байдал үүсэх шалтгаан болж байна. Одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй векселийн тухай хуульд зөвхөн иргэн, хуулийн этгээд, тэдгээрийн хооронд хийх төлбөр тооцоонд векселийг хэрэглэхтэй холбогдсон харилцааг зохицуулсан боловч Засгийн газар өнөөг хүртэл тус хэрэгслийг ашиглаж байна. Түүнчлэн уг хуулийг батлах үеийн санхүүгийн зах зээлийн нөхцөл байдал, бүтэц, хөгжлийн түвшин зэргээс шалтгаалан төлбөр тооцоо хийх хугацаа, хүү, төлбөр хариуцагчийн тоо зэрэг нь уян хатан бус, төрийн байгууллагын оролцоо их, тэдгээрийн зарим эрх, үүрэг давхардсан нь хуулийг шинэчлэх шаардлагатайг харуулж байна. Мөн нийлүүлсэн бараа, үзүүлсэн ажил, үйлчилгээний төлбөрийг тогтоосон хугацаанд төлөхийг амалж бичсэн төлбөр тооцооны хэрэгслийн зориулалтаар векселийг анх бичдэг ч тогтоосон хугацаанаас нь өмнө банкинд хямдруулан худалдах, банк нь Монголбанкинд худалдах боломжтой байдаг нь векселийн төлбөрөөр баталгаажуулан хоёрдогч зах зээл дээр шинээр өр бий болох хөшүүрэг болохоос гадна Монголбанкнаас төсвийн болон аж ахуйн нэгжийн зардлыг санхүүжүүлэх, энэ нь эргээд мөнгөний бодлогын үр нөлөөг бууруулах сөрөг үр дагавартай байна. Иймд дээр дурдсан асуудлыг шийдвэрлэх зорилгоор векселийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулсан. Хуулийн төслөөр иргэн, хуулийн этгээд, Засгийн газар, орон нутгийн засаг захиргааны байгууллага хооронд хийх төлбөр тооцоонд векселийг хэрэглэхтэй холбогдох харилцааг зохицуулна.

Стратеги

- Хууль, эрх зүйн зохицуулалтын шаардлагыг улсын хөгжлийн бодлогын баримт бичиг, төлөвлөгөөнд тусгагдсан зорилтын эрэмбэ, хугацааны хүчин зүйлээр тодорхойлно.
- Дотоод болон гадаад, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн судалгааны институци байгууллагатай хамтран судалж, нотолгоонд суурилсан санал боловсруулна.
- Төрийн эрх бүхий байгууллага болон олон нийтийн дунд судалгааны үр дүн, хуулийн хэрэгцээ шаардлагын талаар мэдээлж, дэмжлэг бүрдүүлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ

- Хууль тогтоомжийн тухай хуульд нийцүүлэн хуулийн төслийн санал, холбогдох судалгааг боловсруулах
- Хуулийн төслийг өргөн мэдүүлэх, хэлэлцүүлэх, батлуулахад хууль санаачлагч, Улсын Их Хурал, холбогдох бусад байгууллагатай хамтран ажиллах
- Хуулийн төсөл батлагдсаны дараа хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор хуулийг таниулах, холбогдох дүрэм, журмыг батлах арга хэмжээ авах

САНХҮҮГИЙН ЗАХЫН ДЭД БҮТЭЦ, ТҮҮНИЙ ИНСТИТУЦИЙГ БЭХЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД

ЗОРИЛТ 3.1.

Төв банкны цахим мөнгө гаргах талаар судалж, хөгжүүлнэ.

Үндэслэл

Сүүлийн жилүүдэд дэлхий дахинд технологийн хөгжлийг даган зөвхөн технологид суурилсан, аль нэг улсын баялгаар баталгаажуулаагүй виртуал хөрөнгө, криптовалют гэх ойлголт эрчимжиж, олон улсын эдийн засаг, санхүүгийн салбарт тодорхой бус байдлыг нэмэгдүүлэх болсон. Улс орнуудад бэлэн мөнгөний хэрэглээ буурч, хувийн хэвшлийн гаргаж буй цахим мөнгө, криптовалютын эрэлт нэмэгдэх хандлагатай болсноор цаашид санхүүгийн тогтвортой байдлыг хангах зорилт хийгээд мөнгөний бодлого хэрэгжүүлэх орон зай хумигдах эрсдэлийг харгалзан төв банкуудын авч буй хариу арга хэмжээний нэг нь төв банкнаас өөрийн цахим мөнгө (ТБЦМ) гүйлгээнд гаргах санаачилга болж байна.

ТБЦМ гэдэг нь (i) төв банкнаас гаргасан (ii) албан ёсоор хуульчлагдсан (iii) төв банкаар баталгаажсан, (iv) гүйлгээ дундын зуучлагчгүй хийгдэхийг зөвшөөрсөн, (v) програмчлах боломжтой зэрэг шинжүүдийг агуулсан цахим мөнгийг ойлгоно. Энгийнээр тайлбарлавал ТБЦМ гэдэг нь тухайн улсын төв банкаар баталгаажсан, үндэсний мөнгөн дэвсгэртэй нэгжээр илэрхийлэгдсэн цаасан болон зоосон мөнгөний дижитал буюу цахим хувилбар юм.

Бэлэн мөнгөний хэрэглээ буурч буй өнөө үед ТБЦМ нь түүнийг нөхөх, аюулгүй, найдвартай төлбөрийн хэрэгсэл бөгөөд цаашид төлбөрийн системийн аюулгүй, үр ашигт байдлыг сайжруулж чадна гэдэгт төв банкууд санал нэгдэж байгаа ч улс орны онцлогоос шалтгаалж ТБЦМ гаргах үндсэн зорилго нь харилцан адилгүй байна. Тодруулбал, хөгжиж буй орнуудын хувьд банкны үйлчилгээ авч чаддаггүй иргэдэд хүрэх байдлаар санхүүгийн хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх гол зорилготой бол хөгжингүй орнуудын хувьд хил дамнасан төлбөр тооцоог сайжруулах, хувийн хэвшлийн гаргаж буй цахим мөнгөний хэрэглээ нэмэгдсэнтэй холбоотойгоор үүсэх төлбөрийн систем дэх үйл ажиллагааны болон монополь байдлын эрсдэлийг бууруулах нь ТБЦМ-г гаргах гол хөшүүрэг болж байна. Түүнчлэн бодлогын хүү нам дор түвшинд байгаа орнуудын хувьд мөнгөний бодлогын орон зайг тэлэх, нөлөөллийг нэмэгдүүлэх зорилго зонхилж байна.

Ковид-19 цар тахлын үеэр бэлэн мөнгө хэрэглэх нь халдвар тархах магадлалыг нэмэгдүүлэх эрсдэлтэй тул засгийн газраас иргэд рүү шууд хүрэх төлбөрийн шинэ схем буюу цахим төлбөр тооцоо руу шилжих шилжилтийг эхлүүлж, төв банкуудын ТБЦМ гаргах боломжийн талаарх судалгаа, туршилтын ажлууд эрчимжиж байна¹⁷. Өнөөдрийн байдлаар Бахама, Камбожи зэрэг

¹⁷ BIS (2020) судалгааны үр дүнгээр нийт судалгаанд оролцсон 65 төв банкны 86 хувь нь ТБЦМ-ний эдийн засагт үзүүлэх эерэг болон сөрөг нөлөөг судалж байгаа бол тэдгээрийн 60 орчим хувь (БНХАУ, БНСУ, Уругвай, Сингапур, Франц, Швед, Канад) нь дараагийн шат болох ТБЦМ-г турших үйл ажиллагааг хэрэгжүүлж эхлээд байгаа юм. Харин Дани, Финланд, Эквадор, Тунис, Гаити зэрэг орнуудын хувьд цахим мөнгө гаргах ажлыг 3-5 жилийн хугацаанд судалсны эцэст цуцлах шийдвэрийг гаргаж, ойрын ирээдүйд цахим мөнгө гаргах шаадлагагүй гэдгээ илэрхийлсэн байна.

хоёр орныг эс тооцвол ТБЦМ-ийг албан ёсоор нэвтрүүлж, гүйлгээнд гаргасан улс хараахан байхгүй байна.

Төв банкууд өөрийн орны онцлогт суурилсан, төв банкны зорилго зорилгод нийцсэн, хамгийн үр ашиг бүхий цахим мөнгөний хувилбарыг сонгож хэрэгжүүлэх нь чухал юм. Учир нь ТБЦМ нь банкны салбарт эх үүсвэрийн хомсдол бий болох, мөнгөний бодлогын зарим шилжих сувгууд ажиллах нөлөө муудах, санхүүгийн тогтвортой байдалд сөрөг нөлөө үзүүлэх зэрэг эрсдэлийг дагуулж болзошгүй. Иймд төв банкууд цахим мөнгө гаргахдаа: 1) хамрах хүрээ, 2) үйл ажиллагааны загвар, 3) дэд бүтэц, технологийн шийдэл, 4) хүү төлөх, хязгаар тогтоох зарчим зэрэг асуудалд шийдлээ тодорхойлох шаардлагатай тулгардаг байна.

ТБЦМ нь хамрах хүрээний хувьд бага дүнтэй буюу олон нийтэд зориулсан, их дүнтэй буюу зөвхөн банк санхүүгийн байгууллагад зориулсан цахим мөнгө гэсэн 2 төрөлтэй байдаг бөгөөд төв банкууд гаргасан цахим мөнгө нь зөвхөн дотооддоо ашиглагдах эсвэл хил дамнасан байх эсэхийг тодорхойлдог. Үйл ажиллагааны загварын хувьд төв банкууд өөрийн орны санхүүгийн систем, түүний дэд бүтцийн онцлог, хүний нөөцийн чадавх зэрэгт тулгуурлан ТБЦМ гаргахтай холбоотой бүхий л дэд бүтэц, програм хангамж, түүнийг хөгжүүлэх ажлыг өөрөө дангаар хариуцах эсвэл банк болон төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч операторуудад тусгай зөвшөөрөл олгон оролцуулах эсэхийг шийднэ. Харин цахим мөнгөний суурь бүртгэлийн технологийн шийдлийн хувьд гүйлгээний мэдээлэл дамжуулалт, баталгаажуулалт зэргийг харгалзан уламжлалт буюу төвлөрсөн систем, тархмал бүртгэлийн систем, эдгээрийг хослуулсан систем зэргээс сонгодог байна. Цахим мөнгөний нууцлал, аюулгүй байдал нь ТБЦМ дансанд эсвэл токенд суурилсан эсэхээс хамаарч тодорхойлогдох бөгөөд эдгээр сонголтууд нь гүйлгээний мэдээллийг таних, суурь технологийн шаардлага, сонголтоор ялгагддаг. Банкны систем, ялангуяа эх үүсвэрийн дутагдалд хүргэх эрсдэлээс хамгаалах чиглэлд ТБЦМ-д хүү тооцох эсвэл эзэмшлийн хэмжээнд хязгаар тогтоох аргуудыг төв банкууд одоогоор дэвшүүлээд байгаа бөгөөд энэ нь мөнгөний бодлогын хүүний сувгийг нөлөөллийг хадгалж үзнэ гэж үзэж байна.

ТБЦМ гаргах нь дээрх загварын сонголтуудын хүрээнд хууль эрх зүй, дэд бүтэц, хүний нөөцийг хөгжүүлэхийг шаарддаг. Манай улсын хувьд бусад орнуудын адилаар олон улсын болон өөрийн орны түвшинд ТБЦМ-ний талаарх хийгдэж буй судалгаа, шинжилгээний үр дүнг харьцуулах, хөгжүүлэх улмаар өөрийн орны онцлогт тохирох ТБЦМ-ний загвар, технологийн шийдлийг тодорхойлох нь нэн тэргүүний зорилт болохоор байна.

Стратеги

- Төв банкны цахим мөнгө гаргах хэрэгцээ шаардлага, ач холбогдлыг тодорхойлно.
- Төв банкны цахим мөнгө гаргах талаар бусад улс орон, төв банкуудын хийсэн судалгаа, зөвлөмжүүдэд үндэслэн Монгол улсын нийгэм, эдийн засаг, санхүүгийн зах зээлийн онцлогт тохирсон ТБЦМ, түүний хамрах хүрээ, үйл ажиллагааны загвар, технологийн шийдлийг судалгаа шинжилгээнд тулгуурлан тодорхойлж, дараа дараагийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулна.

Хэрэгжүүлэх арга хэмжээ

- Төв банкны цахим мөнгө гаргах хэрэгцээ шаардлага, ач холбогдлыг гүнзгийрүүлэн судалж, хүний нөөц, дэд бүтэц, хууль эрх зүйн орчныг тодорхойлох
- Бусад улс орон, төв банкуудад хийгдсэн судалгаа, туршилтын үр дүнг нарийвчлан судалж, Монголбанкнаас гаргах Төв банкны цахим мөнгөний хамрах хүрээ, үйл ажиллагааны загвар, технологийн шийдэл, дэд бүтцийг дотоодын санхүүгийн зах зээлийн онцлогт тохируулан загварчлах
- Төв банкны цахим мөнгө гарган турших үйл явцын төлөвлөгөө боловсруулж, бэлтгэл ажлыг хангах

ЗОРИЛТ 3.2.

Үндэсний төлбөрийн системийн эрх зүйн орчныг сайжруулах замаар шинэ технологид суурилсан санхүүгийн үйлчилгээг дэмжиж, төлбөрийн систем дэх хяналтын чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Үндэслэл

Технологид суурилсан санхүүгийн үйлчилгээг үзүүлэгч финтек байгууллагууд олноор бий болж, олон төрлийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд нэвтэрсээр буй энэ үед дэлхий дахинд төдийгүй Монгол Улс дахь зохицуулагч байгууллагуудын бодлого шийдвэр, зохицуулалтын орчин, дотоод зохион байгуулалт нь хурдацтай даган шинэчлэгдэж байна. Дэлхий дахинд төдийгүй манай орны хувьд эрчимтэй хөгжиж буй финтек үйлчилгээ нь ихэвчлэн төлбөрийн үйлчилгээг хамарч байгаа бөгөөд иргэд, байгууллагууд олон янзын төлбөрийн суваг, хэрэгсэл ашиглан өөр хоорондоо мөнгөн хөрөнгө шилжүүлэх, төлбөр төлөх үзэгдэл жилээс жилд эрчимжиж байна. Хэдхэн жилийн өмнө иргэд бэлэн мөнгө болон банкуудын төлбөрийн картыг төлбөр тооцоонд ашигладаг байсан бол сүүлийн жилүүдэд банк бус санхүүгийн байгууллагууд, технологийн байгууллагууд болон үүрэн холбооны операторууд энэ салбарт өрсөлдөх болж гар утасны болон бусад ухаалаг төхөөрөмж дээрх аппликейшн ашиглан төлбөр төлөх, урамшуулалт оноогоор төлбөр гүйцэтгэх, цахим зээл хормын дотор олгох замаар худалдан авалтыг санхүүжүүлэх гэх мэт цоо шинэ төлбөрийн шийдлийг нэвтрүүлэх болсон.

Энэхүү үзэгдэл нь санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, өрсөлдөөнийг бий болгох давуу талтай ч нөгөө талдаа шинэ эрсдэлийг дагуулж болзошгүй тул зохицуулагч байгууллагууд инновацийг дэмжихийн зэрэгцээ эрсдэлийг бууруулах зохицуулалтыг хийх шаардлага тулгардаг. Зарим тохиолдолд одоогийн мөрдөгдөж буй журам зааврын хүрээнд зохицуулах боломжгүй цоо шинэ үйлчилгээг зах зээлд нэвтэрч тодорхой бус байдал үүсгэдэг. Энэ тохиолдолд олон улсад Сэндбокс гэх мэт туршилт, ажиглалтын орчныг бүрдүүлэх замаар шинэ үйлчилгээ, технологийг төр, хувийн хэвшил хамтран судалж, суралцаж холбогдох журам зааварт тухай бүр шинэчлэлт хийж хөгждөг жишиг тогтож байна.

Иймээс зах зээлд нэвтэрч буй технологийг цаг алдалгүй судлах, тогтмол ажиглах, бусдаас суралцах замаар зохицуулалтын орчныг тухай бүр шинэчилж, төлбөрийн системд тавих хяналтыг хэрэгжүүлэх нь хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, иргэдийн төгрөгт итгэх итгэл, эдийн засаг, санхүүгийн тогтвортой байдалд чухал нөлөө бүхий Төв банкны хуулиар хүлээсэн үндсэн үүргийн нэг юм.

Стратеги

Төлбөрийн системийн эрх зүйн орчныг сайжруулж, олон улсын шилдэг технологийг нутагшуулах, санхүүгийн үйлчилгээний инновацийг дэмжиж, төлбөрийн системд хяналт тавих замаар төлбөрийн системийн найдвартай, тасралтгүй ажиллагааг хангаж ажиллана.

Хэрэгжүүлэх арга хэмжээ

- Үндэсний төлбөрийн системийн бодлого, зохицуулалтыг сайжруулж, шинэ технологид суурилсан төлбөрийн хэрэгсэл, үйлчилгээг дэмжих
- Үндэсний төлбөрийн системийн тасралтгүй, найдвартай ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг зөв удирдах, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, оролцогчдын тэгш, тэнцвэртэй оролцоо, системийн нууцлал, аюулгүй байдлыг хангах зарчмыг баримтлан төлбөрийн системд тавих хяналтыг хэрэгжүүлэх

ЗОРИЛТ 3.3.

Санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах хүрээнд иргэд, бичил, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн санхүүгийн суурь мэдлэгийг дэмжинэ

Үндэслэл

Монголбанк, Сангийн яам, БСШУЯ, СЗХ хамтран “Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр”-ийг 2015 онд баталж 2016-2021 оны хооронд дараах 4 тэргүүлэх чиглэлээр хэрэгжүүллээ. Үүнд: 1) Сургуулийн насанд санхүүгийн мэдлэг олгох; 2) Залуу үед санхүүгийн мэдлэг олгох; 3) Хөдөө орон нутгийн иргэдэд санхүүгийн мэдлэг олгох; 4) Цахим хуудас, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл гэсэн чиглэлүүд багтаж байна. Цаашид тус хөтөлбөрийн хүртээмжийг нэмэгдүүлэх, санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх дараагийн шатны стратегийг боловсруулахын тулд иргэдийн санхүүгийн боловсролыг дэмжих ажлын үр дүнг үнэлэх шаардлагатай.

Монголбанкаас 2020 онд “Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн хүрээнд хийсэн түүвэр судалгааны үр дүнгээр бичил, жижиг дунд үйлдвэрлэл (БЖДҮ) эрхлэгчдийн өдөр тутмын үйл ажиллагаанд санхүүгийн мэдлэг, боловсрол зайлшгүй хэрэгцээтэй байгааг тогтоосон. Иймд холбогдох дэд хөтөлбөрийг Европын сэргээн босголт, хөгжлийн банкны дэмжлэгтэй боловсруулан 2021 онд Монголбанкны Ерөнхийлөгч, Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын хамтарсан тушаалаар баталлаа. Тус хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж 2022 онд бичил, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлнэ.

Стратеги

- Санхүүгийн боловсролыг дээшлүүлэх арга хэмжээнүүд нь судалгаанд үндэслэнэ.
- Сургагч багш нарыг бэлтгэж, мэдээллээр тогтмол хангаж, чадавхжуулна.
- Сургалт, семинар, уулзалтуудын үр дүнг технологийн дэвшлийг ашиглан сайжруулна.
- Гарын авлага, сургалтын материалуудыг шинэчилж боловсруулна.

Хэрэгжүүлэх арга хэмжээ

Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад санхүүгийн суурь мэдлэг олгох:

- Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрт тусгагдсан сонгон судлах “Бизнес судлал” хичээлийн хүртээмжийг дээшлүүлэх чиглэлд ажиллана.
- “Дэлхийн мөнгөний долоо хоног”, “Дэлхийн хуримтлалын өдөр” аянуудыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулна.

Их дээд сургуулиудын оюутнуудын санхүүгийн мэдлэг олгох:

- “Хувь хүний санхүү” хичээлийн хүртээмжийг дээшлүүлэх, идэвхжүүлэлтийн арга хэмжээг үе шаттайгаар зохион байгуулна.
- “Тинк Банк” хөтөлбөрийн хүрээнд оюутнуудын судалгаа, эрдэм шинжилгээ хийх идэвхийг нэмэгдүүлж, эрдэм шинжилгээний хурал зохион байгуулна.

Хөдөө, орон нутгийн иргэдэд санхүүгийн мэдлэг олгох:

- Сургагч багш нарыг бэлтгэнэ.
- Монголбанкны хэлтэс, салбаруудын ажилтнуудыг мэдээлэл, гарын авлагаар хангаж, иргэдэд санхүүгийн боловсролын ач холбогдлыг ойлгуулах, мэдлэг түгээх ажлыг дэмжинэ.
- Төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллана
- Орон нутгийн иргэдэд сургалт, контент хийж үр дүнтэй түгээхэд технологийн дэвшлүүдийг ашиглана.

Бичил, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд санхүүгийн боловсрол олгох дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх:

- Оролцогч талуудтай хамтран БЖДҮ эрхлэгчдэд чиглэсэн гарын авлага бэлтгэнэ.
- БЖДҮ эрхлэгчдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэсэн бусад төсөл, үйл ажиллагаануудтай хамтран ажиллаж, сургагч багш нарын тоог нэмэгдүүлнэ.

Хөтөлбөрийн хэрэгжилтийг дүгнэх, цаашид сунгах:

- Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх дунд хугацааны хөтөлбөрийн үр дүнг харуулах, иргэдийн санхүүгийн мэдлэгийн түвшинг тогтоох судалгаа хийнэ.
- Судалгааны үр дүнд үндэслэн дараагийн шатны хөтөлбөрийг боловсруулна.

ЗОРИЛТ 3.4.


Макро эдийн засаг, санхүүгийн зах зээлийн шинжилгээнд их өгөгдлийг ашиглах техникийн болон мэргэшлийн ур чадварыг үе шаттайгаар бүрдүүлж эхэлнэ.

Үндэслэл

Ирвинг Фишерийн хороо (IFC)-ноос дэлхийн улс орнуудын төв банкуудыг хамруулсан судалгаагаар их өгөгдлийг үйл ажиллагаандаа ашиглаж байгаа төв банкуудын хувь 2015 онд 30 орчим хувь байснаас 2020 онд 80 гаруй хувьд хүрч нэмэгдсэн бөгөөд дийлэнх нь дээд удирдлагын түвшинд нэн чухал асуудал болгон авч үзэж байна. Төв банкууд ийнхүү өндөр ач холбогдол өгөхөд олон шалтгаан байгаагаас нэн тэргүүнд өндөр давтамжтай, анхдагч тоон өгөгдлийг цаг алдалгүй авч ашиглан эдийн засгийн үзүүлэлтүүдийн таамаглалыг цаг тухайд нь шинэчилж шийдвэр гаргалтад тусгах зайлшгүй шаардлага тулгарсантай холбоотой юм. Түүнчлэн төв банкууд сүүлийн жилүүдэд их өгөгдлийг мөнгөний бодлогын шинжилгээ, санхүүгийн тогтвортой байдал, хяналт шалгалтын зорилгоор илүүтэй ашиглаж байна¹⁸.

¹⁸ Эх сурвалж: Олон Улсын Төлбөр Тооцооны Банк (2021)

Зураг 10. Төв банкуудын их өгөгдлийн хэрэглээ



Мөнгөний бодлогын хүрээнд томоохон төв банкууд их өгөгдлийг мөнгөний бодлогын зорилгоор бодлогын тооцоо, шинжилгээг сайжруулах, төсөөллийн алдааг бууруулахад ашиглаж байна. Тухайлбал, эдийн засгийн төлөвийг тодорхойлох, мөчлөгийн эргэлтийн цэгийг цаг алдалгүй таних, макро эдийн засгийн эрсдэлийг урьдчилан дохиолох системийг хөгжүүлэх хэрэглээг дурдаж болно. Түүнчлэн төрөл бүрийн бичвэр өгөгдлийг шинжилж, зах зээлд оролцогчдын итгэл, хүлээлт, эдийн засгийн тодорхой бус байдлыг хэмжих, улмаар түүнийг удирдахад чиглэсэн арга хэмжээг авч, бодлогын үр нөлөөг дээшлүүлэхэд ашигладаг туршлага бий¹⁹.

Санхүүгийн тогтвортой байдал, хяналт шалгалтын хүрээнд өрхийн өрийн дарамтыг үнэлэх, зээлийн мэдээллийн сан үүсгэх, зээл олголтыг хянах, банкны балансын үзүүлэлтүүдийн богино хугацааны төсөөлөл гаргах, системийн эрсдэлийн урьдчилан дохиологчийг шалгах зэрэгт түгээмэл ашиглагддаг байна (Cœuré 2017). Түүнчлэн санхүүгийн зах зээлийн хөгжлийг хэмжих, зээлийн өсөлтөөс үүсэх эрсдэлийг тодорхойлох, зорилтот бүлгийн зээлдэгчдийн санхүүгийн чадамжийг үнэлэх, эх үүсвэрийн зардлыг бууруулах зорилгоор олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, гар утасны хэрэглээ, хэрэглэгчийн төлбөр тооцооны түүхэн цувааг ашиглаж байна (Tian, Hassan and Razak 2018). Мөн их өгөгдлийг ашигласнаар мэдээллийн хоцрогдол багасч, таамаглалын нарийвчлал нэмэгдэж, бодлогын арга хэмжээ цаг алдахгүй авах боломжтой болдог байна.

Дээр дурдсан чиглэлээр Монголбанканд их өгөгдлийг ашиглах, нэгдсэн өгөгдлийн сан бий болгох, түүнийг боловсруулах, удирдах техникийн болон хүний нөөцийн хүчин чадлыг хөгжүүлэх, кибер аюулгүй байдлыг хангах, өгөгдлийн шинжилгээ хийх хиймэл оюун ухааны алгоритмыг хөгжүүлэх/олж авах сорилтууд тулгарч байна.

Улмаар их өгөгдлийг Монгол Улсын санхүүгийн системийн хувьд хөгжүүлж, түүнийг бодлого боловсруулалтад ашиглахын тулд стратегийн баримт бичгийг боловсруулах нь зүйтэй. Энэхүү стратегийн баримт бичигт их өгөгдлийн сан бүрдүүлэх, түүнийг ашиглах, удирдах, кибер аюулгүй байдлыг хангах тухай хууль эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэх, програм хангамж, хүний нөөц зэрэг дэд бүтцийн хөгжүүлэлт, түүнийг шийдвэрлэх санхүүгийн эх үүсвэр зэргийг тусгана.

- **Бодит цагийн, нэгдсэн өгөгдлийн сан, түүний дэд бүтцийг бий болгох:** Азийн Хөгжлийн Банкны санхүүжилтээр банкуудаас өндөр давтамжтай, задгай тоон мэдээлэл авах ажлыг эхлүүлээд байна. Цаашид компьютер, програм хангамж, тоног төхөөрөмжийг худалдан авах, хүний нөөцийг бэлтгэх, холбогдох зардлыг төсөвт тусгах хэрэгтэй.

¹⁹ Эх сурвалж: S.Baker, N.Bloom and S.Davis “Measuring economic policy uncertainty” (2016), Quarterly Journal of Economics, Vol.131, Issue 4, p.1593; Bholat, et al., “Big Data and Central Banks” (2015), Big Data & Society.

- **Их өгөгдлийг шинжлэх алгоритм сургах:** Их тоон өгөгдөлд шинжилгээ хийх сургасан машин сургалтын алгоритмыг аутсорсинг хийх туршлагыг бусад Төв банкуудаас суралцах нь Төв банкны их өгөгдлийн чиглэлээр хийх дараагийн ажил болохоор байна.
- **Хууль эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэх:** Тоон өгөгдлийг хэрэглэх, хамгаалахыг зохицуулсан, олон нийтэд нээлттэй тогтолцоог бий болгох хэрэгтэй. “Кибер аюулгүй байдлын тухай” хуулийн төсөл УИХ-аар хэлэлцэгдэж байна. Уг хууль гарч байгаатай холбогдуулан, хуулийг батлагдсаны дараа түүнд нийцтэйгээр тоон өгөгдлийг нэвтрэх эрхийг олгох, хэрэглэх, хамгаалахыг зохицуулсан кибер аюулгүй байдлын нарийвчилсан журам боловсруулж, баталж, мөрдөх хэрэгтэй.
- **Кибер аюулгүй байдлыг хангах:** Кибер эрсдэлийн үнэлгээг хийж, Төв банкны кибер аюулгүй байдалд хяналт тавих ажлын нэгжийг байгуулах, түүнд тогтмол хяналт тавих ажлыг үйл ажиллагааны эрсдэлийн төлөвлөгөөнд оруулах хэрэгтэй (ОУВС, 2021).

Стратеги

- Их өгөгдөл цуглуулах, түүнийг ашиглан судалгаа хийхэд шаардагдах эрх зүйн, оюуны өмчийн, дэд бүтцийн, хамтын ажиллагааны стратеги боловсруулна.

Хэрэгжүүлэх арга хэмжээ

- Их өгөгдлийг бүрдүүлж, хадгалж ашиглах, удирдах тогтолцоог бий болгоход шаардлагатай хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх
- Их өгөгдлийг ашиглан дүн шинжилгээ, боловсруулалт хийх чадавх бүхий дэд бүтцийг бий болгох стратеги боловсруулах

ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2021 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ БАТЛАХ ТУХАЙ УИХ-ЫН 2020 ОНЫ 32 ДУГААР ТОГТООЛЫН ХЭРЭГЖИЛТ

(2021 оны 2 дугаар улирлын байдлаар)

1. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог сайжруулах хүрээнд хууль, эрх зүйн орчныг ФАТФ-ын зөвлөмжид нийцүүлэн боловсронгуй болгох, Монгол Улсын үнэлгээний үр дүнтэй байдлыг дээшлүүлэх зорилгоор олон улсын болон дотоодын байгууллагуудтай хамтран ажиллах, үндэсний хөтөлбөрийг батлах

1. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог сайжруулах хүрээнд хууль, эрх зүйн орчныг ФАТФ-ын зөвлөмжид нийцүүлэн боловсронгуй болгох

Монгол Улс Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-ын зөвлөмжийн нийцлийг хангаж, дараагийн харилцан үнэлгээний үр дүнг дээшлүүлэх ажлын хүрээнд “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай” хуулийн төслийг Хамтын ажиллагааны зөвлөлийн гишүүдийн төлөөлөлтэй хамтран, олон улсын нийтлэг жишгийн дагуу боловсруулж хууль санаачлагчид уламжиллаа. Засгийн газраас тус хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлсний дагуу 2021 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр УИХ-ын Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн.

Виртуал хөрөнгийн үйлчилгээний тухай хуулийн төслөөр виртуал хөрөнгө, хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийг, тэдгээрт тавигдах нийтлэг болон нэмэлт шаардлагыг олон улсын жишигт нийцүүлэн тодорхойлж, үйлчилгээ үзүүлэгчийг бүртгэх, хяналтын механизмыг бий болгож, Санхүүгийн зохицуулах хороо хяналтыг хэрэгжүүлэхээр тодорхойлж, бүрэн эрхийг төсөлд тусгасан. Түүнчлэн виртуал хөрөнгө, түүнийг худалдсан, шилжүүлсэн, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлснээс олсон орлогод татвар ногдуулах, харин тухайн үйлчилгээ үзүүлэгчийг санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчийн нэгэн адил Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх эрх зүйн орчныг бий болгож, хууль зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагын талаар Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэх тухай хуулийн төсөл болон Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан.

Хуулийн төсөл батлагдсанаар виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчид хяналт тавих эрх зүйн зохицуулалт бий болж, ФАТФ-ын зөвлөмжийг биелүүлэх, өмчийн эрх зүйн хамгаалалт бүрдэж, эдийн засаг дахь хөрөнгийн эргэлт нэмэгдэх, гадны хөрөнгө оруулагч нарыг татах, санхүүгийн хэрэглэгч олон төрлийн төлбөрийн хэрэгслийн сонголттой болж зуучлалын зардал багасах, зохицуулалтгүй зах зээлээс үүсэж болзошгүй мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэл буурах эерэг нөлөөтэй байна.

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр ФАТФ-аас гаргасан техник хэрэгжилтийн 40 Зөвлөмж болон үр дүнтэй байдлын 11 Шууд хэрэгжилтийн шалгуурыг дэлхийн улс орнууд дагаж мөрдөх үүрэгтэй бөгөөд эдгээр хэрэгжилтийг тодорхой давтамжтайгаар үнэлдэг.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог сайжруулах, хууль, эрх зүйн орчныг ФАТФ-ын 40 зөвлөмжид нийцүүлэх зорилгоор “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам”-д Монголбанкны Ерөнхийлөгчийн 2021 оны А-31 дугаар тушаалаар өөрчлөлт оруулан батлуулсан. Захиргааны ерөнхий хуулийн дагуу журмыг Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлсэн.

ФАТФ нь мөнгө угаах, терроризм болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх үйл ажиллагаанд баримтлах олон улсын стандартыг

тогтоон хэрэгжилтэд нь хяналт тавьж ажилладаг. ФАТФ-ын 40 зөвлөмжийн 15 дугаар зөвлөмж шинэчлэгдэн шинэ технологийг нэвтрүүлэх, ашиглахад тавигдах шаардлагыг виртуал хөрөнгө болон виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийг хамруулан өргөжүүлсэн. Энэ хүрээнд улс орнууд виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийг бүртгэлжүүлэх, тэдэнд санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчийн нэгэн адил мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрсдэлд суурилсан хэлбэрээр хэрэгжүүлэхээр эрх зүйн орчны зохицуулалтыг бий болгох шаардлагатай болсон. Иймд Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо болон төрийн бусад байгууллагатай хамтран Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн төслийг боловсруулсан бөгөөд Улсын Их Хурал төслийг хэлэлцэж эхлээд байна. Цаашид Хууль зүйн байнгын хороо ажлын хэсэг байгуулан хуулийн төсөл дээр үргэлжлүүлэн ажиллахаар байна.

ФАТФ-ын техник хэрэгжилтийн 40 зөвлөмжийн хэрэгжилтийн үнэлгээг дээшлүүлэх ажлын тухай

Монгол Улсаас ФАТФ-ын 40 зөвлөмжийн үнэлгээг сайжруулах зорилгоор 2021 оны 1 дүгээр сард зохион байгуулагдсан Хамтын ажиллагааны зөвлөлийн хурлаар Зөвлөмж 1, 8-ын үнэлгээг ахиулах, Зөвлөмж 15-ыг дахин үнэлүүлэхээр шийдвэрлэж үнэлгээг ахиулахтай холбоотой тайланг бэлтгэн хүргүүлсэн.

Үнэлгээг ахиулахаар Мөнгө угаахтай тэмцэх Ази Номхон далайн бүсийн мөнгөн угаахтай тэмцэх бүлэгт хүргүүлсэн тайлантай холбогдуулан үнэлгээчдийн ирүүлсэн тодруулга, нэмэлт асуултад тухай бүр нь хариу тайлбар өгч ажиллаж байгаа бөгөөд Хамтын ажиллагааны зөвлөлөөс Зөвлөмж 1-ийн хувьд үнэлгээчидтэй 2 удаа тайлангийн төсөл дээр санал солилцсоны эцэст үнэлгээг ахиулах боломжтой гэсэн дүгнэлтэд хүрээд байна. Тайланг эцэслэхээс өмнө хөндлөнгийн хяналт хийгддэг бөгөөд энэ хүрээнд Индонез улсын үнэлгээч манай тайлантай холбоотой нэмэлт тодруулга, саналаа ирүүлсэнд бид 2021 оны 6 дугаар сард хариу тайлбар бэлтгэн хүргүүлээд байна.

Монгол Улс нь ФАТФ-ын техник хэрэгжилтийн 40 зөвлөмжөөс 37 зөвлөмжийг “Дийлэнхийг биелүүлсэн” болон “Бүрэн биелүүлсэн” гэсэн үнэлгээг авсан бөгөөд 3 зөвлөмжийн хувьд хагас биелүүлсэн гэж үнэлүүлсэн байна. Үүнтэй холбоотойгоор “Хэсэгчлэн биелүүлсэн” үнэлгээтэй 3 зөвлөмжийн үнэлгээг ахиулах, бусад зөвлөмжүүдийн үнэлгээг хэвээр хадгалах зорилгоор 2020 оны 5 дугаар сарын 25-ны өдөр Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Үндэсний зөвлөлийн дарга бөгөөд Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар “ФАТФ-ын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх 40 Зөвлөмжийн техник хэрэгжилтийн дутагдлыг сайжруулах ажлын төлөвлөгөө”-г баталж, холбогдох байгууллагуудыг хэрэгжүүлж ажиллахыг үүрэг болгосон.

Улмаар Санхүүгийн мэдээллийн албанаас Үндэсний зөвлөл, Хамтын ажиллагааны зөвлөлийн гишүүн байгууллагуудтай хамтран ФАТФ-ын 40 Зөвлөмжийн техник хэрэгжилтийн үнэлгээг ахиулах хүрээнд Монгол Улсын 2021 оны Явцын тайланг боловсруулж, Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэгт 2021 оны 2 дугаар сарын 1-ний өдөр хүргүүлсэн. Уг Явцын тайланд “Хэсэгчлэн биелүүлсэн” үнэлгээтэй 1, 8, 15 гэсэн 3 Зөвлөмжийн үнэлгээг ахиулах зорилгоор гаргасан ахиц дэвшлийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг тусгасан. Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгийн үнэлгээний багаас ирүүлсэн хүсэлтийн дагуу холбогдох нэмэлт мэдээлэл, тайлбарыг тухай бүр хүргүүлээд байна. Улмаар Явцын тайлангийн талаар үнэлгээний багтай 2021 оны 5 дугаар сарын 14-ний өдөр цахим уулзалт зохион байгуулсан.

Зөвлөмж 1-ийн дагуу улс орнууд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлээ тодорхойлох үүрэгтэй бөгөөд эрсдэлийг хэрхэн бууруулах, удирдах талаарх бодлого, стратегийг гаргасан байхыг шаарддаг байна. Иймд Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хуулийн дагуу Санхүүгийн мэдээллийн албанаас Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх Үндэсний эрсдэлийн үнэлгээг хийж гүйцэтгэх ажлыг зохион байгуулж, холбогдох

төр болон хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран ажиллалаа. Мөн уг зөвлөмжийн хүрээнд Монголбанкны Ерөнхийлөгчийн 2021 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн А-31 тоот тушаалаар “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам”-д холбогдох нэмэлт өөрчлөлтүүдийг оруулсан нь мэдээлэх үүрэгтэй этгээдүүд эрсдэлд суурилсан аргачлалын хүрээнд бага эрсдэлтэй харилцагчийн хувьд хялбаршуулсан таньж мэдэх үйл ажиллагааг явуулах боломжийг бүрдүүлэв. Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгээс Монгол Улсыг зохицуулалттай салбаруудын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээг тогтмол хийж гүйцэтгэн, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тогтолцоог сайжруулсан гэж дүгнэсэн бөгөөд техник хэрэгжилтийн Зөвлөмж 1-ийн үнэлгээг ахиулж, “Дийлэнхийг биелүүлсэн” үнэлгээтэй болгохоор тогтоод байна. Үнэлгээний үр дүнг 2021 оны 7 дугаар сард болох хуралдаанаар баталгаажуулах юм.

Зөвлөмж 8-ын үнэлгээг ахиулах хүрээнд ашгийн бус байгууллагын салбарын хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгох, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээ хийх, эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоог бий болгох, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах, уг салбартай холбоотой мөрдөн шалгах, яллах үйл ажиллагааг эрчимжүүлэх чиглэлээр авсан холбогдох арга хэмжээний талаар Явцын тайланд тусгалаа. Тухайлбал, Санхүүгийн мэдээллийн албанаас Хууль зүй, дотоод хэргийн яам болон Терроризмтой тэмцэх зөвлөлтэй хамтран ашгийн бус байгууллагын салбарын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээг хийж гүйцэтгэсэн. Мөн энэ салбарын хууль, эрх зүйн орчинг бүрдүүлэх чиглэлээр боловсруулсан Холбооны эрх зүйн байдлын тухай, Сангийн эрх зүйн байдлын тухай болон Нийгэд тустай үйл ажиллагааны тухай хуулийн төслийг батлуулах чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж байна. Уг хуулийн төслүүдийг батлуулснаар ашгийн бус байгууллагын салбарын хяналт шалгалт, зохицуулалтын тогтолцоо, хууль эрх зүй орчинг бүрдүүлж Зөвлөмж 8-ын шаардлагыг хангах нөхцөл бүрдэнэ.

Зөвлөмж 15 буюу шинэ технологитой холбоотой шаардлагуудын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд ФАТФ-аас дэлхийн улс орнуудад явуулсан судалгаагаар нийт 115 гаруй улс орнууд виртуал хөрөнгийн салбарын үйл ажиллагааг хүлээн зөвшөөрч, зохицуулалтын орчинг бий болгохоор ажиллаж байна. Зөвлөмжийн хүрээнд Монголбанкны Ерөнхийлөгчийн 2020 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн А-23 дугаартай тушаалаар виртуал хөрөнгийн салбарын хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгох, хуулийн төслийг боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан. Санхүүгийн мэдээллийн албанаас тус ажлын хэсэгт идэвхитэй орж ажилласан. Улмаар Виртуал хөрөнгийн салбарын талаарх олон улсын туршлага, хууль, эрх зүйн орчинтой холбоотой судалгааг хийж гүйцэтгэсэн бөгөөд холбогдох байгууллагуудтай хамтран виртуал хөрөнгийн салбарын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээг хийж гүйцэтгэсэн.

Түүнчлэн Санхүүгийн мэдээллийн алба, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо болон бусад эрх бүхий байгууллагуудтай хамтран Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн төслийг боловсруулсан. Тус хуулийн төслийг Засгийн газраас өргөн мэдүүлсэн бөгөөд 2021 оны 6 дугаар сарын 17-ны өдөр Улсын Их Хурлаар хэлэлцэхийг дэмжсэн. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн төсөлд виртуал хөрөнгө болон виртуал хөрөнгийн үйлчилгээг ФАТФ-ын шаардлагад нийцүүлэн тодорхойлж, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч, түүний үйл ажиллагаанд баримтлах зарчим, тавигдах шаардлага, бүртгэх, хяналт тавих, холбогдох эрх, үүргийг тусгаж, хамтын ажиллагаа, хариуцлагын тогтолцоог бүрдүүлэхийг зорьсон. Уг хуулийн төсөл батлагдсанаар виртуал хөрөнгийн салбарын хууль эрх зүйн орчинг бүрдүүлж, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдийг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлээс урьдчилан сэргийлэх, ФАТФ-ын техник хэрэгжилтийн зөвлөмжийн стандартыг хангах ач холбогдолтой юм.

Монгол Улсын ФАТФ-ын техник хэрэгжилтийн 40 Зөвлөмжийн үнэлгээ дараах үр дүнтэй байна. Үүнд:

Үнэлгээ	Зөвлөмжийн тоо
Биелүүлсэн (C)	8
Дийлэнхийг биелүүлсэн (LC)	30
Хэсэгчлэн биелүүлсэн (PC)	2
Биелүүлээгүй (NC)	0
Нийт зөвлөмж	40

2022 онд ФАТФ, Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэг болон олон улсын холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж, Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх ФАТФ-ын 40 Зөвлөмжийн үнэлгээг ахиулах зорилгоор үргэлжлүүлэн ажлын явцыг тайлагнаж ажиллах болно.

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх Үндэсний эрсдэлийн үнэлгээг хийж гүйцэтгэх тухай

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхтэй холбоотой Үндэсний эрсдэлийн үнэлгээг хийх ажлыг Дэлхийн банкны техник туслалцаатайгаар гүйцэтгэхээр тохиролцсон. Энэ хүрээнд Сангийн сайдын 2020 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн 20 дугаар тушаалаар Үндэсний эрсдэлийн үнэлгээг хийх ажлын хэсэг байгуулагдав. Ажлын хэсэгт төрийн байгууллагууд болон холбогдох бүхий л салбарын хувийн хэвшлийн төлөөлөл оролцож, банк, үнэт цаас, даатгал, банк бус санхүүгийн байгууллага, санхүүгийн бус бизнес мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчид зэрэг салбар тус бүрийн хувьд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээг хийж ажиллав. Улмаар Сангийн сайдын 2020 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн 90 дугаар тушаалаар нийт 10 салбарын эрсдэлийг үнэлж, тайлагнах дэд ажлын хэсгүүдийг байгуулан ажиллаж байна. Банкны салбарын эрсдэлийн үнэлгээг хийх дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Санхүүгийн мэдээллийн алба (СМА), 13 банкны төлөөлөл, Монголын банкны холбоо төлөөллийг оролцуулан Монголбанк ахлан ажиллаж байна. Энэ дэд ажлын хэсэг банкны салбарын эрсдэлийн үнэлгээний тайлангийн эхний төслийг англи, монгол хэл дээр боловсруулан Дэлхийн банкны техник туслалцааны багт танилцуулан санал, зөвлөгөө авч тусгасан.

Дээрх эрсдэлийн үнэлгээний тайлангийн үр дүнд тулгуурлан цаашид банкны салбарт авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний төслийг боловсруулан Үндэсний хөтөлбөрт тусгуулахаар хүргүүлээд байна.

2. Монгол Улсын үнэлгээний үр дүнтэй байдлыг дээшлүүлэх зорилгоор олон улсын болон дотоодын байгууллагуудтай хамтран ажиллах

Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог бэхжүүлэх чиглэлээр Санхүүгийн мэдээллийн албанаас олон улсын байгууллагууд болон Үндэсний зөвлөл, Хамтын ажиллагааны зөвлөлийн гишүүн байгууллагууд болон хувийн хэвшилтэй хамтран ажиллаж байна.

Хамтын ажиллагааны зөвлөлийн гишүүн байгууллагуудын бүтэц, орон тоо өөрчлөгдөж, дийлэнх албан тушаалтнууд солигдсонтой холбоотойгоор Монголбанкны Ерөнхийлөгчийн 2021 оны 5 дугаар сарын 04-ний өдрийн А-110 тоот тушаалаар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан. Улмаар Санхүүгийн мэдээллийн албанаас 2021 оны 5 дугаар сарын 13-ны өдөр Хамтын ажиллагааны зөвлөлийн ээлжит хурлыг шинээр томилогдсон бүрэлдэхүүнтэйгээр зохион байгуулав. Тус хуралдаанаар Хамтын ажиллагааны зөвлөлийн дэргэдэх ажлын хэсгүүдийг шинэчлэн байгуулах, Монгол Улсын 2021 оны Явцын тайлангийн хүрээнд цаашид авч хэрэгжүүлэх шаардлагатай ажлууд, ФАТФ-ын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх 40 зөвлөмжийн техник хэрэгжилтийн дутагдлыг сайжруулах ажлын төлөвлөгөөний хэрэгжилт,

Үндэсний эрсдэлийн үнэлгээний ажлын явц болон Үндэсний хөтөлбөрийн талаар хэлэлцсэн.

Гадаад хамтын ажиллагааны хүрээнд Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх Үндэсний эрсдэлийн үнэлгээг Дэлхийн банкны техник туслалцааны хүрээнд хийж гүйцэтгэсэн. Мөн виртуал хөрөнгийн үйлчилгээг үзүүлэх хууль, эрх зүйн орчныг бий болгох чиглэлээр төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын боловсон хүчнийг чадавхжуулах зорилгоор Санхүүгийн мэдээллийн албанаас гадны донор байгууллагуудтай хамтран сургалтуудыг амжилттай зохион байгуулав. Тухайлбал, АНУ-ын Сангийн яамны техник туслалцааны хүрээнд зөвлөхүүдтэй хамтран холбогдох төрийн байгууллагуудад виртуал хөрөнгийн салбарын талаарх ойлголт, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой сэжигтэй үйлдлүүдийг хэрхэн таньж мэдэх талаарх сургалтуудыг зохион байгуулсан. Түүнээс гадна олон улсын судалгааны байгууллага болох Чэйналисис компани, Япон Улсын Санхүүгийн үйлчилгээний агентлаг, Дэлхийн банкны мэргэжилтнүүдтэй хамтран зохион байгуулсан сургалтуудад нийтдээ 20 гаруй байгууллагын 100 гаруй төлөөлөгчид хамрагдсан.

ФАТФ, Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэг, Евро-Азийн мөнгө угаахтай тэмцэх бүлэг, Эгмонт бүлэг зэрэг олон улсын байгууллагуудаас 2021 оны эхний хагас жилд хийсэн сургалт, семинаруудыг Санхүүгийн мэдээллийн албанаас төр, хувийн хэвшлийн байгууллага болон мэргэжлийн холбоодын давхардсан тоогоор нийт 300 гаруй албан тушаалтнуудыг хамруулж, зохион байгуулах ажлуудыг идэвхтэй хийж гүйцэтгэв. Мөн ФАТФ-аас явуулсан дэлхийн улс орнуудын виртуал хөрөнгө, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдийн зохицуулалтын орчны талаарх судалгаанд хамрагдсан.

3. Монгол Улсын Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Үндэсний хөтөлбөрийг багтах

ФАТФ-аас гаргасан Зөвлөмж 1-ийн дагуу улс орнууд өөрсдийн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх Үндэсний эрсдэлийн үнэлгээг хийж гүйцэтгэх, түүний үр дүнд тулгуурлан эрсдэлд суурилсан аргачлалыг хэрэгжүүлж, тухайн эрсдэл үүсэхээс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээг авахыг зөвлөсөн байдаг. Үүнтэй холбоотойгоор 2016 онд Монгол Улсын анхны Үндэсний эрсдэлийн үнэлгээний тайланг боловсруулж гаргасан бөгөөд 2017 онд Засгийн газрын 143 дугаар тогтоолоор “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг батлуулсан. Уг хөтөлбөрийг 2017-2019 онд хэрэгжүүлж, улмаар 2020 онд хэрэгжилтийг үнэлсэн.

Иймд Сангийн сайдын 2020 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн 20 дугаар тушаалаар Үндэсний эрсдэлийн үнэлгээг хийх ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсэгт төрийн байгууллагууд, холбогдох бүхий л салбарын хувийн хэвшлийн төлөөлөл болон мэргэжлийн холбоод оролцож, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээг хийж ажиллав. Улмаар Сангийн сайдын 2020 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн 90 дүгээр тушаалаар батлагдсан нийт 11 дэд ажлын хэсэгт 52 байгууллагын 128 төлөөлөгчдөөс бүрдсэн том баг салбар тус бүрийн эрсдэлийн үнэлгээг Дэлхийн банкны аргачлалын дагуу дараах модулийн хүрээнд хийж гүйцэтгэв. Үүнд:

- | | |
|-----------|---|
| Модуль 1. | Мөнгө угаах аюул заналхийллийг үнэлэх дэд ажлын хэсэг |
| Модуль 2. | Үндэсний эмзэг байдлыг үнэлэх дэд ажлын хэсэг |
| Модуль 3. | Банкны салбарын эмзэг байдлыг үнэлэх дэд ажлын хэсэг |
| Модуль 4. | Үнэт цаасны салбарын эмзэг байдлыг үнэлэх дэд ажлын хэсэг |
| Модуль 5. | Даатгалын салбарын эмзэг байдлыг үнэлэх дэд ажлын хэсэг |
| Модуль 6. | Банк бус санхүүгийн байгууллагын салбарын эмзэг байдлыг үнэлэх дэд ажлын хэсэг |
| Модуль 7. | Санхүүгийн бус бизнес мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдийн салбарын эмзэг байдлыг үнэлэх дэд ажлын хэсэг |

- Модуль 8. Терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг үнэлэх дэд ажлын хэсэг
- Модуль 9. Санхүүгийн хүртээмжтэй бүтээгдэхүүний эрсдэлийг үнэлэх дэд ажлын хэсэг
- Модуль 10. Ашгийн бус байгууллагын эмзэг байдлыг үнэлэх дэд ажлын хэсэг

Үндэсний эрсдэлийн үнэлгээг хийснээр мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх нөөц бололцоог зохистой хуваарилах, болзошгүй эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх боломж нөхцөл бүрдэх юм. Мөн түүнчлэн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны бодит үр нөлөөг дээшлүүлэх, Шууд хэрэгжилтийн үр дүнг сайжруулах, тогтолцоог чанаржуулах ач холбогдолтой. Иймд Үндэсний эрсдэлийн үнэлгээний тайланг эцэслэх ажлын хүрээнд Сангийн сайдын тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн бүрэлдэхүүний Дэлхийн банкны зөвлөхүүдтэй 2021 оны 06 дугаар сарын 04-ний өдөр хийсэн цахим уулзалтыг Санхүүгийн мэдээллийн албанаас зохион байгуулав. Уг уулзалтаар эрсдэлийн үнэлгээний тайлантай холбоотой тулгамдаж буй асуудлууд болон эрсдэлийн үнэлгээний үр дүнгийн талаар хэлэлцэж Дэлхийн банкны зөвлөхүүдээс санал зөвлөмжүүд авсан.

Энэ хүрээнд эрсдэлийн үнэлгээний тайлангийн урьдчилсан үр дүнд үндэслэн “Монгол Улсын Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дунд хугацааны Үндэсний хөтөлбөр” болон түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг Санхүүгийн мэдээллийн албанаас боловсруулж, Терроризмтой тэмцэх зөвлөлийн хуралдаанд танилцуулсан. Цаашид хөтөлбөр болон төлөвлөгөөний төсөлд холбогдох саналуудыг тусган сайжруулж, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх Үндэсний зөвлөл болон Хамтын ажиллагааны зөвлөлөөр хэлэлцүүлэн, Засгийн газар, Улсын Их Хуралд танилцуулж батлуулахаар төлөвлөж байна.

Үндэсний хөтөлбөр болон түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг бууруулах, ФАТФ-ын техникийн хэрэгжилт болон үр дүнтэй байдлыг нэмэгдүүлэх асуудлуудыг дэлгэрэнгүй тусгах бөгөөд Санхүүгийн мэдээллийн алба, Монголбанк, Хууль зүй, дотоод хэргийн яам, Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороо, хууль сахиулах байгууллагууд болон бусад холбогдох байгууллагууд хамтран хэрэгжүүлж ажиллах болно.

Түүнчлэн энэхүү Үндэсний хөтөлбөрөөр дамжуулан Улсын Их Хурлын 2020 оны 52 тоот тогтоолоор батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 2021-2030 оны хооронд хэрэгжүүлэх үйл ажиллагаа, Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Улсын Их Хурлын 2020 оны 24 дугаар тогтоолоор батлагдсан Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах ач холбогдолтой юм.

2. Санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах эрх зүйн орчныг сайжруулж, санхүүгийн маргааныг олон улсын шилдэг туршлагад үндэслэн шийдвэрлэх оновчтой тогтолцоог бүрдүүлэх

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2021 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн А-6 дугаар тушаалаар “Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай” хуулийн төслийг боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан бөгөөд 2018 оны 3 дугаар сард Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Азийн хөгжлийн банк (АХБ)-тай хамтран байгуулсан “Санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах салбарын хөгжлийг дэмжих, мэдлэг олгох техникийн туслалцаа”-ны төслийн хүрээнд “Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай” хуулийн төслийг дотоодын болон гадаад зөвлөхийн туслалцаатайгаар дахин шинэчлэн боловсруулж байна. Энэхүү шинэчлэн боловсруулсан хуулийн төслийг бусад төрийн болон санхүүгийн байгууллагуудад танилцуулан санал авах зорилгоор 2021 оны 5 дугаар сарын 18-ны өдөр банкууд буюу Монголын банкны холбоо, банк бус санхүүгийн байгууллага болон санхүүгийн мэргэжлийн холбоодод, 2021 оны

7 дугаар сарын 01-ний өдөр шүүх, хууль сахиулах төрийн байгууллагын төлөөллүүдэд цахим семинарыг тус тус амжилттай зохион байгууллаа. Ажлын хэсгийн зүгээс хуулийн төслийг 2021 оны УИХ-ын намрын чуулганаар, хэлэлцүүлэн батлуулахаар хууль санаачлагчид уламжлахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

Уг хуулийн төсөл батлагдсанаар Улсын Их Хурлаас 2021 оны 5 дугаар сарын 21-ний өдөр баталсан Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуульд заасан санхүүгийн үйлчилгээний шаардлага, гэрээ, хэлцлийн зохицуулалт бодитой хэрэгжиж, санхүүгийн салбар дахь хэрэглэгчийн эрх, үүрэг болон санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчээс үзүүлэх санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний нэгдсэн стандартыг баталгаажуулах, үүгээрээ санхүүгийн аливаа гомдол, маргааныг шүүхийн бус журмаар хурдан шуурхай, зардал багатай шийдвэрлэдэг байх эрх зүйн орчин сайжирна гэж үзэж байна.

3. Санхүүгийн гэрээ, хэлцэлд оролцогч талуудын үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлж, тэдгээрийн хооронд үүссэн маргааныг шүүхээс богино хугацаанд үр дүнтэй шийдвэрлэх, барьцаалагчийн шаардах эрхийг хангуулах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд төлбөр авагчийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр хууль, эрх зүйн орчныг сайжруулах

Улсын Их Хурлын 2020 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн “Зээлийн хүүг бууруулах стратеги батлах тухай” 21 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Зээлийн хүүг бууруулах стратеги”-ийн хэрэгжилтийг хангах, үүргийн гүйцэтгэлийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмаар хангуулахад гардаг аливаа хүндрэлийг бууруулах зорилгоор Хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хууль, Хөрөнгийн үнэлгээний тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль, Санхүүгийн түрээсийн тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Татварын багц хууль, Зээлийн мэдээллийн тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, Хөдлөх хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хууль болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн саналыг боловсруулах чиг үүрэг бүхий Ажлын хэсгийг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2020 оны 11 дүгээр сарын 3-ны өдрийн А-411 дүгээр тушаалаар байгуулж, хууль тогтоомжид заасан хэрэгцээ шаардлагын тандан болон үр нөлөө, зардлын холбогдох судалгааг хийж дуусав.

Мөн үүргийн гүйцэтгэлийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмаар хангуулахад гардаг аливаа хүндрэлийг бууруулах зорилгоор Иргэний хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд холбогдох нэмэлт, өөрчлөлтийг оруулах тухай хуулийн төслийн саналын боловсруулж Хууль, зүй дотоод хэргийн яаманд хүргүүлсэн бөгөөд хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэлд тусгагдсан хуулийн багц шинэчлэлд тусгуулахаар ажиллаж байна.

4. Банкны салбарын актив хөрөнгийг ангилж, эрсдэлийн сан байгуулж, зарцуулах эрх зүйн зохицуулалтыг олон улсын шилдэг туршлага, зөвлөмж, Монгол Улсын банкны салбарын онцлогт тулгуурлан боловсронгуй болгож, үе шаттайгаар мөрдүүлэх

Банкны актив хөрөнгийг ангилж, эрсдэлийн сан байгуулж, зарцуулах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох үйл ажиллагааны хүрээнд “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-ын төслийг шинэчлэн боловсруулж, Захиргааны Ерөнхий хуулийн дагуу банкуудад хэлэлцүүлсэн. Журмыг баталж, мөрдүүлэх төлөвлөгөөтэй байсан боловч Ковид-19 цар тахалтай холбоотойгоор журмын шинэчилсэн найруулгын төслийг батлуулах хугацааг хойшлуулсан.

5. Банк, санхүүгийн үйлчилгээний цахим шилжилтийг эрчимжүүлэх

Улсын Их Хурлын 2020 оны 32 дугаар тогтоолоор баталсан “Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлын үед санхүү, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, эрсдэлээс урьдчилан

сэргийлэх, төрийн үйлчилгээнд цахим шилжилт хийх арга хэмжээ”-ний дагуу, түүнчлэн “Цахим засаглал, ухаалаг дэд бүтцийг хөгжүүлэх” хөгжлийн бодлоготой уялдуулан банк, санхүүгийн үйлчилгээний цахим шилжилтийг хийж байна. Тухайлбал оролцогч талууд цахим хэлбэрээр хүсэлт гаргах, баримт бичгийг бүрдүүлэх, цахим архив бий болгохтой холбогдсон эрх зүйн зохицуулалтыг бий болгох зайлшгүй хэрэгцээ шаардлага бий болсон тул УИХ-ын 2021 оны хаврын ээлжит чуулганы хуралдаанаар Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн шинэчилсэн найруулгад дээрх зохицуулалтыг тусган батлуулсан.

Хэрэглэгчийн авч байгаа үйлчилгээний чанарыг сайжруулж, технологийн дэвшилээр санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зардлыг бууруулах, шинэ орлогын эх үүсвэрийг бий болгох, улмаар хүү, шимтгэлийг бууруулах зэрэг нь цахим шилжилтийн үндсэн зорилго, алсын хараа юм. Цахим шилжилтийг хийхдээ дараах хүчин зүйлсийг зохицуулсан хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэхээр Засгийн газраас Нийтийн мэдээллийн тухай хуулийн төсөл, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн төслийг УИХ-ын нэгдсэн чуулганы хуралдаанаар хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлээд байна. Монголбанкнаас хууль санаачлагч болон хууль тогтоогчидтой уг хуулийн төсөлд санал өгөх, ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллах зэргээр хамтран ажиллаж байна:

- Харилцагчийг таньж мэдэх, эцсийн өмчлөгчийг цаг алдалгүй тогтоох зорилгоор мэдээллийн эх үүсвэр (Улсын Бүртгэлийн Ерөнхий Газрын мэдээллийн сан гэх мэт)-т банк, санхүүгийн зохицуулагч байгууллага болон банк, санхүүгийн байгууллага хандах эрх бүхий дэд бүтцийг бий болгох, боловсронгуй болгох;
- Big data буюу их өгөгдлийг боловсруулах, түүний аюулгүй байдлыг хангах;
- AI буюу хиймэл оюун ухааны тусламжтайгаар мэдээллийн боловсруулалт хийх замаар харилцагчийн онцлог, хэв маягт тохирсон оновчтой санхүүгийн зуучлагчийн үйлчилгээ үзүүлэх боломжийг бүрдүүлэх, холбогдох хувийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах;
- Үйлчилгээний болон холбогдох зардлыг бууруулах, аюулгүй байдлыг хангах зэрэг зорилгоор шинэ технологид суурилсан төлбөрийн болон бусад системийг хөгжүүлэх;
- Мэдээллийн сангийн аюулгүй байдлыг хангах, мэдээллийн технологиос үүдэлтэй зардлыг бууруулах зэрэг зорилгоор Үүлэн технологийг нэвтрүүлэх.

УИХ-аас 2020 оны хаврын чуулганаар Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталсан бөгөөд тус хуулиар цахим албан хэрэг хөтлөлт, архив үүсгэхтэй холбогдсон харилцааг зохицуулсан хууль, эрх зүйн орчин бүрдүүлсэн ба цахим нотлох баримт, цахим нотлох баримт хуульд заасны дагуу бүрдүүлэх, аливаа этгээдийн хооронд үүссэн хэрэг, маргааныг үр дүнтэй, түргэн шуурхай хянан шийдвэрлэх чухал ач холбогдолтой.

Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.10 дахь хэсэгт “Цар тахлын үед банкнаас цахим хэлбэрээр төрөөс хэрэгжүүлж байгаа орон сууцны ипотекийн хөнгөлөлттэй хүүтэй зээл болон бусад зээлийн гэрээнд өөрчлөлт оруулахтай холбоотой журмыг Монголбанк батлах”-аар заасны дагуу “Банкнаас цахим хэлбэрээр зээлийн гэрээнд өөрчлөлт оруулах түр журам»-ыг 2021 оны 4 дүгээр сарын 12-ны өдөр баталж, Хууль зүйн дотоод хэргийн яаманд бүртгүүлэв. Тус хуулийн үйлчлэх хугацааг 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал сунгасантай холбогдуулан журамд төрөөс хэрэгжүүлж буй хөнгөлөлттэй хүүтэй ипотекийн болон бусад зээлийн гэрээнд цахимаар өөрчлөлт оруулах зохицуулалтыг хуультай нийцүүлэн мөн хугацаагаар сунгах өөрчлөлт орууллаа.

6. Олон улсын сайн туршлагад үндэслэн орон сууцны ипотекийн зээлийн санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх

Төв банк (Монголбанк)-ны тухай хууль, эрх зүйн зохицуулалт, олон улсын байгууллагуудын шаардлагын дагуу орон сууцны ипотекийн зээлийн хөтөлбөрийг 2020 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн Засгийн газарт шилжүүлэх ажлыг хийж гүйцэтгэхээр хөтөлбөрийн санхүүжилтийг зогсоогоод байв. Энэхүү ажлын хүрээнд Засгийн газраас “хүүгийн хөнгөлөлт олгох” зарчмаар тус хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр шийдвэрлэж, холбогдох журмын төслийг боловсруулаад байв.

Харин Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль (цаашид “цар тахлын тухай хууль” гэх), УИХ-ын 2020 оны 32 дугаар тогтоолын дагуу цар тахлын үед хөтөлбөрийн тасралтгүй байдлыг хангаж ажиллах шаардлага бий болж Монголбанк хөтөлбөрийг цар тахлын тухай хуулийн хэрэгжилтийн хугацаанд санхүүжүүлж байна.

Мөн Монгол Улсын Засгийн газраас баталсан “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-ний хэрэгжилтийн хугацаанд хөтөлбөрийн санхүүжилтийн хэмжээг нэмэгдүүлэхээр ажиллаж байна.

Дээрх шаардлага болон төлөвлөгөөний хүрээнд хөтөлбөрийн Монголбанк болон Засгийн газрын оролцоог тодорхой болгож, олон улсын туршлагад суурилсан бүтэц, санхүүжилтийн схемийг сайжруулах зорилгоор дараах ажлуудыг хийж гүйцэтгээд байна. Үүнд:

1. Монгол Улсын Их Хурлын дэргэдэх Эдийн засгийн байнгын хороонд үүсээд буй нөхцөл байдлын талаар мэдээллийг хүргүүлэх;
2. Сангийн сайд, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2018 оны 285/А-334 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Монголбанкийг орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоо бүрдүүлэх хөтөлбөрөөс гаргах төлөвлөгөө”-нд холбогдох нэмэлт, өөрчлөлтийг оруулах;
3. Монголбанкны зүгээс хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлэгч банкууд болон бусад талуудтай “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн ерөнхий гэрээ” болон “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн эх үүсвэрийн гэрээ”-г шинэчлэн батлах.

Үр дүнд нь 2021 оны эхнээс 2 дугаар улирлын эцсийн байдлаар Монголбанк болон банкуудын эх үүсвэрээр 447.1 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй хүүтэй ипотекийн зээлийг 6,045 өрхөд олгосон буюу ипотекийн хөнгөлөлттэй хүүтэй хөтөлбөр хэрэгжиж эхэлснээс хойш нийт 5.5 их наяд төгрөгийн хөтөлбөрийн зээлийг Монголбанк, Засгийн газар, банкуудын эх үүсвэрээр 95.6 мянган өрхөд олгоод байна.

7. “Зээлийн хүүг бууруулах стратеги”-ийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулан хэрэгжилтийг хангах

Улсын Их Хурлын 2020 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн “Зээлийн хүүг бууруулах стратеги батлах тухай” 21 дүгээр тогтоолоор зээлийн хүүг 2019 оны суурь түвшнээс 4 нэгж хувиар бууруулж, 2023 оны эцэст сарын 1 хувьд хүргэх зорилтыг тавьсан. Тус стратегийн хүрээнд зээлийн эх үүсвэрийн зардлыг бууруулах макро тогтвортой орчныг бүрдүүлэх, зээлийн эрсдэлийн зардлыг бууруулах, банкны үйл ажиллагааны зардлыг бууруулах, хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, өрсөлдөөнийг бий болгож санхүүжилтийн зардлыг бууруулах үндсэн чиглэлээр холбогдох байгууллагууд шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр тусгасан. Мөн уг стратегийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, биелэлтийг заасан хугацаанд Улсын Их Хуралд танилцуулах чиг үүрэг бүхий Ажлын хэсэг Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Сангийн сайд, Хадгаламжийн даатгалын корпорацийн гүйцэтгэх

захирлын А-410/348/200/151 дугаартай хамтарсан тушаалаар холбогдох төрийн байгууллага, төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулан байгуулагдан Монголбанкны Тэргүүн Дэд ерөнхийлөгчөөр ахлуулан ажиллаж байна.

Зээлийн хүүг бууруулах стратегийн зорилт, үр дүнд тогтоосон хугацаанд хүрэх, стратегийн арга хэмжээг бодитой хэрэгжүүлэх үүднээс төрийн байгууллагаас гарах шийдвэрийн уялдаа холбоог ханган түргэн шуурхай гаргах, шаардлагатай хууль тогтоомжийн өөрчлөлтийн төслийг боловсруулж, хэрэгжилтийг эрчимжүүлэх үүднээс Монголбанкны Ерөнхийлөгчийн²⁰ болон Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны дарга нарын шийдвэрээр²¹ тус тус холбогдох төрийн байгууллага, үнэт цаасны зах зээлийн дэд бүтцийн байгууллага болон мэргэжлийн холбоодын төлөөллөөс бүрдсэн ажлын хэсгүүд байгуулагдан ажиллаж байна.

Мөнгөний бодлогын хороо 2021 оны 3, 6 дугаар саруудад хуралдаж, эдийн засаг, санхүүгийн зах зээлийн өнөөгийн байдал, ирээдүйн төлөв болон гадаад, дотоод орчны тодорхой бус байдал, үүсэж буй эрсдэл, бодлогын хувилбаруудыг хэлэлцэв. Дээрх хурлуудаар 1) бодлогын хүүг 6 хувьд хэвээр хадгалах, 2) жижиг, дунд үйлдвэрлэл, уул уурхайн бус экспортыг дэмжихэд зориулсан урт хугацаат дахин санхүүжилтийн хэрэгслээр 2021 оны 2 дугаар улиралд 350 тэрбум хүртэлх, 3 дугаар улиралд 250 тэрбум хүртэлх төгрөгийн санхүүжилт олгох, уг санхүүжилтийг боловсруулах, үйлчилгээ болон 200 дээш ажиллагчидтай худалдааны салбарын аж, ахуйн нэгжүүдийг хамруулах шийдвэрийг гаргав. Энэхүү шийдвэрүүд нь банкны салбараас эдийн засгийн бодит секторт олгох зээлийн хэмжээг нэмэгдүүлэх, зээлийн хүү буурах зах зээлийн нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн болно.

Дотоодод цар тахлын тархалт өндөр байгаа хэдий ч хөл хорио суларсан, эдийн засгийн үйл ажиллагаа хэсэгчлэн сэргэж байгаагаас эрэлтийн шалтгаантай инфляц 2 дугаар улирлын дунд үеэс алгуур нэмэгдэх хандлагатай боллоо.

Сүүлийн саруудад дотоодод тархсан Ковид-19 цар тахлын нөлөөгөөр эдийн засгийн идэвхжил суларч, эрэлтийн шалтгаантай инфляц бага байна. Инфляц нам түвшинд харьцангуй тогтвортой байсан нь мөнгөний бодлогын төлөвийг зөөлрүүлэх тодорхой хэмжээний бодлогын орон зайг олгосон тул Монголбанкнаас эдийн засгийг дэмжих, зээлийн хүү буурах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор бодлогын хүүг түүхэн доод хэмжээнд хүргэж бууруулаад байна.

Дээр дурдсан арга хэмжээний үр дүнд шинээр олгосон төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү / ЖДХ/ 2021 оны 6 дугаар сарын байдлаар 14.8 хувь, гадаад валютын зээлийн ЖДХ 7.62 хувь болж, шинээр олгосон төгрөгийн зээлийн хүү өмнөх оны мөн үеэс 1.6 нэгж хувиар буурсан үзүүлэлтэй байна. Шинээр олгосон зээлийн ЖДХ 2021 оны 6 дугаар сард 14.8%, шинээр татсан төгрөгийн эх үүсвэр (Харилцах + Хадгаламж)-ийн ЖДХ 6.1% хувьд хүрч түүхэн доод түвшинд хүрээд байна.

Банкны салбар дахь хувь эзэмшлийн төвлөрлийг бууруулах, ил тод нээлттэй, олон нийтийн хяналттай эрх зүйн орчныг бий болгох үүднээс банкны салбарын шинэтгэлийн хөтөлбөрийг Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар баталсан. Уг хөтөлбөрийн хүрээнд банкны хувь эзэмшлийн төвлөрлийг бууруулахтай холбоотой Банкны тухай хуульд оруулах нэмэлт өөрчлөлтийн хуулийн төслийг, Банкны тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн хамт боловсруулж УИХ-ын 2020 оны намрын чуулганаар хэлэлцүүлж, батлуулсан. Банкныг хувьцаат компанийн хэлбэрээр өөрчлөн байгуулах, банкны хувь эзэмшлийн төвлөрлийг бууруулах зохицуулалтын хүрээнд “Банкийг хувьцаат хэлбэртэйгээр өөрчлөн байгуулах, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өөрчлөх

²⁰ Монголбанкны Ерөнхийлөгчийн 2020 оны 11 дүгээр сарын 3-ны өдрийн А-411 дүгээр тушаалаар Зээлийн хүүг бууруулах стратегийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд холбогдох хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна.

²¹ Хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, өрсөлдөөнийг бий болгож санхүүжилтийн зардлыг бууруулах чиглэлд хамаарах арга хэмжээний хэрэгжилтийг хангуулах зорилго бүхий Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Сангийн сайдын 2020 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн 329/187 дугаар хамтарсан тушаалаар Ажлын хэсэг байгуулагдсан.

төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх, тайлагнах, хянах түр журам"-ыг Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны дарга нарын 2021 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн А-90/85 тоот хамтарсан тушаалаар батлуулж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлсэн.

Мөн Банкны тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд “Банкны системд нөлөө бүхий банкийг тогтоох аргачлал”-ыг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2021 оны 7 дугаар сарын 19-ний өдрийн А/104 тушаалаар баталсан. Энэхүү аргачлалын дагуу банкны системд нөлөө бүхий банкийг жилд нэгээс доошгүй удаа тогтооно.

Монгол Улсын Засгийн газраас олон улсын зээлжих зэрэглэл тогтоогч агентлагуудтай уулзалт зохион байгуулах, Монголбанкны зүгээс банк санхүү, эдийн засаг болон холбогдох бодлогын шийдвэрийн талаар мэдээллээр хангаж, дэмжиж ажиллах хүрээнд олон улсын зэрэглэл тогтоогч Фитч агентлагтай 2021 оны 5 дугаар сарын 6-ны өдөр уулзалт хийж Ковид-19 цар тахлын банкны салбарт үзүүлсэн нөлөөлөл, банкны салбарын нөхцөл байдлын мэдээлэл өгөв.

Түүнчлэн Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулан хууль санаачлагчдад уламжилсан. Тус хуулийн шинэчилсэн найруулга 2021 оны 5 дугаар сарын 21-ний өдөр УИХ-аар “Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль” нэртэйгээр батлагдсан.

Санхүүгийн хэрэгслийг ангилах, хэмжих, түүний үнэ цэнийн бууралтыг тооцох тухай Санхүүгийн тайлагналын олон улсын 9 дүгээр стандартыг банкуудад мөрдүүлэх ажлын хүрээнд активын эрсдэлийн параметр тооцооллыг хийх, шаардлагатай тоон мэдээлэл цуглуулах талаар банкуудтай уулзалт зохион байгуулж танилцуулга хийсэн. Мөн банкуудын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн багц журмыг СТОУС-9 олон улсын стандартын дагуу нийцүүлэхээр олон улсын байгууллагуудтай хамтран ажиллаж байна.

Эдийн засаг, санхүүгийн тогтвортой байдлын төлөвтэй уялдуулан банкны салбараас олгох зээлийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх, эдийн засгийн идэвхжилийг нэмэгдүүлэх, зээлийн хүүг бууруулах ажлын хүрээнд Төв банкны тухай хууль, Улсын Их Хурлын 2020 оны 21 дүгээр тогтоол, 32 дугаар тогтоол, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2020 оны А-425 тушаалаар батлагдсан Репо арилжааны журам, Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны 2020 оны 5, 6, 7 дугаар тогтоол, 2021 оны 1, 2 дугаар тогтоолыг тус тус үндэслэн эдийн засгийн ач холбогдол бүхий салбаруудыг дэмжих зорилгоор 2 жилийн хугацаатай, репо арилжааг зохион байгуулахаар шийдвэрлэсэн.

Дээрх шийдвэрийн дагуу Монголбанкны Мөнгөний бодлогын хороо 2020 оны 4-р улиралд нийт 230 тэрбум төгрөг, 2021 оны 1 дүгээр улиралд 250 тэрбум төгрөг, 2021 оны 2 дугаар улиралд 350 тэрбум төгрөг, 2021 оны 3 дугаар улиралд 250 тэрбум төгрөгийн дүн бүхий санхүүжилтийг банкуудад олгохоор тогтоосноос энэ оны 2 дугаар улирлын байдлаар 755 тэрбум төгрөгийн дүн бүхий репо арилжааг Төв банкнаас хүлээн зөвшөөрсөн активыг барьцаалан хийгээд байна.

2021 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар нийт 822.7 тэрбум төгрөгийн зээлийг дахин санхүүжүүлэх, болон шинээр санхүүжүүлэхээр судалсан бөгөөд үүнээс 552.4 тэрбум төгрөгийн дүн бүхий гэрээг 2517 зээлдэгчтэй байгуулаад байна. Ингэснээр репо арилжаанд хамрагдаж буй салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн өрийн дарамт тодорхой хэмжээнд буурч байгаа бөгөөд 166.9 тэрбум төгрөгийн зээлийг шинээр олгов. Ийнхүү репо арилжааны санхүүжилтийн хэмжээг нэмэгдүүлснээр цар тахлын эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөг богино хугацаанд арилгах, ажлын байрыг хадгалах, зээлийн хүүг бууруулах, дунд, урт хугацааны эдийн засгийн хөгжилд эерэгээр нөлөөлнө гэж үзэж байна.

Олон улсын байгууллагуудтай үүсмэл хэрэгсэл байгуулж, өртөг багатай, төгрөгийн санхүүжилт олгох нөхцөлийг бүрдүүлэх ажлын хүрээнд Европын Сэргээн Босголт, Хөгжлийн банк (EBRD)-

тай “Банк хоорондын валютын үүсмэл хэрэгслийн ерөнхий гэрээ” (ISDA) -г 2021 оны 1 дүгээр сарын 4-ний өдөр байгуулсан. Тус гэрээний дагуу Монголбанк ЕСБХБ-тай 2021 оны 4 дүгээр сарын 14 болон 5 дугаар сарын 24-нд нийт 3,2 сая ам.долларын бодит хэлцлийг байгуулаад байна. Харин Олон Улсын Санхүүгийн Корпорац (IFC)-тай санхүүжилтийн нөхцөлийг хэлэлцэх шатандаа явж байна.

8. Цар тахлаас үүдсэн эдийн засгийн хүндрэлийн үед импортыг орлох, экспортыг төрөлжүүлэх, хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний үйлдвэрлэлтийг нэмэгдүүлэх, эдийн засгийг идэвхжүүлэхэд чиглэсэн мөнгө, санхүү, төсвийн бодлогыг хэрэгжүүлэх

8.1. Эдийн засгийн хүндрэлийн үед иргэд, ААН-үүдийн үйл ажиллагааг дэмжиж эдийн засгийг сэргээх тал дээр СТБЗ-ийн гишүүн байгууллагуудын үйл ажиллагаа, бодлогын уялдаа холбоог хангаж ажиллах

Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл (СТБЗ)-ийн 2021 оны 1 дүгээр улирлын ээлжит хурлаар эдийн засгийг сэргээх хүрээнд ажлын байрыг дэмжих зээл, ипотекийн зээл, репо санхүүжилтийн хэмжээг нэмэгдүүлэх арга хэмжээний саналыг хэлэлцэн шийдвэрлэв. Монголбанкны Тэргүүн Дэд Ерөнхийлөгчөөр ахлуулсан хамтарсан ажлын хэсгийн зүгээс тус арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. Түүнчлэн СТБЗ-ийн гишүүн байгууллагууд хамтран “CENTURY” төслийн хүрээнд 1 тэрбум ам.долларын бондыг амжилттай арилжааллаа. Монголбанк нь Ковид-19 цар тахлын үед хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээнүүдийн үр нөлөө, эдийн засгийн төлөв байдал, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар дэлгэрэнгүй мэдээллийг хөрөнгө оруулагчдад өгч, хэлэлцээрт хамтран ажиллав.

8.2 Цар тахлаас үүдсэн эдийн засгийн хүндрэлийг бууруулахтай холбоотойгоор авч хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээний нөлөөллийн шинжилгээг хийж, танилцуулах, бодлогын шийдвэр гаргахад ашиглах

Цар тахлаас үүдсэн эдийн засгийн хүндрэлийг бууруулахад чиглэсэн бодлогын арга хэмжээнүүдийн эдийн засагт үзүүлэх нөлөөг тооцож, макро эдийн засгийн төсөөллийг 2021 оны 6 дугаар сар хүртэлх боломжит тоо, мэдээллээр шинэчлэн боловсруулсан. Ингэхдээ Засгийн газраас хэрэгжүүлж буй “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наяд төгрөгийн цогц төлөвлөгөө”-ний бодлогын нөлөөг тооцож мөнгөний болон санхүүгийн бодлогын шийдвэр гаргахад ашигласан. Түүнчлэн, ирээдүйд үүсэж болзошгүй эрсдэл, бодлогын өөрчлөлтүүдийг агуулсан хувилбар төсөөллийг боловсруулан Мөнгөний бодлогын хороонд танилцуулж, бодлогын шийдвэр гаргахад ашиглаж байна.

8.3. Жижиг дунд үйлдвэрлэл, уул уурхайн бус экспортын салбарыг дэмжих зориулалттай Монголбанкны урт хугацаат репо санхүүжилтийн хүү, хэмжээ, нөхцөлийг эдийн засаг, банк санхүүгийн салбар, болон зах зээлийн өнөөгийн болон ирээдүйн төлөвт гарч буй өөрчлөлтийг харгалзан үзсэний үндсэн дээр шаардлагатай тохиолдолд санал боловсруулан Мөнгөний бодлогын хороогоор хэлэлцүүлнэ.

Жижиг, дунд үйлдвэрлэл, уул уурхайн бус экспортыг дэмжихэд зориулсан урт хугацаат дахин санхүүжилтийн хэрэгслийг нэвтрүүлэх шийдвэрийг 2020 оны 9 дүгээр сарын Мөнгөний бодлогын хороо (МБХ)-ны ээлжит хурлаар гаргасан. Цар тахлын нөхцөл байдалтай холбоотойгоор санхүүжилтийг 2021 оны 1 дүгээр улирлын МБХ-ны хурлаар боловсруулах, үйлчилгээ болон 200-аас дээш ажиллагчидтай худалдааны салбарын аж, ахуйн нэгжүүдийг хамруулан өргөтгөх шийдвэр гаргав. Уг хэрэгслээр 2020 оны 4 дүгээр улиралд 230 тэрбум төгрөг, 2021 оны 1 дүгээр улиралд 250 тэрбум төгрөг, 2021 оны 2 дугаар улиралд 275 тэрбум төгрөгийн санхүүжилтийг зорилтот аж ахуйн нэгжүүдэд олгоод байна. Эдийн засгийн нөхцөл байдал, “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наяд төгрөгийн цогц төлөвлөгөө”-ний хүрээнд хэрэгжүүлж буй бодлогын олон арга хэмжээтэй нийцтэйгээр Монголбанкны урт хугацаат репо санхүүжилтийн

хэмжээний танилцуулга, холбогдох тооцооллыг боловсруулан 2021 оны 6 дугаар сарын мөнгөний бодлогын хорооны ээлжит хурлаар хэлэлцүүлсэн. Уг хуралдаанаар Монголбанкнаас урт хугацаат дахин санхүүжилтийн хэрэгслээр 2021 оны 3 дугаар улиралд олгох санхүүжилтийн хэмжээг 250 хүртэлх тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх шийдвэрийг гаргалаа.

8.4 ОУСК-тай байгуулсан хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд нийлүүлэлтийн сүлжээний санхүүжилтийн тогтолцоог бий болгох хүрээнд арилжааны банкуудын мэргэжилтнүүдэд зориулсан гарын авлага боловсруулах

ОУСК-аас монгол хэлнээ орчуулан бэлтгэсэн "Нийлүүлэлтийн сүлжээний санхүүжилтийн аргачлал, техникүүдийн стандарт тодорхойлолтууд" гарын авлагын хэвлэлийн эхтэй танилцаж, Монголбанкнаас Өмнөх үгийг оруулсан. Уг гарын авлага бэлэн болж, хэвлэгдэн гараад байна. Гарын авлагын хэвлэн бэлтгэсэн эцсийн хувилбарыг 2021 оны 6 дугаар сарын 4-ний өдөр ОУСК-аас Монголбанканд ирүүлэв. Цаашид тус гарын авлагыг арилжааны банкууд, зохицуулагч байгууллага болон олон нийт зэрэг нийлүүлэлтийн сүлжээний санхүүжилтийн бүх оролцогчдод мэдээлэн таниулах ажилд Монголбанк үргэлжлүүлэн хамтран ажиллана.

8.5 ОУСК-тай байгуулсан хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд эдийн засгийн тодорхой салбарууд дээрх өртгийн сүлжээний судалгаа гүйцэтгэх

ОУСК, Монголбанк хамтран Нийлүүлэлтийн сүлжээний санхүүжилтийг хөгжүүлэх харилцан ойлголцлын санамж бичгийн хүрээнд "Мах, ноолуурын салбаруудад Нийлүүлэлтийн сүлжээний санхүүжилтийн бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэх боломжийг тодорхойлох судалгаа"-г боловсруулж бэлэн болгов. Судалгааны ажлын эцсийн хувилбарыг ОУСК-ийн суурин төлөөлөгчийн албан бичгийн хавсралтаар 2021 оны 6 дугаар сарын 4-ний өдөр хүлээн авав.

8.6 Нийлүүлэлтийн сүлжээний санхүүжилтийн тогтолцоог хөгжүүлэх ажлын хэсэгт орсон Монголбанкны ажилтнуудын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх

Нийлүүлэлтийн сүлжээний санхүүжилтийн тогтолцоог хөгжүүлэх ажлын хэсэгт орсон Монголбанкны ажилтнууд болон Төв салбарын болон орон нутгийн бусад ажилтнууд мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилгоор уулзалт, семинарт өнгөрсөн онд тогтмол хамрагдаж, холбогдох судалгаа, материалуудтай танилцаж, хамтран ажиллаж байна. ОУСК, Монголбанк хооронд байгуулсан харилцан ойлголцлын санамж бичгийн хүрээнд ОУСК-ын зүгээс зохион байгуулсан уулзалт, хэлэлцүүлэг, семинаруудад Монголбанкны ажилтнуудыг хамруулан ажиллав. Тухайлбал, 2021 оны 4 дүгээр сарын 8-ны өдөр зохион байгуулсан "Авлага санхүүжүүлэх үйл ажиллагаанд технологийн шийдлийг ашиглах нь" сэдэвт цахим танилцуулга, семинар болон 2021 оны 5 дугаар сарын 27-28-ны өдрүүдэд зохион байгуулсан "Авлага худалдан авалт буюу Факторингийн үйл ажиллагаа эрхлэх нь" цахим танилцуулга, семинарт Нийлүүлэлтийн сүлжээний санхүүжилтийг хөгжүүлэх ажлын хэсэгт орсон Монголбанкны ажилтнууд болон бусад ажилтнуудыг өргөнөөр хамруулж оролцлоо.

ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2021 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ХЭРЭГЖИЛТ

(2021 оны 2 дугаар улирлын байдлаар)


1. МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:

1.1 Мөнгөний бодлогыг зах зээлийн зарчимд тулгуурлан хэрэгжүүлж, хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляц 2021-2023 онд +/-2 нэгж хувийн интервалд 6 хувийн орчимд тогтворжуулна


Хэрэглээний үнийн индекс (ХҮИ)-ээр хэмжигдэх инфляц 2021 оны 6 дугаар сард улсын хэмжээнд жилийн 6.6 хувь буюу зорилтот түвшин (6 хувь(+/-2))-д байна (Зураг 11). Дотоодод цар тахлын тархалт өндөр байгаа хэдий ч хөл хорио суларсан, эдийн засгийн үйл ажиллагаа хэсэгчлэн сэргэж байгаагаас эрэлтийн шалтгаантай инфляц 2 дугаар улирлын дунд үеэс алгуур нэмэгдэх хандлагатай боллоо. Цаашид цар тахалтай холбоотой хязгаарлалтын арга хэмжээнүүд болон хөл хориог дахин чангаруулахгүй тохиолдолд эдийн засгийн идэвхжилтэй уялдан эрэлтийн инфляц аажим нэмэгдэх хүлээлттэй байна.

Нийлүүлэлт талаас махны үнэ 4 дүгээр сард улирлын хандлагаасаа давж өссөн, сайжруулсан түлшний үнийг 75%-аар хөнгөлөх Засгийн газрын шийдвэрийн хэрэгжих хугацаа дуусгавар болсон, мөн шатахууны үнэ өмнөх жил буурсан суурь нөлөө арилж, үнэ нь өсөж байна (Зураг 12). Эдгээр хүчин зүйлсийн нөлөөгөөр инфляц богино хугацаанд өсөх хэдий ч 2022 оноос зорилтот түвшин болох 6 хувь (+/-2)-ийн орчимд тогтворжих хүлээлттэй байна.

Зураг 11. Улсын болон УБ хотын инфляц



Зураг 12. УБ хотын жилийн инфляц (бүрэлдэхүүнээр)



Эх сурвалж: УСХ

1.1.8 Иргэд, ААН, судлаачид болон банкны эдийн засагчдын инфляц болон эдийн засгийн цаашидын төлөв талаарх хүлээлтийг тодорхойлох түүвэр судалгааг хийж, үр дүнг тайлагнах.

2021 оны 7 дугаар сард иргэд, аж ахуйн нэгжүүдээс үнийн талаарх хүлээлтийг тодорхойлох түүвэр судалгааг зохион байгуулж, үр дүнг танилцуулсан. Тус судалгааны үр дүнгээс харахад 2021 оны 3 дугаар улиралд иргэд инфляцыг 8.9% орчимд, аж ахуйн нэгжүүд 3.6% орчимд байхаар хүлээж байна. Өөрөөр хэлбэл, эдийн засагт оролцогч талуудын дунд 2021 оны 3 дугаар улиралд инфляц зорилтот түвшинг давах хүлээлт зонхилж байна.

1.2. Банкны системийн эрсдэлээс сэргийлэх, санхүүгийн зуучлалыг хэвийн үргэлжлүүлэхэд чиглэсэн макро зохистой бодлогыг мөнгөний бодлоготой хослуулан хэрэгжүүлнэ.

Монголбанк нь Ковид-19 цар тахлын санхүүгийн салбарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, санхүүгийн зуучлалыг хэвийн үргэлжлүүлэх зорилгоор хэд хэдэн макро зохистой бодлогын арга хэмжээг хэрэгжүүлж байна. Тухайлбал, Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн 2020 оны 3 дугаар сарын хурлаар “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-д онцгой нөхцөл байдал үүссэн хугацаанд мөрдөх нэмэлт, өөрчлөлтийг оруулж, иргэдийн зээлийн ангилал буурах хугацааг уртасгаж, зээлийн мэдээллийн санд 90 хоногийн хугацаанд ангилал бууруулж бүртгэхгүй байх нөхцөлийг бүрдүүлж өгсөн. Үүний зэрэгцээ эргэн төлөлт нь доголдсон зээлүүдэд бүтцийн өөрчлөлт хийж, төлбөрийн хугацааг хойшлуулах боломжийг бүрдүүлж ажиллав. Түүнчлэн Мөнгөний бодлогын хорооны 2020 оны 4, 8, 11 дүгээр сарын ээлжит бус хурлуудаар хэрэглээний зээлийн хугацааг макро зохистой бодлогын өр, орлогын болон хугацааны зохицуулалтыг үл харгалзан 12 хүртэлх сараар сунгах боломжийг зээлдэгчдэд олгосон. Дээрх шийдвэрүүдийн хүрээнд 2021 оны 5 дугаар сарын байдлаар төлбөрийн хүндрэлд орсон 152,266 зээлдэгчийн 1.3 их наяд төгрөгийн хэрэглээний зээл, 2,441 ААН-ийн 2.7 их наяд төгрөгийн бизнесийн зээл, 59,597 өрхийн 3.1 их наяд төгрөгийн ипотекийн зээлийн эргэн төлөлтийг хойшлуулаад байна. Өөрөөр хэлбэл, банкны системээс гаргасан нийт зээлийн 30.6 хувьд бүтцийн өөрчлөлт хийсэн байна.

Банкны салбарт эх үүсвэрийн долларжилтын түвшин өндөр байх нь мөнгөний бодлого, түүний шилжих механизмын нөлөөг сулруулахын зэрэгцээ санхүүгийн системийн эмзэг байдлыг нэмэгдүүлдэг. Системийн эрсдэлээс сэргийлэх ажлын хүрээнд Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны 2020 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн ээлжит хуралдаанаар банкны эх үүсвэрийн долларжилтыг бууруулах, төгрөгийн харьцангуй өгөөжийг хадгалах зорилгоор 2020 оны 7 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн өндөр хүүтэй гадаад валютын хадгаламж болон хүү төлж буй гадаад валютын харилцахын эзлэх хувиар банканд олгох төгрөгийн заавал байлгах нөөцийн урамшууллыг бууруулан тооцох шийдвэрийг гаргасан. Энэ дагуу 2020 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн Монголбанкны Ерөнхийлөгчийн А-235 дугаар тушаалаар “Банкны заавал байлгах нөөцийг тогтоох, тооцох, хяналт тавих журам”-д өөрчлөлт оруулаад байна. 2021 оны 5 дугаар сарын байдлаар банкны харилцах, хадгаламжийн долларжилт 24.6 хувьд хүрч, 2020 оны 7 дугаар сараас хойш 8.5 нэгж хувиар буурлаа.

Санхүүгийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн системийн дархлааг бэхжүүлэх, системийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгын хүрээнд олон улсын байгууллагуудтай хамтран ажиллаж, зорилтот төслүүдийг хэрэгжүүлж байна. Тодруулбал, Дэлхийн банк болон Азийн хөгжлийн банктай хамтарсан төслүүдийн үр дүнд системийн эрсдэлийн үнэлгээний цогц шийдлийг хөгжүүлэхээр ажиллаж байна. “Төсөв, санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх” төслийн үр дүнд санхүүгийн салбарын эрсдэлийг үнэлэгч зураглал болон макро эрсдэлийн хүчин зүйлсийн модуль загварыг тус тус хөгжүүлэв. Тус төслийн үр дүнг ашиглан банкны системд нөлөөлөгч эрсдэлийн хүчин зүйлсийг үнэлэх ба нэг талаас макро эдийн засгийн, нөгөө талаас санхүүгийн зах зээлийн гол хувьсагчдын нөхцөлт бус тархалтыг үнэлсний үндсэн дээр эцэст нь хамтын тархалтыг үнэлж, суурь болон стресс сценариудыг тодорхойлно. Улмаар Монгол Улсын санхүүгийн системийн эрсдэлийн мониторинг хийгээд зогсохгүй, макро эдийн засгийн стресс тест, бодлогын үнэлгээний шинжилгээ зэргийг гүйцэтгэх боломжтой болно. Цаашлаад эдийн засгийн хүндрэлийн санхүүгийн салбарт үзүүлэх шууд үр нөлөө болон бусад салбаруудын уялдаа холбооноос хамаарах дам нөлөөг хэмжих боломжтой болох юм.

1.3. Төв банкны ил тод, хариуцлагатай байдлыг нэмэгдүүлж, зах зээлд оролцогчдын хүлээлтийг удирдах зорилгоор олон нийтийг мэдээллээр хангаж ажиллана.

Монголбанк бодлогын шийдвэр, түүний үндэслэлийг олон нийтэд ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар тайлбарлан таниулж, Төв банкны нээлттэй, ил тод, хариуцлагатай байдлыг ханган ажиллаж байна. Тухайлбал:

- Мөнгөний бодлогын хорооны 2021 оны 6 дугаар сарын хурлаас гаргасан мөнгөний бодлогын мэдэгдлийг Монголбанкны албан ёсны цахим хаягуудаар дамжуулан олон нийтэд түгээв.
- Мөнгөний бодлогын шийдвэрийг олон нийтэд танилцуулах хэвлэлийн бага хурлыг Ковид-19 цар тахалын нөхцөл байдлаас шалтгаалан цахимаар зохион байгуулж, хэвлэл мэдээллийн байгууллагуудын асуултад хариулж, бодлогын шийдвэрүүдийн үндэслэлийг олон нийтэд мэдээлэв.
- Эдийн засгийн төсөөлөл, Монголбанкнаас хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээний талаар Монголбанкны Ерөнхийлөгч болон газар нэгжийн захирлуудын ярилцлагыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээж ажиллав.
- Макро эдийн засаг, Төв банкны үйл ажиллагаатай холбоотой цаг үеийн асуудлаар хэвлэл мэдээллийн байгууллагуудаас ирсэн асуултуудад Монголбанкны газар нэгжийн захирлуудыг оролцуулан тухай бүр хариулт, тодруулга өгч ажиллав.
- 2020 оны Монголбанкны Жилийн тайланг нэгтгэн боловсруулж, олон нийтэд түгээв.
- Монголбанкны 2020 оны онцлох 20 ажлын тайланг хэвлэмэл болон цахим хэлбэрээр олон нийтэд түгээж ажиллав.

2. САНХҮҮГИЙН САЛБАРЫН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ХҮРЭЭНД:

2.1. Санхүүгийн мөчлөг сөрсөн арга хэрэгслийг ашиглан банкны салбарт учирч болзошгүй сөрөг нөлөөг бууруулж, банкны эрсдэл даах чадварыг хадгална.

Ковид-19 цар тахлын банк, санхүүгийн салбарт үзүүлэх сөрөг нөлөөг бууруулахад шаардлагатай боломжит арга хэмжээг бусад улс орнуудын туршлага болон Банкны тухай хууль тогтоомжид нийцүүлэн хэрэгжүүлж байна. Тухайлбал, Монголбанкнаас банкнуудын үйл ажиллагаанд мөрдүүлж буй “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”, “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”-д тус тус журмуудын тодорхой зохицуулалтыг түр хугацаагаар буюу 2020 оны 3 дугаар сарын 19-ний өдрөөс 2021 оны 6 дугаар сарын 30-ны өдрийг дуустал хугацаанд мөрдүүлэхээр шийдвэрлэж, биелэлтэд хяналт тавин ажиллаж байна.

Монголбанкны Банкны хяналт шалгалтын хорооны 2021 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн ээлжит хурлаас гарсан зөвлөмжийн дагуу банкнуудад түр хугацаагаар мөрдүүлж буй “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-ын хөнгөлөлттэй зохицуулалтыг 2022 оны 3 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл урьдчилан тогтоосон хуваарийн дагуу, хэсэгчлэн сунгахаар шийдвэрлэсэн.

Ингэснээр зээлдэгчдийн зээлийн эргэн төлөх нөхцөлийг дахин өөрчлөх, эргэн төлөлтийн доголдолтой зээлийн ангилал, зээлийн түүхийг түр хугацаанд бууруулахгүй, дордуулахгүй байх эсэхийг бие даан шийдвэрлэх боломжийг банканд нээлттэй үлдээлээ.

Монголбанкны зүгээс мөнгө, макро зохистой бодлогын арга хэмжээнүүд болон хяналт шалгалтын хүрээнд банкнуудын мөрдөж буй дээрх журам, зааварт түр хугацааны хөнгөлөлттэй зохицуулалтуудыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх нь банкны салбарын тогтвортой байдлыг хадгалах, системийн эрсдэлийг бууруулах, төлбөрийн чадварыг хангахад чухал нөлөө үзүүлнэ.

Банк, санхүүгийн салбарт үзүүлэх Ковид-19 цар тахлын нөлөөг бууруулахад шаардлагатай боломжит арга хэмжээг бусад улс орнуудын туршлага, банкны болон холбогдох хууль

тогтоомжид нийцүүлэн хэрэгжүүлж байгаа бөгөөд энэхүү шийдвэрийн хүрээнд банкнууд нийт 181,783 зээлдэгчийн 5.3 их наяд төгрөгийн зээлд бүтцийн өөрчлөлт хийж, эргэн төлөх нөхцөлд өөрчлөлт оруулсан.

Харин банкнуудад түр хугацаанд мөрдүүлж байсан төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцаа болон экспортын аккредитивт хамаарах хөнгөлөлттэй зохицуулалтыг тус тус 2021 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн хэвийн горимд шилжүүлэхээр шийдвэрлэлээ.

2.2. Банкны хяналт шалгалт, зохицуулалтын арга хэрэгслийг олон улсын стандарт, зөвлөмжид нийцүүлэн сайжруулж, банкны хяналт шалгалт, зохицуулалтын орчныг боловсронгуй болгоно.

Банкуудын өөрийн хөрөнгийн дотоод үнэлгээ, удирдлагыг оновчтой хийх чадварыг бэхжүүлэх үүднээс Базел стандартын II бүлгийн банкууд өөрийн хөрөнгийн хүрэлцээг дотооддоо үнэлэх аргачлал (ICAAP)-ыг нэвтрүүлэх талаар судалгаа болон зааврын төслийг урьдчилсан байдлаар боловсрууллаа. Ковид-19 цар тахлын нөлөө банкны салбарын тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөхөөр байгааг харгалзан уг зааврын төслийг батлуулж, банкуудад мөрдүүлэх ажлыг түр хугацаагаар хойшлуулахаар болов. Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны А-139 дүгээр тушаалаар банкны үйл ажиллагааны зохистой харьцааны зохицуулалтад орсон шинэчлэлийг 2020-2021 онд нэвтрүүлэх хуваарийг баталсан. Энэ хуваарийн холбогдох өөрчлөлтийг шат дараатай нэвтрүүлж байгаа бөгөөд зарим заалтыг нэвтрүүлэх хугацааг түр зохицуулалттай холбоотойгоор хойшлуулсан.

Монголбанкнаас банк, санхүүгийн салбарын эрх зүйн шинэтгэлийн хүрээнд хяналт шалгалтын олон улсын сайн туршлага, зарчим, зохицуулалтыг манай улсын банкны системийн онцлогт нийцүүлэн, шат дараатайгаар нэвтрүүлэх, эрсдэлд суурилсан хяналт шалгалтын арга барилд шилжих ажлууд үргэлжлэн хийгдэж байгаа бөгөөд энэ хүрээнд хяналт шалгалт, зохицуулалтын арга хэрэгслийг олон улсын стандарт, зөвлөмжид нийцүүлэн сайжруулж, банкны хяналт шалгалт, зохицуулалтын орчныг боловсронгуй болгохоор ажиллаж байна.

УИХ-аас 2021 оны 1 дүгээр сарын 29-ний өдөр баталсан Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд банкны хувьцаа эзэмшилд тавигдах тоо хэмжээний хязгаарлалтыг тогтоож, банкны үйл ажиллагааг хувьцаат компанийн хэлбэрээр явуулах шаардлагыг тогтоосонтой холбоотойгоор хувьцаат компанид тавигдах ерөнхий шаардлагыг олон улсын шилдэг туршлага, зарчимд нийцүүлсэн тусгаснаас гадна банканд хийх хяналт шалгалтыг шаардлагатай тохиолдолд мэргэшсэн бусад этгээдтэй хамтран гүйцэтгэх эрх зүйн зохицуулалтыг бий болгосон. Улмаар банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигчийн шалгуурыг илүү нарийвчлан тодорхойлж, хадгаламж, харилцагчийн эрх ашгийг хамгаалах хүрээнд банкны үйл ажиллагааны хэвийн, тасралтгүй байдлыг хангуулах, эрсдэлд суурилсан банкны хяналт шалгалтыг үр нөлөөтэй хэрэгжүүлэх эрх зүйн орчинг бүрдүүллээ.

2.3. Банк, санхүүгийн салбарын хууль тогтоомжийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор хууль, эрх зүйн шинэтгэлийг үргэлжлүүлнэ.

Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль

Банкны тухай хууль дахь банкны хувьцаа эзэмшилд тавигдах тоо хэмжээний хязгаарлалтыг тогтоож, банкны үйл ажиллагааг хувьцаат компанийн хэлбэрээр явуулах шаардлагыг хуульчлан хувьцаат компанид тавигдах ерөнхий шаардлагыг банканд онолын үндэслэлтэйгээр олон улсын шилдэг туршлага, зарчимд нийцүүлэн шилжүүлэхгүй тохиолдолд банкны хувьцаа эзэмшигчээс зохистой засаглалын зарчмыг алдагдуулсан шийдвэр гаргах, банкны өдөр тутмын үйл ажиллагаанд томилгоо, шийдвэр гаргалтаар дамжуулан нөлөөлж улмаар банкныг төлбөрийн чадварыг алдагдуулсан алдаа дутагдлыг давтах, цаашлаад банкны салбарт итгэх олон нийтийн итгэл буурч, санхүүгийн зуучлал сааран банкны тогтолцооны тогтвортой байдал, эдийн

засгийн урт хугацааны өсөлтөд сөргөөр нөлөөлөх үр дагавартай байдаг. Монгол Улсын банкны салбарын одоогийн нөхцөлд байдалд шинжилгээ хийсэн судалгааны үр дүнг харгалзан хууль, эрх зүйн зохицуулалтыг сайжруулах хэрэгцээ, шаардлагын хүрээнд банкны хувьцаа эзэмшлийн хэт төвлөрлийг бууруулж өмчлөл-удирдлага-хяналтын тэнцвэртэй байдлыг бүрдүүлэх, үүнд компанийн эрх зүйн зохицуулалтыг ашиглан банкны үйл ажиллагааг хувьцаат компани хэлбэртэйгээр явуулах шаардлагыг тогтоосон дараах агуулга бүхий Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийг УИХ-аас 2021 оны намрын ээлжит чуулганы хуралдаанаар баталлаа:

- Банк үүсгэн байгуулах, банкны үйл ажиллагааг зөвхөн хувьцаат компани хэлбэртэй компани эрхлэх;
- Банкны хувьцаа эзэмшил аливаа этгээд, түүний холбогдох этгээдийн хувьд банкны нийт саналын эрхтэй хувьцааны 20 хувиас хэтрэхгүй байх бөгөөд энэ зохицуулалт мөрдөгдөхгүй байх шаардлагатай тохиолдлыг хуулиар тодорхойлох;
- Банкны хувьцаа эзэмшилд хязгаарлалт хийхтэй холбогдуулан нөлөө бүхий хувьцаа эзэмшигчийн тодорхойлолт, банк байгуулах, банкны хувьцаа эзэмшихэд Монголбанкнаас зөвшөөрөл олгоход баримтлах хэм хэмжээ;
- Банканд албадлагын арга хэмжээ авах, татан буулгах үндэслэл, бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээний үндэслэлийг зөвхөн банкны тогтолцоонд нөлөө бүхий байдлаар хязгаарлах.

Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль

Улсын Их Хурлын нэр бүхий гишүүдээс 2020 оны 8 дугаар сарын 20-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн /Шинэчилсэн найруулгын/ төсөл”-ийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн бөгөөд Эдийн засгийн байнгын хороо 2020 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн 04 тоот тогтоолоор уг хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын дэд хэсгийг байгуулсан. Монголбанкнаас банк, санхүүгийн тогтолцооны найдвартай байдлыг бэхжүүлэх, зохистой хөгжлийг дэмжих, харилцагч, хадгаламж эзэмшигчийн хууль ёсны эрхийг хамгаалах хүрээнд хадгаламжийн гэрээ, зээлийн гэрээтэй холбоотой зохицуулалтуудыг Иргэний хуульд нийцүүлэн, эдгээр гэрээнд санхүүгийн хэрэглэгчийн хууль ёсны эрхийг хамгаалах зорилгоор зайлшгүй тусгах шаардлагатай нөхцөлийг тодорхой болгон хуульчлахтай холбоотой саналууд, холбогдох тайлбар, судалгааг тухай бүр Ажлын хэсэгт хүргүүлэн хамтран ажилласан. Улсын Их Хурлын 2021 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар эцэслэн батлагдаж, 2021 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн тус хуулинд дараах гол зохицуулалт тусгагдсан байна:

- Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагаанд баримтлах зарчим, ерөнхий нөхцөл буюу шимтгэл, хураамжийн зохицуулалт;
- Мөнгөн хадгаламжийн хугацаагүй гэрээг зөвхөн иргэнтэй байгуулах, хадгаламжийн дансыг харилцах данс буюу төлбөрийн зориулалтаар ашиглахгүй байх;
- Төлбөр тооцооны гэрээг Үндэсний төлбөрийн системийн тухай хуультай нийцүүлж мөнгөн хөрөнгийн шилжүүлэг болгох өөрчлөх;
- Зээлийн эрсдэлийг бууруулахтай холбоотой зээлийг санхүүгийн тайландаа тусгадаг байх, гадаад валютын зээлийг гадаад валютын орлоготой эсвэл ханшийн эрсдэлээс хамгаалагдсан этгээдэд олгох.

Валютын зохицуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл

Монгол Улсын Засгийн Газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “иргэндээ ээлтэй, эдийн засагтаа үр өгөөжтэй банк санхүү, хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх”-ээр, Төрөөс мөнгөний бодлогын талаар 2017 онд баримтлах үндсэн чиглэлд “санхүүгийн зах зээлийн дэд бүтэц, институцийг бэхжүүлэх”-ээр тусгасан. Мөн Валютын зохицуулалтын тухай хуулийн давхардал, зөрчил, хийдэлийг арилгах, тус хууль болон Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулиудыг нэгтгэж, валютын нэгдсэн зохицуулалтыг бий болгох, хөрөнгийн болон санхүүгийн зах зээлийн хөгжлийг дэмжсэн эрх зүйн орчинг бий болгох, гадаад секторын статистик, тоон мэдээллийн чанарыг олон улсын жишигт нийцүүлэх практик шаардлага бий болсон. Дээр дурдсан зорилт, шаардлагын хүрээнд “эдийн засгийн харьяат хоорондын болон тэдгээрээс харьяат бустай хийх валютын гүйлгээ, валютын дотоодын захын зохицуулалт, Монгол Улсын нутаг дэвсгэрт төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэхтэй холбоотой харилцаа”-г зохицуулах Валютын зохицуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулсан. Хуулийн төслийн макро эдийн засгийн бодлогын суурь нь хөрөнгийн чөлөөтэй урсгал, зохицуулалттай хөвөгч ханшийн дэглэм болон төрийн мөнгөний бодлогын бие даасан байдал байна. Хуулийн төслийг Улсын Их Хурлаар хэлэлцүүлэхэд хууль санаачлагч, Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо, холбогдох бусад байгууллагатай хамтран ажиллаж байна.

3. САНХҮҮГИЙН ЗАХЫН ДЭД БҮТЭЦ, ТҮҮНИЙ ИНСТИТУЦИЙГ БЭХЖҮҮЛЭХ АЖЛЫН ХҮРЭЭНД:

3.1. Үндэсний төлбөрийн системийн эрх зүйн орчныг сайжруулах замаар шинэ технологид суурилсан санхүүгийн үйлчилгээг дэмжиж, хяналтын чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Санхүүгийн үйлчилгээг үзүүлэхэд ашиглаж байгаа технологи (хиймэл оюун ухаан зэрэг)-ийн аюулгүй, найдвартай байдал, нууцлалыг хангах, мэдээлэл задруулахгүй, мэдээллийг буруугаар ашиглахгүй байх, уг технологи ашиглагчид үүрэг хүлээлгэх талаарх суурь зарчмыг тогтоох хүрээнд хиймэл оюун ухаан, санхүүгийн технологийн олон улсын зохицуулалтыг судалж байна.

2021 оны эхний хагас жилд Төв банкны цахим мөнгөний чиг хандлага, үр дүн, эрсдэл сэдвээр судалгааны ажил гүйцэтгэн, үр дүнг танилцуулсан. Төв банкнуудын цахим мөнгө гаргах талаар судалгаа, туршилтын ажил эрчимжиж байгаа хэдий ч цөөн тооны орнууд л цахим мөнгийг албан ёсоор нэвтрүүлж, гүйлгээнд гаргаад байна. Монгол улсын хувьд ч энэ талаар хийгдсэн судалгааны ажил байхгүй байгаа тул төв банкны цахим мөнгөний талаарх ойлголт, мөн чанар, олон улсын хэрэглээ, цаашдын чиг хандлага, мөнгөний бодлогод үзүүлж болзошгүй нөлөөлөл, бусад төв банкнуудын байр суурь зэргийг олон улсад хийгдсэн судалгаа, туршилтын үр дүн болон өөрсдийн олж авсан мэдлэгт суурилан судлахыг зорьсон.

Судалгааны ажлын үр дүнд улс орнууд өөрсдийн онцлогт тохирсон, тулгамдаж буй асуудалдаа шийдэл олох зорилгоор ТБЦМ-г судалж, цөөнгүй улс туршилтын үе шатандаа явж байна. Жишээ дурдвал, хөгжиж буй орнууд санхүүгийн хүртээмжтэй байдлаа дээшлүүлэх үүднээс ТБЦМ-г хэрэгжүүлэх зорилго зонхилж байгаа бол хөгжингүй орнуудын хувьд хил дамнасан төлбөр тооцоо, хувийн хэвшлийн цахим мөнгөтэй өрсөлдөхүйц төрөөр баталгаажсан төлбөрийн хэрэгслийг гүйлгээнд оруулахаар ажиллаж байгаа юм. Гэхдээ ойрын 5 жилдээ албан ёсоор ТБЦМ-г гүйлгээнд гаргах цөөн тооны улс байгаа бөгөөд ихэнх орнууд технологи, түүний эдийн засагт үзүүлэх үр нөлөөг сайтар судлахыг нэн тэргүүнд тавьж байна.

Манай улсын хувьд бэлэн мөнгөний хэрэглээ буурч байгаа хэдий ч ТБЦМ-ний талаар эрчимтэй судалж, туршилтын байдлаар хэрэгжүүлж буй орнуудтай ижил хэрэгцээ, шаардлага төдийлөн хүчтэй ажиглагдахгүй байна. Түүнчлэн, олон улс дахь ТБЦМ-ний талаарх байр суурь, судалгаа, туршилтын үр дүн, оновчтой шийдэл бүрэн тодорхой болоогүй учир манай улсын хувьд ойрын

хугацаанд ТБЦМ гаргах нь эрт байна гэж үзэж байна. Харин улс орнуудын хийж буй туршилт, судалгааны үр дүнг анхааралтай ажиглаж, ахисан түвшний эмпирик судалгааны ажлууд гүйцэтгэж, улмаар эдгээрийг цаашдын бодлогын шийдвэртээ тусгах нь зүйтэй гэсэн үр дүн гарсан.

Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийг дагалдан гарсан төлбөрийн картын журамд нэмэлт өөрчлөлт оруулж орон сууцны хэрэглээний төлбөр төлөх явцад картаар үйлчилсний шимтгэлийг картаар үйлчилсэн байгууллага бус харилцагчаар төлүүлдэг байх зохицуулалтыг тусгаж өгсөн. Ингэснээр картаар үйлчлэх байгууллагын тоо нэмэгдэх, орон сууцны хэрэглээний төлбөрийг картаар хүлээн авах үйл ажиллагаа эрчимжих давуу талтай. Мөн, банк хоорондын бага дүнтэй төлбөрийн систем буюу Автомат клиринг хаус системийн дүрэмд зарим өөрчлөлтийг оруулах замаар төлбөрийн системийн оролцогчдын үйл ажиллагааг хялбаршуулах, хэрэглэгчийн гүйлгээ буцаагдахгүй байх нөхцөлийг хангаж ажиллалаа.

Үндэсний төлбөрийн ₮ картыг EMV чип технологид шилжүүлэх ажлын хүрээнд Үндэсний цахим гүйлгээний төвийн картын системийг сүлжээний дүрмийн хамт шинэчилж нэмэлт өөрчлөлт оруулах ажлыг хийж гүйцэтгэсэн. Шинэ систем нэвтэрч дүрэмд өөрчлөлт орсноор төлбөрийн карт гаргагч, хүлээн авагчийн гүйлгээний төрөл нэмэгдэх, хэрэглэгчдэд олон төрлийн сонголт бий болох, Үндэсний цахим гүйлгээний төвийн үйл ажиллагааны хүчин чадал, цар хүрээ нэмэгдэх юм.

Түүнчлэн, төлбөрийн үйлчилгээнд ашиглагдаж буй QR кодыг стандартчилах зорилгоор олон улсад түгээмэл ашиглагдаж буй EMV QR стандартыг өөрийн орны нөхцөлд тохируулан боловсруулах ажлыг хийж, оролцогчдоос санал авч дууссан бөгөөд цаашид энэхүү стандартыг улам боловсронгуй болгох, зах зээлд оролцогчдын хүсэл сонирхол, шаардлагад нийцэхүйц хэмжээнд хүргэх зорилгоор Дэлхийн банк болон олон улсад энэ чиглэлээр төсөл хөтөлбөр хэрэгжүүлж байсан туршлага бүхий компанитай хамтран ажиллаж байна. Эдгээр ажил нь нэмэлт үнэ төлбөргүй бөгөөд Дэлхийн банкны техник туслалцааны хүрээнд авч хэрэгжүүлж байгаа ажил юм.

Үндэсний төлбөрийн системийн тасралтгүй, найдвартай ажиллагааг хангах, учирч болзошгүй эрсдэлээс сэргийлэх үүднээс оролцогч болон операторын үйл ажиллагааны тайланд хяналт тавьж ажилласан.

Их дүнтэй төлбөрийн систем болон Монголбанкнаас хариуцан ажиллуулж буй Төв банкны үнэт цаасны системийн үйл ажиллагаанд Санхүүгийн зах зээлийн дэд бүтцийн зарчмуудын дагуу үнэлгээг хийж, хэрэгжилтийн түвшинг ахиулах, тогтмол хангуулах, зөвлөмж гаргаж, тайланг бэлтгэв.

Хуулийн этгээдээс ирүүлсэн төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой зөвшөөрөл хүссэн материалыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу хянан шалгаж, шалгуур, шаардлагыг хангасан 1 байгууллагад цахим мөнгө гаргах, 2 байгууллагад төлбөрийн картын процессор, 1 байгууллагад хөдөлгөөнт банкны процессорын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг тус тус олголоо.

3.2. Төв банкны суурь бүртгэлийн болон дотоод удирдлагын цогц системийг нэвтрүүлж, бүртгэл, удирдлага, хяналт, тайлагналд олон улсын шилдэг туршлагыг нэвтрүүлнэ.

Төв банкны суурь бүртгэлийн болон дотоод удирдлагын цогц системийг нэвтрүүлж байгаатай холбогдуулан нийлүүлэгч байгууллагатай 2021 оны 2 дугаар сарын дунд үеэс эхлэн Монголбанк дээр сургалтыг зохион байгуулан амжилттай дуусгаж, 5 дугаар сараас системийн туршилтыг өдөр бүр явуулж байгаа бөгөөд 8 дугаар сарын дунд үе хүртэл үргэлжлүүлэх төлөвлөгөөтэй байна. Туршилтын явцад гарсан алдаа болон бусад асуудлыг тухай бүрд нь хэлэлцэж санал солилцон ажиллаж байна.

3.3. Санхүүгийн хүртээмжийг сайжруулах, санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалахад дэмжлэг үзүүлэх зорилгоор иргэд, бичил, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлнэ.

Монгол Улсын санхүүгийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх зорилтын хүрээнд иргэдийн санхүүгийн зах зээлд ухаалгаар оролцох оролцоог нэмэгдүүлэх, оновчтой шийдвэр гаргалтыг дээшлүүлэх зорилгоор Монголбанк, Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороо, БСШУЯ хамтран “Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг тэргүүлэх 4 чиглэлд 2016 оноос хэрэгжүүлэн ажиллаж байна.

Олон улсад тархаад байгаа цар тахлын улмаас Улсын онцгой комиссын шийдвэрийг мөрдлөг болгон Монголбанк олон нийтэд зориулсан танхимын сургалт, арга хэмжээнүүдийг цуцалсан хэдий ч 2021 оноос цахим сургалтуудыг эрчимжүүлэн зохион байгуулав.

Тайлант хугацаанд тус хөтөлбөрийг өргөжүүлж, хүртээмжийг ахиулах хүрээнд олон нийтийн сүлжээ, цахим хэлбэрээр дараах ажлуудыг хийж гүйцэтгэв. Үүнд:

- Бичил жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд чиглэсэн дэд хөтөлбөрийг боловсруулах ажлыг үргэлжлүүлэв. Үүний дагуу бусад талуудын оролцоог хангаж сургагч багш бэлтгэх 8 өдрийн цахим сургалтыг зохион байгууллаа. Тус сургалтад нийт 32 хүн хамрагдсан ба сургагч багшийн заах арга зүй, цахим худалдаа, хямралын үеийн эрсдэл ба санхүүгийн удирдлага сэдвээр мэдлэг, мэдээлэл олгов. Улмаар бэлтгэгдсэн 32 багш нарыг багт хувааж, 100 бичил, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд “Цахим худалдаа”, “Хямралын үеийн эрсдэл, санхүүгийн удирдлага” сэдэвт цахим сургалт оров.
- БЖДҮ эрхлэгчдийн санхүүгийн боловсрол олгох дэд хөтөлбөрийн төслийг эцэслэн Хүнс хөдөө аж ахуйн яамтай хамтран батлахаар ажиллаж байна. Энэхүү ажилд Жижиг дунд үйлдвэрлэлийн газар, Зээлийн батлан даалтын сан, Санхүүгийн зохицуулах хороо, Нийслэлийн ЖДҮ дэмжих төв, Монголын худалдаа аж үйлдвэрлэлийн танхим, Насан туршийн боловсролын үндэсний төв, Монголын банкны холбоо зэрэг байгууллагууд хамтран хэрэгжүүлэгчээр оролцож байна.
- “БЖДҮ эрхлэгчдэд санхүүгийн мэдлэг олгох хөтөлбөр боловсруулах” төслийг дүгнэх олон улсын хурал 3-р сарын 22-ны өдөр цахимаар боллоо. Төслийг хэрэгжүүлсэн зөвлөх багийн зүгээс “БЖДҮ эрхлэгчдийн санхүүгийн боловсролын хэрэгцээ” судалгааны үр дүн, сургагч багш бэлтгэх сургалт, БЖДҮ эрхлэгчдэд Санхүүгийн боловсрол олгох стратеги, бизнес эрхлэгчдэд сургалт орсон үйл явц сэдэвт танилцуулгуудыг хийв.
- “Дэлхийн мөнгөний долоо хоног 2021” аяныг Монголбанкнаас бусад байгууллагуудтай хамтран амжилттай зохион байгуулав. Тус аяныг 3 дугаар сарын 22-ны өдөр нээж, цахим хурал зохион байгуулсан. Аян 3 долоо хоногийн хугацаанд үргэлжилж, халдвар хамгааллын дэглэмийг сахин уралдаан, тэмцээн, цахим сургалт, уулзалтуудыг улс даяар бусад талуудтай хамтран зохион байгуулсан ба нийт 30,847 хүүхэд, залуучуудад хүрлээ. Тухайлбал, аяны хугацаанд 1,569 уулзалт, сургалтууд танхимаар болон цахимаар хийсний зэрэгцээ 192 уралдаан, тэмцээн, арга хэмжээнүүдийг зохион байгуулав. Нөгөөтгээгүүр, шууд бусаар буюу цахим орчинд мэдээлэл, контент түгээсэн нь давхардсан тоогоор 2.5 сая хандалт авч, үүрэн телефоны операторуудтай хамтран 18-35 насны 782,750 иргэдэд мессежээр санхүүгийн боловсролыг сурталчиллаа.
- Санхүүгийн мэдлэг олгох цахим хуудас (www.sankhuuginbolovsrol.mn) болон facebook пэйжийг (@sankhuuginbolovsrol) шинэ мэдээ, мэдээлэл, подкастаар тогтмол баяжуулан ажиллаж байна. Тайлант хугацаанд мөн Санхүүгийн зохицуулах хороотой хамтран ажиллав.

- “Монголбанкны мэдээлэл” товхимол бэлтгэж түгээх ажлын хүрээнд тайлант хугацаанд нийт 4 дугаар эрхлэн гаргаж, 1500 хувийг хэвлүүлэн, дугаар бүрийг МУЕТГ, УИХ, ЗГ, арилжааны банкнууд, Монголбанкны газар нэгжүүд, орон нутаг дахь хэлтэс салбар, аймаг, сумын ЗДТГ, номын сан, сургуулиудад түгээж ажиллалаа. Мөн хөл хорионы үед хэвлэлийн үйлдвэрүүд ажиллахгүй байсныг харгалзан тус товхимлын 53 дахь дугаарыг цахимаар түгээв.
- Залууст санхүүгийн боловсрол олгох зорилтот үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр Засгийн газрын хэрэгжүүлэх агентлаг Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газартай хамтран ажиллах санамж бичиг байгуулсан ба тус санамж бичгийн хэрэгжилтийг хангаж, орон нутаг, нийслэлийн Залуучуудын хөгжлийн газрын нийт 70 албан хаагчдыг санхүүгийн мэдлэг олгох сургагч багшаар бэлтгэж цахим сургалтад хамруулав. Бэлтгэгдсэн сургагч багш нар нь үргэлжлүүлэн дүүрэг, аймагтаа ажиллаж, сургалт уулзалтуудыг бие дааж болон Монголбанктай хамтран хийж байна.

ТӨСЛИЙН ТООЦОО СУДАЛГАА

1. ИНФЛЯЦ

“КОВИД-19” цар тахлын сөрөг нөлөөгөөр хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх жилийн инфляц өмнөх оны 3-р сараас эхлэн саарч 2020 оны эцэст улсын хэмжээнд 2.3 хувьд хүрч буурав. Харин 2021 оны 4-р сараас нийлүүлэлтийн болон нэг удаагийн шинжтэй хүчин зүйлсийн нөлөөгөөр инфляц нэмэгдсэн хэдий ч 2021 оны 6 дугаар сарын байдлаар улсын хэмжээнд 6.6 хувь, Улаанбаатар хотод 7.1 хувь буюу төв банкны зорилтот түвшний хэмжээнд байна (Зураг 13). Цаашид хорио цээрийн дэглэм шат дараатай суларч, цар тахлын сөрөг нөлөөг зөөллөх бодлогын арга хэмжээнүүд үргэлжлэн хэрэгжиж байгаагийн зэрэгцээ эдийн засгийн идэвхжил сэргэж байгаа тул эрэлтийн гаралтай үнийн өсөлт алгуур нэмэгдэх төлөвтэй байна. Нийлүүлэлт талаас дэлхийн зах зээл дээрх газрын тосны үнэ өссөнтэй холбоотой дотоодын шатахууны үнэ нэмэгдсэн, олон улс, дотоодын тээврийн зардал өссөн, худалдааны түнш орнуудын инфляц нэмэгдэж импортын бараа, бүтээгдэхүүний үнэ өсөх, олон улсын тээврийн хүндрэл, түүнийг дагасан тээврийн үнэ өсөх зэргээс нийлүүлэлтийн шалтгаантай хүчин зүйлсийн инфляцад үзүүлэх нөлөө мөн нэмэгдэхээр байна.

2021 оны 6 дугаар сарын байдлаар инфляцад дараах хүчин зүйлс голлох нөлөөг үзүүллээ.

Өмнөх онд махны үнэ харьцангуй тогтвортой байсан бол энэ оны 6-р сарын байдлаар махны үнэ жилийн 18.5% өсөж, инфляцад үзүүлэх нөлөө нь 2.1 нэгж хувь болж нэмэгдлээ. Махны үнэ өндөр өсөхөд 1) өмнөх оны 3-5-р саруудад махны экспорт саарч, нийлүүлэлт тогтвортой байснаар 2020 оны II улиралд дотоодын махны үнийн өсөлт бага байсан суурь нөлөө, 2) хатуу хөл хорионы нөлөөгөөр нийлүүлэлт удааширч, тээвэр, логистикийн зардал өссөн зэрэг нь нөлөөлсөн байж болохоор байна (Зураг 14).


Засгийн газрын шийдвэрээр сайжруулсан түлшний үнийг өмнөх оны 12-р сараас энэ оны 4-р сарын 1-ний өдөр хүртэл 75%-аар хөнгөлсөн бөгөөд энэ нь инфляцыг 2.1 нэгж хувиар бууруулах нөлөөтэй байв. Энэхүү нэг удаагийн шинжтэй нөлөө нь 4-р сараас арилсан, түлшний модны үнэ өссөн нь хатуу түлш бүлгийн инфляцад үзүүлэх нөлөө 0.5 нэгж хувь болон нэмэгдсэн байна (Зураг 14).

Өнгөрсөн онд дэлхийн зах зээл дээрх газрын тосны үнэ огцом буурсан²² нь дотоодын шатахууны үнэ хямдрах нөхцөл болж байв. Тодруулбал, 2020 оны II улирлаас шатахууны үнэ хямдарч, инфляцыг 1.1 нэгж орчим хувиар бууруулах нөлөө үзүүлж байсан бол уг суурь нөлөө энэ оны 5-р сард ариллаа. Түүнчлэн энэ онд дэлхийн эдийн засаг сэргэж, эрэлт нэмэгдэж эхэлсэнтэй уялдан газрын тосны үнэ өсөж²³ цар тахлын өмнөх үеэс өндөр болсон нь дотоодын шатахууны үнэ нэмэгдэх шалтгаан болж байна. Ийнхүү дотоодын шатахууны үнэ 5-р сараас нэмэгдэж эхэлсэн бөгөөд ирэх саруудад инфляцыг 1.7 орчим нэгж хувиар нэмэгдүүлэх шууд нөлөө үзүүлэхээр байна (Зураг 14).


²² Тухайлбал, Brent газрын тосны 2020 оны 3-р сарын дундаж үнэ \$23/баррель хүртэл буурсан байна.

²³ Brent газрын тосны 2021 оны 6-р сарын дундаж үнэ \$75/баррель байв.

Зураг 13. Улсын болон Улаанбаатар хотын инфляц



Зураг 14. Улаанбаатар хотын жилийн инфляцын задаргаа



Эх сурвалж: УСХ

Хүснэгт 2. Жилийн инфляцад голлох нөлөө үзүүлсэн бараа, бүтээгдэхүүнүүд 6 дугаар сарын байдлаар:


Нэр төрөл	Жин	Жилийн өсөлт	Жилийн инфляцид эзлэх хувь
Мах	0.10	18.5%	2.1% ()
Нийтийн хоолны үйлчилгээ	0.04	14.1%	0.6% ()
Сүү, сүүн бүтээгдэхүүн	0.04	15.9%	0.6% (↓)
Хатуу түлш	0.03	11.6%	0.5% (↔)
Автомашин	0.04	12.8%	0.5% ()
Шатахуун	0.06	8.7%	0.4% ()

2. БОДИТ СЕКТОР

2.1. Нийт нийлүүлэлт

КОВИД-19 цар тахал, түүнтэй холбоотой хорио цээрийн арга хэмжээнүүд 2020 онд эдийн засгийн ихэнх салбаруудад томоохон сөрөг нөлөөг үзүүлсэн бол 2021 он гарсаар эдийн засаг сэргэх хандлага ажиглагдаж байна. Үйлдвэрлэлийн аргаар тооцсон бодит дотоодын нийт бүтээгдэхүүн 2021 оны эхний хагаст өмнөх оны мөн үеэс 6.3 хувиар өсөхөд 1) тайлант хугацаанд гадаад эрэлт нэмэгдэж, дэлхийн зах зээл дээр эрдэс бүтээгдэхүүний үнэ өндөр түвшинд хадгалагдсан нь манай экспортын орлого, уул уурхайн салбарт эерэг нөлөө үзүүлсэн, 2) Засгийн газар, Монголбанкнаас хэрэгжүүлж буй эдийн засгийг дэмжих арга хэмжээнүүд үргэлжлэн хэрэгжсэн, 3) хорио цээрийн дэглэм шат дараатай суларч эдийн засгийн идэвхжил нэмэгдсэн нь голлон нөлөөллөө (Зураг 15).

Зураг 15. Улирал бүрийн ДНБ-ий өсөлт, бүрэлдэхүүн хэсгээр




Эх сурвалж: YCX

Гэвч эдийн засгийн сэргэлт харилцан адилгүй, тэгш бус байна. Тодруулбал, уул уурхайн салбар 2021 оны эхний хагас жилийн байдлаар 24.3 хувиар өсч, эдийн засгийн өсөлтийн 2.7 нэгж хувийг бүрдүүлжээ. Уул уурхайн бус салбаруудаар авч үзвэл бүтээгдэхүүний цэвэр татвар 3.0 нэгж хувь, боловсруулах 0.8 нэгж хувь, худалдаа 0.8 нэгж хувь, мэдээлэл холбоо 0.3 нэгж хувь, эрчим хүч 0.3 нэгж хувь тус тус эдийн засгийн өсөлтөд эерэг нөлөө үзүүлжээ. Харин барилга, хөдөө аж ахуйн салбар бууралттай байж өсөлтөд -1.1 нэгж хувь болон -0.8 нэгж хувийн сөрөг нөлөөтэй байв (Зураг 16 болон Зураг 17).

Зураг 16. Аж үйлдвэрийн салбаруудын өсөлт



Зураг 17. Үйлчилгээний салбаруудын өсөлт




Эх сурвалж: YCX

2.2. Нийт эрэлт

Эцсийн ашиглалтын аргаар тооцсон бодит дотоодын нийт бүтээгдэхүүн буюу нийт эрэлт 2021 оны эхний хагаст 6.2 хувиар өслөө. Оны эхнээс гадаадын шууд хөрөнгө оруулалт, бизнесийн зээл нэмэгдсэний зэрэгцээ Засгийн Газар, Монголбанкнаас хэрэгжүүлж буй 10 их наядын цогц төлөвлөгөө хэрэгжиж эхэлсэн нь нийт хуримтлалд эергээр нөлөөлж оны эхний хагаст нийт хуримтлал 44.7 хувиар өсчээ. Харин цар тахлын үед өрхийн орлогыг дэмжих зорилгоор тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлэн, орон сууцны ипотекийн зээлийн эргэн төлөлт хойшлуулах, ус, дулаан, цахилгаан, хогны төлбөр хөнгөлөх зэрэг арга хэмжээ хэрэгжүүлж байгаа хэдий ч өрхүүд хэрэглээгээ танаж, хадгалах хандлагатай байв. Түүнчлэн оны эхний хагас жилийн гүйцэтгэлээр экспорт, импорт бодит дүнгээр өмнөх оноос 14.0 хувь, 5.4 хувиар тус тус өссөн ч цар тахлын өмнөх үе буюу 2019 оноос бага түвшинд хэвээр байна. Ийнхүү цэвэр экспорт нийт эрэлтийн өсөлтөд 2.3 нэгж хувийн эерэг нөлөө үзүүллээ (Зураг 18).

Зураг 18. Улирал бүрийн ДНБ-ий жилийн өсөлт, бүрэлдэхүүнээр




Эх сурвалж: УСХ


3. УЛСЫН ТӨСӨВ

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн хүрээнд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал, өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн Засгийн өрийн үлдэгдлийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээний талаарх тусгай шаардлагуудыг шинэчлэн, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2021 оны тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлын ДНБ-д эзлэх хувь хэмжээг 3.7 нэгж хувиар нэмэгдүүлж 8.8 хувь байхаар тодотголоо. Тодотгосон төсвийн мэдээгээр 2021 онд төсвийн тэнцвэржүүлсэн орлого өмнөх оноос 2.6 их наяд төгрөг, төсвийн нийт зардал 1.8 их наяд төгрөгөөр нэмэгдэж төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал 3.7 их наяд төгрөгт хүрэхээр байна (Зураг 19).

Зураг 19. Нэгдсэн төсвийн орлого, зардал, тэнцэл



Зураг 20. Нэгдсэн төсвийн орлого, зардлын жилийн өөрчлөлт (%)



Эх сурвалж: Сангийн яам

Тайлант оны эхний хагас жилд цар тахлын тархалт өндөр байсан хэдий ч төсвийн тэнцвэржүүлсэн орлого өмнөх оны мөн үеэс 57 хувь, төсвийн зардал 19 хувиар нэмэгдээд байна (Зураг 20). Орлого нэмэгдэхэд аж ахуй нэгжийн орлогын албан татвар (ААНОАТ), нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ)-ын дэд бүлгүүд өндөр нөлөөтэй байв. Түүнчлэн, “Оюу толгой” компанийн татварын маргаантай орлогоос 600 тэрбум төгрөгийг ААНОАТ орлогод бүртгэсэн нь тус дэд бүлгийн орлого өнгөрсөн оны мөн үеэс 150 гаруй хувиар огцом нэмэгдэхэд нөлөөлжээ.

Төсвийн зардал 2021 оны эхний хагаст өмнөх оноос 1’200 тэрбум төгрөгөөр нэмэгдэхэд голчлон төсвийн татаас, шилжүүлгийн зардал өссөнтэй холбоотой байв (Хүснэгт 3). Тодруулбал, Засгийн газраас цар тахлын үед хэрэгжүүлж буй тэтгэмж, урамшууллын зардлын нөлөөгөөр татаас, шилжүүлгийн зардал 66 хувиар өсчээ. Үүнд, цар тахлын үед i) иргэн бүрт олгох 300 мянган төгрөгийн тусламж, ii) вакцинжуулалтад хамрагдсан иргэдэд олгох 50 мянган төгрөгийн урамшуулал, iii) төрөөс сар бүр хүүхдэд олгох мөнгөн тэтгэмжийг 100.0 мянган төгрөгт хүргэж нэмэгдүүлсэн, iv) халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг 100.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн зэрэг арга хэмжээ багтаж байна.

Хүснэгт 3. Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл

тэрбум төгрөг	2020		2021		2021.06		2021.06/ 2020.06 өөрчлөлт
	Тод.	Урьд.Гүй.	Бат.	Тод.	Гүй.	Гүй %	
Нийт орлого	10729	10402	13134	13732	7106	107.1	63%
Ирээдүйн өв сан	943	914	1180	1062	418	80.3	69%
Тогтворжуулалтын сан	55	66	156	613	260	360.3	2072%
Тэнцвэржүүлсэн орлого	9731	9422	11798	12056	6429	106.4	57%
Татварын орлого	8847	8502	10754	10626	5588	101.3	49%
Татварын бус орлого	884	920	1043	1431	840	160.1	135%
Нийт зардал	14577	13961	13952	15748	7498	87.5	19%
Анхдагч зардал	13605	13001	12992	14783	7078	87.5	21%
Урсгал зардал /-хүүний зардал/	10178	9912	10052	12018	6139	86.9	33%
Хөрөнгийн зардал	3408	3052	3498	3364	860	65.1	-30%
Цэвэр зээл	19	38	-559	-599	79	-26.9	322%
Хүүний зардал	973	959	1138	966	420	87.5	-1.2%
Нийт тэнцэл	-3848	-3559	-818	-2017	-392		
<i>ДНБ-д эзлэх хувь</i>	-9.9%	-9.5%	-1.9%	-4.8%	-0.9%		
Нийт тэнцвэржүүлсэн тэнцэл	-4847	-4539	-2154	-3692	-1069		
<i>ДНБ-д эзлэх хувь</i>	-12.5%	-12.2%	-5.1%	-8.8%	-2.5%		
Анхдагч тэнцэл	-3874	-3580	-1016	-2726	-649		
<i>ДНБ-д эзлэх хувь</i>	-10.0%	-9.6%	-2.4%	-6.5%	-1.5%		

Эх сурвалж: Сангийн яам

Тайлант хугацаанд гадаад зээл, гадаад дотоод үнэт цаас эргүүлэн төлөх, төсвийн алдагдлыг санхүүжүүлэхэд нийлбэр дүнгээр 1'964 тэрбум төгрөгийн санхүүжилт шаардагдав. Үүнээс 654 тэрбум төгрөгийг гадаад зээлээр, үлдсэн 1310 тэрбум төгрөгийг харилцах данснаас бүрдүүлжээ (Хүснэгт 4).

Хүснэгт 4. Санхүүжилтийн шаардлага болон эх үүсвэр бүрдүүлсэн байдал

тэрбум төгрөг	2021 он			тэрбум төгрөг	2021 он				
	Жилийн төлөвлөгөө	Гүйцэтгэл			Жилийн төлөвлөгөө	Гүйцэтгэл			
		Эхний 6 сард	6-р сард			Эхний 6 сард	6-р сард		
1	Шаардлагатай санхүүжилтийн хэмжээ	5078	1964	233	2	Эх үүсвэрийн бүрдэл	5078	1964	233
1.1	Үнэт цаас эргэн төлөхөд	594	468	378	2.1	Шинээр гаргасан үнэт цаас	2852	0	0
	Дотоод	216	90	0		Дотоод	2852	0	0
	Гадаад	378	378	378		Гадаад	0	0	0
1.2	Зээл эргэн төлөхөд	793	427	-348	2.2	Шинээр авсан зээл	1490	654	86
	Дотоод	0	0	0		Дотоод	0	0	0
	Гадаад	793	427	-348		Гадаад	1490	654	86
						Төслийн зээл	1205	369	86
						Хөтөлбөрийн зээл	285	285	0
1.3	Төсвийн алдагдлыг санхүүжүүлэхэд	3692	1069	203	2.3	Сангийн орлогоос	613	0	0
						Ирээдүйн өв сан	0	0	0
						Тогтворжуулалтын сан	613	0	0
					2.4	Монголбанкнд байрших дансны цэвэр өөрчлөлт	123	1311	147

Эх сурвалж: Сангийн яам

ШИГТГЭЭ 1. Ковид-19 цар тахлын эсрэг төсвийн бодлого: Монгол Улс ба бусад улсын туршлага


Цар тахлаас үүдэлтэй эдийн засгийн хямралын үед 1) иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, 2) ядуурал, тэгш бус байдал нэмэгдэхээс сэргийлэх, 3) ажлын байр хадгалах, 4) бүтээмж өндөртэй, дижитал салбар руу шилжих, 5) ажиллагсадын ур чадвар, бүтээмжийг нэмэгдүүлэх, 6) эмзэг бүлгийн санхүүгийн дарамтыг хөнгөлөх, 7) хөрвөх чадварыг дэмжих, 8) хөл хорио, цар тахлын улмаас орлого нэмэгдсэн салбараас санхүүгийн эх үүсвэр төвлөрүүлэх зэрэг олон сорилттой тулгарч байна. Эдгээр сорилтыг амжилттай даван туулахын тулд улс орнууд олон төрлийн халамж, тэтгэмж, татаас, татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлүүлэх, зээл олгох, зээлийн баталгаа гаргах зэрэг төсвийн шинжтэй олон төрлийн арга хэмжээг хэрэгжүүлэв. ОУВС-гийн тооцоноор 2020 онд дэлхийн хэмжээнд төсвийн алдагдал ДНБ-ий -10.8 хувьд хүрч цар тахлын өмнөх үеэс 3 дахин өссөн бол Өр/ДНБ харьцаа 83.7 хувиас 97.3 хувьд хүрч нэмэгджээ.

Цар тахлын үед улс орнуудын хэрэгжүүлж буй төсвийн арга хэмжээг дүгнэхэд эхний ээлжинд эрүүл мэндийн салбарт шаардлагатай хөрөнгө оруулалт, урсгал зардлыг санхүүжүүлэх, эмзэг бүлэгт чиглэсэн нийгмийн халамжийг нэмэгдүүлэх, ажлын байрыг хадгалахад зориулж татаас олгох, зээлийн баталгаа гаргах болон бусад төсвийн шинжтэй үйл ажиллагааг санхүүжүүлэн эдийн засагт хөрвөх чадварыг нэмэгдүүлсэн байна. Бусад орнуудын адилаар Монгол Улсын Засгийн Газраас өрхийн орлогыг дэмжих зорилгоор хэрэгжүүлсэн халамжийн нэмэгдлийн нөлөөгөөр татаас, урсгал шилжүүлгийн зардал 2020 онд 50 хувь, 2021 онд дахин 44 хувиар нэмэгджээ. Тодруулбал, цар тахлын үед иргэн бүрт 300.0 мянган төгрөгийн нэг удаагийн тусламж, вакцинжуулалтад хамрагдсан иргэдэд 50.0 мянган төгрөгийн урамшуулал олгож, хүүхдэд олгох сар бүрийн мөнгөн тэтгэмжийг 100.0 мянган төгрөг болгох, халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг 100.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэх зэрэг арга хэмжээг авсан байна.

Түүнчлэн өндөр хөгжилтэй орнуудын санхүүгийн чадавхи өндөр тул төсвийн хариу арга хэмжээг илүү хурдтай авч хэрэгжүүлж байна. Улс орнуудын Засгийн газраас хэрэгжүүлж буй нэмэлт арга хэмжээний нөлөөгөөр 2020 онд дэлхийн эдийн засгийн уналт 2 нэгж хувиар багассан гэх судалгааны үр дүн гарчээ²⁴.

ОУВС-гийн тайлангаас²⁵ харахад өндөр хөгжилтэй орнууд төсвийн алдагдлыг 2022 оноос эхлэн хурдтай бууруулж, Өр/ДНБ харьцааг цаашид тогтмол түвшинд хадгалах хүлээлттэй байгаа бол хөгжиж буй орнуудын хувьд төсвийн алдагдал 2026 он хүртэл харьцангуй удаан буурч, өрийн хэмжээ үргэлжлэн нэмэгдэх төлөвтэй байна (Зураг 21).

Зураг 21. Хөгжсөн болон эрчимтэй хөгжиж буй орнуудын төсвийн тэнцэл, ДНБ-д эзлэх хувиар




Эх сурвалж: ОУВС

Харин 2020, 2021 онуудад өндөр хөгжилтэй орнуудын төсвийн алдагдал өндөр байж, мөчлөг сөрсөн илүү хүчтэй бодлого хэрэгжүүлж байна. Манай улсын хувьд Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.2 заалт дахь төсвийн тусгай шаардлагын хэрэгжилтийг 2 жилээр хойшлуулан төсвийн алдагдлыг 2020 онд 12.2 хувь, 2021 онд 8.8 хувьд хүргэсэн бөгөөд цаашид хуулийн хүрээнд алгуур бууруулах хүлээлттэй байна.

²⁴ Эх сурвалж: Chudik et al., “Covid-19 Fiscal Support and its Effectiveness” (2021), CAMA Working Paper 28/2021, Australian National University.

²⁵ “Fiscal Monitor” (2021), International Monetary Fund.

Зураг 22. Цар тахлын үед Монгол Улсын Засгийн газраас авч хэрэгжүүлсэн Төсвийн бодлогын арга хэмжээ




4. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ, БОДЛОГЫН АНХААРАХ АСУУДЛУУД

4.1. Эдийн засгийн өсөлтийн төсөөлөл

Эдийн засаг 2021 онд 5.1 хувиар өсөх хүлээлттэй байна. Эдийн засгийн өсөлт 2020 оны 2-р улиралд төсөөллөөс бага гарлаа. Тодруулбал, уул уурхайн салбарын хувьд нүүрсний экспорт буурсан, төмрийн хүдрийн олборлолт буурсан мөн Оюу толгойн баяжмалын алтны агууламж төсөөллөөс бага байсан нь нөлөөлөв. Харин уул уурхайн бус салбарын хувьд малын зүй бус хорогдол өндөр байсан нь хөдөө аж ахуйн салбарыг бууруулсан бол цар тахал, хөл хорионы нөлөө барилга, боловсруулах, үйлчилгээний салбарт хүлээлтээс илүү нөлөөлж, эдгээр салбарын өсөлт төсөөллөөс бага гарав. Мөн нүүрс, уул уурхайн бүтээгдэхүүний экспортын бууралттай холбоотойгоор тээврийн салбарын идэвхжил муудсан. 2021 оны сүүлийн хагаст уул уурхайн салбарын хувьд нүүрсний экспорт Ковид-19 вирусийн тархалттай холбоотойгоор буурсан, уул уурхайн баяжмалын агууламж саарсан хандлага хадгалагдан уул уурхайн салбарын өсөлтийг удаашруулахаар байна. Харин хөл хорионы дэглэм суларч, дахин хөл хорио тогтоохгүй, Засгийн газар болон Төв банкнаас хэрэгжүүлж буй эдийн засгийг дэмжих бодлого үргэлжлэн хэрэгжихээр байгаа зэргээс шалтгаалан уул уурхайн бус салбарын өсөлт оны сүүлийн хагаст аажмаар сэргэх хүлээлттэй байна.

Зураг 23. Эдийн засгийн өсөлтийн төсөөлөл (эрэлт болон нийлүүлэлт талаас)



Эх сурвалж: ҮСХ, Монголбанк

Нийт эрэлтийг энэ оны сүүлийн хагаст хөрөнгө оруулалт, өрхийн хэрэглээ тэтгэж байгаа бол Засгийн газрын хэрэглээ, цэвэр экспорт бууруулах тооцоололтой байна. Оны эхнээс гадаадын шууд хөрөнгө оруулалт, бизнесийн зээл нэмэгдсэний зэрэгцээ Засгийн Газар, Монголбанкнаас хэрэгжүүлж буй 10 их наядын цогц төлөвлөгөө хэрэгжиж эхэлсэн нь нийт хуримтлалыг 44.7 хувиар өсөхөд эерэг нөлөө үзүүллээ. Оны хоёрдугаар хагаст эдийн засгийн үйл ажиллагаа сэргэн, төсвийн хөрөнгө оруулалт бүрэн зарцуулагдах таамаглалд үндэслэн нийт хуримтлал эдийн засгийн өсөлтийг голчлон дэмжихээр байна. Нөгөөтэйгүүр Ковид-19 халдварын дотоод нөхцөл байдлаас үүдэн нүүрсний тээвэр 3-р улирлын дийлэнхи хугацаанд үргэлжлэн саатах, алтны экспорт өмнөх оноос буурах нөлөөгөөр экспорт сүүлийн хагас жилд нийт эрэлтэд сэргөөр нөлөөлөхөөр байна.

Харин 2022, 2023 онуудад эдийн засгийн өсөлтийн төсөөллийг 30 хувийн итгэх интервалд авч үзвэл харгалзан 3.7-8.0 хувь, 2.6-7.8 хувь байхаар байна. Ирэх онд Оюу толгойн зэсийн баяжмал, түүний алтны агууламж буурах хүлээлттэй байгаа нь уул уурхайн үйлдвэрлэлийг бууруулах нөлөө үзүүлэх бол бусад салбаруудын хувьд цар тахалтай холбоотой уналтаас гарч урт хугацааны хэвийн түвшиндээ хүрэх, мөн гадаадын шууд хөрөнгө оруулалт тэр дундаа Оюу толгойн хөрөнгө оруулалт нэмэгдэх нөлөөгөөр дотоод эрэлт сэргэж уул уурхайн бус салбар эрчимжин эдийн засгийн өсөлтийг дэмжихээр байна. 2023 оны хувьд Оюу толгойн алтны агууламж үргэлжлэн бага хэмжээгээр буурах бол нөгөө талдаа далд уурхайн үйлдвэрлэл эхлэх нөлөөгөөр олборлолтоо өсгөж уул уурхайн салбарын өсөлт буцаад сайжрахаар байна. Харин гадаад эрэлт үргэлжлэн саарах, гадаадын шууд хөрөнгө оруулалт өмнөх оноос төдийлөн өсөхөөргүй байгаа нь уул уурхайн бус салбарын өсөлт удаашрахад нөлөөлөхөөр байна.

ШИГТГЭЭ 2. КОВИД-19 цар тахлын үеийн эдийн засгийн өсөлт

КОВИД-19 цар тахал Монгол улс болон бусад орнуудын эдийн засагт хүчтэй нөлөөлсөн төдийгүй улс орнуудын эдийн засгийн сэргэлт харилцан адилгүй байна.

КОВИД-19 цар тахлын эдийн засагт үзүүлсэн сөрөг нөлөө

Дэлхийн улс орнуудад цар тахал дэгдэж, түүнээс сэргийлэх хорио хязгаар тогтоосноор глобал эдийн засаг 2009 оноос хойш анх удаа агшиж, 2020 онд дэлхийн эдийн засаг 3.6 хувиар унав²⁶. Вирусын шокоос шалтгаалсан дэлхийн эдийн засгийн хямрал урьд өмнө тохиолдож байсан хямралаас нилээд онцлог байна. Тодруулбал, улс орнуудын хямралын эсрэг авч хэрэгжүүлсэн бодлогын арга хэмжээ далайцтай байсан хэдий ч эдийн засгийн уналт гүнзгий, тэгш бус байсан юм. Бангладеш, Хятад, Египт, Этиоп, Иран, Ирланд, Мьянмар, Тажикстан, Турк, Вьетнам зэрэг орнуудын КОВИД-19 цар тахлын сөрөг нөлөө зарим орнуудад харьцангуй бага буюу эдийн засгийн өсөлт нь эерэг түвшинд байжээ. Дэлхийн улс орнуудын 2020 оны эдийн засгийн өсөлтийг орлогын ангилал болон бүс нутгаар нь задлан авч үзвэл:

Хүснэгт 5. Эдийн засгийн өсөлт 2020 оны өсөлт, орлогын ангилалаар

Бага орлоготой	0.9
Дундаас доогуур орлоготой орнууд	-4.1
Дунд орлоготой	-1.9
Дундаас дээгүүр орлоготой орнууд	-1.1
Өндөр орлоготой	-4.7
Монгол	-4.6
Дэлхий	-3.6

Хүснэгт 6. Эдийн засгийн өсөлт 2020 оны өсөлт, бүс нутгаар

Европ, төв Ази	-1.8
Ойрх дорнод, Хойд Африк	-3.7
Саб-сахарын Африк	-2.4
Дэлхийн дундаж	-3.6
Латин Америк, Карибын тэнгис	-6.3
Хойд Америк	-3.7
Монгол	-4.6

Эх сурвалж: Дэлхийн банк

- *Орлогын ангилалаар:* КОВИД-19 цар тахал бага орлоготой орнуудад үзүүлсэн сөрөг нөлөө нь харьцангуй бага²⁷ байсан бол өндөр орлоготой орнуудын²⁸ үйлдвэрлэл 2020 онд дунджаар 4.7 хувиар агшжээ. Түүнчлэн, дунд орлоготой орнуудын үйлдвэрлэл 1.9 хувиар, дундаас дээгүүр орлоготой орнуудын үйлдвэрлэл 1.1 хувиар тус тус буурсан бол дундаас доогуур орлоготой орнуудын үйлдвэрлэл -4.1 хувиар буурсан байна (Хүснэгт 5).
- *Бүс нутгаар:* Эдийн засгийн өсөлтийг бүс нутгаар авч үзвэл Латин Америк, Карибын тэнгисийн орнуудын эдийн засаг хамгийн их хэмжээгээр буюу дунджаар -6.3 хувиар агшсан байна. Харин КОВИД-19 цар тахлын сөрөг нөлөө Европ, төв Азийн орнуудын хувьд хамгийн бага байснаар тус бүс нутгийн эдийн засаг 2020 онд -1.8 хувиар буурчээ. Бусад бүс нутгуудын эдийн засаг -2-оос -4 хувийн орчим агшсан байна (Хүснэгт 6).

Томоохон эдийн засагтай орнуудаас авч үзвэл 2020 онд АНУ, Евро бүс, Японы эдийн засаг агшсан бол Хятадын эдийн засгийн өсөлттэй гарсан байна. АНУ-ын эдийн засаг 2020 онд хувийн хэрэглээ, экспорт, материалын нөөц буурснаас шалтгаалж 2020 онд 3.5 хувиар буурчээ (Bureau of Economic Analysis, 2021). Үйлдвэрлэл талаас үүний гол шалтгааныг авч үзвэл жижиглэн болон бөөний худалдаа, үйлчилгээ, тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл буурсан байна. Мөн Евро бүсийн эдийн засаг 2020 онд 6.5 хувиар агшсан нь 2009 оны хямралын үеэс²⁹ муу үзүүлэлт болж байна. 2020 онд цар тахлын нөлөөгөөр нийлүүлэлтийн сүлжээ доголдож, аялал жуучлалын салбарт хүндрэл учирч, дотоод гадаад эрэлт саарч Евро бүсийн орнуудын эдийн засаг огцом унажээ (Хүснэгт 7).

²⁶ Дэлхийн банкны статистик мэдээнд 2020 онд дэлхийн эдийн засаг 3.6 хувиар агшсан гэсэн байна. Бусад эх сурвалжуудад жишээлбэл Блүүмбэргийн мэдээлснээр дэлхийн эдийн засаг 2020 онд 3.5 хувиар агшжээ.

²⁷ Эдгээр орнуудын эдийн засаг 2020 онд дунджаар 0.9 хувийн өсөлттэй байв.

²⁸ 2019 оны дэлхийн банкны тодорхойлсноор 1 хүнд ногдох орлого нь 12536 доллараас их бол орлогын түвшин өндөртэй орон гэнэ.

²⁹ Евро бүс 2009 онд 4.5 хувиар агшсан байна.

Хүснэгт 7. Европын холбооны улсуудын 2020 оны эдийн засгийн өсөлт, өмнөх оны мөн үетэй харьцуулахад

	2020Q1	2020Q2	2020Q3	2020Q4
Евро бүс	-3.2	-14.7	-4.3	-5.1
Европын холбоо	-2.6	-13.9	-4.2	-4.8
Белги	-2.0	-13.9	-4.3	-4.8
Чех	-1.9	-10.8	-5.0	-5.0
Герман	-2.2	-11.3	-4.0	-3.9
Испани	-4.2	-21.6	-9.0	-9.1
Франц	-5.7	-18.8	-3.9	-5.0
Итали	-5.6	-18.1	-5.1	-6.6
Латви	-1.0	-8.6	-2.6	-1.7
Литва	2.2	-4.6	-1.6	-1.3
Австри	-3.3	-14.2	-4.2	-7.8
Португали	-2.4	-16.4	-5.7	-5.9
Швед	0.7	-7.4	-2.7	-2.6

Эх сурвалж: Евро-Стат

Дэлхийн хоёр дахь том эдийн засаг болох Хятадын эдийн засаг 2020 онд 2.3 хувиар өссөн нь 1976 оноос хойш хамгийн муу үзүүлэлт боллоо. Цар тахлаас шалтгаалан Хятад улс нь сүүлийн 10 жилд анх удаагаа өсөлтийн зорилт тогтоогоогүй³⁰ бөгөөд 2020 оны 1 дүгээр улиралд Хятадын эдийн засаг 6.8 хувиар унасан байна. Харин 2020 оны 2 дугаар улирлаас Хятадын засгийн газар эдийн засгаа дэмжих зорилгоор дэд бүтцийн хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлж, иргэдэд бэлэн мөнгө тарааж эхэлсний зэрэгцээ вирусын дотоодын тархалт хяналтад орсноор тус улсын эдийн засаг 2020 оны 2 дугаар улирлаас сэргэж эхэлсэн байна.

Цар тахлаас шалтгаалж Япон улсын эдийн засаг өмнөх онд 4.7 хувиар агшсан нь 2009 оноос хойш Японы эдийн засаг унаж байгаа анхны тохиолдол болов. 2020 оны эхний 2 улиралд хэрэглээ, экспорт буурснаар Японы эдийн засаг агшиж, харин 2020 оны сүүлийн хагаст эргэн сэргэсэн байна.

Монгол Улсын хувьд 2020 онд 4.6 хувиар агшсан нь дэлхийн санхүүгийн хямралаас хойш манай эдийн засаг буурсан анхны тохиолдол боллоо. Үйлдвэрлэл талаас авч үзвэл КОВИД-19 цар тахлын арга хэмжээнээс шалтгаалж 2020 онд хөдөө аж ахуй, мэдээлэл холбооноос бусад бүх салбарууд агшлаа. Эрэлт талаас хэрэглээнээс бусад бүрэлдэхүүн хэсгүүд буурсан байна. Монгол орны 2020 оны эдийн засгийн уналтын хувийг бусад орнуудтай харьцуулж авч үзвэл Австри, Сингапур, Словак, Япон, Малайз, Чех, Чили, Канад, Тайланд зэрэг орнуудтай ойролцоо байна.

КОВИД-19 цар тахлын дараах сэргэлт

Энэ оны 6 дугаар сард Дэлхийн банкнаас танилцуулсан “Дэлхийн эдийн засгийн төлөв” тайланд дурдсанаар дэлхийн эдийн засаг 2021 онд 5.6 хувь, 2022 онд 4.3 хувиар өсөх төлөвтэй байна (Хүснэгт 8). Энэхүү 5.6 хувийн өсөлт нь сүүлийн 80 жилд хямралын дараа глобал эдийн засаг хамгийн хурдтай сэргэж буй тохиолдол болохоор байна (Зураг 13 зураг 24).

³⁰ КОВИД-19 вирус тархсан нь Хятадын нийгэм, эдийн засагт томоохон тодорхой бус байдал үүссэн байна. Иймд 2020 онд эдийн засгийн өсөлтийн ямар нэгэн зорилт тавихгүй болохыг БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайд Ли Кэчян хэлсэн. Харин БНХАУ-ын 2021 оны эдийн засгийн өсөлтийн зорилт 6 хувь байна.

Зураг 24. Цар тахлын үеийн худалдааны салбарын сэргэлт, сүүлийн 2 хямралтай харьцуулахад



Эх сурвалж: НҮБ-ийн худалдаа хөгжлийн бага хурал

Хүснэгт 8. Эдийн засгийн өсөлтийн төсөөлөл

	2018	2019	2020	2021*	2022*	2023*
Дэлхий	3.2	2.5	-3.6	5.6	4.3	3.1
Хөгжсөн орнууд	2.3	1.6	-4.7	5.4	4.0	2.2
АНУ	3.0	2.2	-3.5	6.8	4.2	2.3
Евро бүс	1.9	1.3	-6.6	4.2	4.4	2.4
Япон	0.6	0.0	-4.7	2.9	2.6	1.0
Хөгжиж буй орнууд	4.6	3.8	-1.7	6.0	4.7	4.4
Зүүн Ази, Номхон Далайн орнууд	6.5	5.8	1.2	7.7	5.3	5.2
Европ, Төв Ази	3.5	2.7	-2.1	3.9	3.9	3.5
Латин Америк, Карибын тэнгис	1.8	0.9	-6.5	5.2	2.9	2.5
Хойд Америк, Дундад Ази	0.6	0.6	-3.9	2.4	3.5	3.2
Өмнөд Ази	6.4	4.4	-5.4	6.8	6.8	5.2
Саб-сахарын Африк	2.7	2.5	-2.4	2.8	3.3	3.8
Түүхий эд импортлогч хөгжиж буй орнууд	6.0	4.9	-0.6	7.3	5.4	5.0
Хятадаас бусад түүхий эд импортлогч	4.9	3.2	-4.7	5.4	5.3	4.5
Түүхий эд экспортлогч хөгжиж буй орнууд	2.0	1.8	-4.0	3.6	3.3	3.1
Монгол**	7.7	5.6	-4.6	5.1	5.8	5.2

Энд: ** - Монголбанкны төсөөлөл

Эх сурвалж: Дэлхийн банк “Дэлхийн эдийн засгийн төлөв, 2021 он 6-р сар”

Гэсэн хэдий ч нийт үйлдвэрлэл 2021 онд КОВИД-19 цар тахлын өмнөх 2021 оны төсөөллөөс 2 хувиар бага байхаар байна.

Хөгжингүй орнууд дундаас 2021 онд АНУ хурдтай (6.8%) сэргэх хүлээлттэй байгаа бол хөгжиж буй орнуудаас Перу (10.3%), Хятад (8.5%), Энэтхэг (8.3%), Вьетнам (6.6%) орнууд эрчимтэй сэргэх төлөвтэй байна.

Хөгжиж буй орнуудын 2021 оны сэргэлтийг эдийн засгийн дэд бүлгүүдээр задлан харвал экспорт, хөрөнгө оруулалт сэргэж, өрхийн хэрэглээний өсөлт харьцангуй нам түвшинд байх тооцоололтой (Хүснэгт 9). Улс орнуудад жижиглэн худалдаа, барилга, аж үйлдвэрийн салбар түрүүлж сэргэж эхэлсэн бол цар тахлаас сэргийлэх хязгаарлалтуудаас шалтгаалж өрхийн хэрэглээ тэр дундаа үйлчилгээ сэргэхгүй удах төлөвтэй байна.

Хүснэгт 9. Хөгжиж буй орнуудын 2021 оны эдийн засгийн дэд бүлгүүдийн өсөлт, бүс нутгаар

	Өрхийн хэрэглээ	Төрийн байгууллагын хэрэглээ	Хөрөнгө оруулалт	Экспорт	Импорт
Европ, Төв Ази	3.7	0.8	4.9	5.6	5.1
Латин Америк, Карибын тэнгис	5.3	0.7	8.8	7.3	9.7
Хойд Америк, Дундад Ази	2.4	1.9	3.5	4.6	4.2
Өмнөд Ази	5.7	19.5	11.7	12.1	13.8
Саб-сахарын Африк	1.9	1.1	1.7	6.8	3.1
Зүүн Ази, Номхон Далайн орнууд	9.9	6.8	5.7	6.9	7.4
Монгол**	-1.2	-8.8	68.9	-6.5	9.6

Эх сурвалж: Дэлхийн банк “Дэлхийн эдийн засгийн төлөв, 2021 он 6-р сар”

Бусад улсуудын адилаар Монгол улсад 2021 онд хөрөнгө оруулалт харьцангуй хурдан сэргэх хүлээлттэй байгаа бол өрхийн хэрэглээ уналттай байна. Тодруулбал, энэ оны эхний хагас жилд бэлэн байдлын “Улаан” болон “Улбар шар” түвшин ээлжлэн хэрэгжсэнээр өрхийн хэрэглээ огцом танагдсан бөгөөд цаашид алгуур сэргэх хүлээлтээс үзэхэд хэрэглээ оны нийт дүнгээр өмнөх оны түвшнээс өсөхгүй байх эрсдэлтэй байна. Нөгөөтэйгүүр ГШХО, бизнесийн зээл оны эхнээс сэргэн, Засгийн Газар, Монголбанкнаас хэрэгжүүлж буй 10 их наядын цогц төлөвлөгөө хэрэгжиж эхэлснээр хөрөнгө оруулалт өмнөх оны бага түвшнээс (2020 онд -40.7 хувь) өндөр хувиар сэргэх төлөвтэй байна.

4.2. Төсвийн бодлогын төлөв

Цар тахлын үед эдийн засгийг сэргээх, өрхийн орлогыг дэмжих зорилгоор хэрэгжүүлж буй арга хэмжээний нөлөөгөөр төсвийн төлөв 2020 онд 9.1 хувиар суларсан бол 2021-2023 онуудад харгалзан 4.0, 3.6, 1.6 хувиар чангарч цар тахлын өмнөх үеийн буюу 2019 оны түвшний орчимд очих төлөвтэй байна³¹ (Зураг 25).

Төсвийн төлөв суларсантай холбоотойгоор өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн Засгийн газрын нийт өрийн үзүүлэлт 2020 онд 6.7 хувиар нэгж хувиар муудлаа. Цаашлаад цар тахалтай холбоотойгоор төсөв тодотгож “Монгол Улсын нэгдсэн төсвийн 2021 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2022-2023 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хууль батлагдсанаар өрийн хязгаарын тусгай шаардлагын хугацааг хойшлуулж 2021 болон 2022 онд 70.0 хүртэлх хувь байхаар тусгасан билээ. Өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн Засгийн газрын нийт өрийн нэрлэсэн ДНБ-д эзлэх хувь 2021 онд 61.3 хувь, 2022 онд 55.5 хувь байхаар тодотголд туссан нь хуульд заасан хязгаарыг хангаж байна (Хүснэгт 10).

Зураг 25. Төсвийн импульс



Эх сурвалж: Сангийн яам, Монголбанк

³¹ Монголбанкны тооцоолол

Хүснэгт 10. Засгийн газрын өрийн үзүүлэлт

тэрбум төгрөг	2018	2019	2020	2021*		2022*
	Гүй.	Гүй.	Гүй.	Бат.	Тод.	ТХМ.
Засгийн газрын нийт өр (ӨҮЦ)	18956	20526	23024	26141	25818	27074
ДНБ-д эзлэх хувь (ӨҮЦ-ээр тооцсон)	58.9	55.6	62.3	61.9	61.3	59.2
Өрийн хязгаар (ДНБ-д эзлэх хувь)	80.0	75.0	70.0	70.0	70.0	70.0
Зээлийн үйлчилгээний төлбөр	1046	861	959	1138	966	
Төсвийн орлогод эзлэх хувь	11.3	8.0	10.2	9.6	8.0	
Төсвийн тэнцэл	12	-628	-4539	-2154	-3692	-1646
ДНБ-д эзлэх хувь	0.0	-1.7	-12.2	-5.1	-8.8	-3.6

ШИГТГЭЭ 3. Төмөр замын бүтээн байгуулалтын ашиглалтанд орох байдал

(Төмөр замын байгуулалтын талаарх ерөнхий мэдээллийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын Газар болон “Монголын төмөр зам” ТӨҮК-ийн сайтад тавигдсан мэдээ, тайлангуудад үндэслэн хураангуйлав)

Энэхүү шигтгээнд Монгол улсад шинээр баригдаж байгаа стратегийн ач холбогдол бүхий төмөр замын томоохон төслүүд болох 1) Тавантолгой – Гашуунсухайт 2) Тавантолгой – Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслүүдийн явцын талаар авч үзнэ. Манай улсын хувьд нийт экспортын 40 орчим хувийг бүрдүүлдэг нүүрсний экспортыг төмөр замаар тээвэрлэх нь нүүрсний тээврийн зардлыг бууруулах, ачилт, тээвэрлэлтийн үед чанар муудах асуудлыг шийдэх, дотоодод нэмүү өртөг, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, Монголын нүүрсийг Хятадын бусад бүс нутгууд болон гуравдагч орнуудад экспортлох боломжийг нээхийн зэрэгцээ агаарын болон хөрсний бохирдол, тоосжилт, цөлжилт зэрэг байгаль орчинд бий болгож буй олон сөрөг нөлөөг багасгах ач холбогдолтой юм. Шигтгээнд авч үзэх төмөр замын төслүүдийн чиглэл болон байршлыг дараах зургаас харна уу.



1. ТАВАНТОЛГОЙ – ГАШУУНСУХАЙТ ЧИГЛЭЛИЙН ТӨМӨР ЗАМ

Төмөр замын захиалагчаар “Тавантолгой төмөр зам” компани, ерөнхий гүйцэтгэгчээр “Бодь интернэйшнл”, туслан гүйцэтгэгчээр 62 аж ахуйн нэгж оролцож байгаа бөгөөд төслийн хүрээнд 200 гаруй аж ахуйн нэгж, нэг ээлжинд 3’000 инженер, техникийн ажилтан, 1’200 хүнд даацын машин ажиллаж байна. Өмнөговь аймгийн Цогтцэций, Баян-Овоо, Ханбогд сумдын нутгийг дайран өнгөрөх нэгдүгээр зэрэглэлийн тус төмөр зам нь нийтдээ 2 өртөө, 6 зөрлөгтэй байх юм.

Засгийн газар Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 258.4 км замыг 2022 оны 7-р сард ашиглалтад оруулахыг зорьж буйгаа мэдэгдсэн. Ашиглалтад орсноос хойш эхний 2 жилийн хугацаанд жил бүр 10 сая тонн нүүрс тээвэрлэж туршилт хийнэ. Түүнээс хойш Тавантолгойн бүлэг ордын олборлолтын хэмжээ 2-3 дахин нэмэгдэж, жилд 30 сая тонн коксжих болон эрчим хүчний нүүрсийг экспортлох тээврийн хүчин чадал бий болох юм. Ингэснээр Монгол улс байгалийн баялгаа БНХАУ-ын Хуанхуа, Тяньжин, Чиндао, Жинжоу зэрэг далайн боомтоор дамжуулан олон улсын зах зээлд өрсөлдөхүйц үнээр гаргах боломжтой болно. Түүнчлэн, нүүрсийг төмөр замаар тээвэрлэснээр авто замын тээвэртэй харьцуулахад тээврийн зардлыг 4 дахин буюу тонн тутамд \$32-оос \$8 болгож бууруулахаас гадна бэлчээр сүйтгэх, тоосжилт, чимээ шуугиан, хөрс болон агаарын бохирдол үлэмж хэмжээгээр багасаж, байнгын 2’000 орчим ажлын байр бий болно гэж тооцоолжээ.

2021 оны 5-р сарын 10-ны байдлаар буюу хамгийн сүүлд нийтэд зарласан мэдээгээр газар шорооны ажил 81 хувь, дэд бүтцийн барилга угсралт 67 хувь буюу 233 км гол замын 201 км-ыг хийгээд байна. Мөн төмөр замын эхлэлийн цэг буюу Тавантолгой өртөөний дэргэд баригдаж буй зогсолтгүйгээр нүүрс тээвэрлэх тойрог замын барилгын ажил 92.8 хувийн гүйцэтгэлтэй байна. Ийнхүү Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр зам төгсгөлийн цэгтээ буюу Монгол Улс-БНХАУ-ын хилд ирснээр хил холболтын асуудлыг шийдвэрлэх асуудал үлдээд байна.

2. ТАВАНТОЛГОЙ – ЗҮҮНБАЯН ЧИГЛЭЛИЙН ТӨМӨР ЗАМ

2018 оны 5-р сарын 23-ны өдрийн Засгийн газрын 153 дугаар тогтоолоор тус чиглэлийг төмөр замыг “Дорнын төмөр зам” ХХК-тай хамтарсан “Зүүнбаян Төмөр Зам” ХХК байгуулахыг “Монголын Төмөр Зам” ХХК-д даалгасан.

“Монголын төмөр зам” ТӨХК-ийн захиалгаар баригдаж буй Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын доод бүтэц буюу газар шороо, хиймэл байгууламжийн ажлын ерөнхий гүйцэтгэгчээр Зэвсэгт хүчний Жанжин штаб, дээд бүтцийн ажлын ерөнхий гүйцэтгэгчээр “Улаанбаатар төмөр зам” ХНН ажиллаж байна. Тус төмөр замын доод бүтцийн ажлыг Зэвсэгт хүчний 10 гаруй анги, туслан гүйцэтгэгч дотоодын 60 гаруй аж ахуйн нэгжийн 6,000 орчим хүний нөөцөөр 1.2 жилийн хугацаанд гүйцэтгэж, 2020 оны 8-р сарын 25-ны өдөр хүлээлгэн өгсөн байна. Харин төмөр замын дээд бүтцийн үндсэн бүрдэл хэсэг болох рейльс төмрийг угсрах, 2 үе балластыг дэвсэх, чигжих ажилд “Улаанбаатар төмөр зам” ХНН-ийн туслан гүйцэтгэгчээр Зэвсэгт хүчний Жанжин штаб оролцож, 195 км, 221 км-ийн ажлыг тус тус хуваан гүйцэтгэжээ. Мөн төмөр зам дагасан бүх 6 зөрлөг, 1 өртөөний барилгын ажлыг мөн Зэвсэгт хүчний ангиуд барьж дуусгаад байна.

2019 оны 5-р сарын 24-ний өдөр нээлтээ хийсэн Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн 416.1 км хэвтээ тэнхлэгийн төмөр замын дээд, доод бүтцийн ажил үндсэндээ дуусч, 2021 оны 6-р сард хүлээлгэн өгөх төлөвлөгөөтэй байсан ч импортын тээвэр саатсан, санхүүжилт удаашралтай байгаа зэргээс шалтгаалж 10-р сарын 1 хүртэл хойшлоод байна. Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн гол төмөр замын урт 416.1 км, дэлгэмэл урт нь 463 км ба үүнээс 2021 оны 5-р сарын 10-ны өдрийн байдлаар 422 км-ыг нь угсарч дуусгасан, мөн 6 зөрлөгийг Улсын комисст хүлээлгэж өгсөн байна. Төмөр зам ашиглалтад орсны дараа хоёр сарын хугацаанд суман шилжүүлэг болон цариг тохируулах, дохиолол, холбооны системийн уялдаа холбоог хангах зэрэг туршилт, тохируулгын ажлууд хийгдэнэ. Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр зам ТЭЗҮ-ээрээ эхний жилдээ зургаан сая тонн ачаа тээвэрлэх бол энэ хэмжээ цаашид жилээс жилд нэмэгдэх юм.

Тус төмөр зам нь жилд 15 сая тонн ачаа тээвэрлэх (үүний 10 сая тонн нь нүүрс байх боломжтой) хүчин чадалтай. Төмөр зам Тавантолгойн уурхайгаас коксжих нүүрс экспортлох, уул уурхай болон аж үйлдвэрийн бүтээгдэхүүний тээвэрлэлт, экспортыг нэмэгдүүлэх, бүс нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийг дэмжихэд хувь нэмэр оруулна гэж тооцож байна.

Түүнчлэн, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн хэвтээ тэнхлэгийн төмөр замын төслийг дуусгасны дараа Дорноговь аймгийн Алтанширээ суманд баригдаж буй Газрын тос боловсруулах үйлдвэртэй холбож, улмаар Сүхбаатар, Дорнод аймгаар дамжуулан Бичигтийн боомттой холбох төмөр замын дэд бүтцийг барьж байгуулах талаар яригдаж байна. Төмөр замын дотоодын нэгдсэн сүлжээг Бичигтийн боомт хүртэл барьж байгуулснаар төмөр замын дагуу байрлах 37 орд газрын баялгийг эргэлтэд оруулах, нүүрс тээвэрлэлтийг нэмэгдүүлэх, транзит тээврийн маршрутыг хөгжүүлэх замаар эдийн засгийг тэлэх, нэг зах зээлээс хараат байдлыг бууруулах ач холбогдолтой.


Хүснэгт 11. Төмөр замын төслүүдийн харьцуулалт

	Тавантолгой - Гашуунсухайт	Тавантолгой – Зүүнбаян
Төмөр замын урт	258.4 км	416.1 км
Хүчин чадал, жилд	30 сая тонн ачаа	15 сая тонн ачаа
Бүтээн байгуулалт дуусах хугацаа	2022 оны 7-р сар	2021 оны 6-р сар
Шинэ ажлын байр	2'000 орчим	1'000 орчим


4.3. Мөнгө, зээлийн үзүүлэлтийн төлөв

M2 мөнгөний өсөлтийг гадаад цэвэр актив (ГЦА) болон банкны системийн зээлийн өсөлт голлон бүрдүүлж байна. Энэ оны 1 дүгээр улирлаас эхлэн банкны системийн зээл олголт сэргэж, M2 мөнгөний өсөлтийг нэмэгдүүлж байна. Сүүлийн 1 жилийн хугацаанд төлбөрийн тэнцэл ашигтай гарч, гадаад валютын албан нөөцийн хуримтлал 1 орчим тэрбум ам.доллаароор нэмэгдэж, ГЦА-ын өсөлтийг тэтгэв. Харин сүүлийн саруудад төлбөрийн тэнцэл алдагдалтай байгаа нь ГЦА-ын өсөлт саарахад нөлөөлөв.

Зураг 26. M2 мөнгөний жилийн өсөлтийн бүрэлдэхүүн, актив тал



Зураг 27. Зээлийн жилийн өсөлт, зориулалтаар




Эх сурвалж: Монголбанк

M2 мөнгөний өсөлтийг эх үүсвэр талаас төгрөгийн эх үүсвэр голлон бүрдүүлж, эх үүсвэрийн долларжилт сүүлийн 3 улирлын турш буурч **24.3** хувьд хүрэв. Үүнд нэг талаас төгрөгийн ам.доллартай харьцах ханш сүүлийн 1 жилийн хугацаанд тогтвортой байгаа нь голлон нөлөөлж байна. Түүнчлэн Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны 2020 оны 6 дугаар сарын хурлаар банкны эх үүсвэрийн долларжилтыг бууруулах, төгрөгийн харьцангуй өгөөжийг хадгалах бодлогын шийдвэр³² авч хэрэгжүүлсэн нь нөлөөллөө.


³² Өндөр хүүтэй гадаад валютын хадгаламж болон хүү төлж буй гадаад валютын харилцахын эзлэх хувиар банкинд олгох төгрөгийн ЗБН-ийн урамшууллыг бууруулан тооцох.

“Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-ний хэрэгжилттэй холбоотойгоор банкны системийн зээл олголт үргэлжлэн нэмэгдэж байна. Банкны системээс 2021 оны эхний 7 сарын байдлаар нийт 16 их наяд төгрөгийн зээл олгосон нь өмнөх оны мөн үеэс 4.6 их наяд төгрөгөөр буюу 41 хувиар өслөө. Зээл олголтын 2.5 их наяд орчим төгрөг нь 10 их наядын хөтөлбөрийн хүрээнд олгогджээ. Харин зээлийн эргэн төлөлт 13.6 их наяд төгрөг байгаа нь өмнөх оны мөн үеэс 1.7 их наяд төгрөг буюу 14.6 хувиар өссөн дүн юм. Улмаар банкны системийн зээлийн үлдэгдэл 2021 оны 7 дугаар сарын байдлаар оны эхнээс 2.2 их наяд төгрөгөөр нэмэгдэж 19.3 их наяд төгрөгт, жилийн өсөлт 12.3 хувьд хүрч нэмэгдлээ. Үүнийг ангилж харвал бизнесийн зээл 10 их наядын хөтөлбөрийн нөлөөгөөр жилийн 18.2 хувиар өсч, харин хэрэглээний зориулалттай зээл 4.6 хувиар буурсан байна.

Зураг 28. Банкны системийн долларжилт



Зураг 29. Банкны системээс олгосон зээл болон зээлийн эргэн төлөлт



Эх сурвалж: Монголбанк

Энэ онд зээлийн өсөлт үргэлжлэн нэмэгдэх, төсвийн алдагдлыг дотоод бондын эх үүсвэрээр санхүүжүүлэхээр байгаа нь М2 мөнгөний өсөлтийг голлон бүрдүүлэх хүлээлттэй байна. Түүнчлэн төлбөрийн тэнцлийн алдагдалтай холбоотойгоор энэ онд ГЦА-ын өсөлт саарах тооцооллыг боловсруулав. Харин 2022 болон 2023 онуудад төсөөллөөр зээлийн өсөлт энэ оны түвшинд тогтворжиж, төлбөрийн тэнцэл ашигтай байгаа нь М2 мөнгөний өсөлтийг тэтгэнэ. Төсвийн хүрээний мэдэгдэлд тусгаснаар төсвийн төлөв ирэх онуудад үргэлжлэн чангарахаар байгаа нь М2 мөнгөний нийлүүлэлтийг бууруулах нөлөөтэй. Цаашид КОВИД-19 цар тахлын тархалт болон Засгийн газраас авч хэрэгжүүлэх арга хэмжээ, арилжааны банкуудын зээлийн нөхцөл, шалгуур хэрхэн өөрчлөгдөхөөс зээлийн өсөлт болон М2 мөнгөний өсөлтийн төлөв хамаарна.

Хэдийгээр өмнөх жилтэй харьцуулахад зээлийн өсөлт сэргэж, эх үүсвэрийн долларжилт буурч санхүүгийн салбарт эерэг өөрчлөлтүүд ажиглагдаж байгаа ч КОВИД-19 цар тахалтай холбоотой тодорхой бус байдал хэвээр байна. Цар тахалтай холбоотойгоор зээлийн чанар муудах, улмаар банкны системийн тогтвортой үйл ажиллагаа болон харьцаа үзүүлэлтүүдэд сөргөөр нөлөөлж зээлийн төлөвт нөлөөлөх эрсдэлтэй байна. Түүнчлэн 10 их наядын цогц төлөвлөгөө амжилттай хэрэгжиж, зээлийн өсөлтийг голлон тэтгэж байгаа хэдий ч цаашид гадаад, дотоод макро эдийн засгийн тэнцвэрийг харгалзан үзэх шаардлагатай.

4.4. Төлбөрийн тэнцэл, гадаад секторын төлөв

Энэ онд төлбөрийн тэнцэл алдагдалтай гарах төлөвтэй байна. Цар тахлын улмаас Хятад-Монголын хилийн хязгаарлалт үргэлжилж, экспортын гол бүтээгдэхүүн болох нүүрсний экспорт удаан байлаа. Оны сүүлийн саруудад чингэлэг терминал ажиллаж эхлэхтэй холбоотойгоор

нүүрсний экспорт алгуур сэргэж энэ онд нийт 20 сая тоннд хүрэх төлөвтэй. Хэдийгээр нүүрс болон бусад гол бүтээгдэхүүнүүдийн экспортын биет хэмжээ цар тахлын өмнөх түвшинд хүрч сэргээгүй ч дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнэ өндөр байгаа³³ нь экспортын орлого 2021 онд өмнөх оноос 11 хувиар өсөхөд нөлөөлж байна. Энэ онд эдийн засгийн идэвхжил нэмэгдэж, уул уурхайн болон дэд бүтцийн томоохон төслүүд хэрэгжиж байгаа, газрын тосны үнэ өссөн, Засгийн газар, Төв банкнаас хэрэгжүүлж буй эдийн засгийг дэмжих багц арга хэмжээний нөлөөгөөр импорт 33 хувиар тэлэхээр байна. Харин цар тахлаас сэргийлэх бодлогын хүрээнд оны туршид Монгол Улсын хил жуулчдад нээгдээгүйгээс аялал жуулчлалын үйлчилгээ сэргэхээргүй, нийт үйлчилгээний дансны алдагдал өмнөх оны түвшинд байхаар байна. Улмаар урсгал тэнцлийн алдагдал өмнөх онд ДНБ-ий 5.1 хувьтай тэнцэж байсан бол энэ онд ДНБ-ий 14 хувьд хүрч тэлэхээр байна. Сүүлийн жилүүдэд урсгал тэнцлийн алдагдлыг ГШХО, гадаад зээл, бондоор санхүүжүүлж ирсэн. Энэ онд ГШХО өмнөх оны түвшинд байх, донор санхүүжилтийн хүрээнд 400 орчим сая ам.долларын санхүүжилт орж ирэх, хувийн секторын гадаад зээлийн ашиглалт буурах нөлөөгөөр санхүүгийн данс 1.9 тэрбум ам.долларын ашигтай гарч, нийт төлбөрийн тэнцэл 370 сая ам.долларын алдагдалтай гарах төлөвтэй байна. Ойрын хугацаанд дэлхийн улс орнуудад КОВИД-19-ын вирусын шинэ хувилбарын тархалт нэмэгдэж, дахин давалгаа үүсэх эрсдэлтэй байгаа нь БНХАУ-ын өсөлт, түүхий эдийн эрэлт, үнээр дамжин манай экспортын орлого болон манай улсыг чиглэх хөрөнгийн урсгалд сөргөөр нөлөөлж, төлбөрийн тэнцлийг дээрх суурь төсөөллөөс муутгаж болзошгүй байна.

Дунд хугацаанд урсгал тэнцлийн алдагдал өндөр хэвээр байх төлөвтэй. Дунд хугацаанд цар тахлын тархалт намжиж, гадаад эрэлт сэргэн, зэс, нүүрсний экспорт нэмэгдэх хэдий ч Оюу толгойн зэсийн баяжмал дахь алтны агууламж буурах, эдийн засгийн идэвхжлийг даган хэрэглээ, хөрөнгө оруулалт, шатахууны импорт үргэлжлэн тэлэх, үйлчилгээний болон орлогын дансны алдагдал нэмэгдэж, урсгал дансны алдагдал ДНБ-ий 14-15 хувь орчимд байхаар байна. Дунд хугацаанд урсгал тэнцлийн алдагдлыг бууруулах эдийн засгийн бүтцийн өөрчлөлтийг хийх, төгрөгийн ханшийг суурь нөхцөлтэй нийцүүлэн сулруулахгүй тохиолдолд гадаад тэнцвэргүй байдлыг бий болгож буй суурь нөхцөл засварлагдахгүй байхаар байна.

Урсгал тэнцлийн алдагдлын зэрэгцээ 2022-2023 онд Засгийн газрын Чингис бондын үлдэгдэл 140 орчим сая ам.доллар, Гэрэгэ бондын үлдэгдэл 540 орчим сая ам.доллар, МУХБ-ны 500 сая ам.долларын бонд, Самурай бондын төлбөр 300 орчим сая ам.доллар, ХАБ-ны своп хэлцэл, Оюу толгойн зээлийн эргэн төлөлт зэрэг нийт 4.0 орчим тэрбум ам.долларын томоохон эргэн төлөлтүүд хүлээгдэж байна. Эдгээр өр, төлбөрийг гадаад бонд, зээлээр дахин санхүүжүүлнэ гэж үзвэл төлбөрийн тэнцэл 2022 онд 260 сая ам.долларын ашигтай, 2023 онд 300 сая ам.долларын алдагдалтай гарахаар байна. Хэрэв эдгээр өр, төлбөрийг дахин санхүүжүүлж чадахгүй, эргэн төлөх шаардлага үүсэх тохиолдолд гадаад санхүүжилтийн хэрэгцээ огцом нэмэгдэж, гадаад тэнцвэрт байдал алдагдах эрсдэлтэй байна.

Гадаад валютын нөөцийн хүрэлцээ, гадаад өрийн дарамт өндөр байна. Сүүлийн 20 жилд урсгал тэнцэл дунджаар ДНБ-ий 11 хувийн алдагдалтай байж, түүнийг ГШХО, гадаад зээл, бондоор санхүүжүүлж ирснээр манай гадаад өр нэмэгдэж байна. Гадаад өрийн тогтвортой байдлын шинжилгээгээр Монгол Улсын нийт гадаад өр энэ онд ДНБ-ий 220 гаруй хувьд хүрэхээр байгаа нь гадаад өрийн дарамт өндөр байгааг илтгэж байна. Түүнчлэн, өрийн үйлчилгээ³⁴ сүүлийн 10 жилийн хугацаанд 10 дахин нэмэгдэж, 2019 онд экспортын орлогын 32 хувь, 2020 онд 44 хувь, энэ онд дунджаар 30 хувьд хүрэх буюу өрийн үйлчилгээний дарамт өндөр байна. Дунд хугацаанд уул уурхайн томоохон хөрөнгө оруулалтууд татрах үед урсгал тэнцлийн алдагдал өндөр хэвээр байх тохиолдолд өрийн үйлчилгээг санхүүжүүлэхэд хүндрэл үүсч болзошгүй. Мөн гадаад өрийн түвшин өсөхийн хэрээр гадаад зээл, бондын хүүний төлбөрүүд жил ирэх бүр өсөн нэмэгдэж

³³ 2021 оны 6-р сарын байдлаар экспортын үнэ өмнөх оны мөн үеэс 42 хувиар өссөн.

³⁴ Эргэн төлөлтийн хуваарийн дагуу төлөгдөх гадаад өрийн үндсэн болон хүүний төлбөрүүд

байгаа нь эргээд урсгал тэнцлийг өндөр алдагдалтай гарахад нөлөөлж байна.


Төлбөрийн тэнцэл 2021 онд алдагдалтай гарах ч Монгол Улсын ОУВС-гаас авсан зээл болон мөнгөжсөн алтны нөөц нэмэгдэх нөлөөгөөр гадаад валютын албан нөөц оны эцэст өмнөх оны түвшинд буюу 4.5 тэрбум ам.доллар байх төлөвтэй³⁵. Энэ нь импортын 7.9 сарын хэрэгцээг хангах, богино хугацаат өр төлбөрийг бүрэн барагдуулах түвшин юм. Харин ГВАН-ийн зохистой түвшинг ОУВС-гийн аргачлал ARA metric ашиглан тооцвол гадаад валютын хүрэлцээ энэ онд өмнөх оноос 3 пунктээр буурч 71 хувьд хүрэх буюу зохистой түвшин (100-150%)-ээс доогуур хэвээр байна³⁶. Гадаад валютын нөөцийн хүрэлцээт байдлын шаардлагыг нэмэгдүүлж байгаа гол хүчин зүйл нь гадаад өрийн эргэн төлөлт болж байна. Иймд одоогийн гадаад валютын албан нөөцийн хэмжээ нь богино, дунд хугацаанд хүлээгдэж буй гадаад өр, төлбөрийг төлж барагдуулах, эдийн засгийн дархлааг хангах зохистой түвшинд хүрээгүй байгаа тул валютын нөөцийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

ШИГТГЭЭ 4. Ковид-19 цар тахлын эсрэг мөнгөний бодлого: Монгол Улс ба бусад улсын туршлага

Цар тахлын үед төв банкууд хямралыг зөөллөх, ажлын байр хадгалах, эдийн засгийн сэргэлтийг дэмжих зорилгоор мөнгөний бодлогын уламжлалт болон уламжлалт бус хэрэгслийг хослуулан ашигласан³⁷ бөгөөд эдгээрийг нэгтгэн дүгнэвэл:

- **Төв банкууд бодлогын хүүгээ бууруулав.** Ихэнх орнуудын хувьд бодлогын хүү сүүлийн жилүүдийн хамгийн доод түвшиндээ хүрсэн байна. Монгол Улсын хувьд ч энэ хандлага ажиглагдсан бөгөөд 2020 оны 11 сард бодлогын хүүг түүхэн доод хэмжээ буюу 6 хувьд хүргэв (Зураг 30).

Зураг 30. Төв банкуудын бодлогын хүү, цар тахлын өмнөх болон цар тахлын үед



Эх сурвалж: Блүүмберг


³⁵ Төлбөрийн тэнцлийн 370 сая ам.долларын алдагдалтай гарч байгаа ч Монголбанк энэ онд худалдан авсан алтны тодорхой хувийг мөнгөжүүлж, нөөцөд хадгалсан (310 гаруй сая ам.доллар), ОУВС-гаас 98 сая ам.долларын зээлийг МУ-д олгосон нь ГВАН-ийг өсгөх нөлөөтэй.

³⁶ МУ-ын гадаад өр нэмэгдэж байгаа, импорт хурдтай тэлж байгаа нь ГВАН-ийн зохистой түвшин/шаардлагыг өсгөх гол хүчин зүйл болж байна. Ийнхүү ГВАН-ийн шаардлага нэмэгдэж байгаа ч бодит байдал дээр төлбөрийн тэнцлийн алдагдлын улмаас ГВАН-ийн өсөхөөргүй байгаа тул ГВАН-ийн хүрэлцээ багасаж байна.

³⁷ Эх сурвалж: English, B., Forbes, K., & Ubide, A., “Monetary policy and central banking in the Covid era” (2021), Centre for Economic Policy Research, London, UK.; Cantu, C, P Cavallino, F de Fiore and J Yetman “A global database on central banks’ monetary responses to Covid-19” (2021), BIS Working papers No.934.

- Төв банкууд зах зээлийг тогтворжуулах, хувийн хэрэглээг дэмжих, аж ахуйн нэгжүүдийн тасралтгүй үйл ажиллагааг хангах, эрүүл мэндийн салбарыг дэмжих зорилгоор актив хөрөнгүүдийг худалдан авч эхэлсэн байна.
- Аж ахуйн нэгжүүдийн төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг нэмэгдүүлэх, зээлийн өсөлтийг дэмжих, ажлын байрыг хадгалах зорилгоор төв банкууд санхүүгийн бус секторуудад шууд болон шууд бус хэлбэрээр зээл олгов. Түүнчлэн, заавал байлгах нөөц болон бусад хөрвөх чадварын, хөрөнгийн шалгуур үзүүлэлтүүдийг сулруулсан байна. Манай улсын хувьд ч эдийн засгийн сэргэлтийг түргэсгэж, бодит сектор, ажлын байр, экспортыг дэмжих зорилгоор 2020 оны 9-р сараас эхлэн урт хугацаат репо санхүүжилтийн хэрэгслийг нэвтрүүлж, төгрөгийн заавал байлгах нөөцийн хувь хэмжээг 10.5 хувиас 6 хувьд хүртэл буулгав.

Зураг 31. Цар тахлын үед Монголбанкнаас авч хэрэгжүүлсэн Мөнгөний бодлогын арга хэмжээ



4.5. Бодлогын анхаарах асуудлууд

Улс орнуудын хувьд эдийн засгийн бодлогын арга хэмжээг цар тахлын үеийн сөрөг нөлөөг сааруулах, цар тахлын дараа тогтвортой, өрсөлдөх чадвартай эдийн засгийн бүтцийг бий болгоход анхаарч байна. Тухайлбал, эдийн засгийн сэргэлтийг хүртээмжтэй байлгах, хөрөнгө оруулалтыг ногоон санхүүжилт болон уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөг бууруулах, өрсөлдөх чадвар, бүтээмжийг дээшлүүлэхэд зориулж байна. Хөгжиж байгаа орнуудын хувьд төсвийн бодлогыг үр ашигтай байлгаж, бүтцийн шинэчлэлд төвлөрүүлэхийн зэрэгцээ өрийн тогтвортой байдлыг хангах нь чухал хэвээр байна. Мөнгөний бодлогын хувьд ихэнх улс орнууд тэлэх бодлогоо эдийн засаг бүрэн сэргэтэл үргэлжлүүлэх төлөвтэй байна.

Монгол Улсын хувьд Засгийн газар болон Төв банкны зүгээс КОВИД-19 цар тахлын эдийн засгийн сөрөг нөлөөг бууруулахаар шат дараатайгаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээ болон гадаад орчны харьцангуй таатай байдал зэрэг нь эдийн засаг сэргэхэд эерэг нөлөө үзүүлж байна. Гэхдээ эдийн засгийн салбаруудын өсөлт жигд бус, вирусын шинэ хувилбартай холбоотойгоор тодорхой бус байдал өндөр хэвээр байна. Цар тахлын үеийн бодлогод анхаарах дараах асуудлууд байна:

- Төсвийн тэлэх бодлогын нөлөөгөөр төсвийн алдагдал нэмэгдэж³⁸, улмаар Засгийн газрын гадаад өрийн хэмжээ 2020 онд ДНБ-ийн 67 хувьд³⁹ хүрч өссөн хэдий ч энэ нь дэлхийн дунджаас доогуур байна. Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, нийгмийн эмзэг бүлэгт

³⁸ 4.5 их наяд төгрөг (ДНБ-ий -12.3%)

³⁹ 4.4 их наяд төгрөгөөр (ДНБ-ий 12.4%) нэмэгдэж 24.8 их наяд төгрөгт хүрсэн.

чиглэсэн бодлого, ажилгүйдлийн тэтгэмж, бага орлоготой иргэдийн татварын хөнгөлөлт, хүнсний тусламж зэргээр төсвийн тэлэх бодлого үргэлжлэх зайлшгүй шаардлагатай байгаа боловч өрийн тогтвортой байдал нь цаашид төсвийн бодлого хэрхэн үргэлжлэхийг тодорхойлох гол хүчин зүйл болно. Иймд бусад орнуудын адилаар төсвийн бодлого илүү зорилтот бүлэг рүү чиглүүлэх, зайлшгүй шаардлагагүй хөрөнгө оруултыг тэвчих, урсгал зардлын үр ашгийг нэмэгдүүлэх зэргээр төсвийн зарцуулалтыг оновчтой болгох, бууруулах шаардлага үүснэ.

- Төв банкны зүгээс мөнгөний болон макро зохистой бодлогын арга хэмжээнүүд, шинээр нэвтрүүлсэн санхүүжилтийн хэрэгслүүд, санхүүгийн хөнгөлөлтийн зохицуулалтууд нь эдийн засгийн сэргэлтийг дэмжиж, санхүүгийн салбарын тогтвортой байдалд эерэгээр нөлөөлж байна. Мөнгөний бодлогын хувьд инфляц зорилтот түвшнээс давах эрсдэлтэй байгаа нь цаашид тэлэх орон зайг хязгаарлах эрсдэл үүсгэж байна. Хэдийгээр нэг талаас эдийн засгийн сэргэлтийн нөлөө алгуур өсөхөөр байгаа боловч нөгөө талаас инфляцийн дийлэнх хэсгийг өмнөх оны үнийн бууралтын нөлөө, шатахууны үнийн өсөлт, хил, гааль дээр үүссэн импортын хадгалалт, тээвэрлэлтийн зардлын өсөлт зэрэг нийлүүлэлтийн шалтгаантай бусад хүчин зүйлс тайлбарлахаар байна. Иймд мөнгөний бодлогын шийдвэрийг гаргахдаа эрэлтийн инфляцын цаашдын төлөвийг анхаарахаас гадна нийлүүлэлтийн шалтгаантай инфляцийн дам нөлөө өндөр, удаан үргэлжлэх эсэхийг нягтлах болно.
- Хилийн гацаа, тээвэр логистикийн асуудлыг шийдвэрлэх. Гадаад харилцаа, гадаад худалдаа болон эдийн засгийг дэмжих бодлогуудыг нягт уялдуулан экспорт, импортын тээвэр хэвийн үргэлжлэх боломжийг бүрдүүлэхэд хөрш оронтойгоо Засгийн газрын түвшинд яриа, хэлэлцээр хийх замаар гадаад валютын урсгал татрахаас сэргийлэх, дотоодод нийлүүлэлтийн шалтгаантай үнийн хөөрөгдөл даамжрахаас сэргийлэх нь эдийн засгийн сэргэлтийг хадгалахад голлох нөлөөг үзүүлэхээр байна.
- КОВИД-19 цар тахал болон гадаад орчны бусад таагүй нөлөөгөөр 2020 онд гадаад эрэлт агших, гадаад худалдаа саатах, ГШХО саарах, гадаад өр нэмэгдэх сорилтуудтай тулгарсан. Цаашид цар тахлын тархалт, мутацад орсон вирусын давалгаа гарах эрсдэлээс шалтгаалан импортлогч талаас хилийн хязгаарлалтаа чангатгах, импортын бараа, үйлчилгээний зардал, тээврийн зардал хурдтай өсөх зэрэг нь эрсдэл болж байна. Мөн эдийн засаг дахь гадаад валютын нийлүүлэлт буурах нь долларжилтыг нэмэгдүүлж, банкны баланс дахь тэнцвэрт бус байдалд нөлөөлөх эрсдэлтэй. Иймд эдийн засгийн шокыг шингээх эсхүл түүний сөрөг үр дагаврыг хохирол багатай даван туулах чадвар, дархлааг бэхжүүлэхийн тулд гадаад тэнцвэрийг худалдааны тэнцэл болон гадаад өрийн зохистой түвшинг хослуулах байдлаар бүрдүүлэхэд анхаарах шаардлага тулгарч байна. Мөн дунд, урт хугацаанд бусад улс орны жишгээр экспортыг төрөлжүүлэх урт хугацааны тогтвортой бодлогыг хэрэгжүүлэх нь зүйтэй.

Эцэст нь цар тахлын нөхцөл байдлаас авах сургамж нь цаашид зөвхөн эдийн засгийн өсөлт төдийгүй ажил эрхлэлт, иргэд үндсэн хэрэгцээгээ хангах боломж, тогтвортой байдлын зорилт, ирээдүйд чиглэсэн хөрөнгө оруулалт, ногоон хөгжил зэрэг олон талт үзүүлэлтүүдийг хамруулан авч үзэх шаардлагатайг дэлхий нийтээрээ онцолж байгааг бодлого боловсруулагчид анхаарах шаардлагатай байна.

ШИГТГЭЭ 5. Уул уурхайн бус экспортод тулгамдаж буй асуудлууд

- **Санхүүжилт:** Уул уурхайн бус экспортлогч ААН-ийн үйлвэрлэлийн онцлогт зохицсон эргэлтийн хөрөнгийн санхүүжилт шаардлагатай байна. Тухайлбал, ноос ноолуурын салбарт түүхий эдийг эцсийн бүтээгдэхүүн болгож хэрэглэгчдэд хүргэхэд 1-2 жил шаардагддаг бөгөөд эргэлтийн хөрөнгийн санхүүжилт, түүний эргэн төлөх хугацаа харьцангуй урт байх шаардлагатай болдог. Мөн зарим экспортлогч ААН-ууд нь барьцаа хөрөнгийн шаардлагаас үүдэн эргэлтийн хөрөнгийн санхүүжилт банкнаас авахад хүндрэлтэй байдаг тул үүнийг шийдвэрлэх санхүүгийн хэрэгсэл, дэмжлэг чухал байна. Үүний дээр ихэнх уул уурхайн бус экспорт ХАА гаралтай бүтээгдэхүүн бөгөөд түүхий эд бэлтгэх үеэр санхүүжилтийн хэрэгцээ ихээр гардаг байна. Үүнээс шалтгаалан зарим тохиолдолд хангалттай түүхий эд бэлтгэж чадахгүй байна. **Олон улсад өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх үүднээс ААН-үүдийн үйлдвэрийн тоног төхөөрөмж, технологийн шинэчлэлтэд шаардагдах санхүүжилтийн боломжийг нэмэгдүүлэх нь мөн чухал юм. Энэ нь ихэвчлэн урт хугацаатай санхүүжилт байх шаардлагатай.**
- **Ажиллах хүч:** Уул уурхайн бус экспортын үйлдвэрлэлд ажиллах хүчний хомсдол үүсэх эрсдэлтэй байгаа тул мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, ажлын байрыг хадгалах тал дээр бодлогын зүгээс дэмжих шаардлагатай байна. Тодруулбал, зарим экспортын бүтээгдэхүүний үйлдвэрлэл нарийн мэргэжил шаарддаг тул туршлагатай, мэргэшсэн боловсон хүчин бэлтгэхэд олон жил шаарддаг хэдий ч иргэдийн энэ чиглэлээр суралцах сонирхол бага байж болзошгүй байна. Түүнчлэн, цар тахлын сөрөг нөлөө экспортлогч ААН-үүдэд харилцан адилгүй байгаа бөгөөд ялангуяа аялал жуулчлал зэрэг улирлын чанартай үйл ажиллагаа эрхлэгчдийн хувьд ажлын байрыг хадгалж үлдэх нь хүнд сорилт болж байна.
- **Олон улсын харилцаа, өрсөлдөх чадвар:** Экспортын зах зээлийг тэлэх, шинээр нээх, дэлхийн нийлүүлэлтийн сүлжээнд Монголын бүтээгдэхүүнийг холбох шаардлагатай. Үүний тулд гадаад зах зээлд ажиллаж буй бизнесүүдтэй дотоодын бизнесүүдийг нийцүүлэн холбох, технологийн болон стандартын нийцлийг хангах, хөрөнгө оруулалт татаж хамтарсан бизнес үүсгэх гэх мэт асуудлуудыг шийдвэрлэх шаардлагатай. Тухайлбал, манай экспортлогчдын хувьд импортлогч улсын зөвшөөрөл, чанар стандартыг хангасан тухай гэрчилгээ авах нь хүндрэлтэй байдаг. Иймд, хариуцсан байгууллагуудаар дамжуулан олон улсын зөвшөөрөл, чанар стандартыг хэрхэн хангах, дотоодын аж ахуй нэгжүүдийн экспортын боломжийг нэмэгдүүлэх шаардлагатай байна. Жишээлбэл, манай улс одоогоор БНХАУ болон ОХУ-тай л ихэнхдээ махны экспорт эрхэлж байгаа бөгөөд Монгол Улсын Засгийн газар гадаад харилцааны бодлогоор дэмжсэнээр Иран, Кувейт, Зүүн өмнөд Азийн орнуудад мах, махан бүтээгдэхүүн экспортлох боломжтой байна.
- **Хууль тогтоомж:** Төрөөс хэрэгжүүлж чиглэсэн аливаа бодлого, стратегийг боловсруулж хэрэгжүүлэхдээ хэрэгжих бололцоог үндэс болгон прагматик байдлаар асуудалд хандаж, төрийн байгууллагуудын уялдаа холбоог хангах шаардлагатай. Холбогдох зарим хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотойгоор малын гаралтай түүхий эд ашиглан үйлдвэрлэл эрхлэгч, экспортлогчдод түүхий эд, материалын нөөцөө малчдаас шууд худалдан авах эсвэл эцсийн бүтээгдэхүүнийг экспортлоход хүндрэлтэй байна. Мөн зарим салбарт экспортын гаалийн бүрдүүлэлт, түүнд тавигдах хяналт, шалгалтад давхцал үүсдэг нь аж ахуй нэгжүүдийн үйл ажиллагаанд саад учруулдаг байна.
- **Хамтын ажиллагаа:** Энэ төрлийн бизнесийг хөгжүүлэхэд хамтын ажиллагаа улс хоорондын, төр-хувийн, хувь-хувийн хэвшлийн гэсэн байдлаар бүх талаар эрчимтэй өрнүүлж, мэдээллийн тэгш бус байдлыг, хүнд суртлыг арилгах шаардлагатай. Түүнчлэн, бизнесүүдийг кластер байдлаар дэмжих, банк, санхүүгийн байгууллагуудыг ААН-үүдтэй холбох мэдээлэл урсгалыг бий болгох, түншлэлийг хөгжүүлэх нь дэмжлэг болохоор байна.

Хүснэгт 12. Эдийн засаг болон санхүүгийн үзүүлэлтүүд, (суурь төсөөлөл)

ЭДИЙН ЗАСАГ БОЛОН САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД								
	Гүйцэтгэл					2021	2022	2023
	2017	2018	2019	2020	2021.07	Төс.		
хувь, %								
Бодит сектор (6 сар)								
Бодит ДНБ	5.6	7.7	5.6	-4.6	6.3	5.1 [^]	5.8 ^{^^}	5.2 ^{^^^}
Уул уурхайн ДНБ	-3.9	5.4	-1.6	-9.9	24.3	4.3	-4.7	6.7
Уул уурхайн бус ДНБ	7.7	8.2	6.9	-3.7	4.0	5.2	7.6	5.0
Хэрэглээний үнийн индекс*	6.6	7.5	6.0	2.7	6.6	7.6	6.9	5.8
ДНБ-ний дефлятор	10.6	8.0	8.3	5.9	9.7	9.5	4.0	4.8
тэрбум төгрөгөөр								
Нэгдсэн төсвийн үзүүлэлтүүд								
Нийт орлого	7,922	10,063	11,937	10,402	8,667	14,025	14,513	16,242
Ирээдүйн өв сан	358	621	1,040	914	709	1,188	1,095	1,156
Тогтворжуулалтын сан	326	207	95	66	299	431	268	144
Тэнцвэржүүлсэн орлого	7,239	9,235	10,802	9,422	7,659	12,405	13,150	14,942
Татварын орлого	6,303	8,207	9,749	8,502	6,744	10,844	11,581	13,301
Татварын бус орлого	936	1,028	1,053	920	915	1,465	1,392	1,464
Нийт зардал ба цэвэр зээл	8,981	9,223	11,429	13,961	8,490	15,748	14,852	15,925
Урсгал зардал	6,842	7,348	8,208	10,872	7,396	12,753	10,635	11,061
Хөрөнгийн зардал ба зээл	1,975	1,875	3,222	3,089	1,093	2,995	4,217	4,864
Хөрөнгийн зардал	1,646	1,608	2,818	3,052	993	3,594	3,808	5,143
Эргэж төлөгдөх цэвэр зээл	329	267	403	38	100	-599	409	-279
Тэнцвэржүүлсэн тэнцэл	-1,742	12	-628	-4,539	-831	-3,343	-1,702	-983
Анхдагч тэнцэл (Тэнцвэржүүлсэн тэнцлээс тооцсон)	-586	1,059	233	-3,580	-378	-2,520	-613	-159
Шаардлагатай санхүүжилт	7,290	2,703	1,231	7,378	1,774	4,700	6,573	5,975
Дотоод эх үүсвэр	1,589	1,263	-272	2,307	1,062	3,014	1,825	551
Гадаад эх үүсвэр	5,701	1,440	1,503	5,071	712	1,686	4,748	5,424
хувь, %								
Мөнгө ба зээлийн үзүүлэлтүүд								
M2 мөнгө	30.5	22.8	7.0	16.3	26.5	22.1	15.4	11.5
Зээл+ИЗББ	11.0	24.3	4.5	-4.0	9.6	14.8	14.3	15.3
Зээл	9.6	26.5	5.0	-4.0	12.3	17.3	16.1	17.0
Нийт харилцах, хадгаламж, тэрбум ₮	15,249	18,804	20,219	23,467	26,298	28,645	33,057	36,845
Төгрөгийн харилцах, хадгаламж, тэрбум ₮	10,836	13,517	14,409	16,843	19,940	21,720	25,065	27,937
Гадаад валютын харилцах, хадгаламж, тэрбум ₮	4,413	5,287	5,810	6,624	6,357	6,925	7,992	8,907
сая ам.доллараар								
Төлбөрийн тэнцэл								
Урсгал тэнцэл	-1155	-2207	-2162	-675	-1292	-2106	-2228	-2626
Худалдааны тэнцэл	1494	676	1158	1756	319	677	840	760
Экспорт Ф.О.Б.	5834	6557	7183	6991	4136	7648	8517	9112
Импорт Ф.О.Б.	-4341	-5881	-6025	-5235	-3817	-6970	-7676	-8352
Хөрөнгийн ба санхүүгийн тэнцэл	2677	2181	2838	1607	990	1860	2488	2926
Гадаадын шууд хөрөнгө оруулалт	1446	2137	2316	1693	1120	1690	2213	2653
Санхүүгийн хөрөнгө оруулалт	493	61	372	-563	-121	-94	-339	-30
Бусад	-62	-116	-224	-146	2	264	615	302
Нийт тэнцэл	1460	-142	453	787	-300	-370	260	300
Нэрлэсэн ДНБ, тэрбум төгрөгөөр	28011	32583	37839	37453		43128	47510	52396
Нэрлэсэн ДНБ, жилийн өсөлт	17.0	16.3	16.1	-1.0		15.2	10.2	10.3

*-Оны 4 дүгээр улирлын улирлын дундаж

^ - 30 хувийн магадлалтай итгэх интервал нь [(3.5) - (6.6)]

^^ - 30 хувийн магадлалтай итгэх интервал нь [(3.7) - (8.0)]

^^^ - 30 хувийн магадлалтай итгэх интервал нь [(2.6) - (7.8)]

Хүснэгт 13. Эдийн засаг болон санхүүгийн үзүүлэлтүүд, ДНБ-д эзлэх хувиар (суурь төсөөлөл)

ЭДИЙН ЗАСАГ БОЛОН САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД								
	Гүйцэтгэл					2021	2022	2023
	2017	2018	2019	2020	2021.07	Төс.		
Өөрөөр заагаагүй бол ДНБ-д эзлэх хувиар, %								
Бодит сектор (6 сар)								
Нэрлэсэн ДНБ, тэрбум төгрөгөөр	28011	32583	37839	37453	40168	43128	47510	52396
Бодит ДНБ (жилийн өсөлт)	5.6	7.7	5.6	-4.6	6.3	5.1 [^]	5.8 ^{^^}	5.2 ^{^^^}
Хэрэглээний үнийн индекс* (жилийн өсөлт)	6.6	7.5	6.0	2.7	6.6	7.6	6.9	5.8
ДНБ-ний дефлятор (жилийн өсөлт)	10.6	8.0	8.3	5.9	9.7	9.5	4.0	4.8
Нэгдсэн төсвийн үзүүлэлтүүд								
Нийт орлого	28.3	30.9	31.5	27.8	20.1	32.5	30.5	31.0
Ирээдүйн өв сан	1.3	1.9	2.7	2.4	1.6	2.8	2.3	2.2
Тогтворжуулалтын сан	1.2	0.6	0.2	0.2	0.7	1.0	0.6	0.3
Тэнцвэржүүлсэн орлого	25.8	28.3	28.5	25.2	17.8	28.8	27.7	28.5
Татварын орлого	22.5	25.2	25.8	22.7	15.6	25.1	24.4	25.4
Татварын бус орлого	3.3	3.2	2.8	2.5	2.1	3.4	2.9	2.8
Нийт зардал ба цэвэр зээл	32.1	28.3	30.2	37.3	19.7	36.5	31.3	30.4
Урсгал зардал	24.4	22.6	21.7	29.0	17.1	29.6	22.4	21.1
Хөрөнгийн зардал ба зээл	7.1	5.8	8.5	8.2	2.5	6.9	8.9	9.3
Хөрөнгийн зардал	5.9	4.9	7.4	8.1	2.3	8.3	8.0	9.8
Эргэж төлөгдөх цэвэр зээл	1.2	0.8	1.1	0.1	0.2	-1.4	0.9	-0.5
Тэнцвэржүүлсэн тэнцэл	-6.2	0.0	-1.7	-12.1	-1.9	-7.8	-3.6	-1.9
Анхдагч тэнцэл (Тэнцвэржүүлсэн тэнцгээс тооцсон)	-2.1	3.2	0.6	-9.6	-0.9	-5.8	-1.3	-0.3
Шаардлагатай санхүүжилт	26.0	8.3	3.3	19.7	4.1	10.9	13.8	11.4
Дотоод эх үүсвэр	5.7	3.9	-0.7	6.2	2.5	7.0	3.8	1.1
Гадаад эх үүсвэр	20.4	4.4	4.0	13.5	1.7	3.9	10.0	10.4
Мөнгө ба зээлийн үзүүлэлтүүд								
M2 мөнгө (жилийн өсөлт)	30.5	22.8	7.0	16.3	26.5	22.1	15.4	11.5
Зээл+ИЗББ (жилийн өсөлт)	11.0	24.3	4.5	-4.0	9.6	14.8	14.3	15.3
Зээл (жилийн өсөлт)	9.6	26.5	5.0	-4.0	12.3	17.3	16.1	17.0
Нийт харилцах, хадгаламж, тэрбум ₮	54.4	57.7	53.4	62.7	61.0	66.4	69.6	70.3
Төгрөгийн харилцах, хадгаламж, тэрбум ₮	38.7	41.5	38.1	45.0	46.2	50.4	52.8	53.3
Гадаад валютын харилцах, хадгаламж, тэрбум ₮	15.8	16.2	15.4	17.7	14.7	16.1	16.8	17.0
Төлбөрийн тэнцэл								
Урсгал тэнцэл	-10.0	-17.9	-15.6	-5.1	-8.6	-14.1	-13.8	-14.5
Худалдааны тэнцэл	12.9	5.5	8.4	13.4	2.1	4.5	5.2	4.2
Экспорт Ф.О.Б.	50.6	53.2	51.9	53.2	27.6	51.1	52.8	50.5
Импорт Ф.О.Б.	-37.6	-47.7	-43.5	-39.8	-25.5	-46.6	-47.6	-46.3
Хөрөнгийн ба санхүүгийн тэнцэл	23.2	17.7	20.5	12.2	6.6	12.4	15.4	16.2
Гадаадын шууд хөрөнгө оруулалт	12.5	17.3	16.7	12.9	7.5	11.3	13.7	14.7
Санхүүгийн хөрөнгө оруулалт	4.3	0.5	2.7	-4.3	-0.8	-0.6	-2.1	-0.2
Бусад	-0.5	-0.9	-1.6	-1.1	0.0	1.8	3.8	1.7
Нийт тэнцэл	12.7	-1.2	3.3	6.0	-2.0	-2.5	1.6	1.7

*-Оны 4 дүгээр улирлын улирлын дундаж

^ - 30 хувийн магадлалтай итгэх интервал нь [(3.5) - (6.6)]

^^ - 30 хувийн магадлалтай итгэх интервал нь [(3.7) - (8.0)]


^^^ - 30 хувийн магадлалтай итгэх интервал нь [(2.6) - (7.8)]

ШИГТГЭЭ 6. Монгол Улсын зээлжих зэрэглэлд нөлөөлөх хүчин зүйлс

Улсын зээлжих зэрэглэл гэдэг нь гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдаас тухайн улсад олгосон зээлийн төлбөрийг эргэн төлөх чадвар, зээлдэгчийн ерөнхий эрсдэлийг үнэлэх гол үзүүлэлт болохын зэрэгцээ улсын эрсдэлийн түвшинг илтгэх хамгийн түгээмэл ашиглагддаг цогц, найдвартай хэмжүүр юм. Зээлжих зэрэглэл тогтоогч агентлагууд нь эдийн засаг, төсөв санхүү, улс төр, нийгмийн гэх мэт шаардлагатай асуудлуудаар албан уулзалтын болон олон нийтэд зарласан мэдээлэлд үндэслэн өөрсдийн аргачлалын дагуу тухайн улсын үнэлгээг гүйцэтгэдэг.

Манай улсын хувьд 1999 оноос эхлэн олон улсад нэр хүндтэй Эс энд Пи (S&P), Фитч (Fitch) болон Мүүдиз (Moody's) зэрэг агентлагуудаар зээлжих зэрэглэлийн үнэлгээг тогтоолгож байна. Эдгээр агентлагийн үнэлгээний аргачлал, ангиллууд хоорондоо ижил төстэй бөгөөд аргачлалын дагуу гаргасан олон төрлийн үзүүлэлтүүдээс “гадаад валютын урт хугацаат зээлжих зэрэглэл” нь тухайн улсын ерөнхий зээлжих зэрэглэлийг илтгэж, зээлжих зэрэглэлийн төлөв нь цаашид үнэлгээг өсгөх, эсхүл бууруулах магадлалыг илэрхийлдэг.

Зураг 32. Монгол Улсын зээлжих зэрэглэл, **Хүснэгт 14.** Зээлжих зэрэглэлийн хэмжүүрүүд, агентлаг тус бүрээр



Эх сурвалж: Мүүдиз, Фитч, Эс энд Пи, Монголбанк

Эх сурвалж: Мүүдиз, Фитч, Эс энд Пи

Монгол Улсын зээлжих зэрэглэл 2010-2013 онд хамгийн өндөр түвшинд хүрч байсан бол 2014 оноос эхэлсэн эдийн засгийн хүндрэлээс шалтгаалан зээлжих зэрэглэл буурч, 2016-2017 онд өөрийн улсын хувьд хамгийн багаар үнэлэгдэж байв. Харин Засгийн газар, Төв банкнаас эдийн засгийн хүндрэлээс гарах шаардлагатай арга хэмжээнүүдийг авснаас гадна Олон улсын валютын сангийн хөтөлбөрийн дагуух холбогдох ажлуудыг гүйцэтгэсний үр дүнд 2018 оноос эхлэн үнэлгээ сайжирч, тогтвортой түвшинд байна (Зураг 32). Ковид-19 цар тахлын улмаас эдийн засгийн нөхцөл байдал хүндэрсэн ч агентлаг тус бүрийн 2021 оны үнэлгээгээр манай улсын зээлжих зэрэглэлийг цар тахлын өмнөх үетэй ижил түвшинд хэвээр үлдээж, нэг агентлаг төлөвийг сайжруулаад байна. Зээлжих зэрэглэл тогтоогч агентлагуудын тооцооллоор энэ онд улсын төсөв, засгийн газрын өр, гадаад сектортой холбоотой үзүүлэлтүүд сайжирч байгаа бөгөөд ирэх саруудад эдийн засгийн сэргэлт үргэлжилнэ гэж дүгнэж байна. Тодруулбал:

Бодит эдийн засгийн өсөлт

- Нэг хүнд ногдох орлого нь бусад ижил үнэлгээтэй улсуудтай харьцуулахад сайн байгаа.
- Бодит эдийн засгийн өсөлт 2021 онд 5.0 – 6.7% -д хүрч, цаашид сэргэх төсөөлөлтэй байна.
- Дэлхийн болон БНХАУ-ын эдийн засгийн сэргэлт, эрдэс бүтээгдэхүүний үнийн өсөлт, Монгол Улсын вакцинжуулалтын түвшин, төмөр замын бүтээн байгуулалт зэрэг нь эдийн засгийн салбаруудын өсөлтөд дэмжлэг үзүүлнэ.
- Мөнгөний зөөлөн бодлого, Засгийн газраас аж ахуйн нэгжүүдийг дэмжсэн санхүүгийн арга хэмжээнүүд, зарим аж ахуйн нэгжүүдийг үе шаттайгаар нээж байгаа нь уул уурхайн бус салбаруудын идэвхжилд дэмжлэг үзүүлнэ.

- Цаашид Таван толгой, Оюу толгой болон бусад уул уурхайн төслүүд дэх гадаадын шууд хөрөнгө оруулалт тогтвортой байх төлөвтэй байна.

Улсын төсөв, ЗГ-ын гадаад өр

- Ирэх 3 жилд төсвийн алдагдлын ДНБ-д эзлэх хувь буурч, Засгийн газрын гадаадаас зээл авах хэрэгцээ 2020 онд төсөөлж байсантай харьцуулахад буурахаар байна.
- МУЗГ гадаадын хөнгөлөлттэй санхүүжилтийг амжилттай татлаа. Тухайлбал, 2020 онд 600 сая ам.долларын бондыг арилжаалснаар ойрын хугацааны гадаад өр, төлбөрийн эрсдэлээ бууруулав.
- Цар тахлын эсрэг авч хэрэгжүүлсэн арга хэмжээний зардлуудыг донор санхүүжилтүүд болон улсын төсвийн нөөц сангаас санхүүжүүлсний үр дүнд ЗГ-ын төлбөр түргэн гүйцэтгэх чадварын дарамт буурсан байна.
- МУЗГ 2022-2024 онд нийт 2.2 тэрбум ам.долларын бондын төлбөр төлөх хэдий ч ижил түвшний зээлжих зэрэглэл бүхий бусад улсуудтай харьцуулахад тийм ч өндөр дүн биш юм.
- Төсвийн алдагдал буурч, эдийн засгийн өсөлт нэмэгдсэнээр ЗГ-ын гадаад өрийн дарамт ирэх жилүүдэд аажмаар буурч, 2021 онд ДНБ-ий 70% орчимд хүрэхээр байна.

Гадаад валютын албан нөөц

- Урсгал дансны алдагдлын буурч, гадаад зээл, санхүүжилтийг амжилттай татсанаар гадаад валютын нөөцийг нэмэгдүүлээ.
- Монголбанк 2020 онд БНХАУ-ын Ардын банкттай хийсэн юанийн своп хэлцлийг амжилттай сунгаснаар валютын нөөцөд ирэх дарамтыг бууруулав.
- Гадаад валютын албан нөөц 2021 оны эцэст өсч, урсгал дансны төлбөрийн 5.6 сарын хэрэгцээг хангах, 2022-2024 оны засгийн газрын гадаад өрийн дарамтыг бууруулж чадахуйц түвшинд хүрнэ гэж төсөөлөв.

Цаашид Монгол Улсын зээлжих зэрэглэлийн үнэлгээг сайжруулах болон бууруулахад дараах хүчин зүйлс голлон нөлөөлөхөөр байна. Үүнд:

▲ САЙЖРУУЛАХ:	▼ БУУРУУЛАХ:
Улсын төсөв, ЗГ-ын өрийн удирдлага	
<ul style="list-style-type: none"> - Засгийн газрын өрийн ДНБ-д эзлэх хувь болон төсвийн алдагдлыг тогтвортойгоор бууруулах. - Засгийн газрын өр төлбөрийн дарамтыг бууруулж, төсвийн чадамжийг сайжруулах. - Улсын төсвийн санхүүжилтийн хэрэгцээ, гадаад өр төлбөрийг барагдуулахад чиглэсэн ЗГ-ын санхүүгийн менежментийг сайжруулах. 	<ul style="list-style-type: none"> - Төсвийн алдагдал болон засгийн газрын өрийн ДНБ-д эзлэх хувийг бууруулах ажлууд амжилтгүй болох.

Гадаад сектор	
<ul style="list-style-type: none"> - Гадаад өрийн тогтвортой байдлыг сайжруулах, дахин санхүүжилтэд учрах эрсдэлийг бууруулах зорилгоор гадаад өрийн удирдлагыг сайжруулах, гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх. 	<ul style="list-style-type: none"> - Гадаад валютын улсын нөөц их хэмжээгээр буурах. - Гадаад санхүүжилтийн хэрэгцээ их хэмжээгээр тэлэх. - Засгийн газрын активын хөрвөх чадварын эрсдэл нэмэгдэж, зээлийн хэрэгцээ нэмэгдэх. - Макро эдийн засгийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөхүйц гадаад санхүүжилтийн дутагдалтай байдал үүссээр байх.

Макро эдийн засаг	
<ul style="list-style-type: none"> - Эдийн засгийн өсөлт тогтвортой хадгалагдах. - Гадаадын шууд хөрөнгө оруулалтын таатай орчинг бүрдүүлэхэд чиглэж ажиллах. - Эрдэс бүтээгдэхүүний зах зээлийн мөчлөгөөс хэт хамааралтай байгаа эдийн засгаа цаашид төрөлжүүлэх талаар чиглэж ажиллах. 	<ul style="list-style-type: none"> - Стратегийн ач холбогдол бүхий уул уурхайн төслүүд, гадаадын шууд хөрөнгө оруулалтууд татрах хэмжээнд хүртэл улс төрийн тогтворгүй байдлууд үүсэх. - Уул уурхайн томоохон төслүүд зогсох гэх мэт эдийн засгийн өсөлтөд сөрөг нөлөөтэй том хэмжээний шок үүсэх.


Ерөнхийд нь дүгнэвэл цаашид улсын төсөв, засгийн газрын өр, гадаад сектор, эдийн засгийн өсөлтийн үзүүлэлтүүд нь үнэлгээний байгууллагуудын төсөөллөөс илүү хурдтайгаар сайжирсан тохиолдолд манай улсын зээлжих зэрэглэл сайжрах боломжтой. Харин эдийн засгийн сэргэлт удааширч, улсын төсвийн болон гадаад өрийн үзүүлэлтүүд муудсан тохиолдолд зээлжих зэрэглэл буурах магадлалтай.

5. МӨНГӨНИЙ ҮЗҮҮЛЭЛТҮҮД


5.1. Мөнгөний нийлүүлэлт, зээл

Мөнгөний нийлүүлэлтийн өсөлт 2020 оны 3 дугаар улирлаас үргэлжлэн нэмэгдэж, банкны системийн зээлийн өсөлт 2021 оны 1 дүгээр улирлаас сэргэж эхэллээ. Энэ оны эхний хагасын байдлаар мөнгөний нийлүүлэлт өмнөх жилийн мөн үеэс 29.8 хувиар өсөв. Өмнөх онд төсвийн алдагдлыг санхүүжүүлэхтэй холбоотой Засгийн газрын гадаад зээлийн эх үүсвэр татсан нь гадаад валютын нөөцийн хуримтлалыг нэмэгдүүлж, мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийг голчлон бүрдүүлж байсан бол 2021 оны эхний хагаст банкны системээс бизнесийн салбаруудад олгох зээлийн өсөлт сэргэж мөнгөний нийлүүлэлтийн өсөлтөд эерэг нөлөө үзүүлж эхлэв. Түүнчлэн КОВИД-19 вирусын цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан 2021 оны эхний хагаст төсвийн алдагдал тэлж, үүний дийлэнх хэсгийг дотоод банкны систем дэх хуримтлалаар санхүүжүүлж байгаа нь мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлж байна.

Зураг 33. М2 мөнгөний жилийн өсөлт, бүрэлдэхүүнээр /актив/ (улирлаар)




Зураг 34. М2 мөнгөний жилийн өсөлт, бүрэлдэхүүнээр /пассив/ (улирлаар)




Эх сурвалж: Монголбанк

Мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийг эх үүсвэр талаас төгрөгийн харилцах болон хадгаламж голчлон бүрдүүлж байна. Тодруулбал, 2021 оны 2 дугаар улирлын эцсийн байдлаар мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийн 28.7 нэгж хувийг төгрөгийн эх үүсвэр бүрдүүлэв. Ийнхүү төгрөгийн эх үүсвэрийн өсөлт эрчимжиж, гадаад валютын эх үүсвэр харьцангуй тогтвортой байгаа нөлөөгөөр банкны системийн эх үүсвэрийн долларжилтын түвшин сүүлийн 3 улирлын турш тасралтгүй буурч, 2021 оны 2 дугаар улирлын эцэст 25.4 хувьд хүрсэн нь 2020 оны 3 дугаар улирлаас 8 орчим нэгж хувиар буурсан үзүүлэлт юм. Харин зээлийн долларжилт сүүлийн улиралд 9-10 хувийн орчимд тогтвортой байна.

Зураг 35. Банкны системийн долларжилт (улирлаар)



Зураг 36. Зээлийн жилийн өсөлт, эдийн засгийн салбаруудаар (улирлаар)



Эх сурвалж: Монголбанк

Ковид-19 вирусийн тархалттай холбоотойгоор 2020 онд дотоод эдийн засгийн идэвхжил сул, зах зээл дээрх эрсдэл өндөр байсан нь банкны системийн зээлийн нийлүүлэлтийг хязгаарласан. Тухайлбал, банкны системийн зээлийн үлдэгдэл 2020 онд 900 орчим тэрбум төгрөгөөр буурч, жилийн өсөлт -5 хувьд⁴⁰ хүрсэн байна. Харин 2021 оны эхний хагаст “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-ний хэрэгжилт болон эдийн засгийн сэргэлттэй холбоотойгоор банкны системийн зээлийн өсөлт нэмэгдэж эхэллээ. Тодруулбал, банкуудын зээлийн үлдэгдэл 2021 оны 6 дугаар сарын эцэст 19 их наяд төгрөгт хүрч, өмнөх жилийн мөн үеэс 10.3 хувиар өсөв. Эдийн засгийн салбараар нь харвал үйлчилгээ, худалдаа, боловсруулах, тээвэр, агуулах болон уул уурхайн салбарын зээлийн өсөлт голлон бүрдүүлжээ. Зээлдэгчдээр нь харвал уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг улсын байгууллага, ААН болон иргэдийн худалдаа, ЖДҮ-ийн чиглэлээр авсан зээлийн өсөлт голлон нэмэгдсэн байна.

Банкны системийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл 2021 оны 6 дугаар сард 1.2 орчим их наяд төгрөгт хүрч, жилийн 18.3 хувиар өсөв. Харин чанаргүй зээлийн үлдэгдэл 1.9 орчим их наяд төгрөгт хүрсэн нь өмнөх жилийн мөн үеэс 2 хувиар нэмэгдсэн үзүүлэлт юм. Улмаар банкны системийн хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн нийлбэр дүн нийт зээлийн багцын 16.5 хувийг бүрдүүлж байгаа нь өмнөх жилийн мөн үеэс 0.4 нэгж хувиар буурав. КОВИД-19 цар тахлын онцгой нөхцөл байдал үүссэнтэй холбоотой Монголбанкнаас авч хэрэгжүүлсэн бодлогын арга хэмжээнүүд чанаргүй зээлийн өөрчлөлтөд нөлөөлж байгааг онцлох нь зүйтэй. Эдгээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээнээс дурдвал 1) хэрэглээний зээлийн эргэн төлөлт нь хүндрэлд орсон тохиолдолд зээлийн хугацааг 12 хүртэлх сараар сунгах, зээлдэгчийн зээлийн эргэн төлөх нөхцөлийг дахин өөрчлөх, 2) эргэн төлөлтийн доголдолд орсон зээлийн ангиллийг түр хугацаанд бууруулахгүй байх асуудлыг банкууд бие даан шийдвэрлэх 3) ипотекийн зээлийн эргэн төлөлтийг хойшлуулах.

⁴⁰ Тэтгэврийн зээл тэглэсэн нөлөөг хасч тооцвол -1.3 хувь байна.

Хүснэгт 15. Мөнгөний үзүүлэлтүүд, суурь төсөөлөл

Мөнгөний тойм	(өөрөөр заагаагүй бол тэрбум төгрөг)										
	2017	2018	2019	2020	2021			2022	2023		
	Q4	Q4	Q4	Q4	Q1	Q2	M07	Q3	Q4	Q4	Q4
	Гүйцэтгэл										
M2 мөнгө	15861	19475	20834	24220	25136	27719	27149	28039	29571	34127	38037
M1 мөнгө	2826	4031	3904	4197	4328	5963	5585	5768	6083	7020	7825
Банкнаас гадуурх мөнгө	612	670	614	753	739	884	851	879	927	1070	1192
Харилцах ₮	2214	3360	3290	3444	3589	5079	4734	4889	5156	5951	6633
Бараг мөнгө	13035	15444	16930	20023	20808	21757	21564	22271	23488	27106	30212
Хадгаламж ₮	8622	10156	11120	13398	14171	14974	15206	15705	16563	19115	21305
Хадгаламж \$	2532	3020	3484	4642	4375	4300	4099	4233	4465	5153	5743
Харилцах \$	1881	2268	2326	1983	2261	2483	2259	2333	2460	2839	3164
Гадаад цэвэр актив	-1252	249	1847	5356	6209	6072	5485	5102	5398	6278	7349
Төв банкны	2283	3892	5182	6273	6850	6691	6304	5545	6260	7047	7887
Арилжааны банкны	-3536	-3643	-3335	-916	-641	-619	-826	-443	-861	-769	-538
Дотоод цэвэр актив	17114	19226	18987	18864	18927	21648	21664	22937	24173	27848	30688
Дотоодын цэвэр зээл	17203	20194	18825	19333	19126	22117	22147	23391	24608	27767	30611
ЗГ-ын цэвэр зээл	-77	-771	-2488	-1524	-2238	-885	-1130	-592	468	307	-899
Төв банк	-1111	-177	-1229	-1114	-2270	-883	-1407	-521	-2256	-2300	-1888
Арилжааны банкууд	1034	-594	-1258	-411	32	277	-3	277	-71	2724	2606
ЗГ-аас авах авлага	2649	1519	1480	1690	1906	1779	1781	1711	4505	4388	2770
ЗГ-ын хадгаламж	-1615	-2112	2738	2100	1874	1781	-1503	-1781	-1781	-1781	-1781
Банк бусаас авах авлага	17280	20965	21313	20857	21364	23002	23277	23983	24140	27460	31510
Зээл+ИЗББ	16133	20060	20979	19975	20637	22062	22326	22968	23131	26446	30490
Үүнээс зээл	13615	17226	18096	17207	17636	19159	19451	19975	20191	23449	27436
Хэрэглээний зээл	3597	5572	5143	4196	4269	4254	4275	4275	4275	4489	4938
Бизнесийн зээл	10018	11653	12953	13011	13367	14905	15176	15700	15916	18960	22498
Бусад санхүүгийн байгууллагаас авах авлага	3665	3739	3381	3650	3728	4742	3826	4008	3949	4012	4075
Төв банк											
Нөөц мөнгө	3943	4908	5172	4516	3589	4237	4158	4278	6016	6805	8067
Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө	906	969	897	991	1006	1174	1121	1157	1221	1409	1570
Арилжааны банкуудын харилцах, хадгаламж	3036	3939	4275	3525	2583	3063	3038	3121	4796	5396	6497
Гадаад цэвэр актив	2283	3892	5182	6273	6850	6691	6304	5161	5871	6650	7496
Дотоод цэвэр актив	1659	1016	-10	-1757	-3262	-2454	-2146	-882	145	155	571
Меморандум үзүүлэлтүүд:											
M2 мөнгөний жилийн өөрчлөлт (%)	30.5	22.8	7.0	16.3	22.9	29.8	26.5	25.0	22.1	15.4	11.5
Нөөц мөнгөний жилийн өөрчлөлт (%)	28.6	24.5	5.4	-12.7	-19.7	-4.7	-8.4	-10.3	33.2	13.1	18.5
M2 мөнгөний үржүүлэгч (нэгжээр)	4.02	3.97	4.03	5.36	7.00	6.54	6.53	6.55	4.92	5.02	4.72
Зээл+ИЗББ жилийн өөрчлөлт (%)	10.9	24.3	4.5	-4.0	2.4	8.6	9.6	12.9	14.8	14.3	15.3
Зээлийн жилийн өөрчлөлт (%)	9.6	26.5	5.0	-4.0	2.9	10.3	12.3	15.1	17.3	16.1	17.0
Хэрэглээний зээлийн жилийн өөрчлөлт (%)	51.5	54.9	-7.7	-18.4	-4.8	-5.9	-4.5	-5.2	3.6	5.0	10.0
Бизнесийн зээлийн жилийн өөрчлөлт (%)	-0.5	16.1	11.1	1.7	5.6	16.0	16.8	22.3	21.7	19.1	18.7
Зээл/ДНБ	0.58	0.62	0.57	0.55	0.53	0.55		0.55	0.54	0.56	0.58
Мөнгөний эргэлтийн хурд	1.76	1.66	1.77	1.48	1.54	1.45		1.48	1.46	1.39	1.38
Банкуудын ТБ дахь нөөц/Нэрлэсэн ДНБ	10.9	12.2	11.6	9.6	6.7	7.6		7.5	11.1	11.4	12.4
Нэрлэсэн ДНБ /тэрбум төгрөг/	28011	32583	37839	37453	39183	40168		41419	43128	47510	52396
Нэрлэсэн ДНБ-ий жилийн өсөлт (%)	17.0	16.3	16.1	-1.0	5.0	9.0		12.6	15.2	10.2	10.3
Жилд шилжүүлсэн бодит ДНБ-ий өсөлт (%)	5.3	7.3	5.1	-5.3	-0.7	2.3		3.7	5.1	5.9	5.2

ШИГТГЭЭ 7. Эдийн засгийн сектор хоорондын хөрөнгийн урсгалын шинжилгээ

ОУВС-гаас боловсруулсан хөрөнгийн урсгалын матриц шинжилгээг ашиглан эдийн засгийн үндсэн 4 сектор буюу Засгийн газар, хувийн сектор, гадаад сектор болон санхүүгийн салбар хооронд нэг жилийн хугацаанд шилжиж буй хөрөнгийн урсгалыг макро эдийн засгийн үндсэн тэгшитгэлүүдтэй нийцтэй байдлаар тайлагнаж болдог. Уг шинжилгээний үр дүнд эдийн засгийн сектор бүрт үүссэн хөрөнгийн илүүдэл болон дутагдлыг тодорхойлж, дутагдалтай салбарууд нь алдагдлаа хөрөнгийн илүүдэлтэй бусад салбаруудын хөрөнгөөр хэрхэн санхүүжүүлж байгааг тайлбарлах боломжтой. Энэхүү аргачлалыг ашиглан Монгол Улсын сектор хоорондын хөрөнгийн урсгалын шинжилгээг 2020 оны байдлаар гүйцэтгэж, үр дүнг доор танилцуулж байна.

А. Санхүүгийн бус тэнцэл эдийн засгийн үндсэн адилтгал буюу хуримтлал, хөрөнгө оруулалтын зөрүүгээр⁴¹ тодорхойлогддог. Тэгшитгэлийн гол агуулга нь дотоод эдийн засгийн секторуудын хуримтлал нийт хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэхэд хүрэлцэхгүй нөхцөлд гадаад секторын эх үүсвэрээр дотоод хөрөнгө оруулалтын дутагдаж буй хэсгийг санхүүжүүлнэ. Энэ нь нөгөө талаас урсгал тэнцлийн алдагдал тус дүнгээр нэмэгдэхийг харуулна. Шинжилгээнд мөнгөжсөн алттай холбоотой алтны экспортын орлогод нөлөөлсөн хэсгийг засварлаж тооцдог.

Эдийн засгийн харьяатууд 2020 онд нийт 32.2 их наяд төгрөгийн цэвэр орлоготой ажилласнаас 28.4 их наяд төгрөгийг хувийн сектор, 3.4 их наяд төгрөгийг Засгийн газар татварын цэвэр орлого⁴² хэлбэрээр бүрдүүлжээ. Тайлант хугацаанд төсвийн тэнцвэржүүлсэн орлого 9.4 их наяд төгрөг, нийт зардал 14 орчим их наяд төгрөгт хүрч, төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 4.5 их наяд төгрөгийн алдагдалтай гарав. Харин хувийн сектор 21.2 их наяд төгрөгийг хэрэглээнд, 6.6 их наяд төгрөгийг хөрөнгө оруулалтад зарцуулснаар 1 их наяд орчим төгрөгийн орлогын илүүдэлтэй байв. Үүнд, 1.6 орчим их наяд төгрөгтэй тэнцэх мөнгөжсөн алтыг худалдаж экспортын орлогод бүртгэсэн нөлөөг нийт экспортын орлогоос хасч тооцов⁴³. Ийнхүү дотоод эдийн засаг дахь салбаруудын хуримтлал, хөрөнгө оруулалтын зөрүү 2020 онд цэвэр дүнгээр -3.5 их наяд төгрөгт хүрч, тус хэмжээний хөрөнгийг гадаад сектороос санхүүжүүлсэн байна. Үүний дийлэнх нь төсвийн алдагдалтай холбоотой байв.

⁴¹ $[GNDI = C + I + (X - M) + Y_f + Y_r] \Rightarrow [GNDI - C - I = CAB] \Rightarrow [S - I = CAB] \Rightarrow [(S_g - I_g) + (S_p - I_p) = CAB]$. Энд Y – Үндэсний цэвэр орлого, X – Нийт экспорт, M – Нийт импорт, Y_f – Төлбөрийн тэнцлийн анхдагч орлого, Y_r – Төлбөрийн тэнцлийн хоёрдогч орлого, $GNDI$ – Үндэсний нийт цэвэр орлого, C – Эцсийн хэрэглээ, I – Нийт хөрөнгө оруулалт, CAB – Урсгал тэнцэл, S – Дотоодын нийт хуримтлал, S_g – Засгийн газрын хуримтлал, I_g – Засгийн газрын хөрөнгө оруулалт, S_p – Хувийн секторын хуримтлал, I_p – Хувийн секторын хөрөнгө оруулалтыг илэрхийлнэ.

⁴² Төсвийн цэвэр орлого нь нийт тэнцвэржүүлсэн орлогоос зээлийн үйлчилгээний төлбөр, татаас болон бусад урсгал шилжүүлгийг хасч тооцдог.

⁴³ Төв банк дотоодоос худалдаж авсан алтыг цэвэржүүлж, гадаадын харьяатад экспортлох эсвэл мөнгөжсөн алт хэлбэрээр гадаадын банкинд байршуулдаг. Төв банк гадаадын банкинд мөнгөжсөн алт хэлбэрээр хөрөнгөө нэмэгдүүлж, гадаад валютын эх үүсвэр татсан байсан бөгөөд уг мөнгөжсөн алтыг худалдсан нь экспортод бүртгэгдсэн. Тооцооллод энэ алтны экспортын орлогын нөлөөг засварлав.

Хүснэгт 16. Эдийн засгийн секторууд хоорондын хөрөнгийн урсгалын шинжилгээний матриц, тэрбум төгрөгөөр

Гүйлгээ/Салбарууд	Дотоод эдийн засаг	Дотоод эдийн засгийн салбарууд						Гадаад сектор	ХӨНДЛӨН ШАЛГАЛТ
		Засгийн газар	Хувийн сектор	Санхүүгийн сектор	Үүнээс				
					Төв банк	Банк	БСБ (МИК+ Бусад)		
ҮНДЭСНИЙ НИЙТ ОРЛОГО	32158	3426	28733						0.0
Эцсийн хэрэглээ	26630	-5440	-21190						0.0
Нийт хөрөнгө оруулалт	9075	-2524	-6551						0.0
Экспорт	19860							-19860	
Импорт	-20650							20650	0.0
Хүчин зүйлсийн орлого	-3526							3526	0.0
Шилжүүлэг (цэвэр)	769							-769	0.0
А. САНХҮҮГИЙН БУС ТЭНЦЭЛ	-3547	-4539	992					3547	0.0
1. ГАДААД САНХҮҮЖИЛТ	6688	2662	4373	-347			-347	-6688	0.0
Хөрөнгө оруулалт	4949	-5	5067	-112			-112	-4949	0.0
ГШХО	4763		4763					-4763	0.0
Санхүүгийн ХО	-77	-5	14	-112			-112	77	0.0
Хөрөнгийн данс	289		289					-289	0.0
Гадаад цэвэр зээл	1739	2668	-693	-235			-235	-1739	0.0
Бэлэн валют, харилцах	33		33					-33	0.0
2. ДОТООД САНХҮҮЖИЛТ		1837	-4637	2800	12	2413	374		0.0
Дотоод зээл		879	-390	-489	-574	-78	164		0.0
Засгийн газрын цэвэр зээл		879	0	-879	-116	-848	85		0.0
Зээл, үнэт цаас			-390	390	-459	770	79		0.0
Нийт мөнгө			-3534	3534	-46	3580			0.0
Санхүүгийн байгууллага хоорондын хөрөнгийн урсгал					1595	-1674	79		0.0
Бусад цэвэр зүйлс		959	-713	-246	-962	585	131		0.0
3. ГЦАКТИВЫН ӨӨРЧЛӨЛТ (-)	2,571			2571	152	2419		-2,571	0.0
Гадаад актив (+)	2,125			2125	1024	1100		-2,125	0.0
Гадаад пассив (ОУВС-гийн зээл орсон) (-)	-446			-446	872	-1318		446	0.0
Б. САНХҮҮГИЙН ТЭНЦЭЛ	4117	4499	-264	-119	-140	-5	27	-4117	
В. АЛДАА БА ЗАЛРУУЛГА	-569	40	-729	118	140	5	-27	569	0
БОСОО ШАЛГАЛТ	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0

Б. Санхүүгийн тэнцлийг тооцохдоо эдийн засгийн харьяатууд болох Засгийн газар, хувийн секторын хувьд гадаад санхүүжилт болон дотоод санхүүжилтийн нийлбэрээр, харин санхүүгийн секторын хувьд гадаад санхүүжилт, гадаад цэвэр активын өөрчлөлт болон дотоод санхүүжилтийн нийлбэрээр тооцдог. Энэ нь эдийн засгийн харьяатууд гадаад зах зээлээс хэр хэмжээний эх үүсвэр татсан, тэр нь дотоод эдийн засгийн аль аль салбарт шилжсэнийг харуулдаг.

1. Гадаад санхүүжилт нь дотоод эдийн засагт үүссэн хөрөнгийн дутагдлыг санхүүжүүлэх гол эх үүсвэр юм. Дотоод эдийн засгийн салбарууд гадаад сектороос нийт 6.7 орчим их наяд төгрөгтэй тэнцэх гадаад валютын хөрөнгийн урсгалыг хүлээн авснаас дийлэнхийг буюу 4.4 орчим их наяд төгрөг хувийн секторт очжээ. Харин Засгийн газар төсвийн алдагдлыг санхүүжүүлэхээр цэвэр дүнгээр 2.7 их наяд төгрөгийг гадаад зах зээлээс татсан байна. Банкнаас бусад санхүүгийн байгууллага цэвэр дүнгээр 347 тэрбум төгрөгийн гадаад зээлийг эргэн төлөв. Нийт гадаад санхүүжилтийн дүн дотоодын санхүүгийн бус тэнцлээс өндөр (бага) байгаа нь төлбөрийн тэнцлийн ашиг (алдагдал) буюу гадаад цэвэр активын өөрчлөлттэй холбоотой. Харин төлбөрийн тэнцэл, нэгдсэн төсөв болон мөнгөний тоймын статистик хоорондын зөрүү, алдаа, орхигдуулга, валютын ханшийн зөрүү нь цэвэр алдаа ба залруулгыг тайлбарлаж байна.

Хувийн сектор гадаад зах зээлээс цэвэр дүнгээр нийт 4.4 орчим их наяд төгрөгийн эх үүсвэр татсаны дийлэнх нь ГШХО байна. Үүнийг голчлон Оюу толгой төслийн бүтээн байгуулалттай холбоотой хөрөнгө оруулалт бүрдүүлэв. Түүнчлэн хувийн сектор гадаад зээлийн төлбөрт цэвэр дүнгээр 700 орчим тэрбум төгрөг зарцуулсан байна.

Засгийн газрын гадаад цэвэр зээлийн хэмжээ өмнөх оноос 2 дахин нэмэгдэж 2.7 их наяд төгрөгт хүрчээ. КОВИД-19 цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан төсвийн тэнцвэржүүлсэн орлого 2019 оноос 13 хувиар буюу 1.4 их наяд төгрөгөөр буурав. Түүнчлэн, цар тахлын үед 2020 онд Засгийн газраас хэрэгжүүлсэн багц арга хэмжээтэй холбоотойгоор төсвийн зардал өмнөх оноос 22 хувиар тэлж 14 их наяд төгрөгт хүрэв. Улмаар төсвийн тэнцэл 4.5 их наяд төгрөг (ДНБ-ийн -12.3 хувь)-ийн алдагдалтай гарч, үүний дийлэнх хэсгийг гадаад зээлээр санхүүжүүлсэн нь голлон тайлбарлаж байна.

Банкнаас бусад санхүүгийн байгууллагууд гадаад зах зээл рүү цэвэр дүнгээр нийт 347 тэрбум төгрөгийг шилжүүлсэн байна. Уг гадагшлах урсгалын 235 тэрбум төгрөгийг гадаад цэвэр зээл, 112 тэрбум төгрөгийг гадаад үнэт цаасны төлбөрт зарцуулав. Харин **арилжааны банкууд** гадаад үнэт цаас төлж, мөн ностро дансандаа мөнгө байршуулсан нь гадагшлах урсгалыг нэмэгдүүлэв (банкуудын гадаад цэвэр актив нэмэгдэв).

2. Дотоод санхүүжилтийн хэсэгт сектор хоорондын санхүүгийн хөрөнгийн урсгалыг харуулдаг. Дотоод эдийн засагт **хувийн сектороос** цэвэр дүнгээр хөрөнгө шилжсэн бол Засгийн газар болон санхүүгийн сектор хөрөнгө хүлээн авсан байна. Тухайлбал, **хувийн секторын** дотоод хуримтлал, хөрөнгө оруулалтын зөрүү болон гадаад санхүүжилтийн дийлэнхийг дотоод эдийн засагт банкны системд байршуулж, мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлжээ. Харин **Засгийн газар** төсвийн алдагдлыг дотоодын банкны системд хуримтлуулсан эх үүсвэрээс цэвэр дүнгээр 879 тэрбум төгрөг, ирээдүйн өв сан болон тогтворжуулалтын сан, өмч хувьчлалтай холбоотой 959 тэрбум төгрөгийг дотоод зах зээлээс санхүүжүүлэв. **Банкууд** хувийн сектороос татан төвлөрүүлсэн хөрөнгийн 1.3 их наяд төгрөгөөр гадаад бонд эргүүлэн төлж, үлдсэн хэсгээс харгалзан цэвэр дүнгээр 1.67 их наяд төгрөгийг Төв банкинд, 1.1 их наяд төгрөгийг гадаадын банкны ностро дансанд тус тус байршуулсан байна. Ийнхүү КОВИД-19 вирусийн тархалттай холбоотойгоор 2020 онд дотоод эдийн засгийн идэвхжил сул, зах зээл дээрх эрсдэл өндөр байснаар банкууд активын бүтцээ удирдахдаа эрсдэл бага хөрөнгүүдэд байршуулснаар зээлийн нийлүүлэлт хязгаарлагдаж, банкны системийн зээлийн үлдэгдэл жилийн 5 хувиар буурав.

3. Санхүүгийн секторын гадаад цэвэр активын өөрчлөлт 2.6 их наяд төгрөг байгаа нь Төв банк болон арилжааны банкуудын гадаад цэвэр актив тус дүнгээр нэмэгдсэнийг илэрхийлнэ. Тухайлбал, арилжааны банкны хувьд гадаад актив 1.1 их наяд төгрөгөөр, гадаад пассив 1.3 их наяд төгрөгөөр буурч, гадаад цэвэр актив (гадаад актив – гадаад пассив) 2.4 их наяд төгрөгөөр нэмэгдэж, өөрөөр хэлбэл энэ дүнгээр гадаадад байршуулсан хөрөнгө цэвэр дүнгээр нэмэгдсэнийг харуулж байна. Банкуудын гадаад пассив 1.3 их наяд төгрөгөөр буурсан нь Худалдаа хөгжлийн банкны 500 сая ам.долларын гадаад бондын эргэн төлөлттэй холбоотой байв.


Харин Төв банкны гадаад цэвэр актив 152 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүнд, гадаад актив 1 их наяд орчим төгрөгөөр нэмэгдсэн бол гадаад пассив 872 тэрбум төгрөгөөр нэмэгджээ.

Нэгтгэн дүгнэхэд, эдийн засгийн сектор хоорондын хөрөнгийн урсгалын шинжилгээнээс дараах гол дүгнэлтүүд гарч байна. Дотоод эдийн засаг 2020 онд нийт 3.5 орчим их наяд төгрөгийн хөрөнгийн дутагдалтай байсны дийлэнх нь Засгийн газартай холбоотой байна. Энэ алдагдлыг хувийн сектор орж ирсэн ГШХО болон Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэв. Хувийн секторын хуримтлал, хөрөнгө оруулалтын зөрүү болон гадаад хөрөнгийн цэвэр урсгал эерэг байсан нь хувийн сектороос санхүүгийн сектор руу шилжих хөрөнгийн урсгалыг нэмэгдүүлэв. Харин төсвийн алдагдал огцом тэлж, дотоод санхүүжилтийн шаардлага нэмэгдсэн нь санхүүгийн сектороос Засгийн газарт шилжих хөрөнгийн урсгалыг нэмэгдүүлжээ. Арилжааны банкууд бүрдүүлсэн эх үүсвэрээсээ гадаад бондын төлбөр төлж үлдсэн хөрөнгийн дийлэнх хэсгийг Төв банкинд ТБҮЦ болон гадны банкинд харилцах, хадгаламж хэлбэрээр тус тус байршуулав. Ийнхүү 2020 онд банкуудын активын өөрчлөлтийг гадаад актив болон ТБҮЦ-ны өөрчлөлт голлон бүрдүүлж, банкны системээс эдийн засагт нийлүүлсэн зээлийн үлдэгдэл буурсан байна.

5.2. Орон сууцны ипотекийн зээлийн хөтөлбөр

Монголбанк, Засгийн газар болон банкуудын эх үүсвэрээр ипотекийн зээлийн хөтөлбөр 2013 онд хэрэгжиж эхэлснээс хойш 2021 оны эхний хагас жилийг дуустал нийт 5.6 их наяд төгрөгийн ипотекийн зээлийг (хөнгөлөлттэй хүүтэй) 97.1 мянган зээлдэгчид олгоод байна (Зураг 37).

Зураг 37. Орон сууцны ипотекийн зээлийн хөтөлбөрийн нийт санхүүжилт (жилээр, тэрбум төгрөг)




Хөтөлбөрийн хэрэгжилтийг үндсэн зорилттой нь илүүтэй нийцүүлэх, хүртээмжийг нэмэгдүүлэх, зорилтот бүлэгт түлхүү чиглүүлэх зорилгоор Монголбанкнаас “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн журам”-д холбогдох өөрчлөлтийг оруулж, орон сууцны ипотекийн зээлийн жилийн хүүг 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн шинээр олгох зээлийн хувьд жилийн 6 хувь болгон бууруулсан юм. Тус шийдвэр гарснаас хойш 7.8 мянган өрхөд нийт 564.6 тэрбум төгрөгийн зээлийг жилийн 6 хувийн хүүтэй олгосон. Ингэснээр зээлдэгчийн сарын төлбөрийн хэмжээ болон зээлийн шаардлага дахь өрхийн орлогын доод хэмжээ 20 орчим хувиар буурав.

“Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-ний хүрээнд Монголбанк болон банкуудын эх үүсвэрээр жилд нийт 700 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй хүүтэй ипотекийн зээл олгохоор ажиллаж байна. Энэ оны эхний хагас жилд 6.1 мянган зээлдэгчид нийт 447.1 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй хүүтэй ипотекийн зээлийг олгосон нь өмнөх жилийн зээл олголтын түвшинд байна.

Хөтөлбөрийн санхүүжилтийн хэмжээг 2021 онд 2 дахин нэмэгдүүлсэнээр сарын дундаж олголтын хэмжээ 75 тэрбум төгрөгт хүрч, өнгөрсөн 4 жилийн дундажтай харьцуулахад 2.3 дахин өссөн байна (Зураг 38).

Зураг 38. Орон сууцны ипотекийн зээлийн сар бүрийн олголт (тэрбум төгрөг)



Монгол Улсын нийгэм, эдийн засагт Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахал сөргөөр нөлөөлж байгаа нь нэг талаас иргэдийн санхүүд шууд дэмжлэг үзүүлэх, нөгөө талаас зээлийн чанар муудахаас сэргийлж цар тахлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.7 дахь хэсэгт заасны дагуу 2021 оны 7 дугаар сарын 01-ний өдөр хүртэл хөтөлбөрийн хүрээнд олгосон ипотекийн зээлийн төлбөрийг хоёр дахь удаагаа сунгасан. Тус арга хэмжээний хүрээнд давхардсан тоогоор 93,880 зээлдэгчийн 3.0 гаруй их наяд төгрөгийн зээлийн эргэн төлөлтийг хүү хуримтлуулж тооцохгүй нөхцөлөөр хойшлуулсан.

Цар тахлын тухай хуулийн хэрэгжилтийн хугацааг УИХ-аас 2021 оныг дуустал сунгасан бөгөөд хөтөлбөрийн зээлийн эргэн төлөлтийг хойшлуулах арга хэмжээг энэхүү шийдвэртэй уялдуулан 3 дахь удаагаа авч хэрэгжүүлж байна. Зээлдэгчид 2021 оны 7 дугаар сарыг дуустал эргэн төлөлт хойшлуулах хүсэлтийг зээл авсан буюу харилцагч банкандаа өгч, шийдвэрлүүлж байна.


5.3. Мөнгөний зах, хүүний түвшин

Мөнгөний бодлогын хүүний урт хугацааны хүүнд үзүүлэх нөлөө нь банк хоорондын зах дээрх санхүүгийн хэрэгслүүдийн хүүнээс хамаардаг. Иймд Монголбанкнаас нээлттэй захын үйл ажиллагаа, хүүний нэгдсэн бодлого болон бусад мөнгөний бодлогын арга хэрэгслүүдийн тусламжтай банк хоорондын захын жигнэсэн дундаж хүүг бодлогын хүүтэй ойролцоо түвшинд хадгалахыг зорьдог билээ.

Монголбанкны Мөнгөний бодлогын хороо 2020 онд КОВИД-19 цар тахлын улмаас эдийн засагт үүсээд буй хүндрэлийг эрсдэл багатай давах зорилгоор бодлогын хүүг шат дараатай нийт 5.0 нэгж хувиар бууруулан, 6.0 хувьд хүргээд байна. Ингэснээр банк хоорондын захын жигнэсэн дундаж хүү өмнөх оны 2 дугаар улирлаас 3.2 нэгж хувиар буурч 6.0 хувийн түвшинд хүрчээ (Зураг 39).


2020 оноос хойш банк хоорондын захын хүүний бодлогын хүүнээс хазайх абсолют хазайлт -0.05 нэгж хувь байгаа бөгөөд нийт хугацааны 75.0 хувьд хүүний хэлбэлзэл нь [-0.25;0.25] интервалд харьяалагдаж байгаа нь банк хоорондын захын хүү бодлогын хүүтэй ойролцоо түвшинд хадгалагдаж байгааг харуулж байна (Зураг 40).

Зураг 39. Банк хоорондын захын арилжааны хүү (Хувиар, 2020.II-2021.II)




Эх сурвалж: Монголбанк

Зураг 40. Банк хоорондын захын хүүний бодлогын хүүнээс хазайх хэлбэлзлийн хистограмм (Хувиар, 2020.II-2021.II)




Эх сурвалж: Монголбанк

Зураг 41. Банк хоорондын захын арилжааны хэмжээ



Зураг 42. Банк хоорондын захын арилжааны дундаж хугацаа



Эх сурвалж: Монголбанк

Банк хоорондын мөнгөний захад 2021 оны 2 дугаар улиралд нийт 1,866.4 тэрбум төгрөгийн дүн бүхий 254 хэлцэл 6.0 хувийн жигнэсэн дундаж хүүтэйгээр, 10.6 хоногийн дундаж хугацаатайгаар хийгджээ (Зураг 41, Зураг 42). Уг хэлцлийн хэмжээ нь өмнөх оны мөн үеэс 51.6 хувиар буурсан бол нэг хэлцлийн дундаж хэмжээ 7.3 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 1.4 тэрбум төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна. Энэ нь нэг талаас КОВИД-19 цар тахлын нөлөөгөөр эдийн засгийн идэвхжил буурч, тайлант хугацаанд банкуудын нөөцийн хэлбэлзэл багатай, нөгөө талаас системийн бүтцийн илүүдэл өндөр хэвээр байгаагаар тайлбарлагдаж байна.

Мөн арилжааны бүтцийг авч үзвэл банк хоорондын арилжаанд ТБҮЦ-ыг барьцаалан хийж байгаа репо хэлцэл 30.7%, ТБҮЦ-ны шууд хэлцэл 58.0%, овернайт хэлцэл 3.8%, банк хоорондын хадгаламж 7.4%-ийг тус тус эзэлж байна. Банк хоорондын шууд болон репо хэлцэл нь харилцагчийн эрсдэл багатай тул нийт арилжаанд давамгайлж байна (Хүснэгт 17).

Хүснэгт 17. Хоёрдогч захын төгрөгийн арилжаанд эзлэх хэмжээ (Хувиар)


Үзүүлэлт	2020. II	III	IV	2021. I	II
Репо (ТБҮЦ)	28.6%	21.0%	34.6%	39.9%	30.7%
Шууд (ТБҮЦ)	44.1%	67.3%	55.3%	27.3%	58.0%
Овернайт	16.1%	5.0%	2.8%	15.5%	3.8%
Банк хоорондын хадгаламж	11.2%	6.7%	7.3%	17.3%	7.4%

ШИГТГЭЭ 8. Төв банкны үнэт цаасны өсөлтийн шалтгаан

2021 оны 6 дугаар сарын эцсийн байдлаар ТБҮЦ-ны нийт үлдэгдэл 9,821.5 тэрбум төгрөгт хүрч, оны эхнээс 1,846.3 тэрбум төгрөг буюу 23.2 хувиар, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5,295.5 тэрбум төгрөг буюу 117.0 хувиар тус тус өссөн байна. Ингэснээр банкны системийн активт ТБҮЦ-ны эзлэх хувь 24.5 хувь болж оны эхнээс 3.5 нэгж хувиар, өмнөх оны мөн үеэс 12.6 нэгж хувиар тус тус өсчээ (Зураг 43).

Нийт ТБҮЦ-ны үлдэгдлийн 9,626.5 тэрбум төгрөг буюу 98 хувь нь 28 хоногтой үнэт цаасанд, 195.0 тэрбум төгрөг буюу үлдсэн 2 хувь нь 196 хоногтой үнэт цаасанд байршиж байна.

Зураг 43. ТБҮЦ-ны хэмжээ (нийт активт эзлэх хувиар, 2017.01-2021.06, сараар)



Эх сурвалж: Банкны нэгдсэн баланс


Шалтгаан 1: Эдийн засаг, санхүүгийн зах зээлийн бүтцийн онцлог

Санхүүгийн зах зээл сайтар хөгжсөн оронд бүтцийн илүүдэл нөөц нь Засгийн газрын урт хугацаатай бонд, ААА зэрэглэлтэй компанийн бондууд, хөрөнгө оруулалтын сан зэрэгт байршиж, энэ нь эргээд тухайн улсад хэрэгжиж буй томоохон төслийн санхүүжилтийг бүрдүүлэх гол эх үүсвэр болох байдлаар эдийн засгийн хөгжлийг дэмждэг. Гэтэл Монгол Улсад энэ үүргийг гүйцэтгэдэг санхүүгийн зах зээл бүрэн утгаараа хөгжөөгүй байгаагийн дээр манай улсын эдийн засаг, санхүүгийн системийн бүтцээ шалтгаалан банкны системийн нийт нөөц нь эдийн засгийн өсөлт ба хөрөнгийн дотогшлох урсгалаас хамаарч нэмэгддэг онцлогтой. 2017-2019 оны хооронд эдийн засаг дунджаар 5.9 хувиар өсч, дээрх хугацаанд төлбөрийн тэнцэл нийт 1,771.1 сая ам.долларын ашигтай гарсан нь банкны системийн нийт нөөцийн хэмжээ өсөх суурь шалтгаан болсон. Үүний үр дүнд ТБҮЦ-ны хэмжээ 2017 онд дунджаар 1.6 их наяд төгрөгийн үлдэгдэлтэй байсан бол 2018-2019 онд дунджаар 4.6 их наяд төгрөгийн үлдэгдэлтэй болж нэмэгдсэн. Цаашилбал, 2020 онд төлбөрийн тэнцэл 786.9 сая ам.долларын, 2021 оны эхний 5 сарын байдлаар 231.6 сая ам.долларын ашигтай гарч банкны системийн нөөцийг нэмэгдүүлэх чиглэлд нөлөөлжээ. Эдийн засгийн нөхцөл байдал, төлбөрийн тэнцлийн үзүүлэлтүүд нь банкны системийн тэнцлээр дамжин түүнд тусгалаа олж байдаг.

Шалтгаан 2: Банкны баланс дахь харилцах, хадгаламжийн тэлэлт

Энэ оны эхний хагас жилийн байдлаар банкуудын төгрөгийн харилцах, хадгаламж 20.0 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 43.8 хувиар, валютын харилцах, хадгаламж 6.72 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 0.97 хувиар, хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө 884.2 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 27.7 хувиар тус тус өсчээ. Үүний үр дүнд M2 мөнгө 27.7 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 29.8 хувиар өссөн байна. Ийнхүү 2020-2021 онд төгрөгийн харилцах, хадгаламж өсөхөд Ковид-19 цар тахлын үед хэрэгжүүлсэн халамж, ипотекийн зээлийн төлбөрийг хойшлуулсан, хөл хорио тогтоосноор иргэдийн худалдан авалт буурч, хадгалах хандлага нэмэгдсэн нь тус тус нөлөөлжээ.

Зураг 44. Мөнгөний нийлүүлэлт (M2), Нийт зээлийн үлдэгдэл, ТБҮЦ-ны үлдэгдэл



Эх сурвалж: Статистикийн сарын бюллетень, Монголбанк

Онолын хувьд санхүүгийн байгууллагууд зээл олгосноор мөнгөний эргэлтээр дамжин эдийн засагт шинээр харилцах, хадгаламж үүсч, мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлдэг гэж үздэг. Манай нөхцөлд 2020-2021 онд банкны систем дэх харилцах, хадгаламжийн өсөлт нь цар тахлын нөлөөнөөс үүдэлтэй дээрх хүчин зүйлээс хамаарч зээл олголтоос илүүтэйгээр өөрчлөгдсөн байна. Түүнчлэн нийт зээлийн үлдэгдэл 2020 онд 889.2 сая төгрөгөөр буурсан билээ. Ийнхүү өсөн нэмэгдэж буй харилцах, хадгаламжийн эх үүсвэрийг банкууд үр ашигтай, эрсдэл багатай актив хөрөнгөд байршуулах шаардлагатай тулгарсан юм.

Шалтгаан 3: Ковид-19 цар тахлаас үүдсэн тодорхой бус байдал, хөл хорио нь зээлийн эрэлт, нийлүүлэлтэд нөлөөлөв. Улмаар ЗГҮЦ-ны арилжаа зогссон нөхцөлд банкууд ТБҮЦ-нд эх үүсвэрээ байршуулав.

Сүүлийн жил гаруй хугацаанд Ковид-19 цар тахлын нөлөөгөөр хөл хорио тогтоосноос шалтгаалан зээлийн эрэлт буурав. Нөгөө талаас банкууд тодорхой бус байдал давамгайлсан нөхцөлд шинээр зээл олгохоос “болгоомжилж”, эх үүсвэрийн өсөлтийг эрсдэлгүй хөрөнгөд байршуулахыг эрмэлзэж байснаас зээлийн нийлүүлэлт буурахад хүрсэн. Засгийн газрын үнэт цаасны арилжаа зогссон тухайн нөхцөлд банкуудын ТБҮЦ худалдаж авах үйл ажиллагаа нэмэгдсэн бөгөөд 2021 оны 6 дугаар сарын эцэст банкны системийн нийт активт эзлэх дотоодын зээл 48.9 хувьд хүрч, 2020 оны эхнээс 2.5 хувиар буурсан бол ТБҮЦ болон ЗГҮЦ-ны эзлэх хувь 27.1 хувьд хүрч 10.9 нэгж хувиар өссөн байна.

Хүснэгт 18. Банкуудын пассивын өөрчлөлт, тэрбум төгрөгөөр

	Нийт пассив	Харилцах, хадгаламж	Гадаад пассив	Бусад
2020/01/01	32,828.7	18,805.8	5,380.6	8,642.3
2021/06/30	36,905.3	25,877.0	3,916.6	7,111.6
Өөрчлөлт	4,076.6	7,071.3	-1,464.0	-1,530.6

Хүснэгт 19. Банкуудын активын өөрчлөлт, тэрбум төгрөгөөр


	Нийт актив	Дотоодын зээл	ЗГҮЦ+ТБҮЦ	Бусад
2020/01/01	35,859.3	18,439.2	5,825.6	11,594.6
2021/06/30	40,076.7	19,615.0	10,848.6	9,613.1
Өөрчлөлт	4,217.3	1,175.8	5,023.1	-1,981.5

Эх сурвалж: Банкны нэгдсэн баланс


5.4. Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш

Энэ оны I улиралд төгрөгийн ам.доллартой харьцах ханш өмнөх улирлаас 0.0028 хувиар, II улиралд өмнөх улирлаас 0.0330 хувиар тус тус чангарч, 2021 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар 2848.87 төгрөгт хүрч, оны эхнээс 0.036 хувиар чангарсан байна. Ингэхдээ, 2021 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар төгрөгийн ам.доллартой харьцах ханш нэг өдөрт хамгийн ихдээ 0.0284 хувиар чангарч, 0.0235 хувиар суларч, өдрийн дундаж хэлбэлзэл 0.0076% байсан нь 2020 оны мөн үетэй харьцуулахад 0.0248 нэгжээр буурсан байна.

Зураг 45. Төгрөгийн ам.доллартой харьцах албан ханшийн өдрийн хэлбэлзэл



Зураг 46. Төгрөгийн ам.доллартой харьцах албан ханшийн өөрчлөлт



Эх сурвалж: Монголбанк

Ковид-19 цар тахлын эсрэг вакцинжуулалт хурдацтай хийгдэж, томоохон эдийн засгууд сэргэснээр гадаад эрэлт нэмэгдэж, Монгол Улсын экспортын голлох түүхий эдийн үнэд эерэгээр нөлөөлж байна. Тухайлбал, 2020 оны эхэнд 1 тонн зэсийн үнэ 6188.0 ам.доллар байсан бол 2020 оны 5 дугаар сараас хойш тасралтгүй өссөөр 2021 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар 9,374.5 ам.долларт хүрч 51.5 хувиар өссөн. Харин нүүрсний үнэ 2020 оны эхэнд тонн тутамд 67.5 ам.доллар байсан бол 2021 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар 134.7 ам.доллар болж 99.6 хувиар өсөөд байна. Мөн төмрийн хүдэр болон алтны үнэ харгалзан 214.55 ам.доллар, 1,770.11 ам.долларт хүрч 2020 оны эхэнтэй харьцуулахад 131.7 хувь, 16.7 хувиар тус тус өсөөд байна.

Мөн үнийн өсөлтөөс хамааран экспортын хэмжээ өмнөх оны мөн үеэс 45 хувиар сайжирсан бөгөөд 2021 оны эхний 6 сарын байдлаар зэсийн баяжмал, нүүрс, төмрийн хүдэр зэрэг экспортын гол бүтээгдэхүүний орлого өмнөх оноос өсөж, гадаад худалдааны тэнцэл 850.0 сая ам.долларын ашигтай гарлаа. Ийнхүү түүхий эдийн үнэ болон экспортын хэмжээний өсөлт нь төлбөрийн тэнцэлд эерэгээр нөлөөлж байна.

Монгол Улсын төлбөрийн тэнцэл 2020 оны 4 дүгээр улиралд 1,259 сая ам.долларын ашигтай байсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1,071 сая ам.доллароор сайжирсан үзүүлэлт болсон. Улмаар жилийн дүнгээр төлбөрийн тэнцэл 2020 онд 787 сая ам.долларын ашигтай гарлаа. Харин 2021 оны 5 дугаар сарын байдлаар төлбөрийн тэнцэл 232 сая ам.долларын ашигтай гарсан бөгөөд 2021 оны эцэст төлбөрийн тэнцэл 580 орчим сая ам.долларын ашигтай гарах төсөөлөлтэй байна.

Түүнчлэн Засгийн газар өрийн удирдлагын стратегийн хүрээнд 1 тэрбум ам.долларын бондыг 3.5 болон 4.4 хувь буюу харьцангуй бага хүүтэйгээр олон улсын зах зээлд шинээр арилжаалж, 2022 онд төлөгдөх 799 сая ам.долларын үлдэгдэл бүхий “ЧИНГИС” бонд, 2023 онд төлөгдөх 800

сая ам.долларын “ГЭРЭГЭ” бондуудыг хэсэгчлэн дахин санхүүжүүлж, 2022-2023 онд Монгол Улсаас гарахаар хүлээгдэж байсан валютын урсгалыг 1.0 тэрбум ам.доллараар бууруулсан. Энэ нь Монгол Улсын богино хугацааны өрийн дарамтыг бууруулж, гадаад валютын дотоодын захад эерэгээр нөлөөлөхөөс гадна, олон улсын үнэлгээний байгууллагууд болон хөрөнгө оруулагчид эерэг хүлээлттэй байгааг харуулж байна.

Гадаад валютын албан нөөц 2021 оны 6 дугаар сарын байдлаар 4.7 тэрбум ам.долларт хүрч, импортын 11 сарын хэрэгцээг хангах түвшинд хүрсэн. Ийнхүү төлбөрийн тэнцэл ашигтай байгаа нь гадаад валютын албан нөөц нэмэгдэхэд (Монголбанкны үнэт металл худадан авалт сайжирсан) эерэгээр нөлөөлж байна. Монголбанк сүүлийн 5 жилд нийт 100.0 гаруй тонн үнэт металл худалдан авсан бөгөөд 2020 онд түүхэн дээд хэмжээнд буюу 23.6 тонн үнэт металл худалдан авсан. Харин 2021 оны 6 дугаар сарын байдлаар нийт 9.3 тонн үнэт металл худалдан аваад байна. Ингэснээр гадаад валютын албан нөөц нэмэгдэж улмаар олон нийтийн төгрөгт итгэх итгэлийг бэхжүүлэх, Монгол Улсын зээлжих зэрэглэлд эерэгээр нөлөөлөх болон эдийн засгийн дархлааг нэмэгдүүлэхэд өндөр ач холбогдолтой юм.


Монголбанкнаас төгрөгийн гадаад валюттай харьцах ханш нь эдийн засгийн суурь нөхцөлд нийцтэй, уян хатан тогтох зарчмыг баримталж ажилладаг бөгөөд богино хугацааны төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн огцом хэлбэлзлийг бууруулах зорилгоор валютын захад шаардлагатай үед тухай бүр оролцон ажилладаг. Тус зорилгынхоо хүрээнд Монголбанк 2021 оны эхний 6 сарын байдлаар төрийн болон төрийн өмч давамгайлсан ААНБ-уудаас 1,303.8 сая ам.долларыг худалдан авсан. Гадаад валютын дуудлага худалдааг 51 удаа зохион байгуулж, нийт дүнгээр 1,144.1 сая ам.долларыг дотоодын валютын захад нийлүүлсэн. Дээрх хугацаанд Монголбанк цэвэр дүнгээр 159.7 сая ам.долларыг гадаад валютын дотоодын захаас татсан байна.

6. ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ, ГАДААД ЗАХ ЗЭЭЛ


6.1. Төлбөрийн тэнцэл

2021 оны эхний 6 сарын урьдчилсан гүйцэтгэлээр төлбөрийн тэнцлийн санхүүгийн дансны ашиг өнгөрсөн оны мөн үеэс 83 хувиар нэмэгдэж 768.6 сая ам.долларт, урсгал ба хөрөнгийн дансны алдагдал 5 хувиар нэмэгдэж 871.3 сая ам.долларт тус тус хүрснээр, нийт тэнцлийн алдагдал өмнөх оноос 625.0 сая ам.доллараар буурч 54.2 сая ам.долларт хүрчээ.

Зураг 47. Төлбөрийн тэнцэл (улирлаар)



Зураг 48. Урсгал ба хөрөнгийн тэнцэл (улирлаар)




Эх сурвалж: Монголбанк

Урсгал ба хөрөнгийн данс

Урсгал ба хөрөнгийн дансны алдагдал 2021 оны эхний 6 сард өнгөрсөн оны мөн үеэс 39.8 сая ам.доллароор өссөн байна. Үүнд анхдагч орлогын дансны алдагдал 112 хувиар буюу 499.8 сая ам.доллароор нэмэгдсэн нь өсөх чиглэлд, бараа үйлчилгээний дансны алдагдал 81 хувиар буюу 460.5 саяаар багассан нь буурах чиглэлд нөлөө үзүүлэв.

Дотоодын эдийн засгийн сэргэлт, уул уурхайн бүтээн байгуулалтууд болон импортын өсөлтөөс шалтгаалж урсгал дансны алдагдал 2012 онд ДНБ-ий 44 хувьд хүрч байв. 2014 оноос барааны гадаад худалдаа ашигтай гарч эхэлснээр алдагдал буурч 2014 онд ДНБ-ий 16 хувь, 2015 онд 8 хувь, 2016 онд 6 хувь хүрч буурчээ. Харин 2018 онд импортын өсөлттэй холбоотой барааны дансны ашиг буурснаас шалтгаалан уг алдагдал 34 хувьд хүрч өссөн бол, 2021 оны 1 дүгээр улирлын байдлаар 13 хувь байна.

Зураг 49. Урсгал тэнцэл/Нэрлэсэн ДНБ




Гадаад худалдаа тэлж байна. 2021 оны эхний 6 сарын гүйцэтгэлээр гадаад худалдааны тэнцлийн ашиг өнгөрсөн оны мөн үеэс 482.2 сая ам.доллароор өсч 850.2 сая ам.долларт хүрчээ. Улмаар гадаад худалдааны нийт бараа эргэлт өмнөх оны мөн үеэс 39 хувиар буюу 2,084.1 сая ам.доллароор өсч 7,372.4 сая ам.долларт хүрэв. Үүнд экспорт 45 хувиар буюу 1,283.1 сая ам.доллароор, импорт 33 хувиар буюу 800.9 сая ам.доллароор тус тус өссөн үзүүлэлттэй байна.


Манай улсын зэс, төмрийн хүдрийн экспортын биет хэмжээ цар тахлын улмаас үүссэн хөл хорионы дэглэмээс шалтгаалж өмнөх оны мөн үеэс буурсан ч үнийн өсөлтийн нөлөөгөөр экспортын орлого өссөн байна. Тодруулбал, зэс болон төмрийн хүдрийн дэлхийн зах зээл дээрх үнэ сэргэсэнээр хилийн дундаж үнэ өмнөх оны мөн үеэс 61 хувь, 108 хувиар өссөн нөлөөгөөр зэсийн экспортын орлого 571.8 сая ам.доллар, төмрийн хүдрийн экспортын орлого 267.6 сая ам.доллароор нэмэгдэв.

Импорт өмнөх оны мөн үеэс 800.9 сая ам.доллар буюу 33%-аар өсөхөд хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импорт хамгийн их өссөлттэй буюу 392.1 сая ам.доллароор, хэрэглээний бүтээгдэхүүний импорт 279.5 сая ам.доллароор, нефтийн бүтээгдэхүүний импорт 65.9 сая ам.доллароор, аж үйлдвэрлэлийн орц 58.6 сая ам.доллараар тус тус өссөн нь нөлөөлсөн. Хэрэглээний бүтээгдэхүүний хувьд хамгийн өндөр өсөлттэй нь эм, тарианы импорт 149%-аар буюу 78.8 сая ам.доллароор өссөн байна.

Зураг 50. Барааны гадаад худалдаа



Зураг 51. Үйлчилгээний гадаад худалдаа




Эх сурвалж: Монголбанк

Үйлчилгээний дансны алдагдал буурав. Үйлчилгээний дансны алдагдал 2021 оны эхний хагас жилийн урьдчилсан гүйцэтгэлээр өмнөх оны мөн үеэс 242.7 сая ам.доллараар буурч 467.6 сая ам.долларт хүрсэн байна. Үүнд тээврийн үйлчилгээний болон бизнесийн бусад үйлчилгээний дансны алдагдал буурсан нь голлон нөлөөлөв.


Анхдагч орлогын дансны алдагдал өсөв. Анхдагч орлогын дансны алдагдлын хэмжээ өмнөх оны мөн үеэс 499.8 сая ам.доллараар өсч, 945.6 сая ам.долларт хүрэхэд хөрөнгө оруулалтын зарлагын өсөлт голлон нөлөөлжээ.

Санхүүгийн данс

Зураг 52. Санхүүгийн данс



Зураг 53. Гадаад валютын албан нөөц



Эх сурвалж: Монголбанк

Санхүүгийн дансны ашиг 2021 оны эхний хагас жилийн урьдчилсан гүйцэтгэлээр өмнөх оны мөн үеэс 83 хувиар өсч, 768.6 сая ам.долларт хүрчээ. Үүнд шууд хөрөнгө оруулалтын ашиг өмнөх оны мөн үеэс 65.7 сая ам.доллараар өсч, багцын хөрөнгө оруулалтын дансны алдагдал 395.5 сая ам.доллараар буурсан нь голлох нөлөөг үзүүлсэн байна.

Гадаад валютын албан нөөц. 2021 оны эхний хагас жил нийт төлбөрийн тэнцэл алдагдалтай гарсан ч алтны мөнгөжүүлэлт өндөр байснаар гадаад валютын албан нөөц 6 дугаар сарын эцэст 4,731.8 сая ам.долларт хүрэв. Энэ нь сүүлийн гурван сарын дунджаар тооцсон валютын төлбөртэй импортын барааны 8.6 сарын хэрэгцээг хангах түвшин юм.

ШИГТГЭЭ 9. Төлбөрийн тэнцлийн хөрөнгийн урсгалын шинжилгээ: Цар тахлын үеийн нөхцөл байдал


КОВИД-19 цар тахал дэгдсэнээр 2020 оны эхэн үед эрчимтэй хөгжиж буй орнууд болон зарим хөгжингүй орнуудад хөрөнгийн урсгал гэнэт, том хэмжээгээр гадагшлах үзэгдэл бий болж байлаа. Харин 2020 оны сүүлийн хагаст хөгжингүй орнууд мөнгөний зөөлөн бодлого хэрэгжүүлж, бодлогын хүү буурч, үүнтэй холбоотойгоор хөрөнгө оруулагчид илүү өгөөжийг хайн хөгжиж буй болон эрчимтэй хөгжиж буй эдийн засгууд руу чиглэх хөрөнгийн урсгал эргэн сэргэсэн байна¹².

Хөгжингүй орнуудаас хөгжиж буй болон эрчимтэй хөгжиж буй орнуудыг чиглэх хөрөнгийн урсгалын давалгаанд манай эдийн засагт хөрөнгийн дотогшлох урсгал бий болсон эсэх, эсвэл цар тахлаас үүдэлтэй эдийн засгийн хүндрэлээс шалтгаалан хөрөнгийн урсгал гадагшлах үзэгдэл ажиглагдсан эсэхийг Монгол Улсын төлбөрийн тэнцлийн статистик, гадаад гүйлгээний тайлан болон банкуудын нэгдсэн балансын 2020 он, 2021 оны эхний хагасын тоон мэдээллээр шинжиллээ. Хөрөнгийн урсгалын шинжилгээний үр дүнгүүдийг тоймлон дурдвал:

- Цар тахлын үед Монгол Улсад орж ирсэн Оюу толгойгоос бусад ААН-ийн гадаад шууд хөрөнгө оруулалт өмнөх жилүүдээс буурсан дүр зурагтай байна. Монгол Улсад орсон ГШХО-ын нийт орох урсгал 2020 онд 18.2 хувиар, 2021 оны эхний хагаст 7.5 хувиар буурчээ. Үүнд Оюу толгойгоос бусад ААН-ийн ГШХО орох урсгал 2020 онд жилийн 36 хувиар, 2021 оны эхний хагаст жилийн 39 хувиар буурчээ (Зураг 54).
- Багцын хөрөнгө оруулалтын хувьд банкны сектор 2020 онд томоохон бондын эргэн төлөлт хийснээс бусдаар гарах урсгал нэмэгдээгүй байна (Зураг 53).
- ЗГ-ын гадаад зээлийн ашиглалт 2020 онд нэмэгдэн, гадаад зээлийн орох урсгал өндөр байсан бол 2021 оны эхний хагаст гадаад зээлийн орох урсгал багассан дүр зурагтай байна (Зураг 55).
- Эдийн засгийн харьяатын бэлэн мөнгө ба харилцах данс 2020 оны эхний 3 улиралд гарах урсгал өндөр байсан бол 2020 оны 4-р улирал, 2021 оны 1-р улиралд орох урсгал нэмэгдэж, 2-р улиралд гарах урсгал эргээд тэлжээ.
- Хөрөнгийн урсгалын хэлбэлзэл¹³-ийг шинжлэхэд цар тахлын үед хөрөнгийн гарах урсгал нэмэгдэж, 1 стандарт хазайлтын утгаас доош түвшинд орсон боловч 2 стандарт хазайлтын түвшинд арай хүрээгүй байна (Зураг 56). Өөрөөр хэлбэл, уг хэлбэлзэл нь манай эдийн засагт хөрөнгийн урсгал татарч байгааг дохиолж, цаашид хөрөнгийн гэнэтийн, том гарах урсгал бий болж болзошгүйг анхааруулж байсан бол 2021 оны 2-р улирлаас хөрөнгийн урсгал эргээд сэргэх хандлагатай байна.
- Банкны систем дэх харьяат бусын харилцах, хадгаламж, гадаадын банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламжийн дүн харьцангуй тогтвортой байна (Зураг 57).
- Банкуудын гадаад гүйлгээний орох, гарах урсгалын зөрүү буюу хөрөнгийн цэвэр урсгал 2020 оны эхний 8 сард сөрөг байсан бол 2020 оны 9-р сараас хойш хөрөнгийн урсгал эерэг, 2021 оны 5-р сараас эргээд сөрөг болсон байна.


Ийнхүү Монгол Улсын хувьд хөрөнгийн урсгалыг шинжилж үзэхэд 2020-2021 онд хөрөнгийн урсгал бага зэрэг татарсан ч гэнэтийн, том хэлбэлзэл ажиглагдаагүй байна. Энэ нь манай хөрөнгийн захын хөгжил сул, санхүүгийн зах зээлтэй холбогдсон багцын хөрөнгө оруулалт бага тул гадаад зах зээлээс хамаарсан хөрөнгийн урсгалын аливаа шокын нөлөө сул байж болзошгүй юм. Төлбөрийн тэнцлийн санхүүгийн дансны хувьд ГШХО, багцын хөрөнгө оруулалт болон зээлийн дансуудад өндөр дүнтэй харьцангуй цөөн хэлцэл, валютын урсгалууд хүчтэй нөлөөлдөг бөгөөд цар тахлын үед Оюу толгойн бус ГШХО буурснаас бусдаар нийт төлбөрийн тэнцэл, Монголын эдийн засагт нөлөөлөхүйц томоохон хөрөнгийн урсгалын хэлбэлзэл үүсээгүй байна.

Зураг 54. Гадаад шууд хөрөнгө оруулалтын орох урсгал




Эх сурвалж: Төлбөрийн тэнцэл, Оюу толгой ХК-ны мэдээ

Зураг 55. Багцын хөрөнгө оруулалт дахь өрийн бичгийн урсгал




Эх сурвалж: Төлбөрийн тэнцлийн статистик

Зураг 56. Гадаад зээлийн орох, гарах урсгал



Эх сурвалж: Төлбөрийн тэнцлийн статистик

Зураг 57. Хөрөнгийн урсгалын хэлбэлзлийн шинжилгээ



Эх сурвалж: Баярдаваа & Дуламзаяа (2021)

Зураг 58. Эдийн засгийн харьяат бусын Монголын банкууд дахь харилцах, хадгаламж



Эх сурвалж: Банкуудын нэгдсэн баланс

Зураг 59. Банкуудын гадаад валютын орох, гарах урсгал



Эх сурвалж: Гадаад гүйлгээний тайлан

6.2. Хөрөнгө оруулалтын позиц


Монгол Улсын гадаад хөрөнгө оруулалтын цэвэр позиц 2021 оны 1 дүгээр улирлын байдлаар -37.4 тэрбум ам.доллар байна. Өөрөөр хэлбэл, Монгол Улсын гадаадаас татсан хөрөнгө оруулалт гадаадад хийсэн хөрөнгө оруулалтын хэмжээнээс 37.4 тэрбум ам.доллаароор их байна.

Гадаад актив. Монгол Улсаас эдийн засгийн харьяат буст оруулсан хөрөнгө оруулалтын дүн 2021 оны 1 дүгээр улирлын байдлаар 8.3 тэрбум ам.доллар байна. Энэ нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 16 хувиар буюу 1.1 тэрбум ам.доллаароор өссөн үзүүлэлт бөгөөд үүнд нөөц болон шууд хөрөнгө оруулалтын дансны активын өсөлт голлох нөлөөг үзүүлжээ. Нийт гадаад активын 58 хувийг гадаад валютын албан нөөц, 29 хувийг бусад хөрөнгө оруулалт, 9 хувийг шууд хөрөнгө оруулалт, үлдсэн 4 хувийг багцын хөрөнгө оруулалтын активууд тус тус бүрдүүлж байна.


Хүснэгт 20. Монгол Улсын гадаад хөрөнгө оруулалтын позиц, 2021 оны 1-р улирал (тэрбум ам.доллар)

А. ГАДААД АКТИВ		8.3	Б. ГАДААД ПАССИВ		45.7
1. Шууд хөрөнгө оруулалт (гадаад руу)	0.7		6. Шууд хөрөнгө оруулалт (гадаадаас)	24.8	
1.1 Хувь нийлүүлсэн хөрөнгө оруулалт	0.6		6.1 Хувь нийлүүлсэн хөрөнгө оруулалт	13.1	
1.2 Бусад хөрөнгө	0.1		6.2 Бусад хөрөнгө	11.8	
	0.0				
2. Багцын хөрөнгө оруулалт	0.4		7. Багцын хөрөнгө оруулалт	4.7	
2.1 Хөрөнгийн хувьцаа	0.3		7.1 Хөрөнгийн хувьцаа	0.1	
2.2 Өрийн бичиг	0.0		7.2 Өрийн бичиг	4.6	
3. Санхүүгийн дериватив	0.0		8. Санхүүгийн дериватив	0.0	
4. Бусад хөрөнгө оруулалт	2.4		9. Бусад хөрөнгө оруулалт	16.1	
4.1 Худалдааны зээл	0.6		9.1 Худалдааны зээл	0.3	
4.2 Зээл	0.2		9.2 Зээл	13.6	
4.2.1 Төв банк	0.0		9.2.1 Төв банк	0.4	
4.2.2 Засгийн газар	0.2		9.2.2 Засгийн газар	1.2	
4.2.3 Банк санхүүгийн байгууллага	0.0		9.2.3 Банк санхүүгийн байгууллага	5.6	
4.2.4 Аж ахуйн нэгж	0.0		9.2.4 Аж ахуйн нэгж	6.4	
4.3 Бэлэн мөнгө ба харилцах	1.7		9.3 Бэлэн мөнгө ба харилцах	2.2	
4.4 Бусад актив	0.0		9.4 Бусад пассив	0.0	
5. Нөөц актив	4.8		В. ПОЗИЦ	(37.4)	
5.1 Мөнгөжсөн алт	0.6		10. Шууд хөрөнгө оруулалт (цэвэр)	(24.1)	
5.2 Зээлжих тусгай эрх	0.0		11. Багцын хөрөнгө оруулалт (цэвэр)	(4.3)	
5.3 ОУВС-д байршуулсан хөрөнгө (цэвэр)	0.0		12. Санхүүгийн дериватив (цэвэр)	0.0	
5.4 Бэлэн валют ба харилцах	3.3		13. Бусад хөрөнгө оруулалт (цэвэр)	(13.7)	
5.5 Үнэт цаас	0.9		14. Нөөц актив	4.8	
5.6 Санхүүгийн дериватив (цэвэр)	0.0				
5.7 Бусад нөөц актив	0.0				

Зураг 60. Гадаад актив (улирлаар)



Зураг 61. Гадаад пассив (улирлаар)



Гадаад пассив. Монгол Улсын эдийн засгийн харьяатад гадаадаас оруулсан хөрөнгө оруулалтын дүн 45.7 тэрбум ам.долларт хүрчээ. Энэ нь өнгөрсөн мөн үеэс 7 хувиар буюу 2.8 тэрбум ам.доллараар өссөн үзүүлэлт ба үүнд шууд болон бусад хөрөнгө оруулалтын өсөлт голлох нөлөөг үзүүлсэн байна. Нийт гадаад пассивын 54 хувийг гадаадын шууд хөрөнгө оруулалт, 35 хувийг бусад хөрөнгө оруулалт, үлдсэн 10 хувийг багцын хөрөнгө оруулалтын пассив тус тус бүрдүүлж байна. Монгол Улс дахь гадаадын шууд хөрөнгө оруулалтын 53 хувь буюу 13.1 тэрбум ам.долларыг хувь нийлүүлэгчийн дүрмийн сан дахь хөрөнгө оруулалт, 47 хувь буюу 11.8 тэрбум ам.долларыг толгой компаниас авсан зээлийн эх үүсвэрийн үлдэгдэл байна.

ШИГТГЭЭ 10. Монгол Улсын гадаад валютын урсгалын тойм, 2021-2022 он

2021 оны 9 дүгээр сарын төсөөллөөр Монгол Улсын төлбөрийн тэнцэл 2021 онд 370 сая ам.долларын алдагдалтай, 2022 онд 260 сая ам.долларын ашигтай байх тооцоолтой бөгөөд гадаад валютын орох, гарах томоохон урсгалуудаар тоймлон харахад **нийт орох урсгал нь 2021 онд 12.8 тэрбум ам.доллар, 2022 онд 13.7 тэрбум ам.доллар, нийт гарах урсгал нь 2021 онд 13.2 тэрбум ам.доллар, 2022 онд 13.7 тэрбум ам.доллар** байхаар байна¹.

Гадаад валютын нийт орох урсгал 2021 онд өмнөх жилээс 0.5 тэрбум ам.доллараар өсөхөөр байна. Валютын орох урсгал нь: 1) экспортын орлого 7.6 тэрбум ам.доллар, 2) үйлчилгээний орлого 0.7 тэрбум ам.доллар, 3) ГШХО 1.3 тэрбум ам.доллар, 4) гадаад бонд 1.3 тэрбум ам.доллар, 5) гадаад зээл 1.6 тэрбум ам.доллар гэсэн голлох сувгуудаар тэтгэгдэж байна.

Дэлхийн эдийн засаг сэргэж, түүхий эдийн эрэлт, үнэ өссөн эерэг нөлөөгөөр **экспортын орлого** 2021 оны эхний хагаст өмнөх оны мөн үеэс 1.0 тэрбум ам.доллараар өссөн бөгөөд жилийн дүнгээр харвал **2021 онд өмнөх оноос 657 сая ам.доллараар өсөх төсөөлөлтэй** байна. Экспортын өсөлтийг түүхий эдийн үнийн өсөлт голлон тайлбарлаж байна. Тухайлбал, үнэ өссөн, баяжмал дахь алтны агууламж нэмэгдсэн нөлөөгөөр эсийн баяжмалын экспортын орлого 942 сая ам.доллараар, төмрийн хүдрийн орлого 208 сая ам.доллараар, боловсруулаагүй нефтийн экспортын орлого 204 сая ам.доллараар, хэдийгээр биет хэмжээ буурсан ч үнэ өссөн нөлөөгөөр нүүрсний экспортын орлого өмнөх оноос 14 сая ам.доллараар тус тус өсөхөөр байна. Харин алтны экспортын биет хэмжээ буурах нөлөөгөөр алтны экспортын орлого өмнөх оноос 1.2 тэрбум ам.доллараар буурах хүлээлттэй байна.

Цар тахлын улмаас агшсан **үйлчилгээний орлого энэ онд төдийлөн сэргэхээргүй**, өмнөх оны түвшинд байхаар байна. Оюу Толгойн далд уурхайн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөтэй уялдан **ГШХО өмнөх оноос 91 сая ам.доллараар** буурахаар байна. Өмнөх онд МУЗГ 600 сая ам.долларын Номад бондыг гадаад зах дээр шинээр арилжаалсан бол энэ онд хувийн сектор 250 сая ам.долларын бондыг гадаад зах зээл дээрээс босгож, МУЗГ Century төслийн хүрээнд 1.0 тэрбум ам.долларын бондыг босгож, Чингис, Гэрэгэ бондуудыг дахин санхүүжүүлснээр гадаад бондын орох урсгал өмнөх оноос 576 сая ам.доллараар өсөхөөр байна. Засгийн газрын гадаад санхүүжилтийн хэрэгцээ буурч, **гадаад зээлийн ашиглалт 600 сая ам.доллараар буурах** хүлээлттэй байна.

Гадаад валютын нийт гарах урсгал 2021 онд өмнөх жилээс 1.9 тэрбум орчим ам.доллараар өсөхөөр байна. Гадаад валютын гарах урсгал нь (i) импортын төлбөр 7.0 тэрбум ам.доллар, (ii) үйлчилгээний зардал 2.1 тэрбум ам.доллар, (iii) гадаад зээл, бондуудын үндсэн болон хүүгийн төлбөр 3.6 тэрбум ам.доллар, (iv) гадаадын хөрөнгө оруулалттай ААН-ийн хөрөнгө оруулалтын ногдол ашгийн төлбөр 0.3 тэрбум ам.доллар гэсэн гол 4 хэсгээс бүрдэж байна.

Хүснэгт 21. Монгол Улсын гадаад валютын урсгалын тойм /тэрбум ам.доллар/

	2019	2020	2021	2022		2019	2020	2021	2022
	он	он	төсөөлөл			он	он	төсөөлөл	
Орох урсгал	сая \$	сая \$	сая \$	сая \$	Гарах урсгал	сая \$	сая \$	сая \$	сая \$
Экспорт	7183	6,991	7,648	8,517	Импорт	-6025	-5235	-6970	-7676
Чулуун нүүрс	2915	1904	1,918	3,066	Хэрэглээ	-1631	-1549	-1987	-2123
Зэсийн баяжмал	1905	1840	2,782	2,279	Хөр.Ор.бүт.	-2565	-2267	-3123	-3296
Алт	418	1788	570	926	Нефтийн бүт.	-1166	-817	-1130	-1368
Газрын тос	367	151	355	401	Бусад	-663	-603	-731	-890
Үйлчилгээ	1233	655	688	1,042	Үйлчилгээ	-3224	-2105	-2099	-2883
Тээврийн	389	384	439	535	Тээврийн	-983	-596	-592	-932
Аялал	513	29	17	255	Аялал	-525	-184	-274	-481
Бусад үйлч.	330	242	232	252	Боловсрол	-400	-366	-380	-400
					Бусад үйлч.	-1316	-959	-852	-1070
Ажилчдын цалин	196	259	259	233	Зээл, бондын хүүгийн төлбөр	-814	-884	-894	-867
ГНХО	2077	1399	1,308	2,053	Бондуудын үндсэн төлбөр	-681	-1298	-1330	-290
Гадаад бондууд	743	600	1,288	-	ХО-ийн зээлийн төлбөр	-226	-144	-119	-166
Гадаад зээлийн ашиглалт	1871	2287	1,570	1,870	Ногдол ашгийн	-214	-186	-274	-306
Төв банк	0	107	0	0	Гадаад зээлийн төлбөр	-1703	-1620	-1255	-1248
Засгийн газар	621	1199	590	954	Засгийн газар	-146	-244	-285	-284
Банкууд	573	470	429	341	Банкууд	-689	-556	-328	-340
ААН, МУХБ	677	512	552	575	ААН, МУХБ	-868	-805	-506	-619
НИЙТ ОРОХ	13303	12190	12,761	13,725	НИЙТ ГАРАХ	-12887	-11307	-13205	-13665

Эх сурвалж: МУ-ын Төлбөрийн тэнцлийн статистикт суурилсан тооцоолол

Импортын төлбөр 2021 онд өмнөх оноос 1.7 тэрбум ам.доллаароор өсөхөөр байгаа нь хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн, хэрэглээний болон нефтийн бүтээгдэхүүний импортын өсөлттэй холбоотой байна. Дотоод эдийн засгийн идэвхжил нэмэгдэж байгаа, Засгийн газар, Төв банкнаас эдийн засгийг дэмжих багц хөтөлбөрүүдийг хэрэгжүүлсэн, уул уурхай, дэд бүтцийн томоохон төслүүд хэрэгжиж байгаа зэргээс өмнөх онд агшаад байсан хэрэглээний, хөрөнгө оруулалтын, аж үйлдвэрийн орц зэрэг импортын томоохон бүрэлдэхүүн хэсэг бүрт өсөлт бий болж байна. Дэлхийн эдийн засаг сэргэж, түүнийг даган газрын тосны эрэлт, үнэ өссөнөөр нефтийн бүтээгдэхүүний импортын зардал нэмэгдэж байна. Импорт өсөхийн зэрэгцээ, түүнийг тээвэрлэх олон улсын ачаа тээвэрлэлт удааширч, хил дээр бөөгнөрөл үүссэн нөлөөгөөр ачаа тээврийн үйлчилгээний зардал өсөж байна. Олон улсын агаарын нислэгүүдийн тоо алгуур нэмэгдэж, оны сүүлийн хагаст аяллын зардал өсөхөөр байгаа бол цар тахлын нөлөөгөөр бусад үйлчилгээний зардал өмнөх оноос буурч, нийт **үйлчилгээний зардал өмнөх оны орчимд байхаар** байна. Гадаад зээл, бондын эргэн төлөлтийн тооцооллоор гадаад зээл болон бондын хүүний төлбөр өмнөх оны түвшинд, харин **гадаад бондын үндсэн төлбөр өмнөх жилээс 0.2 тэрбум ам.доллаароор тэлэх төлөвтэй байна**². Гадаад зээлийн үндсэн төлбөр 2021 онд 1.2 тэрбум ам.доллар буюу өмнөх оноос 224 орчим сая ам.доллаароор буурахаар байна.

Ийнхүү 2021 онд гадаад валютын гарах урсгал орох урсгалаа давсан нөлөөгөөр төлбөрийн тэнцэл 370 сая ам.долларын алдагдалтай гарахаар байна. Гадаад валютын нийт **орох урсгал 2022 онд өмнөх жилээс 0.9 орчим тэрбум ам.доллаароор нэмэгдэж 13.7 тэрбум ам.доллар** байх төсөөлөлтэй. Нэг талаас гадаад эрэлт тогтворжиж, нүүрсний экспорт 36 сая тонн, газрын тосны экспорт 6.4 сая баррель, ноолуурын экспорт 9.0 мянган тоннд хүрч өсөх бол нөгөө талдаа Оюу толгойн зэсийн баяжмал дахь алтны агууламж 2021 оноос 2.4 дахин буурах болон төмрийн хүдрийн үнэ буурахаар байна. Улмаар экспортын орлого 870 сая ам.доллаароор нэмэгдэж, 8.5 тэрбум ам.долларт хүрэхээр байна. Эдийн засгийн үйл ажиллагаа сэргэж, хэвийн түвшинд хүрэх таамаглалд тулгуурлан үйлчилгээний орлого 354 сая орчим ам.доллаароор нэмэгдэж, нийт үйлчилгээний орлого 2022 онд 1 тэрбум орчим ам.доллар байх, ГНХО өмнөх оноос нэмэгдэж 2 орчим тэрбум³ ам.долларт хүрэхээр төсөөлөв. МУЗГ ирэх онд Чингис бондын үлдэгдэл 134 сая ам.долларыг эргэн төлөхөөр таамаглав. Иймд 2022 оны гадаад бондын орох урсгал өмнөх жилээс 1.2 тэрбум ам.доллаароор буурахаар байна. Засгийн газрын гадаад зээлийн ашиглалт өсөх нөлөөгөөр гадаад зээлийн ашиглалт өмнөх оноос 0.3 тэрбум ам.доллаароор нэмэгдэж 1.9 тэрбум ам.долларт хүрэхээр байна.

Гадаад валютын нийт гарах урсгал 2022 онд өмнөх жилээс 0.4 тэрбум орчим ам.доллаар тэлж 13.6 тэрбум ам.долларт хүрэх төсөөлөлтэй байна. Үүнд эдийн засгийн үйл ажиллагаа сэргэх, гадаад худалдааны эргэлт нэмэгдэх таамаглалын дагуу бараа, үйлчилгээний импортын төлбөр нийт 1.4 тэрбум ам.доллаар тэлж байгаа нь голлон нөлөөлж байна. Харин гадаад бондын үндсэн төлбөр суурь үеийн нөлөөгөөр 1 орчим тэрбум ам.доллаар буурах бол гадаад зээлийн үндсэн болон хүүгийн төлбөр өмнөх оны түвшинд байх төлөвтэй.

6.3. Монгол Улсын гадаад өр

Монгол Улсын нийт гадаад өр 2021 оны 1 дүгээр улирлын эцсийн байдлаар 32.5 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеийн гүйцэтгэлээс 2.0 тэрбум ам.доллаар нэмэгдсэн байна. Энэхүү өсөлтөд Засгийн газрын зээл болон компани хоорондын зээллэг буюу гадаадын хөрөнгө оруулалттай ААН-үүдийн толгой компаниасаа авсан хөрөнгө оруулагчийн зээлийн өсөлт голчлон нөлөөлж байна.

Улсын салбар. Засгийн газрын гадаад өр 1.1 тэрбум ам.доллаар өсч 8.5 тэрбум ам.долларт, Монголбанкны гадаад өр 217.8 сая ам.доллаар өсөж 2.2 тэрбум ам.долларт хүрчээ. Засгийн газрын гадаад өрийн өсөлт нь зээлийн ашиглалт болон гадаад бондуудын зах зээлийн үнэлгээнээс бий болсон бол Төв банкны гадаад өрийн өсөлт нь Япон улсын Мицүбиши ЮФЖ групптай хийсэн алтны санхүүжилтийн ашиглалт болон харилцах хадгаламжийн дансны ханшийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

Хувийн хэвшил. Банк, бусад секторын болон хөрөнгө оруулагчийн зээлийг хувийн хэвшлийн салбарын гадаад өр бөгөөд өнгөрсөн оны мөн үеэс 603.1 сая ам.доллаар нэмэгдэж 21.8 тэрбум ам.доллар болсон байна.


Банкны салбарын гадаад өр. Банкны салбарын гадаад өрийн үлдэгдэл 2021 оны 1 дүгээр улиралд 1.7 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 25 хувиар буюу 543.1 сая ам.доллаар буурчээ. Тус гадаад өрийн 58 хувийг урт хугацаат зээл, 22 хувийг оршин суугч бусын харилцах, хадгаламжийн дансны өглөг, 15 хувийг богино хугацаат зээл, үлдсэн 4 хувийг бонд, өрийн бичиг тус тус бүрдүүлж байна.

Хүснэгт 22. Гадаад өрийн үлдэгдэл /тэрбум \$/

Үзүүлэлт	3/31/2020	3/31/2021	ҮеY, %	%*
Нийт гадаад өр	30.5	32.5	6%	100%
I. Засгийн газар	7.3	8.5	16%	26%
II. Төв банк	2.0	2.2	11%	7%
III. Банк	2.2	1.7	-25%	5%
Богино хугацаат	0.6	0.6	0%	
Урт хугацаат	1.6	1.0	-34%	
IV. Бусад сектор	8.4	8.4	0%	26%
Богино хугацаат	0.6	0.6	-9%	
Урт хугацаат	7.7	7.8	1%	
V. Хөрөнгө оруулагч зээл	10.7	11.8	10%	36%

*Нийтэд эзлэх %

Зураг 62. Гадаад өрийн үлдэгдэл



Бусад (банкны бус) салбарын гадаад өр. Аж ахуйн нэгж, иргэдийн гадаад өр 2021 оны 1 дүгээр улирлын эцэст 20.2 тэрбум ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеийн үлдэгдлээс 1.1 тэрбум ам.доллаар өссөн байна. Тус салбарын нийт зээлийн 58 хувь буюу 11.8 тэрбум ам.долларын эх үүсвэр нь аж ахуйн нэгж, байгууллагуудын гадаадын хөрөнгө оруулагчаас авсан зээл (компани хоорондын зээллэг) байна. Энэ төрлийн зээлийн эх үүсвэр нь компанийн эргэлтийн хөрөнгө, мөнгөн урсгалыг дэмжих зорилгоор олгогддог урт хугацаатай санхүүжилт бөгөөд ихэнх тохиолдолд хүүгүй, хатуу мөрдөх эргэн төлөлтийн хуваарь үгүй, улмаар харилцан тохиролцсоны

үндсэн дээр цаашид дүрмийн санд нэмж тооцогдох боломжтой байдгаараа бусад төрлийн зээлээс ялгаатай юм.

Монгол Улсын нийт гадаад өр/ДНБ-ий харьцаа (**238%**) нь тухайн улсын өрийн эргэн төлөх чадварыг эдийн засгийн үйл ажиллагааных нь хүрээнд хэмждэг үзүүлэлт юм.

Монгол Улсын нийт гадаад өр/Экспорт (**374%**) нь гадаад өрийн хэмжээг бараа, үйлчилгээний экспорт буюу гадаад орлогын үндсэн эх үүсвэрт харьцуулж өрийн дарамтыг тооцдог.

Монгол Улсын нийт гадаад өр/Төсвийн орлогын харьцаа (**838%**) нь тухайн Засгийн газрын (ялангуяа төсөвт гадаад өрийн дарамт өндөр байгаа үед) дотоодоосоо орлого бий болгох чадамжийг харуулдаг.

ШИГТГЭЭ 11. Засгийн газрын өрийн санхүүжилтийн байдал, олон улсын туршлага


Монгол Улсын Их Хурлаас Засгийн газрын өрийн удирдлагын дунд хугацааны зорилт, түүнийг хэрэгжүүлэх арга замыг тодорхойлсон бодлогын баримт бичиг буюу Засгийн газрын өрийн удирдлагын дунд хугацааны стратегийг батлан гаргадаг.

Засгийн газрын өрийн удирдлагын 2019-2022 оны стратегийн баримт бичигт дунд хугацааны таван зорилтыг тусгасан бөгөөд үүнээс гадаад өр төлбөртэй холбоотой дараах хоёр зорилтыг тусгасан байна. Үүнд: 1) Засгийн газрын гадаад, дотоод үнэт цаас, зээлийн төлбөрүүдийг эдийн засаг, төсөвт дарамт учруулахгүйгээр төлж дахин санхүүжилтийн эрсдэлийг бууруулна, 2) Гадаад зээллэгээр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрүүдэд зардал, үр өгөөжийн тооцооллыг хийж, зөвхөн үр ашигтай төслүүдийг санхүүжүүлэх зарчмыг баримтлан тэдгээрийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулна. **Тус стратегийн баримт бичгийн эхний зорилтод заасны дагуу дараах арга хэмжээг авсан байна.**


2020 онд: “Номад” өрийн зохицуулалтын арга хэмжээний хүрээнд олон улсын санхүүгийн зах зээлээс 6 жилийн хугацаатай 5.125 хувийн хүүтэй 500 сая ам.долларын санхүүжилтийг амжилттай татав. Энэхүү арга хэмжээгээр 2021 онд эргэн төлөгдөх 10.875 хувийн хүүтэй “Мазаалай”, 2022 онд эргэн төлөгдөх 5.125 хувийн хүүтэй “Чингис” бондуудын зарим хэсгийг дахин санхүүжүүлэв.

2021 онд: “Century” өрийн зохицуулалтын төслийн хүрээнд 1 тэрбум ам.долларыг бага хүүтэйгээр олон улсын санхүүгийн зах зээлээс татан төвлөрүүлж 2022 онд төлөгдөх 5.125 хувийн хүүтэй 799 сая ам.долларын үлдэгдэл төлбөр бүхий “Чингис” бонд, 2023 онд төлөгдөх 5.625 хувийн хүүтэй 800 сая ам.долларын “ГЭРЭГЭ” бондуудыг хэсэгчлэн дахин санхүүжүүлэх ажлыг хийж гүйцэтгэсэн байна. Уг төслийн хүрээнд зургаан жилийн хугацаатай 3.5 хувийн хүүтэй 500 сая ам.доллар, 10 жилийн хугацаатай 4.45 хувийн хүүтэй 500 сая ам.долларын нийт 1 тэрбум ам.долларын өрийн зохицуулалтыг хийжээ.

Зураг 63. Бондын хүүний хувь



Зураг 64. Бондын хүүний зардал



Эх сурвалж: Сангийн яам

Бондын санхүүжилтийн бусад улстай харьцуулалт:

Дотоод валютаарх бондын санхүүжилт: Дийлэнх хөгжингүй улсуудын Засгийн газар дотоод валютаарх бондыг 1990 оноос эхлэн гаргаж байсан бол Израил, Сингапураас бусад хөгжиж буй улсуудын хувьд дийлэнх нь 1996 болон түүнээс хойш гаргаж эхэлсэн байна.

Гадаад валютаарх бондын санхүүжилт: Хөгжингүй орнуудын хувьд дотоод болон гадаад валютын бондын хэрэгслийг хослуулан ашиглах замаар засгийн газрын санхүүжилтийн хэрэгцээг нөхөж ирсэн бол хөгжиж буй улсуудын хувьд 2000 оны эхэн үе хүртэл гадаад валютаарх бондын санхүүжилт зонхилж байв. Хонг Конг, Мексик, Перу, Саудын Араб зэрэг улсууд 2010-2020 он хүртэл зөвхөн дотоод валютаар бондын санхүүжилт босгож засгийн газрын санхүүжилтийн хэрэгцээг нөхөж ирсэн байна.

Хүснэгт 23. МУ-тай ижил түвшний зээлжих зэрэглэлтэй улсуудын бондын санхүүжилтийн зардал, 2021 оны 1 сарын байдлаар

№	Улс	Зээлжих зэрэглэл	Дундаж бондын хүү
1	Беларус	В3	6%
2	Украйн	В3	7%
3	Армен	Ва3	5%
4	Бразил	Ва2	5%
5	Турк	В2	5%
6	Тунис	В3	38%
5	Коста Рика	В2	6%
6	Монгол	В3	6.2%*

*Century бондын санхүүжилтийг оруулж тооцсон


Эх сурвалж: Eurodad (2021 оны 1 сар)

Монгол Улсын бондын санхүүжилт: Монгол Улсын Засгийн газар олон улсын зах зээл дээрээс нийт 8 удаа бондын санхүүжилт татсан ба эдгээр нь бүгд гадаад валютаар байв.

Бондын санхүүжилтийн зардал: Хөгжиж буй улсуудын засгийн газрын татсан бондын санхүүжилтийн купон нь жилийн 1.2%-9.5% хооронд бөгөөд дунджаар 5.7% байна. Монгол Улсын хувьд Засгийн газрын бондын дундаж хүүний түвшин 6.2%, хамгийн өндөр хүү 10.875% (Мазаалай, 2016), хамгийн бага хүү 3.5% (Century, 2021) байна.

Бондын хэмжээ: 2021 оны 1 дүгээр сарын байдлаар 62 бага, дунд орлоготой орнууд нийт 549 ЗГ-ын бондын санхүүжилт татсан бөгөөд нийт дүн нь 691 их наяд ам.доллар байна. 10 буюу түүнээс доош бонд эзэмшиж буй 45 улсын хувьд дундаж бондын хэмжээ 3.7 тэрбум ам.доллар байна. Монгол Улсын ЗГ-ын гадаад бондын үлдэгдэл 2021 оны 1 дүгээр улиралд 2.8 тэрбум ам.доллар байв. Харин ЗГ-ын нийт өрийн ДНБ-д эзлэх хувь хөгжиж буй улсуудынхтай ойролцоо түвшинд байна (Зураг 65).

Зураг 65. Хөгжиж буй улсуудын ЗГ өр, ДНБ-ий харьцаа, 2020 он



Эх сурвалж: Дэлхийн банк (2020 он)

7. САНХҮҮГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

ШИГТГЭЭ 12. Макро зохистой бодлого, санхүүгийн зохицуулалт

Ковид-19 цар тахлын үед банк, санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хамгаалах зорилгоор дэлхийн улс орнуудад макро зохистой бодлогын арга хэрэгслүүдийг түгээмэл ашиглаж байна. Үүнд:


1. Зээлийн тасалдлаас сэргийлэх, эдийн засгийг дэмжих зорилгоор нөөцийг ашиглахад чиглэсэн арга хэмжээнүүд

Эдийн засгийн нөхцөл байдал хэвийн үед банкны салбарын нөөц хөрөнгийг нэмэгдүүлж, хямралын үед зээл олголтыг дэмжих зорилгоор тухайн нөөцийг ашигладаг. Энэ жишгийн дагуу улс орнууд 2020 оны эхнээс хойш мөчлөг сөрсөн өөрийн хөрөнгийн нөөц, системийн ач холбогдолтой банкны нэмэлт шаардлага, хөрөнгө хамгаалах нөөц сан зэрэг өөрийн хөрөнгийн нэмэлт шаардлагуудыг бууруулах арга хэмжээг түгээмэл авч хэрэгжүүлжээ. Тодруулбал, Базель III стандартыг нэвтрүүлсэн хөгжингүй орнуудад мөчлөг сөрсөн өөрийн хөрөнгийн шаардлагыг сулруулсан бол хөгжиж буй улсуудын хувьд системийн ач холбогдолтой банкуудад тавьж буй өөрийн хөрөнгийн нэмэлт шаардлагыг бууруулах арга хэмжээ хэрэгжүүлсэн байна (Зураг 66). Мөн банкны эх үүсвэрийг ашиглан зээл олголтыг дэмжих зорилгоор зарим орнуудад төлбөр түргэн гүйцэтгэх чадвар (ТТГЧ)-ын харьцаа болон заавал байлгах нөөцийн хувь хэмжээ зэрэг 2 хэрэгслийг голчлон ашиглажээ (Sankar.P et al., 2021). БНХАУ нь 2020 оноос хойш заавал байлгах нөөцийн хувь хэмжээг 3 удаа бууруулсан бол Бүгд Найрамдах Ардчилсан Конго болон Исланд улсуудад тус харьцааг 0 хүртэл бууруулсан тохиолдлууд ч байна. Монгол Улсын хувьд цар тахлын үед зээл олгох эх үүсвэрийг нэмэгдүүлэх зорилгоор дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэв. Үүнд:


- Төгрөгийн заавал байлгах нөөцийн хувь хэмжээг 6 хувь хүртэл бууруулах;
- ТТГЧ-ын харьцааны шаардлагыг сулруулах;
- Банкуудын өөрийн хөрөнгөд тавигдах нэмэлт шаардлагын хэрэгжих хугацааг хойшлуулах.

Зураг 66. Улс орнуудад хэрэгжүүлсэн макро зохистой бодлогын хэрэгслүүд (2020 онд)

Хөгжингүй орнууд



Хөгжиж буй орнууд



Эх сурвалж: ОУВС

2. Зээлдэгчдэд чиглэсэн зохицуулалтын арга хэмжээнүүд

Эргэн төлөлтөд хүндрэл учирсан зээлийн бүтцийг өөрчилж, хугацааг сунгах, зээлийн ангиллыг тодорхой хугацаанд бууруулахгүй хэвээр хадгалах зэрэг зээлдэгчдэд чиглэсэн хөнгөлөлтийн арга хэмжээнүүдийг дэлхийн улс орнуудад түгээмэл ашиглаж байна. Түүнчлэн зарим орнуудад зээлийн өр, орлогын харьцаа болон зээл үнэлгээний харьцааны шаардлагыг сулруулах, кредит картын үлдэгдэл төлбөрийг бага хүүтэй зээлийн бүтээгдэхүүн рүү шилжүүлэх зэрэг зохицуулалтууд хийжээ. Монголбанк нь цар тахалтай холбоотой зээлдэгчдэд үүсч буй дарамтыг бууруулах зорилгоор дараах бодлогын арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэв. Үүнд:

- Ипотек, цалин, тэтгэвэр болон бусад хэрэглээний зориулалтаар иргэнд олгосон зээлийн ангилал бууруулах хугацааг уртасгах;
- Бүх төрлийн зээлд бүтцийн өөрчлөлт хийхэд хязгаарлалтгүй болгох;
- Эргэн төлөлтийн хүндрэлд орсон иргэдийн хэрэглээний зээлийн хугацааг сунгах боломжийг олгох;
- Төрөөс хэрэгжүүлж буй ипотекийн зээлийн хүү болон үндсэн төлбөрийг түр хугацаагаар хойшлуулах.

Хүснэгт 24. Бүтцийн өөрчлөлт хийсэн зээл, тэрбум төгрөгөөр (6-р сарын 30-ны өдрийн байдлаар)

	Зээлийн үлдэгдэл	Ковид-19-т өртсөн	Бүтцийн өөрчлөлт хийсэн зээл (тухайн төрлийн зээлд эзлэх %)
Бизнесийн зээл	9,876	4,050	2,594 (26%)
Ипотекийн зээлээс бусад иргэдийн зээл	7,021	2,246	1,794 (26%)
Ипотекийн зээл	5,153	3,520	3,138 (61%)
Нийт	22,050	9,816	7,526 (34%)

Эх сурвалж: Монголбанк


3. Бусад

Дэлхий дахинд цар тахлын санхүүгийн салбарт үзүүлэх сөрөг нөлөөг хязгаарлах үүднээс банкуудыг ногдол ашиг хуваарилахыг хязгаарлах, шинээр нэвтрүүлэхээр төлөвлөж буй зохицуулалтын арга хэмжээнүүдийн хэрэгжиж эхлэх хугацааг хойшлуулах, банкны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн шаардлага зөрчигдөхөд тавигдах торгууль, шимтгэлийг түдгэлзүүлэх, банкны илүүдэл нөөцөд төлөх хүүний хэмжээг бууруулж, зээл олголтыг дэмжих, хадгаламжаас бусад 1 жил хүртэлх гадаад валютын эх үүсвэрт татвар ноогдуулах, санхүүгийн салбарын нөхцөл байдлын талаарх бодит мэдээллийг зах зээлд хүргэх зэрэг нэмэлт макро зохистой бодлогуудыг хэрэгжүүлсэн туршлага байна. Манай улсын хувьд цар тахлын үед санхүүгийн салбарын долларжилтыг бууруулах зорилгоор дараах арга хэмжээг авав. Үүнд:

- Гадаад валютын хадгаламжийг албан даатгалд хамруулахгүй байх;
- Иргэн хуулийн этгээд хоорондын мөнгөн төлбөрийн үүрэг, гүйлгээг гадаад валютаар гүйцэтгэхийг хязгаарлах;
- Өндөр хүүтэй гадаад валютын хадгаламж болон хүү төлж буй гадаад валютын харилцахын дүнгээс хамааруулан ЗБН-ийн урамшууллыг бууруулах.

Корона вирусын мутацлагдсан хэлбэрүүд тархаж, цар тахлын тархалт намжих эсэх тодорхойгүй байгаа нь санхүүгийн салбарт хэрэгжүүлж буй хөнгөлөлтийн арга хэмжээнүүдийг зогсооход сорилт болж байна. Иймд олон орнуудад эдийн засгийн нөхцөл байдал хэвийн түвшинд хүрэх хүртэл эдгээр хөнгөлөлтийн арга хэмжээнүүдийг үргэлжлүүлэх хандлагатай байгаа бөгөөд цар тахлын нөлөөнд хүчтэй өртөж буй салбаруудад чиглүүлэхийг эрмэлзэж байна. Харин Европын холбооны орнуудад санхүүгийн хөнгөлөлттэй зохицуулалтуудыг шат дараатай хэвийн горимд шилжүүлэх, ингэхдээ эхний ээлжинд зээлдэгчдэд чиглэсэн хөнгөлөлтүүд, сүүлийн хэсэгт банкны өөрийн хөрөнгийн хөнгөлөлтүүдийг цуцлахаар төлөвлөж байна (Beck.T et al., 2021). Манай улсын хувьд цар тахлын эдийн засагт үзүүлж буй сөрөг нөлөө бүрэн арилж, банкны систем хэвийн үйл ажиллагаагаа явуулах нөхцөл бүрдэхэд шаардагдах хугацаа тодорхой бус хэвээр байна. Иймд Монголбанкнаас банкны салбарт хэрэгжүүлж буй хөнгөлөлтийн арга хэмжээг хэрхэн цуцалж, хэвийн горимд шилжүүлэх талаар төлөвлөгөө гарган ажиллаж байна. Тухайлбал, Монголбанк нь хэрэглээний зээлийн хугацааг сунгах, ТТГЧ-ын зохистой харьцааг бууруулах зэрэг хөнгөлөлтийн арга хэмжээнүүдийг зогсоов. Харин иргэдийн зээлийн чанарын ангилалд мөрдөгдөж буй хөнгөлөлттэй зохицуулалтыг шат дараатай халж, 2022 оны 4 дүгээр сараас эхлэн хэвийн түвшинд хүргэхээр төлөвлөж байна. Цаашид Монголбанкнаас цар тахлын нөхцөл байдал, эдийн засгийн сэргэлтийг харгалзан үзэж хөнгөлөлттэй зохицуулалтын арга хэмжээнүүдийн төлөвлөгөөнд тухай бүр өөрчлөлт оруулан ажиллах юм.

Зураг 67. Цар тахлын үед Монголбанкнаас авч хэрэгжүүлсэн Макро зохистой бодлого, санхүүгийн зохицуулалтын арга хэмжээ



7.1. Санхүүгийн салбар

Манай улсын санхүүгийн салбар нь банк давамгайлсан буюу санхүүгийн системийн нийт активын 90 гаруй хувийг банкны салбар дангаараа бүрдүүлж байна. Банкнаас бус санхүүгийн салбарын үйл ажиллагааны цар хүрээ жилээс жилд нэмэгдэж байгаа боловч банктай харьцуулахад санхүүгийн нийт системд эзлэх хувь харьцангуй бага хэвээр байгаа юм (Хүснэгт 25).

Хүснэгт 25. Санхүүгийн салбарын голлох үзүүлэлтүүд /2021 оны 2 дугаар улирлын байдлаар/


Үзүүлэлтүүд	Банк	ББСБ	ХЗХ	Даатгал
Актив	40,076.7	2,263.0	270.5	428.9
Өр төлбөр	36,905.3	709.5	214.6	234.2
Эзэмшигчдийн өмч	3,171.4	1,553.4	55.9	114.2
Зээлийн өрийн үлдэгдэл	19,615.0	1,571.9	186.8	-
Чанаргүй зээл	1,942.9	152.7	6.9	-
Тайлант үеийн ашиг	322.0	84.8	5.2	27.8
Даатгалын хураамжийн орлого	-	-	-	201.5
Даатгалын нөхөн төлбөр	-	-	-	29.0

Эх сурвалж: Монголбанк, СЗХ

Дэлхий даяар тархаад буй Ковид-19 цар тахлын нөхцөл байдлын улмаас манай улсын эдийн засаг 2020 онд хурдтай агшиж, аж ахуйн нэгж, өрхүүдийн секторт орлого тасалдах, зээлийн эргэн төлөлт доголдож төлбөрийн чадварын хүндрэлд орох нөхцөл байдал үүсэв. Санхүүгийн системийн эрсдэлийн нэгдсэн индексээс харахад 2020 оны эхнээс системийн эрсдэл эрчимтэй нэмэгдсэн бөгөөд үүний 50 гаруй хувийг макро болон гадаад секторын эрсдэл дангаараа бүрдүүлж байв. Банкны сектор, хөрөнгийн зах, хөрвөх чадвар, санхүүжилтийн эрсдэлүүд мөн нэмэгдэж, нийт системийн эрсдэл үргэлжлэн нэмэгдэх хандлагатай болсон байлаа (Зураг 68). Энэ нь цаашлаад системийн тогтвортой байдал алдагдах эрсдэлийг үүсгэх тул санхүүгийн зохицуулагч байгууллагуудын зүгээс иргэд, аж ахуйн нэгжүүдийн төлбөрийн дарамтыг бууруулж, санхүүгийн тогтвортой байдалд дэмжлэг үзүүлэх зорилгоор шат дараатай арга хэмжээг өргөн хүрээнд авч хэрэгжүүлсэн байна. Үүний үр дүнд иргэд, аж ахуйн нэгжүүдийн төлбөрийн чадвар сайжирч, банк, санхүүгийн системийн тогтвортой байдалд дэмжлэг үзүүлэв.

Банкуудаас ирүүлсэн мэдээллээр хөнгөлөлттэй зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй тохиолдолд банкны системийн чанаргүй зээл 1.5 их наяд төгрөгөөр илүү дүнтэй байх бөгөөд улмаар чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь 16.1 хувьд хүрэхээр байв. Энэ нь 2008-2009 оны дэлхийн санхүүгийн хямралын үед Монгол улсад тохиолдож байсан банкны салбарын хүндрэлийн нөхцөл байдалтай ижил буюу зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй нөхцөлд банк, санхүүгийн системд томоохон хэмжээний хүндрэл үүсч болзошгүй байсан дүр зураг ажиглагдаж байна.

Зураг 68. Санхүүгийн системийн эрсдэлийн нэгдсэн индекс



Эх сурвалж: Монголбанк


Санхүүгийн зохицуулагч байгууллагуудын зүгээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, эдийн засгийг дэмжих бодлогын нөлөөгөөр санхүүгийн зуучлал хэвийн үргэлжилж, банк, санхүүгийн системийн тогтвортой байдал хангагдаж байгаа боловч цаашид зохицуулалтын арга хэмжээ хэвийн горимд шилжиж, санхүүгийн бодлогын төлөв эргээд чангарах нөхцөлд банк, санхүүгийн системд дараах сорилтууд тулгарч болзошгүй байна. Үүнд:

- Зохицуулалтын арга хэмжээ эргээд хэвийн горимд шилжихэд чанаргүй зээлийн хэмжээ нэмэгдэх эрсдэл өндөр юм. Ялангуяа, цар тахлын нөхцөл байдал сайжрахгүй, эдийн засгийн сэргэх хугацаа удааширвал аж ахуйн нэгжүүдийн орлогод сөргөөр нөлөөлж, зээл чанаргүйдэх эрсдэлийг нэмэгдүүлэх юм. 2021 оны 6 дугаар сарын байдлаар уул уурхай, боловсруулах, барилгын салбарын чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь харгалзан 19.7 хувь, 15.6 хувь, 14.3 хувьтай байгаа бөгөөд эдийн засгийн бүх салбаруудад эргэн төлөлтийн доголдолтой зээл өмнөх оноос нэмэгдсэн байна.
- Засгийн газраас үзүүлж буй дэмжлэгийн хүрээнд банкууд зээл олгох шаардлагаа сулруулж, хөнгөлөлттэй санхүүжилтийг их хэмжээгээр олгож байгаа нь нэг талаас ажлын байрыг хадгалж, аж ахуйн нэгжүүдийн төлбөрийн чадварт дэмжлэг үзүүлж байгаа боловч нөгөө талаас үр ашиггүй аж ахуйн нэгжүүдийг дэмжих, өрийн дарамтыг нэмэгдүүлэх, улмаар хөнгөлөлтийн арга хэмжээ дуусгавар болоход санхүүгийн системд гэнэтийн сөрөг шок үүсгэх эрсдэлтэй юм. 2021 оны 7 дугаар сарын байдлаар хөнгөлөлттэй зээлийн хэмжээ банкны системийн нийт зээлийн 17.8 хувийг эзэлж байна. Цаашид цар тахлын тархалт буурахгүй, эдийн засгийн сэргэлт удааширах нөхцөлд аж ахуйн нэгж, бизнес эрхлэгчдийн борлуулалт буурах, улмаар зээлийн эргэн төлөлтөд хүндрэл учирч, зээлийн чанар муудах, санхүүгийн салбарын эрсдэлийн сангийн зардлыг өсгөж, санхүүгийн секторт эрсдэл үүсгэх магадлалтай юм.


7.2. Банк бус санхүүгийн салбар

Ковид-19 цар тахлын сөрөг нөлөөллөөс иргэд, аж ахуйн нэгжүүдийг хамгаалах зорилгоор үнэт цаасны салбарт авч хэрэгжүүлсэн бодлого, зохицуулалтын арга хэмжээний үр дүнд шинэ бүтээгдэхүүний тоо нэмэгдэж, хөрөнгийн захын идэвхжил эрчимжиж, гол илтгэгч үзүүлэлтүүд 2021 оны эхний хагаст түүхэн дээд түвшинд хүрлээ. Монголын хөрөнгийн бирж дээр хийгдсэн үнэт цаасны гүйлгээний дүн эрчимтэй тэлж, 2021 оны эхний хагаст өмнөх оны мөн үеэс 22 дахин нэмэгдэж 646.7 тэрбум төгрөгт хүрлээ. Хөрөнгийн захын үнэлгээ эрчимтэй өсч, 2021 оны эхний хагаст дунджаар 3,804.0 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 52.1 хувиар өссөн үзүүлэлт болов (Зураг 69).

Зураг 69. Зах зээлийн үнэлгээ



Зураг 70. Даатгалын салбарын нийт хөрөнгө /тэрбум төгрөг/




Эх сурвалж: СЗХ

Даатгалын салбарын нийт хөрөнгийн хэмжээ 2016-2020 онд жилд дунджаар 23.0 хувиар өсч, 382.1 тэрбум төгрөгт хүрэв. Олон улсын даатгалын салбарын хөгжлийн голлох үзүүлэлтийн нэг болох даатгалын гүнзгийрэлт буюу даатгалын хураамжийн орлогын ДНБ-д эзлэх хувь 2016-2020 оны хооронд 0.48-0.57 хувьд хүрсэн. Үүнээс дүгнэхэд даатгалын салбарын нийт эдийн засагт үзүүлж буй нөлөөлөл бага хэвээр байгаа юм. (Зураг 70). Даатгалын компаниудын 2021 оны 1 дүгээр улирлын тайлангаас дүгнэхэд Ковид-19 цар тахлын улмаас даатгалын компаниудын санхүүгийн чадвар болон үйл ажиллагаанд том хохирол учраагүй ч ачааны даатгал, гадаад зорчигчдын гэнэтийн ослын даатгал зэрэг хил дамнасан үйл ажиллагаатай холбогдох даатгалын бүтээгдэхүүнүүдийн хураамжийн орлого ихээр буурсан байна. Мөн хил хаасантай холбоотой иргэд, аж ахуйн нэгжүүдийн орлого буурснаар зээлийн даатгалын бүтээгдэхүүнүүдэд нөхөн төлбөрийн зардал хамгийн их гарлаа.


Манай улсад банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан 536 банк бус санхүүгийн байгууллага (ББСБ) үйл ажиллагаа эрхэлж байгаагаас 92.7 хувь буюу 497 нь зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй. 2021 оны эхний хагаст ББСБ-уудын нийт хөрөнгө 2.3 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 21.5 хувиар, нийт зээлийн хэмжээ 1.6 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 20.2 хувиар тус тус өссөн байна (Зураг 71). Салбарын нийт харилцагчдын тоо давхардсан тоогоор 3.3 сая хүрч өмнөх оны мөн үеэс 18.9 хувиар, зээлдэгчдийн тоо 748.3 мянгад хүрч өмнөх оны мөн үеэс 75.7 хувиар тус тус нэмэгдсэн.

Цаг үеийн нөхцөл байдалтай холбогдуулан “ББСБ-ын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-д нийт 4 удаа өөрчлөлт оруулж, 2021 оныг дуустал сунгав. 2021 оны эхний хагаст ББСБ-ын салбарын зээлийн чанар төдийлөн муудаагүйд дээрх зохицуулалт багагүй хувь нэмэр оруулав (Зураг 72).

Зураг 71. ББСБ-ын нийт хөрөнгө ба зээл /тэрбум төгрөг/




Зураг 72. Зээлийн чанар ба сарын ЖДХ



Эх сурвалж: СЗХ

2021 оны эхний хагасын байдлаар тусгай зөвшөөрөлтэй 234 хадгаламж, зээлийн хоршоо (ХЗХ) манай улсад үйл ажиллагаа эрхэлж байна. Нийт гишүүдийн тоо 73,719 хүрсэн бөгөөд салбарын нийт хөрөнгө сүүлийн 3 жилд 11.4 -19.5 хувийн өсөлттэй гарч байна. ХЗХ-дын нийт хөрөнгө өмнөх оны мөн үеэс 15.4 хувь буюу 36.03 тэрбум төгрөгөөр өсч 270.5 тэрбум төгрөгт хүрсэн нь банкны салбарын 0.69 хувьтай тэнцэж байна (Зураг 73). Салбарын хэмжээнд нийт зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 13.2 хувиар өсч 186.8 тэрбум төгрөгт хүрсэн бол хадгаламж өмнөх оны мөн үеэс 17.0 хувиар тэлж, 191.2 тэрбум төгрөгт хүрээд байна (Зураг 74).

Зураг 73. ХЗХ-дын салбарын нийт хөрөнгө, **Зураг 74.** Зээлийн чанар /тэрбум төгрөг/ хадгаламж /тэрбум төгрөг/



Эх сурвалж: СЗХ

Цаашдын төлөв

Манай улсын санхүүгийн зах зээлийн хөгжил сул, дотоодын хөрөнгийн зах зээлийн хэмжээ бусад Азийн улсуудтай харьцуулахад бага хэвээр, мөн түүний эдийн засагт гүйцэтгэх үүрэг өндөр түвшинд хүрээгүй байгаатай холбогду олон улсын санхүүгийн зах зээлд гарч буй сөрөг нөлөө, шок зэрэгт шууд хариу үзүүлдэггүй талаар судалгааны ажлуудад дурдсан байдаг. Өөрөөр хэлбэл, дотоодын хөрөнгийн зах зээл Монгол Улсын макро эдийн засгийн нөхцөл байдалд гарч буй өөрчлөлтөөс шууд хамаардаг бөгөөд гадаад хүчин зүйлс, шокын нөлөөнд шууд бус замаар хариу үйлдэл үзүүлдэг. Иймд олон улсад гарч болзошгүй санхүүгийн хямрал, томоохон өөрчлөлт, сөрөг нөлөө, шок зэргээс шалтгаалах эрсдэлийн түвшин харьцангуй бага байна.

Гэвч сүүлийн үед дотоодын зах зээлд хурдацтай шинээр бий болж буй виртуал хөрөнгөтэй холбоотой эрх зүйн зохицуулалтын орчныг тодорхой болгох шаардлага үүсч байна. Олон

улсын жишгээс харахад ихэнх хөгжингүй орнуудад виртуал хөрөнгийн талаар холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах, эсхүл одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль, журамд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар зохицуулалтын орчныг тодорхой болгож, хуулийн сул талыг ашиглахыг эрс бууруулах /Regulatory arbitrage/, улмаар хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах, тэдгээрт учрах санхүүгийн эрсдэлийг бууруулах шат дараалсан арга хэмжээг хэрэгжүүлж эхлээд байна. Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжоор дээрх шинэ санхүүгийн бүтээгдэхүүнийг зохицуулаагүй тул дотоодын зах зээлд оролцогчид болон гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын дунд зарим талаар буруу ойлголт, төөрөгдөл үүсгэхээр байна. Үүнтэй холбогдуулан цаашид төрийн зохицуулагч байгууллагаас виртуал хөрөнгийн талаар тодорхой бодлого, зохицуулалтын арга хэмжээг хэрэгжүүлэх, мөн регтек, суптек /regtech, suptech/-ийг бүрэн нэвтрүүлэх замаар одоогийн зохицуулалт, хяналт, шалгалтын тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэх шаардлагатай.

Цаг үеийн нөхцөл байдалтай холбоотойгоор ХЗХ-дыг цахим, дижитал орчинд шилжүүлэх, мөнгөн гүйлгээ ба мэдээлэл өгөх, дамжуулах цахим сувгуудыг нэмэгдүүлэх, зээлийн мэдээллийн сантай гэрээ байгуулах, зээлдэгчийн мэдээлэл нийлүүлэх, ХЗХ ба гишүүдийн мэдээллийг цахим халдлагын гэмт хэргээс хамгаалах зэрэг кибер аюулгүй байдлын системийг хөгжүүлж ажиллах хэрэгцээ, шаардлагатай байгаа боловч ХЗХ-дын хувьд орон нутагт тархсан, интернет болон шилэн кабел хүрэлцээгүй зэрэг бэрхшээл байна.

Цаашид банк бус санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг илүү гүнзгийрүүлж, олон тулгууртай болгох замаар эдийн засагт гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэх, бизнес эрхлэх таатай нөхцөлийг бүрдүүлэх, цахим шилжилтийг эрчимжүүлэхэд анхаарч, салбарын онцлог, бүтээгдэхүүн, үйлчилгээнд нийцсэн эрх зүйн зохицуулалтыг бий болгох ажлыг идэвхжүүлэх нь зүйтэй байна.

7.3. Банкны салбарын өнөөгийн байдал, цаашдын төлөв


Банкны салбарт 2021 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар нийт 12 банк 1,391 салбар нэгжээр дамжуулан банкны үйлчилгээг 3.1 сая хадгаламж эзэмшигч, 1.4 сая зээлдэгчид хүргэж байна.

Активын бүтэц, өөрчлөлт


Банкны салбарын нийт активын хэмжээ 2021 оны 6 дугаар сард 39.7 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 17.0 хувиар буюу 5.7 их наяд төгрөгөөр, оны эхнээс 9.5 хувиар буюу 3.4 их наяд төгрөгөөр тус тус өссөн байна.

2020 оны мөн үетэй харьцуулахад зээл 1.7 их наяд төгрөгөөр, банкуудын эрсдэл багатай үнэт цаас дахь хөрөнгө оруулалт, тухайлбал, Төв банкны үнэт цаас дахь хөрөнгө оруулалт 5.7 их наяд төгрөгөөр өссөн бол мөнгөн хөрөнгө 1.4 их наяд төгрөгөөр, бусад актив 0.4 их наяд төгрөгөөр тус тус буурсан байна.

Зураг 75. Активын бүтэц, өсөлт (их наяд төгрөгөөр)



Жилийн өөрчлөлт (хувиар)



Эх сурвалж: Монголбанк

Банкны системийн хэмжээнд зээлийн багц нийт активын 44.0 хувийг бүрдүүлж байгаа нь өмнөх оны мөн үеэс 3 нэгж хувиар буурсан үзүүлэлт юм. Ковид-19 цар тахалтай холбоотойгоор банкууд тэнцэл дэх эрсдэлээ бууруулан эрсдэл багатай үнэт цаас дахь хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлэх арга хэмжээ авснаар активын бүтэц өөрчлөгдөж, зээлийн багцын эзлэх хувь буурсан боловч Эдийн засгийг идэвхжүүлэх хөтөлбөрийн үр дүнд зээл олголт нэмэгдэж, банкуудын Төв банкны үнэт цаас дахь хөрөнгө оруулалтын өсөлтийн хурд саарч байна.

Нийт активыг бүтцээр нь авч үзвэл 44 хувь нь зээл, 25 хувь нь Төв банкны үнэт цаас, 16 хувь нь мөнгөн хөрөнгө, 4 хувь нь Засгийн газрын үнэт цаас, үлдэх 11 хувь нь бусад хөрөнгө байна.


Зээл, түүний өөрчлөлт

Банкны салбарын зээлийн өрийн үлдэгдэл 2021 оны 6 дугаар сарын эцсийн байдлаар 19.2 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 11.0 хувиар буюу 1.9 их наяд төгрөгөөр, оны эхнээс 12.0 хувиар буюу 2.1 их наяд төгрөгөөр тус тус өссөн байна. Энэхүү өөрчлөлтийг зээлдэгчийн төрлөөр салгаж үзвэл өмнөх оны мөн үетэй харьцуулахад иргэдийн зээл 3.8 хувь буюу 654.1 тэрбум төгрөгөөр, байгууллагын зээл 7.2 хувь буюу 1.3 их наяд төгрөгөөр тус тус өссөн байна.

Хурдацтай өсөлттэй байсан иргэдийн зээлийг хязгаарлах зорилгоор өрхийн өр-орлогын харьцаанд тогтоосон макро-зохистой бодлогын хязгаарлалтыг 2019 оны эхнээс мөрдүүлснээр 2019 онд хэрэглээний зээлийн өсөлтийн хурд буурсан. Харин хэрэглээний зээлийн өсөлт 2020 оны эхнээс сөрөг утгатай болсон нь цар тахалтай холбоотойгоор тогтоосон хөл хорионы улмаас банкууд зээл олголтыг хязгаарласантай холбоотой байсан. 2021 оны 2 дугаар улирлаас хэрэгжсэн Эдийн засгийг идэвхжүүлэх хөтөлбөрийн хүрээнд зээл олголт нэмэгдсэнээр хэрэглээний зээлд өсөлт ажиглагдаж эхэллээ.


Эдийн засгийг идэвхжүүлэх хөтөлбөрийн хүрээнд Ажлын байрыг дэмжих зээл, Орон сууцны ипотекийн хөнгөлөлттэй зээл, Репо санхүүжилтийн урт хугацаат эх үүсвэртэй зээл, Хөдөө аж ахуйн салбарыг дэмжих зээлүүдийг олгосон. 2021 оны эхний улиралд зээлийн үлдэгдэл 2.1 их наяд төгрөгөөр өссөн нь зээлийн жилийн болон хагас жилийн өсөлтөөс өндөр дүнтэй байгаа бөгөөд тайлант сард зээлийн үлдэгдэл 1.0 их наяд төгрөгөөр буюу өмнөх сараас 5.6 хувиар өссөн байна.

Зураг 76. Зээлийн үлдэгдэл (их наяд төгрөгөөр), өсөлт



Эх сурвалж: Монголбанк

Зураг 77. Эдийн засгийн голлох салбаруудын зээлийн үлдэгдэл (тэрбум төгрөгөөр), нийт зээлд эзлэх хувь, жилийн өсөлт




Эх сурвалж: Монголбанк

Зээлийн үлдэгдлийг эдийн засгийн сектороор авч үзвэл өмнөх оны мөн үетэй харьцуулснаар барилгын салбараас бусад эдийн засгийн гол салбаруудын зээл өсжээ. Тухайлбал, уул, уурхайн салбарын зээл 33.9 хувиар, ипотекийн зээл 33.1 хувиар, боловсруулах салбарын зээл 26.4 хувиар, худалдааны салбарын зээл 20.9 хувиар тус тус өссөн бол барилгын салбарын зээл 2.0 хувиар, бусад салбаруудын зээл 33.0 хувиар буурсан байна.

Зээлийн чанар

2021 оны 6 дугаар сарын байдлаар нийт зээлийн 82.1 хувь буюу 15.7 их наяд төгрөгийн зээл хэвийн ангилалд, 8.5 хувь буюу 1.6 их наяд төгрөгийн зээл анхаарал хандуулах ангилалд, 9.5 хувь буюу 1.8 тэрбум төгрөгийн зээл чанаргүй ангилалд тус тус ангилагджээ.

Зураг 78. Хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн үлдэгдэл (тэрбум төгрөгөөр), тэдгээрийн нийт зээлд эзлэх хувь




Эх сурвалж: Монголбанк

2020 онд банкны систем дэх зээлийн эргэн төлөлтийн доголдол үргэлжилж, 2021 оны 06 дугаар сарын байдлаар анхаарал хандуулах ангилалтай болон чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь харгалзан 8.5 хувь, 9.5 хувь болж, эргэн төлөлтийн доголдолтой зээлийн нийт дүн 3.4 их наяд төгрөгт хүрлээ. Тухайлбал, банкны салбарын анхаарал хандуулах ангилалтай зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 29.4 хувиар, чанаргүй зээлийн хэмжээ 7.2 хувиар тус тус өссөн байна.

Тайлант сард өмнөх сартай харьцуулахад чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь **0.5 нэгж хувиар**, өмнөх оны эцсээс **1.2 нэгж хувиар** буурсан нь зээлийн чанар сайжирснаас бус харин системийн нийт зээлийн өсөлтөөр тайлбарлагдаж байна.

Зураг 79. Чанаргүй болон анхаарал хандуулах зээлийн хувь, салбараар




Эх сурвалж: Монголбанк


Эх үүсвэрийн бүтэц, өөрчлөлт

Энэ оны эхний хагас жилийн байдлаар банкны салбарын нийт эх үүсвэр 36.1 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 18.7 хувиар буюу 5.7 их наяд төгрөгөөр өслөө. Тухайлбал, иргэд, аж ахуйн нэгж, төрийн байгууллагаас татсан харилцахын үлдэгдэл 49.6 хувиар, бусад эх үүсвэр 50.0 хувиар, иргэд, аж ахуйн нэгж, төрийн байгууллагын хадгаламж 22.1 хувиар тус тус өссөн байна. Харилцах, хадгаламж нь системийн хувьд тогтвортой эх үүсвэрт тооцогддог бөгөөд түүний өсөлт нь банкны салбарын төлбөр түргэн гүйцэтгэх чадвар болон томоохон төсөл, хөтөлбөр санхүүжүүлэх чадварыг сайжруулж байдаг.

Зураг 80. Эх үүсвэрийн бүтэц, өсөлт



Жилийн өөрчлөлт (хувиар)



Эх сурвалж: Монголбанк

Харилцах дансны үлдэгдэл өсөхөд иргэд, хувийн хэвшлийн харилцах 2.2 их наяд төгрөгөөр буюу 49.6 хувиар өссөн нь голлох нөлөө үзүүлсэн байна. Хадгаламжийн өсөлтийг төрлөөр нь авч үзвэл, хугацаатай хадгаламжийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 12.9 хувиар өсөж, 14.6 их наяд төгрөгт, хугацаагүй хадгаламж 56.9 хувиар өсөж, 5.4 их наяд төгрөгт тус тус хүрчээ. Харин төгрөгийн хадгаламж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 30.3 хувиар өссөн бол валютын хадгаламж 1.2 хувиар өссөн байна.

Банкны салбарын нийт эх үүсвэрийг бүтцээр нь авч үзвэл 77.0 хувийг харилцах, хадгаламж, 14.0 хувийг банк санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр, үлдэх 9.0 хувийг банкнаас дотоод, гадаадын зах зээл дээр гаргасан үнэт цаас, төслийн санхүүжилт зэрэг бусад төрлийн эх үүсвэрүүд бүрдүүлж байна. Эх үүсвэрийн бүтцэд харилцах, хадгаламж давамгайл байр суурь эзэлсэн хэвээр байна.

ШИГТГЭЭ 13. Банкныг нээлттэй хувьцаат компани болгох үйл ажиллагаа

Монгол Улсын Их хурлын 2021 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн нэгдсэн чуулганаар баталсан “Банкны тухай хууль”-ийн нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд банкны салбарт томоохон хэмжээний шинэтгэлийг нэвтрүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлсэн юм. Уг өөрчлөлтөөр: 1) банкныг хувьцаат компани хэлбэртэйгээр өөрчлөн байгуулах, 2) банкны хувь эзэмшлийн төвлөрлийг бууруулах зохицуулалтыг нэвтрүүлж, банкны зохистой засаглал, үйл ажиллагааны ил тод болон хүртээмжтэй байдлыг сайжруулах орчинг бий болгосон.

Банк хувьцаагаа нийтэд санал болгон анх удаагаа гаргах үйл ажиллагаа буюу банкны IPO, банкны хувьцаа эзэмших зөвшөөрлийн бүдүүвч зураглал

2. ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЦУУЛГАА БҮРТГҮҮЛЭХ

Төлөвлөгөөгөө хүргүүлсний дараагаар банк Үнэт цаасны зах зээлийн тухай хуультай нийцүүлэн боловсруулсан үнэт цаасны танилцуулгаа Санхүүгийн зохицуулах хороо, үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад тус тус бүртгүүлнэ

4. АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖАА

Үнэт цаасаа нийтэд танилцуулсны дараа банк анхдагч зах зээлийн арилжааг эхлүүлнэ. Уг үйл ажиллагаа амжилттай болсон гэж Санхүүгийн зохицуулах хорооноос үзвэл хөрөнгийн хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэх, банк нээлттэй хувьцаат компани хэлбэртэйгээр өөрчлөн байгуулагдах нөхцөл бүрдэнэ

6. ХАРИЛЦАГЧ АА ТАНЬЖ МЭДЭХ

Банк, брокер, дилер нь анхдагч, хоёрдогч зах зээлийн арилжаагаар дамжуулан банкны хувьцаа эзэмшигч болох хүсэлтэй этгээдүүдийг таньж мэдэх үүргийг хүлээнэ. Ниймд ҮЦК болон банк нь өөрөө нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн талаарх мэдээллийг бүртгэж, холбогдох байгууллагад буюу үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагад нийлүүлнэ

1. ТӨЛӨВЛӨГӨӨ ИРҮҮЛЭХ

Банкныг хувьцаат компани хэлбэртэйгээр өөрчлөн байгуулах, хувь эзэмшлийн төвлөрлөө бууруулах тухай төлөвлөгөөг Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлэх

3. НИЙТЭД ТАНИЦУУЛАХ, СУРГАЛЧЛАХ


Үнэт цаасны танилцуулгаа Санхүүгийн зохицуулах хороо, үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгүүлсний дараагаар хувьцаагаа олон нийтэд танилцуулна

5. ХОЁРДОГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖАА

Аливаа этгээд үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй үнэт цаасны компаннар дамжуулан хоёрдогч зах зээлийн арилжаанд оролцоно

7. ХЯНАЛТ, ЗӨВШӨӨРӨЛ

Монголбанк болон Санхүүгийн зохицуулах хорооноос ҮЦК болон банк нь холбогдох хууль, журмын дагуу харилцагчаа таньж мэдэж байгаа эсэхэд хяналт тавьж, Монголбанкаас банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигч буюу банкны 5-аас дээш хувийг эзэмших зөвшөөрлийг олгоно. Түүнчлэн аливаа этгээд дангаар болон холбогдох этгээдийн хамт банкны нийт гаргасан хувьцааны 20-оос дээш хувийг байгаа эсэхийг Монголбанк хявана



Банкны тухай хуулийн дагуу банкныг хувьцаат компани хэлбэртэйгээр өөрчлөн байгуулах, хувь эзэмшлийн төвлөрлийг 20 хувь хүртэл бууруулах үйл ажиллагааны хүрээнд Монголбанкаас авч хэрэгжүүлэх арга хэмжээ нь дээрх зураглалд дүрсэлсэн 9 шатнаас бүрдэнэ.

I шат: Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны Даргын 2021 оны А-90/85 дугаар хамтарсан тушаалаар “Банкийг хувьцаат компани хэлбэртэйгээр өөрчлөн байгуулах, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өөрчлөх төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх, тайлагнаж, хянах түр журам” (цаашид түр журам гэх)-ыг баталсан. Энэхүү түр журмын дагуу банкны системд нөлөө бүхий банкныг 2022 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор нээлттэй хувьцаат компани, бусад банкныг хаалттай эсвэл нээлттэй хувьцаат компани хэлбэртэйгээр өөрчлөн байгуулах, 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор нэг хувьцаа эзэмшигчийн хувь эзэмшлийг 20 хувь хүртэл бууруулах төлөвлөгөөг боловсруулж, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороонд 2021 оны 7 дугаар сарын 01-ний өдрийн дотор хүргүүлэх үүрэгтэй;

II шат: Монголбанкны Ерөнхийлөгчийн 2021 оны А-104 дүгээр тушаалаар “Банкны системд нөлөө бүхий банкныг тогтоох аргачлал”-ыг баталсан. Уг аргачлалын дагуу Монголбанкны бодлого, зохицуулалтын чиг үүрэг бүхий газраас банкны системд нөлөө бүхий болон бусад банкуудыг тэдгээрийн хөрөнгө, өр төлбөрийн хэмжээ, төлбөрийн систем дэх гүйлгээний нийт дүн, үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн тогтолцоо дахь хамаарал зэрэг үзүүлэлтийг үндэслэн тогтооно. Банкны системд нөлөө бүхий болон бусад банкуудыг тогтоох нь банкны зохицуулалт, хяналт шалгалтын оновчтой байдлыг сайжруулахын зэрэгцээ аль банкууд “Банкны тухай хууль”-ийн дагуу нээлттэй хувьцаат компани болох шаардлагатайг тодорхойлох юм;

III шат: Банк хувьцаат компанийн хэлбэрт шилжин хувьцаагаа хөрөнгийн зах зээлд арилжаалж эхэлж байгаатай холбогдуулан “Хувьцаат компани хэлбэртэй банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтэцэд өөрчлөлт оруулах журам”-ын төслийг боловсруулж, Захиргааны ерөнхий хуулийн дагуу олон нийтээс санал авч байна;

IV, V шат: Монголбанк, Санхүүгийн зохицуулах хорооноос түр журмын дагуу 2021 оны 7 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлэх банкны төлөвлөгөөг хянаж, хэрэгжих боломжтой, үндэслэлтэй, хувьцаат компани хэлбэрт шилжих үйл ажиллагаа нь холбогдох хууль, журмын зохицуулалттай нийцтэй эсэхийг үнэлнэ;

VI шат: Банкны салбарын эрсдэл буюу алдагдал даах чадварыг бэхжүүлэх, уян хатан байдлыг нэмэгдүүлэх, үүгээрээ банкны салбарын тогтвортой байдлыг хангах зориулалт бүхий хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг банкууд Монголбанкны Ерөнхийлөгчийн 2017 оны А-276 дугаар тушаалын дагуу 100.0 тэрбум төгрөг хүртэл нэмэгдүүлнэ. Энэ шаардлагыг хэрхэн хэрэгжүүлэх талаар банкууд төлөвлөгөөндөө мөн тусгана;

VI, VII шат: Хуулийн дагуу банкууд 2022 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор компанийн хариуцлагын хэлбэрээ хувьцаат компани болгож өөрчилнө. Банк хаалттай эсвэл нээлттэй хувьцаат компани хэлбэрт шилжихэд дараах алхмуудыг баримтална. Үүнд:

- 1. Нээлттэй хувьцаат компани болоход:** Банк түр журмаар ирүүлсэн төлөвлөгөөг хүлээн авсан тухай мэдэгдлийг Монголбанкаас хүлээн авсны дараагаар Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хороо болон үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагын үнэт цаас бүртгэх харилцааг зохицуулсан журамд нийцүүлэн боловсруулсан үнэт цаасны танилцуулгаа эдгээр байгууллагуудад бүртгүүлнэ. Ингэснээр тухайн банкны үнэт цаас буюу хувьцааг нийтэд санал болгон анх удаагаа гаргах нөхцөл бүрдэж, хувьцаагаа анхдагч зах зээлээр дамжуулан нээлттэйгээр арилжаална. Үүний дараа тухайн банкны хувьцааны өмчлөлийн мэдээллийг үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагад бүртгэж, хоёрдогч зах зээлийн арилжаа эхлэх бөгөөд тухайн банкиг улсын бүртгэлд нээлттэй хувьцаат компанийн хэлбэрт шилжүүлэн бүртгэнэ;
- 2. Хаалттай хувьцаат компани болоход:** Дээрх түр журмын дагуу ирүүлсэн төлөвлөгөөг Монголбанк хүлээн авсан тухай мэдэгдлийг үндэслэн банк Санхүүгийн зохицуулах хорооны “Хаалттай хувьцаат компанийн тухай журам”, “Биржийн бус зах зээлийн үйл ажиллагааны журам”-ын дагуу банкиг Санхүүгийн зохицуулах хороонд, тухайн банкны үнэт цаасыг Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоонд тус тус бүртгүүлж, банкиг улсын бүртгэлд хаалттай хувьцаат компанийн хэлбэрт шилжүүлэн бүртгэнэ (хаалттай хүрээнд худалдсан хувьцааны өмчлөлийн мэдээллийг үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх байгууллага мөн бүртгэнэ).

VIII, IX шат: Банкны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсэгт аливаа этгээд дангаар болон холбогдох этгээдийн хамт эзэмших хувьцаа, хувьцаанд хамаарах үнэт цаасны хэмжээ тухайн банкны нийт гаргасан хувьцааны 20 хувиас хэтрэхгүй байхаар зохицуулсан. Энэхүү хуулийн шаардлагыг биелүүлэх зорилгоор банк болон банкны хувьцаа эзэмшигчид өөрсдийн эзэмшилд буй хувьцааг биржийн бус зах зээл, хөрөнгийн биржийн хоёрдогч зах зээлийн арилжаагаар дамжуулан худалдаж, 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор нэг хувьцаа эзэмшигчийн хувь эзэмшлийн төвлөрлийг 20 хувиас хэтрүүлэхгүй байх үүрэгтэй. Энэхүү өөрчлөлт нь банкуудын хувь эзэмшлийн хэт төвлөрлийг бууруулж, өмчлөл-хяналтын тогтолцоог сайжруулан сайн засаглал, давхар хяналтын орчинг бэхжүүлэх юм.

7.4. Банкны салбарын эрсдэл даах чадвар

Банкны системийн Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын харьцаа болон Нийт өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын харьцаа тус бүр 13.9 хувь байгаа нь Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шаардлагаас харгалзан 1.9 болон 4.9 нэгж хувиар өндөр байна. Мөн хөрвөх чадвар сайтай активыг нийт өр төлбөрт харьцуулдаг төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт 45.8 хувь байгаа нь Монголбанкнаас тогтоосон доод хязгаарлалтаас 20.8 нэгжээр, Ковид-19 цар тахалтай холбоотойгоор түр хугацаанд 20 хувь болгож бууруулан тогтоосон доод хязгаараас 25.8 нэгжээр тус тус илүү байна.


Чанаргүй зээлд байгуулах эрсдэлийн сан өндөр байсантай холбоотойгоор банкны салбар 2018 онд алдагдал хүлээсэн бол 2019 онд 186 тэрбум төгрөг, 2020 онд 38.8 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан. 2021 оны эхний хагас жилийн байдлаар банкны систем 71.5 тэрбум төгрөгийн ашигтай ажиллаж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад банкны системийн нийт орлого 11.1 хувиар, нийт зардал 21.2 хувиар тус тус буурсан байна.

Гадаад валютын ханшийн хэлбэлзлээс үүсэж болох алдагдлыг банкны эрсдэл даах чадвартай нь уялдуулах зорилгоор тэдгээрийн гадаад валютын авлага, өглөгийн зөрүү нь өөрийн хөрөнгө буюу эрсдэл даах эх үүсвэрийн +/-30 хувиас хэтрэхгүй байх зохистой харьцааг Монголбанкнаас мөрдүүлдэг бөгөөд тайлант сард энэ үзүүлэлт нь -8.0 хувь байна.

Монголбанкнаас Ковид-19 цар тахлын үед хэрэгжүүлж буй хөнгөлөлттэй зохицуулалтын арга хэмжээг хэвийн горимд шилжүүлэхэд баримталж буй зарчим

Монголбанкнаас банк, санхүүгийн салбарт Ковид-19 цар тахлын үзүүлэх сөрөг нөлөөг бууруулахад шаардлагатай арга хэмжээг дэлхийн улс орнуудын туршлага, банкны болон холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн авч хэрэгжүүлж ирлээ. Эдгээр арга хэмжээний хүрээнд 2021 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар нийт 237,083 зээлдэгчийн 7.35 их наяд төгрөгийн зээл Ковид-19-т өртөж эргэн төлөлт доголдсон байснаас 68 хувь буюу 185,671 зээлдэгчийн нийт 5.2 их наяд төгрөгийн зээлд бүтцийн өөрчлөлт хийгдсэн байна.

Зураг 81. Ковид-19-т өртсөн зээл болон бүтэц өөрчилсөн зээл



Эх сурвалж: Монголбанк

Банкны салбар дахь хөнгөлөлттэй зохицуулалтын арга хэмжээнүүдийн хэрэгжилт нь **2021 оны 7 дугаар сарын 1-ний** өдрөөр дуусгавар болсон бөгөөд Монголбанкнаас эдгээр арга хэмжээг хэрхэн хэвийн горимд шилжүүлэх талаарх төлөвлөгөөг цар тахлын болон эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан, богино, дунд, урт хугацаанд банкны системд төлбөрийн чадварын дарамт үүсгэхгүй байхаар боловсруулж хэрэгжүүлээд байна.

Тухайлбал, эдийн засаг болон банкны салбар дахь цар тахлын нөлөө буурахгүй байгааг харгалзан Монголбанкнаас түр хугацаагаар мөрдүүлж буй хөнгөлөлттэй зохицуулалтыг **2022 оны 3 дугаар сарын 31-ний** өдрийг хүртэл урьдчилан тогтоосон хуваарийн дагуу хэсэгчлэн сунгахаар шийдвэрлэсэн. Үүнд:

- Зээлийн чанарын ангиллыг бууруулах хугацаа хэтэрсэн хоногийг /90 хоног болгосон байгааг/ 2021 оны 8 дугаар сараас 75 хоног, 2021 оны 10 дугаар сараас 60 хоног, 2021 оны 12 дугаар сараас 45 хоног, 2022 оны 02 дугаар сараас 30 хоног, 2022 оны 4 дүгээр сараас 15 хоног болгож, хэвийн горимд аажмаар шилжүүлэх;
- Банкуудад түр хугацаанд мөрдүүлж байсан төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцаа болон экспортын аккредитивт хамаарах хөнгөлөлттэй зохицуулалтыг тус тус хэвийн горимд шилжүүлэх юм.

Ингэснээр банкуудад зээлдэгчдийн зээлийн эргэн төлөх нөхцөлийг дахин өөрчлөх, эргэн төлөлтийн доголдолтой зээлийн ангилал, зээлийн түүхийг түр хугацаанд бууруулахгүй, дордуулахгүй байх эсэхийг бие даан шийдвэрлэх боломжийг нээлттэй үлдээсэн.

Банкуудад хяналт шалгалтын хүрээнд мөрдүүлж буй дээрх журам, зааварт түр хугацааны хөнгөлөлттэй зохицуулалтуудыг хэсэгчилсэн байдлаар үргэлжлүүлэх нь банкны салбарын тогтвортой байдлыг хадгалах, системийн эрсдэлийг бууруулах, төлбөрийн чадварыг хангахад эерэг нөлөөтэй.

Цаашид Монголбанкны зүгээс хөнгөлөлттэй зохицуулалтын арга хэмжээний төлөвлөгөөнд цар тахлын болон эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан тухай бүр зохих тохируулгыг хийж ажиллах болно. Энэ нь банкны салбарын тогтвортой байдлыг хадгалах, системийн эрсдэлийг бууруулах, төлбөрийн чадварыг ханган ажиллах, эрсдэлээс хамгаалах нөөц, хөрөнгийн хуваарилалтыг зохистой түвшинд хадгалах, төлбөрийн чадварын дарамт үүсгэхгүй байх зорилттой уялдах юм.

СТАТИСТИКИЙН ХАВСРАЛТУУД

I. ИНФЛЯЦ							(хувь)
	Инфляцын зорилт	Жилийн инфляц (Улс)	Жилийн инфляц (УБ)	Үүнээс:		Сарын инфляц (УБ)	
				Хүнсний инфляц	Хүнсний бус инфляц		
2000			8.1	14.7	3.4	2.1	
2001			9.2	16.1	(5.0)	1.7	
2002	8.0		2.0	(1.8)	4.3	1.5	
2003	5.0		4.2	8.7	1.7	0.9	
2004	5.0		10.5	15.9	7.3	0.7	
2005	5.0		8.7	16.2	2.2	1.1	
2006	7.0		4.8	2.2	6.3	0.4	
2007	5.0	16.0	14.1	24.6	8.2	0.5	
2008	6.0	11.4	23.2	24.5	22.4	(0.5)	
2009	10.0	4.3	1.9	(0.5)	3.4	0.2	
2010	8.0	13.0	14.3	20.6	10.3	2.4	
2011	10.0	10.2	9.4	7.6	10.2	0.7	
2012	10.0	12.7	14.2	19.9	11.8	0.7	
2013	I	8.0	9.3	9.1	9.5	9.3	0.8
	II	8.0	8.3	7.3	9.2	6.8	(0.4)
	III	8.0	9.1	7.7	9.7	7.8	1.2
	IV	8.0	11.9	12.0	14.0	11.5	1.8
2014	I	8.0	12.4	11.9	10.0	12.8	0.5
	II	8.0	14.6	15.1	13.4	15.9	0.5
	III	8.0	13.0	13.6	11.3	14.7	1.0
	IV	8.0	11.0	10.7	6.9	12.4	0.6
2015	I	7.0	9.3	8.1	3.7	11.4	0.4
	II	7.0	7.3	5.9	2.7	9.6	(0.0)
	III	7.0	4.9	3.6	(1.3)	6.0	(0.7)
	IV	7.0	1.9	0.6	(7.2)	4.1	(0.1)
2016	I	7.0	0.8	0.7	(3.0)	2.7	0.4
	II	7.0	1.2	1.2	(2.5)	2.6	(0.3)
	III	7.0	(0.0)	(0.2)	(3.4)	0.3	(0.7)
	IV	7.0	1.3	0.8	1.4	0.2	0.7
2017	I	8.0	3.1	3.0	3.5	1.9	1.6
	II	8.0	3.4	3.5	1.1	4.5	(0.6)
	III	8.0	5.8	6.6	9.2	5.8	0.5
	IV	8.0	6.4	7.2	7.9	7.0	0.3
2018	I	8.0	6.6	7.7	6.0	8.3	1.2
	II	8.0	7.2	8.0	11.3	6.7	0.7
	III	8.0	5.7	5.9	3.5	6.8	(0.0)
	IV	8.0	8.1	9.7	10.2	9.5	0.7
2019	I	8.0	6.7	7.5	7.7	7.4	0.8
	II	8.0	8.3	9.8	11.7	9.1	1.5
	III	8.0	9.0	10.5	18.1	7.8	(0.0)
	IV	8.0	5.2	5.0	8.0	4.0	0.6
2020	I	8.0	6.4	6.8	11.3	5.1	0.7
	II	8.0	2.8	2.4	4.2	1.7	0.4
	III	8.0	1.7	1.4	0.9	1.6	(0.3)
	IV	8.0	2.3	1.9	9.0	(0.7)	(1.7)
2021	I	6.0	2.5	2.0	8.9	(0.7)	0.7
	II	6.0	6.6	7.1	13.1	4.7	0.9
7 сар	6.0	7.4	7.9	11.0	6.6	1.4	
8 сар	6.0	8.9	9.1	12.8	7.7	0.1	

Үргэлжлэл: Жилийн инфляцын бүрэлдэхүүн				(өсөлтөд үзүүлэх нөлөө, хувь)				
	Мах	Хүнсний ногоо	Шатахуун	Хатуу түлш	Суудлын автомашин	Бусад импорт	Бусад	
2000	0.9	(0.2)	(0.0)				7.4	
2001	0.9	0.2	0.1				8.0	
2002	(0.0)	0.6	0.1				1.4	
2003	1.5	(1.3)	0.2				3.9	
2004	1.8	0.8	0.3				7.6	
2005	3.6	0.7	0.3				4.1	
2006	(0.1)	(0.0)	0.2				4.7	
2007	2.6	0.6	0.4	0.6	0.1	1.4	8.4	
2008	1.5	1.8	0.2	0.5	0.1	4.3	14.7	
2009	(0.9)	(0.0)	0.1	(0.5)	(0.0)	1.2	2.1	
2010	3.1	0.6	(0.1)	(0.1)	0.1	3.2	7.5	
2011	1.5	0.1	0.8	0.8	-	2.6	3.5	
2012	4.0	0.3	0.4	0.2	0.5	2.5	6.4	
2013	I	1.5	0.3	0.1	0.4	0.0	1.8	5.0
	II	1.5	0.1	0.1	(0.1)	0.3	1.4	4.0
	III	1.2	(0.0)	0.1	(0.5)	0.0	1.7	5.3
	IV	1.2	0.2	-	(0.0)	(0.3)	3.1	7.6
2014	I	0.3	0.1	(0.0)	0.3	(0.2)	3.4	8.1
	II	0.8	0.2	0.1	0.9	(0.2)	4.0	9.3
	III	0.0	0.3	0.1	1.3	0.5	3.3	8.2
	IV	0.0	0.1	0.1	1.2	0.5	1.9	6.9
2015	I	(0.6)	0.2	(0.0)	1.1	0.4	1.9	5.1
	II	(0.8)	0.1	-	1.4	0.4	1.1	3.6
	III	(1.1)	0.3	-	1.1	-	0.3	3.0
	IV	(2.1)	0.2	-	0.1	-	0.5	1.9
2016	I	(0.9)	0.1	(0.3)	(0.2)	(0.1)	0.3	1.7
	II	(0.7)	0.2	(0.4)	(0.5)	(0.1)	0.5	2.0
	III	(0.7)	(0.3)	(0.4)	(0.6)	(0.0)	0.9	0.9
	IV	0.2	(0.3)	(0.4)	0.1	(0.0)	0.2	1.1
2017	I	0.3	(0.2)	0.1	0.3	0.3	0.2	1.9
	II	(0.5)	(0.5)	0.3	0.3	0.9	0.7	2.3
	III	0.5	0.7	0.3	0.7	1.0	0.8	2.7
	IV	0.2	0.4	0.2	0.7	1.0	1.6	3.1
2018	I	0.1	0.3	0.4	1.9	0.5	1.5	3.1
	II	0.8	1.0	0.5	1.7	(0.1)	0.8	3.2
	III	0.4	(0.4)	0.9	1.3	(0.4)	1.0	3.1
	IV	1.7	(0.2)	1.3	2.4	(0.3)	1.3	3.5
2019	I	1.5	(0.1)	0.5	0.9	(0.1)	1.8	3.1
	II	3.0	(0.3)	0.6	0.9	(0.3)	2.5	3.5
	III	3.4	0.4	0.2	0.8	(0.2)	2.4	3.4
	IV	1.2	0.1	(0.1)	(0.4)	(0.2)	1.7	2.8
2020	I	2.1	0.3	0.2	(0.0)	0.0	1.6	2.6
	II	0.5	0.2	(1.2)	0.1	0.2	1.0	1.7
	III	(0.3)	(0.3)	(1.1)	0.3	0.3	1.0	1.5
	IV	1.1	0.4	(1.0)	(1.6)	0.4	1.0	1.7
2021	I	0.9	0.2	(0.9)	(1.3)	0.2	0.7	2.2
	II	2.1	0.1	0.4	0.5	0.5	0.9	2.6
	7 сар	1.8	(0.1)	1.7	0.5	0.5	0.9	2.6
8 сар	1.6	0.5	1.7	0.8	0.6	0.9	3.1	

II. БОДИТ СЕКТОР		<i>(өсөлтөд үзүүлэх нөлөө, хувь)</i>						
	Эдийн засгийн өсөлт (нийт эрэлт)	Үүнээс:						
		Өрхийн хэрэглээ	ЗГ-ын хэрэглээ	Үндсэн хөрөнгийн хуримтлал	Материаллаг хөрөнгийн өөрчлөлт	Экспорт	Импорт	
2006	12.5	7.8	1.1	12.9	-9.0	3.3	-3.6	
2007	7.0	8.3	1.3	2.9	3.8	2.0	-11.3	
2008	8.6	10.7	0.1	1.8	4.4	2.1	-10.4	
2009	-1.3	1.2	0.1	-8.5	-3.6	8.7	0.9	
2010	6.5	5.1	1.0	6.2	4.2	1.7	-11.7	
2011	17.5	6.1	1.5	17.4	6.1	4.3	-17.9	
2012	12.5	5.1	2.1	4.3	4.8	1.8	-5.6	
2013	I	8.1	8.4	3.5	-0.7	-7.6	6.0	-1.6
	II	8.8	11.3	2.6	-4.9	-3.4	5.9	-2.6
	III	10.4	9.6	3.0	-2.1	-2.6	6.2	-3.7
	IV	11.6	8.0	1.9	-2.8	4.7	3.6	-3.8
2014	I	9.2	4.8	1.9	-0.9	-1.8	14.3	-9.1
	II	7.1	6.8	3.2	-7.3	-3.4	12.0	-4.3
	III	7.8	8.4	2.4	-9.3	-2.7	13.6	-4.7
	IV	8.1	8.4	3.3	-4.9	-9.4	18.3	-7.7
2015	I	4.0	20.1	4.1	-7.8	-29.0	22.9	-6.4
	II	2.3	10.5	1.7	-5.6	-12.5	11.0	-2.9
	III	4.6	9.3	1.0	-6.1	-7.9	6.5	1.8
	IV	2.5	7.7	-0.1	-7.1	-4.1	2.4	3.7
2016	I	2.8	7.0	2.9	3.0	-4.3	-2.8	-3.0
	II	1.5	0.4	1.9	2.7	0.0	0.5	-4.0
	III	-1.3	-0.3	2.5	0.1	1.4	1.2	-6.3
	IV	1.5	1.1	2.0	1.4	-1.8	6.9	-8.0
2017	I	5.8	-0.1	-0.8	1.8	12.7	8.7	-16.4
	II	5.7	0.7	0.1	4.1	1.2	6.1	-6.5
	III	6.5	2.5	-0.9	4.0	-0.8	7.1	-5.4
	IV	5.6	2.7	-0.4	5.5	2.0	1.9	-6.1
2018	I	6.5	16.3	0.9	10.7	4.5	5.1	-31.2
	II	7.1	9.9	0.2	8.4	5.8	8.6	-25.8
	III	6.7	6.7	0.0	9.7	6.8	5.2	-21.7
	IV	7.6	7.2	0.2	7.5	7.9	3.0	-18.2
2019	I	8.6	3.8	1.4	7.6	-6.1	2.1	-0.2
	II	7.7	3.2	1.8	5.4	-3.6	3.3	-2.4
	III	7.1	3.9	1.8	5.1	-5.0	6.7	-5.4
	IV	5.5	3.7	1.8	4.0	-4.0	5.8	-5.9
2020	I	-7.3	5.3	2.0	-4.5	1.4	-23.3	11.8
	II	-7.5	4.3	1.6	-6.2	-2.5	-14.6	9.9
	III	-6.0	3.9	1.9	-4.6	-6.5	-11.0	10.3
	IV	-4.4	1.3	2.2	-6.6	-9.6	-2.7	11.0
2021	I	15.1	-10.6	-2.2	3.3	5.2	27.7	-8.2
	II	6.2	-7.1	-1.5	3.2	9.3	6.1	-3.7

Үргэлжлэл:		(тэрбум төгрөг)							
	Нэрлэсэн дотоодын нийт бүтээгдэхүүн		Үүнээс:				Экспорт	Импорт	
	тэрбум төгрөг	сая ам.доллар	Өрхийн хэрэглээ	ЗГ-ын хэрэглээ	Үндсэн хөрөнгийн хуримтлал	Материаллаг хөрөнгийн өөрчлөлт			
2006	4,060.9	3,442.3	1,949.4	426.3	1,341.3	104.0	2,394.1	2,154.2	
2007	5,042.5	4,308.3	2,458.6	598.6	1,740.2	178.3	2,954.9	2,888.0	
2008	6,639.3	5,695.1	3,686.4	959.9	2,374.1	481.9	3,541.1	4,404.1	
2009	6,568.4	4,568.4	3,851.3	930.2	1,904.0	361.3	3,313.6	3,792.0	
2010	9,756.6	7,185.1	5,387.3	1,237.9	3,364.7	741.6	4,554.3	5,529.2	
2011	13,173.8	10,409.8	6,782.7	1,614.5	6,377.7	1,282.9	6,923.3	9,807.3	
2012	16,688.4	12,277.8	8,848.0	2,257.4	7,529.2	1,799.4	7,271.5	11,017.1	
2013	I	3,333.9	2,386.4	2,223.5	536.4	1,131.2	231.8	1,239.3	2,028.3
	II	8,409.4	5,932.9	5,154.4	1,161.5	3,185.9	858.5	3,190.2	5,141.1
	III	13,408.6	9,119.2	7,771.9	1,772.7	5,882.7	1,400.6	5,260.6	8,679.8
	IV	19,174.2	12,513.6	10,699.0	2,580.3	7,528.5	2,686.7	7,456.9	11,777.2
2014	I	4,164.1	2,384.6	2,656.6	577.0	1,159.3	273.3	1,931.1	2,433.4
	II	10,007.6	5,617.9	6,298.3	1,343.0	2,724.5	874.3	4,887.2	6,119.6
	III	16,172.3	8,955.0	9,798.3	1,941.0	4,555.8	1,283.1	8,139.1	9,545.0
	IV	22,227.1	12,191.3	12,587.6	2,893.3	6,351.1	1,467.3	11,613.4	12,685.7
2015	I	4,358.2	3,050.7	3,103.1	739.3	517.5	(291.7)	2,386.0	2,095.9
	II	10,346.9	5,270.3	7,104.2	1,651.5	1,550.0	151.1	4,974.5	5,084.4
	III	16,768.9	8,269.4	10,890.2	2,397.3	2,953.9	568.7	7,720.8	7,762.1
	IV	22,894.8	11,487.6	14,171.9	3,404.9	4,184.5	1,427.9	10,115.8	10,410.2
2016	I	4,596.5	2,989.8	3,374.8	844.3	617.9	(333.9)	2,234.0	2,140.5
	II	10,707.7	5,308.7	7,143.1	1,805.4	1,769.2	274.0	5,000.5	5,284.5
	III	16,886.2	7,980.5	10,871.0	2,771.7	2,901.8	835.2	8,017.6	8,511.1
	IV	23,931.3	10,462.3	14,532.6	3,818.3	4,466.7	948.8	12,174.4	12,009.5
2017	I	5,457.9	2,878.6	3,485.4	827.0	769.6	149.0	3,401.7	3,174.8
	II	13,135.2	5,201.2	7,487.1	1,872.4	2,446.9	451.2	8,034.1	7,156.4
	III	20,060.1	8,316.4	11,711.9	2,705.1	3,918.7	761.0	12,361.6	11,398.1
	IV	28,010.7	11,168.3	15,760.1	3,901.6	6,260.1	1,416.6	16,573.0	15,900.6
2018	I	6,516.3	3,322.8	4,505.3	912.1	1,379.6	462.1	3,754.7	4,497.6
	II	15,085.9	5,968.6	9,108.2	1,973.9	3,621.4	1,319.6	9,220.6	10,157.9
	III	23,169.7	9,326.4	13,751.5	2,825.2	6,094.2	2,370.6	14,162.3	16,034.1
	IV	32,582.6	12,384.2	18,883.4	4,135.7	8,747.0	4,083.4	18,951.6	22,218.5
2019	I	7,665.2	3,577.0	5,075.4	1,090.9	1,949.8	31.1	4,974.3	5,456.3
	II	17,652.6	6,461.1	10,372.3	2,399.2	4,636.4	639.4	11,213.5	11,608.1
	III	27,399.3	10,205.6	15,886.2	3,449.4	7,657.3	1,127.3	17,490.7	18,211.7
	IV	37,839.2	13,770.2	21,667.6	4,960.0	10,588.7	2,879.0	22,407.4	24,663.3
2020	I	7,133.6	3,758.4	5,707.7	1,268.1	1,768.7	234.9	2,836.2	4,681.9
	II	17,134.2	6,284.6	11,424.8	2,744.7	3,932.1	579.5	8,082.0	9,628.8
	III	27,279.4	9,787.8	17,281.0	4,040.7	6,931.2	(500.3)	14,707.7	15,181.0
	IV	37,883.1	13,347.6	22,648.6	5,921.5	8,830.8	(447.4)	21,595.7	20,666.1
2021	I	9,085.0	3,720.8	5,194.0	1,122.1	2,028.6	462.4	5,930.0	5,652.1
	II	19,563.9	6,909.8	10,832.8	2,549.3	4,851.6	1,701.2	11,325.0	11,696.0

Үргэлжлэл:		(жилийн өсөлт, хувь)						
		Эдийн засгийн өсөлт (нийт нийлүүлэлт)	Үүнээс:			Хөдөө аж ахуйн		
	УУ-н өсөлт		Боловсруулах	Хөдөө аж ахуйн	Худалдаа	Барилга	Бусад	
2001		4.6	8.8	36.7	-19.2	6.7	13.4	8.6
2002		5.4	-6.0	24.6	-11.0	25.8	22.9	8.9
2003		7.3	-1.0	14.8	4.8	9.8	50.8	6.6
2004		9.5	30.4	-3.8	16.3	-5.9	-6.2	6.4
2005		6.4	11.7	-18.9	11.3	2.4	16.4	6.9
2006		8.1	6.8	13.5	6.5	13.3	4.0	7.8
2007		8.8	0.1	27.4	14.4	6.8	7.8	9.6
2008		7.8	-1.6	1.9	4.7	14.9	-13.9	16.0
2009		-2.1	6.2	-8.6	3.6	-13.1	-34.0	-1.6
2010		7.3	3.1	5.6	-16.6	44.9	17.5	9.7
2011		17.3	7.8	7.9	-0.4	45.9	22.9	19.8
2012		12.3	8.4	8.7	21.1	12.1	85.3	8.5
2013	I	7.5	6.8	17.0	35.4	-15.0	-5.4	13.1
	II	8.7	5.6	8.1	20.0	-10.7	70.8	11.1
	III	12.6	12.8	17.1	18.9	-4.8	91.4	11.6
	IV	11.6	18.2	10.2	19.2	8.5	8.4	8.4
2014	I	7.5	19.8	-12.2	13.9	-2.8	23.0	7.3
	II	8.5	11.7	0.1	30.9	6.9	-1.7	4.1
	III	9.1	20.9	4.3	25.2	8.3	-12.8	3.1
	IV	7.9	19.2	4.1	14.0	2.5	-4.2	4.5
2015	I	4.2	-18.7	34.7	17.0	-19.8	35.7	15.0
	II	3.2	-16.8	26.6	16.3	-21.0	5.4	10.9
	III	2.3	-17.8	26.3	17.6	-18.3	-5.6	11.3
	IV	2.4	-16.9	24.3	18.7	-15.5	8.7	10.4
2016	I	2.6	13.7	-16.7	3.9	-2.1	43.0	1.5
	II	1.6	6.5	-16.3	4.3	2.7	17.3	0.5
	III	-0.9	-2.3	-12.0	3.5	-5.4	-5.6	1.2
	IV	1.5	-1.6	-7.2	5.4	-0.2	-0.4	3.5
2017	I	5.8	-5.4	15.9	1.8	18.9	-27.9	7.6
	II	5.9	-4.7	15.4	1.1	13.6	-14.6	9.8
	III	6.2	0.6	15.2	1.5	10.3	-12.8	9.0
	IV	5.6	-3.9	16.4	-0.3	8.2	-1.3	9.6
2018	I	6.3	3.8	10.5	4.6	3.9	14.2	7.0
	II	6.9	3.1	17.4	3.5	4.8	-4.2	8.8
	III	7.0	1.2	13.5	4.4	2.4	-3.7	10.4
	IV	7.7	5.4	19.5	6.5	0.1	1.8	9.5
2019	I	8.6	15.5	4.3	1.1	16.4	14.3	6.2
	II	7.6	12.2	1.2	2.0	16.0	15.6	6.7
	III	6.8	6.4	2.6	1.2	14.4	16.8	7.1
	IV	5.6	-1.6	3.8	5.2	10.9	20.3	6.1
2020	I	-10.1	-32.9	1.2	12.0	-13.6	13.0	-5.6
	II	-9.0	-31.5	-5.9	12.4	-15.1	-1.8	-7.8
	III	-6.7	-22.1	-5.8	10.8	-14.8	-1.9	-5.8
	IV	-4.6	-9.9	3.4	5.8	-12.5	-3.2	-5.4
2021	I	14.8	39.3	24.6	-4.5	8.1	-6.3	11.5
	II	6.3	24.3	12.7	-4.6	7.8	-39.7	7.4

Үргэлжлэл:			(тэрбум төгрөг)						
	Нэрлэсэн дотоодын нийт бүтээгдэхүүн		Үүнээс:						
	тэрбум төгрөг	сая ам.доллар	Уул уурхай	Боловсруулах	Хөдөө аж ахуйн	Худалдаа	Барилга	Бусад	
2006	4,027.6	3,414.1	1,145.7	218.9	710.6	271.5	86.8	1,594.0	
2007	4,956.6	4,235.0	1,340.9	309.5	913.4	313.2	106.4	1,973.3	
2008	6,555.6	5,623.2	1,324.2	430.2	1,259.7	472.2	122.1	2,947.2	
2009	6,590.6	4,583.9	1,285.9	425.0	1,177.4	432.6	86.2	3,183.5	
2010	9,756.6	7,185.1	2,102.2	664.8	1,144.7	1,199.0	250.2	4,395.7	
2011	13,173.8	10,409.8	2,536.2	931.4	1,357.9	1,973.3	402.8	5,972.2	
2012	16,688.4	12,277.8	2,742.8	1,248.7	1,878.8	2,231.1	837.5	7,749.6	
2013	I	3,508.1	2,511.1	681.9	301.5	107.9	370.4	34.1	2,012.3
	II	8,585.6	6,059.0	1,374.2	701.6	1,183.0	781.0	281.6	4,264.1
	III	13,867.4	9,425.3	2,212.2	1,136.7	1,919.6	1,386.4	779.4	6,433.0
	IV	19,174.2	12,549.7	2,849.4	1,672.3	2,572.0	2,267.2	979.7	8,833.5
2014	I	4,222.1	2,417.8	859.4	371.0	168.5	381.6	38.2	2,403.4
	II	10,192.4	5,721.3	1,668.5	828.7	1,511.6	852.0	283.0	5,048.6
	III	16,559.2	9,124.4	2,812.7	1,434.7	2,410.9	1,527.5	713.7	7,659.8
	IV	22,227.1	12,015.8	3,661.0	1,950.9	2,965.4	2,544.8	989.0	10,116.0
2015	I	4,438.21	2,235.87	937.94	395.76	175.48	386.65	45.11	2,497.26
	II	10,379.55	5,261.00	1,761.05	720.33	1,615.50	842.38	277.13	5,163.15
	III	16,702.43	8,427.19	2,840.26	1,186.42	2,673.38	1,492.51	590.09	7,919.76
	IV	22,894.78	11,529.57	4,150.46	1,606.18	3,223.41	2,664.77	918.31	10,331.63
2016	I	4,586.42	2,238.37	942.00	385.28	193.02	371.08	64.20	2,630.84
	II	10,827.42	5,387.21	1,785.32	700.86	1,776.87	841.55	319.29	5,403.53
	III	17,039.19	8,103.33	2,997.15	1,189.48	2,540.28	1,372.10	542.29	8,397.89
	IV	23,931.34	10,871.26	4,822.68	1,595.62	3,022.01	2,621.29	902.89	10,966.85
2017	I	5,725.53	2,339.82	1,675.39	444.89	202.25	456.33	44.06	2,902.61
	II	13,021.23	5,444.37	3,063.61	799.23	1,840.07	983.69	259.00	6,075.63
	III	20,262.23	8,383.09	4,967.74	1,324.87	2,613.67	1,585.21	457.27	9,313.47
	IV	28,010.71	11,574.39	7,007.87	1,932.25	3,119.63	2,867.79	905.58	12,177.59
2018	I	6,692.97	2,796.90	2,073.62	488.81	238.30	516.94	51.84	3,323.47
	II	15,435.89	6,346.60	3,929.46	909.19	2,187.12	1,130.59	265.96	7,013.57
	III	23,705.26	9,586.95	5,967.99	1,569.08	3,122.47	1,783.76	474.49	10,787.46
	IV	32,582.63	12,944.50	8,370.79	2,298.13	3,723.54	3,090.23	985.72	14,114.22
2019	I	7,972.02	3,028.88	2,627.47	539.85	255.23	652.18	65.29	3,831.99
	II	17,942.80	6,780.12	4,672.45	1,013.09	2,367.86	1,407.82	343.33	8,138.25
	III	27,619.04	10,408.25	7,236.70	1,752.63	3,346.54	2,187.43	617.36	12,478.38
	IV	37,839.23	14,146.44	9,590.14	2,675.07	4,373.60	3,644.11	1,328.92	16,227.39
2020	I	7,457.24	2,684.39	1,905.73	585.35	296.36	622.08	83.94	3,963.78
	II	16,958.40	6,048.83	3,394.62	969.02	2,739.80	1,299.29	363.66	8,192.02
	III	26,579.16	9,418.62	5,682.49	1,681.92	3,871.32	2,023.09	660.31	12,660.04
	IV	37,453.28	13,234.10	8,722.07	2,904.95	4,856.06	3,436.81	1,367.53	16,165.87
2021	I	9,186.54	3,223.35	2,980.72	759.65	303.40	691.21	84.48	4,367.07
	II	19,672.71	6,904.00	4,890.35	1,327.44	2,809.33	1,474.40	277.98	8,893.19

III. МӨНГӨНИЙ ТОЙМ				(тэрбум төгрөг)					
	М2	ГЦА	ДЦА	Үүнээс:					
				ЗГЦЗ	Иргэдээс авах авлага	Хувийн сектороос авах авлага	Бусад байгууллагаас авах авлага	Бусад цэвэр зүйлс	
2000	259	201.7	57.1	17.2		45.5	22.2	(27.7)	
2001	331	220.2	110.9	(6.8)		114.7	21.4	(18.4)	
2002	470	308.5	161.6	(32.4)		203.6	28.9	(38.4)	
2003	703	256.3	447.0	96.7		365.0	52.9	(67.6)	
2004	847	311.0	536.0	40.5	210.9	365.1	30.8	(111.3)	
2005	1,140	570.2	552.7	(108.1)	321.6	489.1	49.2	(199.1)	
2006	1,537	1,131.8	404.7	(496.5)	507.6	659.0	56.7	(322.1)	
2007	2,401	1,352.0	1,049.2	(744.1)	838.8	1,166.1	51.1	(262.7)	
2008	2,267	672.7	1,594.8	(595.3)	1,013.7	1,570.4	51.5	(445.5)	
2009	2,879	1,514.5	1,365.0	(741.1)	904.9	1,716.3	33.9	(549.0)	
2010	4,679	2,722.9	1,955.8	(855.7)	1,370.1	1,854.8	40.8	(454.2)	
2011	6,411	3,046.9	3,364.3	(1,390.8)	2,454.8	3,064.5	124.0	(888.3)	
2012	7,612	4,351.5	3,260.3	(3,060.2)	3,100.9	3,828.1	63.2	(671.7)	
2013	I	7,299	3,852.6	3,446.1	(3,030.8)	3,370.5	3,961.4	53.3	(908.2)
	II	8,002	2,681.0	5,320.6	(2,553.4)	3,813.5	4,727.2	69.2	(735.9)
	III	8,477	1,827.2	6,649.4	(2,293.5)	4,569.3	5,489.5	321.8	(1,437.6)
	IV	9,453	766.7	8,685.8	(976.1)	4,665.3	5,998.8	423.1	(1,425.3)
2014	I	9,947	241.9	9,705.5	(671.9)	5,080.1	6,202.3	884.9	(1,790.0)
	II	10,105	(946.5)	11,051.4	(282.3)	5,604.4	6,590.9	816.2	(1,677.8)
	III	10,072	(1,267.7)	11,339.8	(306.6)	5,779.6	6,654.9	1,081.9	(1,870.0)
	IV	10,634	(2,008.9)	12,643.2	82.5	5,711.5	6,980.2	1,426.1	(1,557.1)
2015	I	9,902	(3,364.2)	13,266.4	289.4	5,541.9	6,976.2	1,774.8	(1,315.9)
	II	10,040	3,320.2)	13,360.2	430.6	5,463.8	6,745.0	1,624.4	(903.6)
	III	9,933	(4,064.6)	13,997.8	606.0	5,336.2	6,750.5	2,277.5	(972.5)
	IV	10,049	(4,218.3)	14,267.3	661.2	5,037.0	6,760.8	2,670.5	(862.1)
2016	I	10,112	(4,358.3)	14,470.8	(17.7)	5,122.6	6,814.4	943.0	1,608.4
	II	11,186	(3,606.6)	14,792.9	(45.9)	5,286.2	7,281.9	954.9	1,315.7
	III	11,557	(4,467.8)	16,023.7	375.3	5,572.0	7,498.8	603.9	1,973.7
	IV	12,159	(5,003.2)	17,161.9	1,850.6	5,689.8	7,324.1	2,498.1	(200.7)
2017	I	12,259	(5,265.7)	17,525.0	2,081.2	5,945.7	7,345.9	2,439.2	(286.9)
	II	13,483	4,312.4)	17,795.6	1,926.3	6,125.5	7,334.8	2,812.6	(403.5)
	III	14,750	(3,797.3)	18,547.0	1,488.7	6,618.8	7,416.3	2,820.3	202.9
	IV	15,861	(1,252.5)	17,113.7	(365.6)	6,716.8	7,454.4	3,107.0	201.1
2018	I	16,074	(1,469.7)	17,543.7	(260.5)	7,086.9	7,613.1	3,198.6	(94.4)
	II	17,343	(1,238.8)	18,581.6	(568.9)	7,590.5	8,340.3	3,282.4	(62.7)
	III	17,920	1,437.1)	19,357.3	(1,075.0)	8,229.2	8,639.6	3,421.2	142.3
	IV	19,475	248.9	19,225.8	(1,345.8)	9,055.8	8,594.1	3,259.5	(337.8)
2019	I	19,700	1,017.8	18,681.8	(1,775.1)	9,205.2	8,563.7	3,343.1	(655.1)
	II	20,229	2,084.5	18,144.9	(2,414.6)	9,541.0	8,976.2	3,046.7	(1,004.3)
	III	20,433	2,805.5	17,627.4	(3,021.9)	9,433.8	9,018.2	3,046.2	(848.9)
	IV	20,834	2,975.1	17,858.7	(3,081.2)	9,430.2	8,857.5	3,025.7	(373.6)
2020	I	20,451	2,642.0	17,809.8	(2,956.5)	8,635.3	8,699.0	3,577.6	(145.5)
	II	21,347	2,878.1	18,470.0	(2,030.7)	8,848.1	8,563.6	3,723.5	(634.5)
	III	22,426	3,896.6	18,529.3	(1,602.6)	8,926.2	8,317.5	3,827.9	(939.7)
	IV	24,220	5,555.7	18,664.3	(2,169.6)	8,704.2	8,207.7	3,945.2	(23.1)
2021	I	25,136	6,551.1	18,584.9	(2,874.5)	9,021.8	8,337.8	4,004.4	95.3
	II	27,719	6,242.7	21,476.6	(1,525.2)	9,517.4	9,316.3	4,168.7	(0.7)
	7 сар	27,149	5,570.3	21,578.2	(1,769.1)	9,673.2	9,389.6	4,213.8	70.7
8 сар	27,147	4,972.2	22,174.4	(1,793.3)	10,050.1	9,434.0	4,366.1	117.5	

Үргэлжлэл:	(тэрбум төгрөг)							
			Үүнээс:			Үүнээс:		
	M2	M1	Хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө	Төгрөгийн харилцах	Бусад хадгаламж	Төгрөгийн хадгаламж	Гадаад валютын хадгаламж	Гадаад валютын харилцах
2000	259	131	101	30	128	59	34	35
2001	331	156	109	47	175	88	47	40
2002	470	188	121	67	283	147	71	64
2003	703	213	132	81	491	240	123	127
2004	847	221	144	78	626	301	216	108
2005	1,140	269	152	117	871	426	246	199
2006	1,537	332	185	147	1,205	692	303	209
2007	2,401	590	283	307	1,811	1,114	376	321
2008	2,267	647	329	319	1,620	899	438	284
2009	2,879	651	285	366	2,228	1,234	622	372
2010	4,679	1,157	388	769	3,521	2,001	754	765
2011	6,411	1,741	517	1,223	4,670	2,912	977	781
2012	7,612	1,835	603	1,231	5,777	3,485	1,433	859
I	7,299	1,589	483	1,106	5,710	3,699	1,186	825
II	8,002	2,026	600	1,426	5,975	3,940	1,099	936
2013	8,477	2,014	597	1,416	6,463	4,084	1,237	1,141
IV	9,453	2,093	582	1,511	7,360	4,911	1,475	974
I	9,947	1,737	550	1,187	8,210	5,184	1,996	1,029
II	10,105	1,862	571	1,291	8,243	5,692	1,445	1,105
2014	10,072	1,836	536	1,300	8,236	5,218	1,754	1,264
IV	10,634	1,816	499	1,317	8,818	5,410	1,969	1,439
I	9,902	1,446	391	1,055	8,456	5,188	2,181	1,087
II	10,040	1,664	431	1,234	8,376	5,293	2,018	1,065
2015	9,933	1,614	407	1,206	8,320	5,183	2,094	1,043
IV	10,049	1,685	459	1,227	8,364	5,434	1,948	982
I	10,112	1,584	427	1,157	8,529	5,467	2,104	958
II	11,186	1,982	562	1,420	9,204	5,631	2,280	1,294
